СОЁЛЫН ӨВИЙНТӨВИЙН 2015 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

2015 оны 12 дугаар сарын 01-ний өдөр Улаанбаатар хот

Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд, Соёлын өвийн төвийн захиралтай 2015 оны 2 дугаар сарын 09-ний өдөр байгуулсан Үр дүнгийн гэрээ, Соёлын өвийн төвийн үйл ажиллагааны жилийн төлөвлөгөөний дагуу 2015 онд хийсэн ажлыг тайлагнаж байна.

Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдтай тус төвийн захирлын байгуулсан Үр дүнгийн гэрээнд Гурван үндсэн бүтээгдэхүүний ангид хамаарах 23 нэр төрлийн ажлыг гүйцэтгэсэн ба үүний 3 нь тусгай арга хэмжээ, 20 нь үндсэн арга хэмжээнд хамаарч байна.

Соёлын өвийн төв 2015 оны Үр дүнгийн гэрээнд тусгагдсан бүхий л ажлыг хийж гүйцэтгэлээ.

БҮТЭЭГДЭХҮҮН НИЙЛҮҮЛЭХ АНГИ-1. СОЁЛЫН БИЕТ ӨВИЙГ ХАМГААЛАХ ХЭЛТСИЙН СТРАТЕГИЙН ЗОРИЛТЫГ ХАНГАХАД ЧИГЛЭСЭН АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭ

Энэ төрлийн ангид 1 тусгай арга хэмжээ, 7 үндсэн арга хэмжээ нийт 8 төрлийн ажил багтсан болно.

ТУСГАЙ ҮЙЛЧИЛГЭЭ

Музейн үзмэр болон үл хөдлөх дурсгалыг 3D-ээр сканнердан, бүртгэн баримтжуулах

Хүрэл тогоог 3D-ээр сканнердан баримтжуулах

Музейн үзмэрийг 3D-ээр сканнердан, бүртгэн баримтжуулах ажлын хүрээнд Монголын үндэсний музейн MYM2013.8.1, MYM2013.8.2, MYM2013.8.3 хувийн дугаар бүхий гурван хүрэл тогоог 3D-ээр сканнердан баримтжуулах, материалын судалгаа хийх ажлыг 2015 оны 3 дугаар сарын 24-ний өдрөөс 4-р сарын 17-ны өдрүүдэд тус төвийн програмист Б.Алтансүх, Ж.Даваацэрэн, техникийн ажилтан П.Чинбат нар хамтран гүйцэтгэлээ.

Энэхүү гурван хүрэл тогоо нь Сүхбаатар аймгийн Онгон сумаас олдсон бөгөөд Монголын үндэсний музейн сан хөмрөгт 2013 онд авсан бөгөөд судалгааны ажил харьцангуй бага хийгдсэн байдаг байна. Иймд эдгээр эдгээр тогоонуудыг судалгааны эргэлтэнд оруулах, 3D хэмжилтийн мэдээллийг СӨУНБМСанд хадгалах зорилгоор энэхүү ажлыг хийлээ.

Хүрэл тогоонуудыг музейгээс зохих журмын дагуу хүлээн авч анхан шатны хуурай цэвэрлэгээ буюу тоос шорооны бохирдлыг механик аргаар хөнгөн цэвэрлээд 3D-ээр хэмжилт хийв.

Хэмжилтийн ажилд Konica Minolta VIVID 9i 3D сканнер ашиглан 0.1 мм хүртэл нарийвчлалтай 3D виртуал загвар үүсгэн хадгаллаа. Энэхүү виртуал загвар нь хүрэл тогооны хэлбэр хэмжээ, багтаамж, ашиглалт зэргийг нарийвчлан судлах, түүнийг цахим хэлбэрээр

олон нийтийн хүртээл болгоход чухал ач холбогдолтой юм.

Монголын үндэсний музейн гурван хүрэл тогоо. MYM2013.8.2 хувийн дугаартай хүрэл тогооны 3D виртуал загварыг ашиглан багтаамж, тогооны зузаан зэргийг тооцсон байдал





Материалын судалгаа хийх ажил

Тогоо тус бүрийг X-MET7000 маркийн зөөврийн X-Ray төхөөрөмжөөр хэмжиж металийн найрлагийг тодорхойлсон бөгөөд бүгд зэс болон тугалганы тодорхой найрлага бүхий Хүрэл болох нь харагдана.

Хэмжилтийн үр дүн:

Хувийн дугаар: MVM2013.8.1

Element	Fe	Ni	Cu	As	Ag	Sn	Sb	Pb	Bi
%	0.22	0.15	84.17	0.34	0.11	10.61	0.13	4.39	0.09
±	0.006	0.005	0.084	0.052	0.012	0.085	0.032	0.136	0.006
Grades:	C927 (2.10), C924 (2.41)								

Хувийн дугаар: MVM2013.8.2

Element	Fe	Ni	Cu	As	Ag	Sn	Sb	Pb	Bi
%	0.31	0.13	90.58	0.66	0.12	4.90	0.20	3.22	0.05
±	0.006	0.005	0.090	0.055	0.014	0.065	0.035	0.143	0.006
Grades:	Cr Copper-C184 (1.80), C544 (2.10)								

Хувийн дугаар: MVM2013.8.3

Element	Ni	Cu	Zn	As	Sn				
%	0.11	99.28	0.00	0.20	0.40				
±	0.004	0.087	0.003	0.006	0.029				
Grades:	Zr Copper-C150 (0.28), Cr Copper-C184 (0.36)								

Хэмжилт хийж байгаа нь

Үл хөдлөх дурсгалыг 3D-ээр скайндаж бүртгэх ажил

Хөргийн хөндийн хүн чулуунуудыг 3D-ээр сканнердан баримтжуулах

Судалгааны баг 2015 оны 6 дугаар сарын 28-ний өдөр Улаанбаатар хотоос хөдөлж 29-ны өдөр 11 цагт Сүхбаатар аймгийн төвд ирэв. Аймгийн музейд ажлаа танилцуулж томилолтоо даруулаад үдээс хойш 15 цагийн үед Дарьганга сумруу хөдөллөө. Дарьганга сумаар дайралгүйгээр зүүн хойноос шууд хөргийн хөндийн гэх газар 23 цагын үед ирж буудалсан. Хүн чулууннууд хоорондоо тодорхой хэмжээний зайтай эгэнэсэн байдлалтай байсан.

3D лазер сканнерийг 2015 оны 6 дугаар сарын 30-наас 7 дугаар сарын 10-н хүртэл амжилттай хийж гүйцэтгэсэн.

3D лазер сканнерийг хээрийн нөхцөлд хийхэд зориулсан сүүдрэвч

3D лазер сканнерийг хийж байгаа нь

Нэг хүн чулууг 3D лазер сканнер хийхэд овор хэмжээ болон гэмтлийн байдлаас шалтгаалан 1-2 хоног шаардагдсан. Хүн чулуу бүрийг сканнер хийхээс өмнө ахан шатны цэвэрлэгээ хийж тоос шороо болон шувууны сангас гэх мэт бохирдсон хэсгүүдийг тухай бүрт нь цэвэрлэн лазер сканнерийн ажил хийсэн.

Урьдчилсан үр дүн

Хээрийн судалгааны ажлын дүнд цуглуулсан хүн чулууны 3D хэмжилтийн мэдээллийг Rapidform Geomagic XOS програм ашиглан анхан шатны байдлаар боловсруулж СӨУНБМСанд цахим хэлбэрээр хадгалахад бэлэн боллоо. Цаашид юунд, ямар зорилгоор ашиглахаас шалтгаалж дараагийн шатны боловсруулалтыг хийх нь зүйтэй.

Анхан шатны боловсруулалтын үр дүн:

1-р хүн чулуу /файлын хэмжээ: 2.91GB, файлын формат: XRL/



2-р хүн чулуу /файлын хэмжээ: 2.67GB, файлын формат: XRL/



3-р хүн чулуу /файлын хэмжээ: 3.03GB, файлын формат: XRL/



69.43.21 хувийн дугаартай Цагаан дара эх 3D-ээр баримтжуулах

Музейн үзмэрийн 3D-ээр скандах ажлын хүрээнд тус төв нь Г.Занабазарын нэрэмжит Дүрслэх урлагийн музей, МУИС-ийн Хэрэглээний шинжлэх ухаан, инженерчлэлийн сургууль нар тохиролцож хамтын ажиллагааны гэрээний дагуу Өндөр гэгээн Г.Занабазарын хосгүй үнэт 69.43.21 хувийн дугаартай Цагаан дара эх бүтээлийн гурван хэмжээст мэдээллийн санг 2015 оны 09-р сарын 02-нд амжилттай хийж гүйцэтгэсэн.

Унгар улсаар ирсэн Аюуш бурханыг Дүрслэх урлагийн музейн Аюуш бурхантай харьцуулсан судалгаа хийх, 3D-ээр баримтжуулах ажил

Унгар улсын иргэн Ласло Кадараас Монгол улсад хүлээлгэн Аюуш бурханыг тодорхойлоход Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2015 оны А/244 тоот тушаалын дагуу байгуулагдсан Ажлын хэсгийн хурлын шийдвэрийн дагуу уг Аюуш бурханыг Дүрслэх урлагийн музейн Занабазарын сургууль хийцийн гэх Аюуш бурхантай харьцуулсан судалгаа, материалын судалгаа хийж 3D-ээр сканнердан баримтжуулалтыг 2015 оны 7 дугаар сарын 17-24-ны өдрүүдэд хийж гүйцэтгэлээ.

3D-ээр баримтжуулах ажлыг тус төвийн програмист Б.Алтансүх, Ж.Даваацэрэн, техникийн ажилтан П.Чинбат нар хамтран гүйцэтгэлээ.

2015.07.17нд Г.Занабазарын нэрэмжит Дүрслэх урлагийн музейд техник тоног төхөөрөмжөө зөөн байршуулж сан хөмрөгийн эрхлэгч Д.Уранчимэг Аюуш бурханыг музейн сан хөмрөгөөс зохих журмын дагуу гаргаж өөрийн биеэр байлцан 3D-ээр хэмжих, материалын судалгаа хийх ажлыг 3 хоногт хийв.

Мөн 2015.07.22нд 72.83.01 хувийн дугаартай Аюуш бурханыг үзэсгэлэнгийн танхимаас 3D хэмжилт хийж буй өрөөрүү зөөн байрлуулан 3D-ээр хэмжих, материалын судалгаа хийх ажлыг хийв.

Хэмжилтийн ажилд Konica Minolta VIVID 9i 3D сканнер ашиглан 0.1 мм хүртэл нарийвчлалтай 3D виртуал загвар үүсгэн хадгаллаа. Энэхүү виртуал загвар нь Аюуш бурханы хэлбэр хэмжээ, ур хийц, харьцуулсан судалгаа хийх мөн нарийвчлан судлах, түүнийг цахим хэлбэрээр олон нийтийн хүртээл болгоход чухал ач холбогдолтой юм.

Хоёр Аюуш бурханыг 115 удаа 3D лазер скан хийж, 110 кадр гэрэл зураг авч баримтжуулсан бөгөөд нийт 3.1gb хэмжээтэй файлыг СӨУНБМСанд хадгалсан.

Г.Занабазар хийцийн гэх Аюуш бурхан



72.83.01 хувийн дугаартай Аюуш бурхан



3D лазер скан хийж буй ажлын явцын зураг

Мөн хоёр Аюуш бурханыг 3D виртуал загварыг үүсгэж цэгэн үүл (Point cloud) өргөтгөлөөр хадгалсан бөгөөд файл тус бүр 1.55gb, 1.20gb хэмжээтэй байна.

Мөн 2 Аюуш бурханыг тэгш хэмийн харьцуулсан зураг хийж ажлын хэсгийн гишүүн, бурханч лам Г.Пүрэвбатад хүлээлгэн өгсөн.



Тэгш хэмийн харьцуулсан зураг

Материалын судалгаа хийх ажил

Аюуш бурхан тус бүрийг X-MET7000 маркийн зөөврийн X-Ray төхөөрөмжөөр хэмжиж металийн найрлагыг тодорхойлсон бөгөөд Г.Занабазар хийцийн гэх Аюуш бурханы металийн найрлагыг тодорхойлсон байдал

- Хэмжилт хийсэн хэсгийн тэмдэглэгээ

Хэмжилтийн үр дүн:

Хэмжилт-1

Element	Au	Ag	Cu	Zn	As	W
%	94.81	2.69	1.81	0.35	0.06	0.02
±	0.148	0.055	0.017	0.008	0.007	0.018

Хэмжилт-2

Element	Cu	Zn	Pb	Fe	Ni	As	Mn		
%	96.20	2.53	0.61	0.24	0.21	0.09	0.01		
±	0.087	0.013	0.061	0.005	0.005	0.024	0.003		

Хэмжилт-3

Element	Au	Ag	Cu	Zn	Sn	As	W		
%	95.30	2.45	1.51	0.33	0.28	0.11	0.03		
±	0.151	0.056	0.016	0.008	0.056	0.008	0.020		

72.83.01 хувийн дугаартай Аюуш бурхан X-MET7000 маркийн зөөврийн X-Ray төхөөрөмжөөр хэмжиж металийн найрлагыг тодорхойлсон байдал





Хэмжилт-1

Element	Cu	Zn	As	Se	Ag	Sn	Au		
%	12.19	1.82	0.05	0.02	3.03	0.20	82.68		
±	0.045	0.016	0.008	0.009	0.057	0.051	0.151		

Хэмжилт-2

Element	Ni	Cu	Zn	As	Pb				
%	0.13	99.13	0.18	0.08	0.51				
±	0.004	0.088	0.004	0.022	0.057				

Хэмжилт-3

Element	Cu	Zn	As	Ag	Sn	Hf	Au		
%	9.02	1.65	0.03	2.71	0.18	0.17	86.23		
±	0.037	0.014	0.007	0.053	0.051	0.027	0.143		

Тоног төхөөрөмжийн тодорхойлт

3D лазер скан хийх, материалын судалгаа хийхэд дараах тоног төхөөрөмж болон програм хангамж ашиглалаа.

Д/д	Тоног төхөөрөмж	Зориулалт
1	**Konica Minolta VIVID 9i Non-Contact 3D digitizer**	Дунд болон жижиг хэмжээтэй обьектыг лазераар хэмжиж 3D загвар боловсруулах зориулалттай төхөөрөмж.
2	**Dell Precision Laptop**	Хээрийн судалгааны ажилд тохиромжтой, 3D хэмжилтийн мэдээллийг сканнераас тусгай програм хангамжийн тусламжтай хүлээн авч хадгалах, анхан шатны боловсруулалт хийх зориулалт бүхий өндөр хүчин чадалтай зөөврийн компьютер.
3	**Konica Minolta Polygon editing tool software**	VIVID 9i 3D сканнертай хоршин ажиллаж хэмжилтийн мэдээллийг компьютерт хадгалах, анхан шатны боловсруулалт хийх зориулалттай програм хангамж.
4	**Rapidform Geomagic XOS**	Бүх төрлийн 3н хэмжээст мэдээллийг мэргэжлийн түвшинд боловсруулах өргөн боломж бүхий програм хангамж.
5	Canon EOS 60D Review	Мэргэлжлийн зургын аппарат.
6		Бүх төрлийн эд материалын найрлагийг тогтоох зориулалттай төхөөрөмж. (X-MET 7500)

2015 онд музейн үзмэр 6 ширхэг, үл хөдлөх дурсгал 6 ширхэгийг тус бүр 3D лазер скан хийж, гэрэл зургаар баримтжуулан, нийт 34GB 3D цэгэн мэдээл, 1397 кадр дижитал гэрэл зургийн файлыг СӨУНБМСанд хадгалсан.

Д/д	Нэр, Хувийн дугаар	3D Файлын хэмжээ (GB)	Гэрэл зургийн кадрын тоо
1	Хүрэл тогоо МҮМ 2013.8.1	2.42	42
2	Хүрэл тогоо МҮМ 2013.8.2	6.02	54
3	Хүрэл тогоо МҮМ 2013.8.3	1.67	50
4	Аюуш 72.83.01	1.20	
5	Аюуш	1.55	110
6	Цагаан дара эх 69.43.21	5.67	
7	Хөргийн хөндийн 1-р хүн чулуу	2.91	176
8	Хөргийн хөндийн 2-р хүн чулуу	2.67	189
9	Хөргийн хөндийн 3-р хүн чулуу	3.03	182
10	Хөргийн хөндийн 4-р хүн чулуу	2.35	193
11	Хөргийн хөндийн 5-р хүн чулуу	2.12	199
12	Хөргийн хөндийн 6-р хүн чулуу	2.46	202
	нийт	34.07 **(GB)**	1397

1.1 Түүх, соёлын үл хөдлөх дурсгалын хадгалалт хамгаалалтыг төлөвлөх цахим удирдлагын системийн хэрэглэгчийн шаардлага боловсруулах

Түүх, соёлын үл хөдлөх дурсгалын хадгалалт хамгаалалтын байдлыг хянах, удирдах, төлөвлөх зорилго бүхий үндэсний хэмжээний цахим удирлагын мэдээллийн системийн ерөнхий ойлголт, хэрэглэгчийн талаарх мэдээлэл, түүний онцлог, системийн хамрах хүрээ болон хэрэглэгчийн шаардлагыг тодорхойлсон “Хэрэглэгчийн шаардлага тодорхойлох бичиг баримт”-ыг хэлтсийн мэргэжилтэн Б.Алтансүх, Г.Анхсанаа, Д.Отгон нар боловсруулаа.

Аливаа соёлын өв, түүн дотроо түүх, соёлын үл хөдлөх дурсгалыг хадгалж хамгаалах нь бүртгэх, судлан шинжлэх, сэргээн засварлах, сурталчлах зэрэг цогц ажлуудаас бүрдсэн цаг хугацаа, хөрөнгө мөнгө ихээхэн шаардсан ажил юм.

Монгол орны хувьд өргөн уудам газар нутагт тархан байршсан түүх, соёлын үл хөдлөх дурсгалаар арвин баялаг билээ. Өнгөрсөн хугацаанд эдгээр дурсгалуудыг бүртгэх, судлан шинжлэх, сэргээн засварлах, сурталчлах, хадгалах, хамгаалах ажлыг яам, агентлаг, мэргэжлийн байгууллагууд, орон нутгийн захиргаа дор бүр өөр өөрийн түвшинд хийсээр ирсэн боловч хоорондын ажлын уялдаа холбоо, мэдээлэл солилцох арга хэлбэр болоод идэвхи санаачлага муу байдгаас шалтгаалж үл хөдлөх дурсгалын урт хугацааны хадгалалт хамгаалалтын цогц бодлого, түүнийг хянах, хэрэгжлүүлэх, төлөвлөх нэгдсэн систем үгүй явж ирсэн байна.

Мэдээлэл дээр суурилсан аливаа үйл ажиллагааны хамгийн гол нь мэдээллийн системийг байгуулж, түүний тусламжтай компьютерийн системд мэдээллийг оруулах, нэгтгэн боловсруулах боломжтой болгох явдал юм.

Цахим удирдлагын систем нь түүх, соёлын үл хөдлөх дурсгалын хадгалалт хамгаалалтын тухай мэдээллүүдийг нэгтгэн боловсруулахад зориулагдсан систем буюу веб-д суурилсан програм хангамж юм. Програм хангамж нь доорх хоёр дэд системээс бүрдэнэ.

1. Улс, аймгийн хамгаалалтанд байх 451 түүх, соёлын үл хөдлөх дурсгалын хадгалалт хамгаалалтын менежментийн систем

2. Палеонтологи, археологийн эрдэм шинжилгээний болон авран хамгаалах хайгуул, малтлага судалгааны ажлыг хянах, төлөвлөх удирдлагын систем

Дэд систем тус бүр дараах 3 модультай байна.

Бүртгэл мэдээлэл, тохиргооны модуль

Хадгалалт хамгаалалтын чиглэл тодорхойлох модуль

Тайлангийн модуль

Системийн үйл ажиллагааны бүтцийг схемээр харуулав.

Системийн үйл ажиллагааны бүтэц



Энэхүү систем нь Соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, 21 аймгийн боловсрол, соёлын газар, палеонтологи, археологийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг мэргэжлийн байгууллагуудыг хамрах болно.

№	Байгууллагууд	Байгууллагын тоо
Соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага		
1	Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам	1
Судалгааны байгууллага		
1	ШУА-ын Түүх, археологийн хүрээлэн	1
2	Нүүдлийн соёл иргэншлийг судлах олон улсын хүрээлэн	1
3	Монголын үндэсний музей	1
4	МУИС-ийн Анторпологи-Археологийн хүрээлэн	1
5	Улаанбаатар Их сургууль	1
6	ШУТИС-ийн Түүх, аялал жуулчлалын порфессорын баг	1
7	Ховд Их сургааль	1
Соёлын өвийн бүртгэл, мэдээллийн сан		
1	Улсын нэгдсэн бүртгэл, мэдээллийн сан (Соёлын өвийн төв)	1
2	Аймаг, нийслэлийн бүртгэл, мэдээллийн сан	22
Орон нутгийн соёлын өвийн асуудал эрхэлсэн байгууллага		
1	Аймгийн Боловсрол соёлын газар	21
	Нийт	**52**

Системийн хэрэглэгчийн зүгээс оруулж буй мэдээлэл дараах агуулгатай байж болно.

Хадгалалтын байдал

- о Хадгалалтын нөхцөл байдал
- о Хадгалалтыг сайжруулах санал

Ашиглалтын байдал

- о Ашиглалтын одоогийн нөхцөл байдал
- о Ашиглалтын байдлыг сайжруулах санал

Судлагдсан байдал

- о Судалгааны баримт материалууд
- о Цаашдын судалгааны төлөвлөгөө

Сэргээн засварлалтын байдал

- о Сэргээн засварласан байдал
- о Сэргээн засварлалтын цаашдын төлөвлөгөө

Түүх, соёлын үл хөдлөх дурсгалын хадгалалт хамгаалалтын байдлын мэдээллийн нэгдсэн сан үүсгэснээр бодит мэдээлэлд тулгуурлан дурсгалын хадгалалт хамгаалалтыг урт хугацаанд төлөвлөх, түүнийг удирдах боломж бий болох юм. Түүнчлэн соёлын өвийн хадгалалт хамгаалалтын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн болоод орон нутгийн байгууллагуудын ажлын уялдаа холбоо сайжирч тэр хэрээр дурсгалын хадгалалт хамгаалалтанд бодит ахиц гарах юм.

Цаашид энэхүү системийг өргөжүүлэн хөгжүүлж түүх, соёлын хөдлөх дурсгал болох музейн үзмэр эд өлгийн зүйлс, археологийн малтлага судалгаагаар илэрсэн олдворуудыг хамруулах бүрэн боломжтой.

Системийг бүрэн тодорхойлж, веб-д суурилсан програм хангамж зохиох ажилд 50-60 сая төгрөгний санхүүжилт шаардлагатай ба зургаан сарын хугацаанд системийг бүрэн нэвтрүүлэх боломжтой.

1.2 Баянхонгор аймгийн өмнө болон баруун хойд талын 10 сум, Өмнөговь аймгийн зүүн болон хойд талын 7 сумдын нутаг дахь түүх, соёлын үл хөдлөх дурсгалыг бүртгэн баримтжуулах

Баянхонгор аймгийн өмнө болон баруун хойд талын 10 сум, Өмнөговь аймгийн зүүн болон хойд талын сумдын нутаг дахь түүх, соёлын үл хөдлөх дурсгалыг бүртгэн баримтжуулах ажлыг

энэ онд улс орон даяар явагдаж байгаа “Түүх, соёлын үл хөдлөх дурсгалын үзлэг тооллого-2015”-тай уялдуулан тухайн аймгуудтай үйл ажиллагааны гэрээ байгуулан шаардлагатай төсвийг шилжүүлэн, Соёлын өвийн төвөөс мэргэжлийн арга зүйгээр хангасан.

Түүх, соёлын үл хөдлөх дурсгалын үзлэг тооллогын ажлыг орон нутагт хийх хээрийн бүртгэлийн багийг чадваржуулж дэмжих үүднээс хэлстийн мэргэжилтэнгүүд Баянхонгор, Өмнөговь, Хөвсгөл, Төв, Баян-Өлгий зэрэг аймаг, хөдөө орон нутгаар явж тухай аймгийн тооллогын багтай хамтран ажилласан.

Мэргэжилтэн Г.Анхсанаа 2015 оны 7 дугаар сарын 19-аас 7 дугаар сарын 22 хүртэл 4 хоног Баянхонгор аймгийн Баян-Овоо сумын нутагт, аймгийн соёлын мэргэжилтэн Д.Мөнхцэцэг тэргүүтэй, музейн ажилтан БМС Б.Эрдэнэхуяаг, ЭША Д.Насантогтох, сумаас ИТХ-ийн дарга Ж.Хатанбаатар, Соёлын төвийн эрхлэгч Ц.Должинсүрэн, II багийн дарга Г.Орхонтуул нарын хамт ажилласан болно. Уг ажлаар суман дахь 23 дурсгалт газрын 242 үл хөдлөх дурсгалыг тоолж бүртгэв.

Үл хөдлөх дурсгалын үзлэг тооллогоор 2015 оны 7 дугаар сар 28-аас 8 дугаар сарын 3 хүртэл 6 хоног Өмнөговь аймгийн Булган, Мандал-Овоо, Цогт-Овоо, Ханхонгор сум гэсэн маршрутаар 4 сумын нутагт ажиллаа. Хээрийн бүртгэлийн багт аймгийн Боловсрол, соёлын газрын мэргэжилтэн Б.Золзаяа, Музейн Бүртгэл мэдээллийн санч Б.Энхтөр, тайлбарлагч Э.Отгонжаргал, Ахмад багш С.Ренчинхорлоо, жолооч Б.Мөнхбаатар нар оролцов. Мөн 2015 оны 6 дугаар сар 2-6 хооронд Хөвсгөл аймгийн Арбулаг суманд тус аймгийн багтай хамтран ажиллаж үзлэг тооллогыг хийлээ.

Мэргэжилтэн Т.Эрдэнэцогт 2015 оны 5 дугаар сар 18-21 хооронд Төв аймгийн Алтанбулаг суманд тус аймгийн багтай, 2015 оны 7 дугаар сарын 25-наас 7 хоногийн хугацаатай Баян-Өлгийн аймгийн Алтай суманд тус тус ажилласан.

Хэлтсийн мэргэжилтэнгүүд үзлэг тооллогын үеэр Баянхонгор, Өмнөговь, Хөвсгөл, Төв, Баян-Өлгий аймагт ажиллаж 185 дурсгалт газрын 869 үл хөдлөх дурсгалыг тоолж бүртгэх ажлыг хийж гүйцэтгэлээ.

№	Аймаг, сум	Дурсгалт газрын тоо	Дурсгалын тоо
1	Хөвсгөл аймгийн Арбулаг сум	58	199
2	Баянхонгор аймгийн Баян-Овоо сум	24	242
3	Өмнөговь аймгийн Булган сум	14	27
4	Өмнөговь аймгийн Мандал-Овоо сум	8	17
5	Өмнөговь аймгийн Цогт-Овоо сум	10	13
6	Өмнөговь аймгийн Ханхонгор сум	9	25
7	Төв аймгийн Алтанбулаг сум	18	64
8	Баян-өлгий аймгийн Алтай сум	44	282
	Нийт	**185**	**869**

Баянхонгор аймгийн Баян-Овоо сумын нутаг дахь түүх, соёлын үл хөдлөх дурсгалын жагсаалт

№	Дурсгалын төрөл	Оршин буй газрын нэр	Дурсгалын тоо
1	Хиргисүүр	Баруун булаг	2
2	Агуй	Дархайн уул	1
3	Дөрвөлжин булш , хиргисүүр	Дуурсахын хөндийд	3
4	Хиргисүүр	Мааньтын үзүүрийт	1
5	Цулгуй хөшөө	Намын үзүүрийт	1
6	Тахилын онгон-1 Хүн чулуун хөшөө	Номгоны хөндийд	3
7	Олон овоо	Өнгөтийн нурууны оройд	5
8	Таван хошуу малын баримал	Сумын төвд	1
9	Хиргисүүр	Улаан их уулын энгэрт	40
10	Хадны зураг	Улаан толгойд	1
11	Хиргисүүр	Улаан хадны үзүүрийт	1

12	Булш, хадны зураг	Уран хайрхан уулын хормойд	1
13	Хиргисүүр , дөрвөлжин булш	Уртын голд	1
14	Хиргисүүр	Уяагийн усан хөтөлд	2
15	Агуй -1, Хиргисүүр 20,	Халзан хайрхан уулын дэлд дурсгал	131
16	Хиргисүүр	Ханангийн хормойд	1
17	Хиргисүүр	Хар үзүүрийн дурсгал	1
18	Тахилын онгон	Хаяагийн үзүүрт	1
19	Булш	Хонхор дэрс	7
20	Хиргисүүр	Хөвших хайрханд	21
21	Хиргисүүр	Худагтын ард	1
22	Хадны сүг зураг	Хүрэн жинсний бэлд	1
23	Хадны сүг зураг	Хээрийн өвөрт	1
24	Агуй , хиргисүүр	Цагаан дэлийн энгэрт	4
	Нийт		**242**

Өмнөговь аймгийн Булган сумын нутаг дахь түүх, соёлын үл хөдлөх дурсгалын жагсаалт

№	Дурсгалын төрөл	Оршин буй газрын нэр	Дурсгалын тоо
1	Хадны сүг зураг	Булагтайд	1
2	Булш	Булагтайд	10
3	Хиргисүүр	Булагтайд	1
4	Палеонтологийн дурсгалт газар	Баянзаг	1
5	Бичээс	Хадат рашаа	1
6	Хадны сүг зураг	Хавцгайтын	5
7	хиргисүүр	Хавцгайтын	1
8	Ганданчоймзадлин хийд	Сумаас урд зүгт 35 км	1
9	Чулуун зэвсэг	Цахиуртын хөндийд	1
10	Палеонтологийн дурсгалт газар	Төгрөгийн ширээ	1
11	Палеонтологийн дурсгалт газар	Алаг тээг	1
12	Овоо	Монгол эр хүний хийморийн овоо	1
13	Палеонтологийн дурсгалт газар	Авдрантын нуруу	1
14	Палеонтологийн дурсгалт газар	Хөрхийн цоорхой	1
	Нийт		**27**

Өмнөговь аймгийн Мандал-Овоо сумын нутаг дахь түүх, соёлын үл хөдлөх дурсгалын жагсаалт

№	Дурсгалын төрөл	Оршин буй газрын нэр	Дурсгалын тоо
1	Хиргисүүр	Хулгар хайрханы	5
2	Сүм, хийд	Шар хулсангийн хийд	1
3	Овоо	Морьт хөв	1
4	Хадний сүг зураг	Тээгийн хар дэлний	3
5	Суврага	Цагааны орчим	1
6	Шивээ	Харуулийн шивээ	1
7	Булш	Авдрантын	4
8	Палеонтологийн дурсгалт газар	Алгуй улаан цав	1
	Нийт		**17**

Өмнөговь аймгийн Цогт-Овоо сумын нутаг дахь түүх, соёлын үл хөдлөх дурсгалын жагсаалт

№	Дурсгалын төрөл	Оршин буй газрын нэр	Дурсгалын тоо
1	Эртний хот	Хотын хөх	1
2	Эртний хот	Тогоон төмөр хааны өвлийн ордны туурь	1
3	Эртний хот	Тогоон төмөр хааны сэрүүн дэнж	1
4	Бичээс	Цагаан хад	1
5	Үйлдвэрлэлийн ул мөр бүхий газар	Тариалангийн талбай	1
6	Хөшөө дурсгал	Сумын төвийн хөшөө	2
7	Хадны зураг	Бичигтийн хадны сүг зураг	3
8	Хадны зураг	Зараа хайрханы булш	1
9	Хадны зураг	Зараа хайрханы хадны сүг зураг	1
10	Сүм хийд	Довийн хийд	1
	Нийт		**13**

Өмнөговь аймгийн Ханхонгор сумын нутаг дахь түүх, соёлын үл хөдлөх дурсгалын жагсаалт

№	Дурсгалын төрөл	Оршин буй газрын нэр	Дурсгалын тоо
1	Хөшөө дурсгал	Хуянгийн хөшөө	1
2	Хадны зураг	Шар хороот бууц	1
3	Хиргисүүр	Булаг хайрхан	11
4	Сүм хийд	Балгасны хийд	1
5	Сүм хийд	Маанийн хийд	1
6	Хөшөө дурсгал	Эцэг мал	1
7	Хадны зураг	Хүрэн овоотын бууц	1
8	Булш	Өгөөмөр хайрханы булш	6
9	Хадны зураг	Өгөөмөр хайрханы	1
	Нийт		**25**

Хөвсгөл аймгийн Арбулаг сумын нутаг дахь түүх, соёлын үл хөдлөх дурсгалын жагсаалт

№	Дурсгалын төрөл	Оршин буй газрын нэр	Дурсгалын тоо
1	Булш оршуулгын дурсгал	Хар толгойн булш	2
2	Хиргисүүр	Харын завсрын үзүүрийн “Гол мод” -ын хиргисүүс	1
3	Булш оршуулгын дурсгал	Хавцгайтын эхний нуурын зүүн талын булш	1
4	Хиргисүүр	Булш /хиргисүүр/	1
5	Сийлмэл зураг	Маанийн үсэгтэй чулуу	1
6	Хиргисүүр	Улаан толгойн үзүүрийн хиргисүүр	1
7	Хиргисүүр	Худгийн амны хиргисүүр	1
8	Булш оршуулгын дурсгал	Улаан толгойн ар дахь Хийтийн голын хойт дэнж дээрх дугуй булш	1
9	Буган чулуун хөшөө	Бадрахын өврийн гурван буган хөшөө	3
10	Булш оршуулгын дурсгал	Хүйсийн булгийн булш	1

11	Булш оршуулгын дурсгал	Харын завсрын Хөндлөн цахирын булш	7
12	Хиргисүүр	Хавцгайтын эхийн хиргисүүр	4
13	Зос, бэхэн зураг	Бэлчрийн амны хадны зураг	1
14	Булш оршуулгын дурсгал	Хиргисүүр, булш	5
15	Булш оршуулгын дурсгал	“Чингүнжавын гэрийн буурь” гэдэг эртний булш	24
16	Хиргисүүр	Хүрхрээн баруун булгийн амны хиргисүүр	1
17	Сүм хийдийн турь	Урд гялаадын амны дуганы туурь	1
18	Хиргисүүр	Хиргисүүр, Харын үзүүр гэдэг газар	1
19	Хиргисүүр	Хавцгайтын эхний Дэлийн өврийн хиргисүүр	2
20	Сийлмэл зураг	Дэлгэрхааны өвөр дахь хадны зураг	4
21	Буган чулуун хөшөө	Цартын дэнжийн буган чулуун хөшөө	1
22	Хадны зураг, бичгийн дурсгал	Хадны зураг	1
23	Буган чулуун хөшөө	Цартын арын шувтрах үзүүрийн буган хөшөө	1
24	Хиргисүүр	Дунд Салдаргын амны хиргисүүр	1
25	Зос, бэхэн зураг	Мэнгэт хад	1
26	Булш оршуулгын дурсгал	Дэлгэрхааны өвөр дэхь Хадны зураг, булш	3
27	Овоо	Цагаан чулуутын овоо	17
28	Хиргисүүр	Хиргисүүр	1
29	Хиргисүүр	Хиргисүүр	1
30	Хиргисүүр	Хиргисүүр /Бадрахын өврийн гурван нуурын ар шил/	1
31	Тахилын онгон	Бортын амны тахилын байгууламж	1
32	Хиргисүүр	Харын үзүүрийн хиргисүүр	10
33	Хадны зураг, бичгийн дурсгал	Бурхант хад	13
34	Булш оршуулгын дурсгал	Хөндлөнгийн өврийн 3 булш	1
35	Сүм хийдийн туурь	Хүйсийн хүрээний туурь	1
36	Булш оршуулгын дурсгал	Улаан толгойн ар шилний булш	1
37	Хиргисүүр	Товгорын Улаан чулууны хиргисүүр	1
38	Булш оршуулгын дурсгал	Улаан амны булш	1
39	Сүм хийдийн турь	Эрчүү хотын туурь	2
40	Буган чулуун хөшөө	Бадрахын өврийн буган хөшөө	3
41	Хиргисүүр	Харын завсар Хөндлөн цахирын булш, хиргисүүр	7
42	Булш оршуулгын дурсгал	Хиргисүүр, булш	4
43	Хиргисүүр	Хиргисүүр	1
44	Булш оршуулгын дурсгал	“Чингинжавын гэрийн буурь” булш	4
45	Булш оршуулгын дурсгал	Булш	1
46	Сийлмэл зураг	Хадны зураг	1
47	Овоо	Цагаан чулуутын овоо	17
48	Булш оршуулгын дурсгал	Дугуй булш	1
49	Булш оршуулгын дурсгал	Дөрвөлжин булш	1
50	Булш оршуулгын дурсгал	Булш	2
51	Хиргисүүр	Хиргисүүр	1
52	Хиргисүүр	Харын үзүүрээс Галбангийн өвөр хүртлэх хиргисүүр	20
53	Хиргисүүр	Дөрвөлжин хүрээтэй хиргисүүр	1

54	Хиргисүүр	Булш	1
55	Хиргисүүр	Хиргисүүрүүд	10
56	Булш оршуулгын дурсгал	Булш	1
57	Булш оршуулгын дурсгал	Булш	1
	Нийт		**199**

1.2.1 Төв аймгийн Алтанбулаг суманд явуулсан түүх, соёлын үл хөдлөх дурсгалын үзлэг тооллогын тайлан

Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамнаас Монгол Улсын Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 212.1-д заасан түүх, соёлын үл хөдлөх дурсгалын үзлэг, тооллогын ажлыг улс даяар 2015 оны 05 дугаар сарын 01-нээс 10 дугаар сарын 01-ний хугацаанд зохион байгуулахаар төлөвлөсөн билээ.

Энэ ажлын хүрээнд Төв аймгийн музейтэй хамтран тус аймгийн Алтанбулаг суманд түүх, соёлын үл хөдлөх дурсгалын үзлэг, тооллогын ажлыг RICH 0.3 программ оруулан үзлэг тооллогоор тоологдсон бүртгэл, мэдээллээ 5 дугаар сард багтаан Соёлын өвийн төвийн cch@monheritage.mn хаягаар илгээх мөн үзлэг тооллогын ажлыг тайлагнах зорилготой ажиллаа.
Алтанбулаг сум нь анх 1936 онд Бор-Өндөр уулын өвөр дэх Даржаалингийн жасын суурин дээр Бор-Өндөр нэртэйгээр байгуулагдсан. Хуучнаар Богдын Их Шавийн отог. Одоогийн Алтанбулаг сум нь 1959 онд байгуулагдсан.

Газар зүйн байршил: Төв аймгийн Алтанбулаг сум нь нийслэл Улаанбаатар хотоос баруун тийш 52 км, аймгийн төвөөс 48 км зайтай Туул голын хөвөөнд байрладаг. Зүүн урд, урд талаараа Сэргэлэн, Баянцагаан Баян-Өнжүүл, баруун, баруун хойд, хойд талаараа Бүрэн, Өндөрширээт, Лүн,Баянхангай, Аргалант, Баянцогт сумдууд болон зүүн талаараа Улаанбаатар хотын Сонгинохайрхан, Хан-Уул дүүрэгтэй хиллэдэг. Тус сум нь Улаанбаатар хотоос 54 км зайд оршдог, замын хувьд 36 км нь засмал, 18 км нь шороон замтай. Хүн ам шилжилт хөдөлгөөн харьцангуй тогтвортой байна. Далайн төвшинээс дээш 1260 м өргөгдсөн. Газар хөдлөлийн 7-8 балл эрчимтэй бүсэд оршдог.

Нийт хэмжээ 565295га нутаг дэвсгэрийн 487411,91 га буюу 90 хувийг бэлчээрийн газар эзэлдэг байна. 1959га ойн сангийн газраас ойгоор бүрхэгдсэн талбай 18104га бөгөөд хусан ой 624га бургасан ой 1186га байна. Нийт газар нутгийн хэмжээ 565295 га.

Алтанбулаг сум нь. 1-р Сумт, 2-р Аргал, 3-р Алтан-Овоо, 4-р Замт гэсэн засаг захиргааны 4 багтай. Нийт 954 өрхийн 3024 хүн амтай. Үүнээс 1578 эрэгтэй, 1446 эмэгтэй байна.

2015-оны 05-р сарын 13 ны Лхавга гаригийн өглөө Төв аймгийн Музейгээс Алтанбулаг сумыг зорин явсан билээ. Алтанбулаг суманд очин сумын Тамгын газрын дарга Б.Цэрэнбаттай уулзан түүх, соёлын үл хөдлөх дурсгалын үзлэг, тооллогын ажлыг танилцуулан хамтарч ажиллахаар тогтож Алтанбулаг сумын Тамгын газраас тус суманд зарцуулах бензинээр хангаж, газар нутгийн нэр сайн мэдэх Алтанбулаг сумын 4-р багийн дарга Баярсайхан, Соёлын төвийн номын сангч Цэцгээ нарыг хамруулан ажиллуулах боломжийг ханган хамтран ажиллахаар болсон юм.

Алтанбулаг сумын Түүх, соёлын үл хөдлөх дурсгалын үзлэг, тооллогын ажлын явцад бүртгэсэн дурсгалт газрын нэрс.

1. Алтанбулаг сумын Алтан-Овоо III багийн нутагт сумын төвөөс баруун урагш 35 км / GPS-ээр хэмжсэн км / орших өвөр тавинтай гэдэг газар
2. Алтанбулаг сумын төвөөс баруун урагш 36 км-т Алтан-Овоо III багийн нутагт Тамирын хөтөл.
3. Алтанбулаг сумын төвөөс баруун урд зүгт 40 км-т Алтан-Овоо III багийн нутагт Ивгээлт.
4. Алтанбулаг сумын төвөөс баруун урд зүгт 42 км-т Алтан-Овоо III багийн нутагт Нарийний ам.
5. Алтанбулаг сумын төвөөс баруун зүгт 34 км-т Алтан-Овоо III багийн нутагт Тэмээн чулуут.

6. Алтанбулаг сумын төвөөс баруун урагш 32 км Замт IV багийн нутагт Гэндлэн.

7. Алтанбулаг сумын төвөөс баруун тийш 75 км Замт IV багийн нутаг Шандны адагт.

8. Алтанбулаг сумын төвөөс баруун тийш 50 гаруй км Замт IV багийн нутаг Эрдэнэ хайрхан.

9. Алтанбулаг сумын төвөөс баруун хойш 50 км-т орших Хоньтийн нуруу.

10. Алтанбулаг сумын төвөөс баруун зүгт Замт 4-р багийн нутагт Морин толгой уул.

11. Алтанбулаг сумын төвөөс баруун зүгт 38 км-т Замт 4-р багийн нутагт Тариат.

12. Алтанбулаг сумын төвөөс баруун зүгт 35 км зайд орших Замт 4-р багийн нутаг Цагаан бургастай.

13. Алтанбулаг сумын төвөөс баруун зүгт 32 км зайд орших Замт 4-р багийн нутагт Дөрвөнжин.

14. Алтанбулаг сумын төвөөс баруун зүгт 32 км зайд орших уг дурсгал нь Замт 4-р багийн нутагт Морин чих.

15. Алтанбулаг сумын төвөөс баруун хойш Туул голын хөндийд 32 км зайд орших Замт 4-р багийн нутагт Өнгөт уул.

16. Алтанбулаг сумын төвөөс баруун хойно 30 км зайд орших Замт 4-р багийн нутагт Уртын ам.

17. Алтанбулаг сумын төвөөс баруун хойш 40км-т 4-р багийн нутагт орших уг дурсгал нь Батхуяг малчины өвөлжөөний энгэрт /газрын нэрийг мэдэхгүй байсан/

18. Алтанбулаг сумын төвөөс баруун хойш 30км-т Замт 4-р багийн нутаг Доод мандал.

Төв аймгийн Алтанбулаг суманд нийт 500 гаруй км зам туулан 1 шөнө 2 өдөр зарцуулан ажиллаж нийт 18 дурсгалт газар бүртгэж 140 гаруй солиболцлын цэг, хамрах хүрээний 8 дурсгалт газрын цэг авч баримтжуулсан билээ. Үл хөдлөх дурсгалын үзлэг тоологын Ажлын хэсэг Төв аймгийн Музейн захирал Б.Даваасүрэн, музейн эрдэм шинжилгээний ажилтан Ц.Цэцэгжаргал, музейн сан хөмрөгч Г.Дагмидмаа, музейн жолооч Б. Мэндбаяр, Соёлын өвийн төвийн үл хөдлөх дурсгал хариуцсан мэргэжилтэн Т.Эрдэнэцогт, Алтанбулаг сумын Соёлын төвийн номын санч Цэцгээ, Алтанбулаг сумын Замт багийн дарга Баярсайхан нарын бүрэлдэхүүнтэй ажиллав.



№	Gx	Mx	Sx	Gy	My	Sy	x	y	Дурсгалт газрын нэр
1	97	16	45	47	15	31	97.27917	47.25861	баян улаан
1	105	57	20	47	2	11	105.9556	47.03639	Өвөр тавинтайн тахилын онгон
2	106	12	6.3	47	23	42.8	106.2018	47.39522	Тамирын хөтлийн хиргисүүр
3	106	3	21.9	47	25	21.9	106.0561	47.42275	Ивгээлтийн хиргисүүр
4	108	3	21.9	47	25	21.9	108.0561	47.42275	1 дэх цэг
5	106	3	53.1	47	25	42.7	106.0648	47.42853	2 дэх цэг
6	106	3	57.2	47	25	45.1	106.0659	47.42919	3 дэх цэг
7	106	4	12.5	47	25	46.5	106.0701	47.42958	4 дэх цэг
8	106	3	24.4	47	25	43.8	106.0568	47.42883	Жаргалантын амны хадны зураг
9	106	3	17.4	47	25	44.8	106.0548	47.42911	Жаргалантын амны хиргисүүр, булш
10	106	12	51.1	47	26	81	106.2142	47.45583	Нарийний амны булш, хиргисүүр
11	106	2	24.3	47	26	31.8	106.0401	47.44217	Нарийний амны хиргисүүр
12	106	2	22.1	47	26	32	106.0395	47.44222	Тэмээн чулуутын хадны зураг, булш, хиргисүүр
13	106	2	17.2	47	30	34.6	106.0381	47.50961	Тэмээн чулуутын хиргисүүр
14	106	2	10.7	47	30	20.7	106.0363	47.50575	Тэмээн чулуутын булш
15	106	2	21.6	47	30	50.2	106.0393	47.51394	1 дэх цэг
16	106	2	25.3	47	30	49.2	106.0404	47.51367	2 дэх цэг
17	106	2	18.8	47	30	33.4	106.0386	47.50928	3 дэх цэг
18	105	49	2.6	47	27	22.1	105.8174	47.45614	Гэндлэнгийн шороон овоолго бүхий байгууламж
19	105	47	45.8	47	15	56.5	105.7961	47.26569	Шандны адгийн хиргисүүр
20	105	47	46.7	47	18	0	105.7963	47.3	Шандны адгийн булш
21	105	42	55.6	47	18	21.3	105.7154	47.30592	Эрдэнэ хайрханы булшнууд
22	105	37	11.2	47	16	49.3	105.6198	47.28036	Хоньтийн нурууны урд Наваанэрэнгийн хүрээний туурь /Туулийн гүний хүрээ/
23	105	39	18.8	47	18	4.9	105.6552	47.30136	1 дэх цэг
24	105	39	20.7	47	18	5	105.6558	47.30139	2 дэх цэг
25	105	39	22.1	47	18	3.6	105.6561	47.301	3 дэх цэг
26	105	39	26.7	47	17	45.8	105.6574	47.29606	Хоньтийн нурууны урд энгэрийн хиргисүүр

27	105	39	18.8	47	18	4.9	105.6552	47.30136	Хоньтийн нурууны урд амны бэлд хиргисүүр
28	105	39	18.8	47	18	4.9	105.6552	47.30136	1 дэх цэг
29	105	39	20.7	47	18	5	105.6558	47.30139	2 дэх цэг
30	105	39	22.1	47	18	3.6	105.6561	47.301	3 дэх цэг
31	105	39	41.7	47	18	3.1	105.6616	47.30086	Хоньтийн нурууны урд амны бэлд хиргисүүр
32	105	39	49.9	47	18	45.1	105.6639	47.31253	Морин толгойн олон үеийн дурсгал
33	105	39	49.9	47	18	45.1	105.6639	47.31253	Баруун хойд-1
34	105	39	57.5	47	18	47	105.666	47.31306	Хойд зүг-2
35	105	40	12.2	47	18	50.9	105.6701	47.31414	Зүүн хойд -3
36	105	40	15.8	47	18	41.8	105.6711	47.31161	Зүүн урд-4
37	105	40	0	47	18	32.4	105.6667	47.309	Баруун урд-5
38	105	41	53.1	47	21	11.1	105.6981	47.35308	Зэл чулуу
39	105	41	16.8	47	22	48.6	105.688	47.38017	Тариатын Хиргисүүр, булш
40	105	41	54.8	47	23	36.6	105.6986	47.3935	Тариатын дөрвөлжин булш
41	105	41	59	47	24	18	105.6997	47.405	Тариатын булш, хиргисүүр
42	105	41	59	47	24	18	105.6997	47.405	Баруун хойд-1
43	105	42	34.4	47	24	2.5	105.7096	47.40069	Зүүн урд-2
44	105	42	28.1	47	24	23.6	105.7078	47.40656	Зүүн хойд зүг-3
45	105	43	19	47	25	45.4	105.7219	47.42928	Цагаан бургастайн амны тахилын байгууламжтай хиргисүүр
46	105	45	11.4	47	28	35.8	105.7532	47.47661	Дөрвөлжингийн энгэрийн булш
47	108	2	7	47	47	38	108.0353	47.79389	Морин чих уулын амны булш, хиргисүүр
48	105	46	43	47	31	4.1	105.7786	47.51781	Баруун хойно-1
49	105	47	24.6	47	31	53	105.7902	47.53139	Зүүн хойно-2
50	105	47	33	47	31	45.7	105.7925	47.52936	Зүүн урд-3
51	105	50	54	47	33	11.2	105.8483	47.55311	Өнгөт уулын цогцолборт газар
52	105	50	54	47	33	11.2	105.8483	47.55311	Баруун хойд - 1
53	105	51	0.6	47	33	16.2	105.8502	47.5545	Зүүн хойд - 2
54	105	52	44.6	47	33	9.7	105.8791	47.55269	Зүүн урд- 3
55	105	52	29.6	47	32	51.7	105.8749	47.54769	Баруун урд- 4

56	105	48	4.4	47	38	26.8	105.8012	47.64078	Уртын амны зүүн салааны булш, хиргисүүр, буган чулуун хөшөө
57	105	48	4.4	47	35	27.2	105.8012	47.59089	Хиргисүүр /Батхуяг малчны өвөлжөөний энгэрийн/
58	105	49	44.9	47	34	57.5	105.8291	47.58264	Өнгөт уулын энгэрийн булш, хиргисүүр
59	106	0	11.8	47	36	33.1	106.0033	47.60919	Доод мандалын бунхан
60	106	11	3	47	43	40	106.1842	47.72778	Шувууны амны хиргисүүр
61	106	5	51	47	42	23	106.0975	47.70639	Хонгорын амны хиргисүүр
62	106	2	44	47	39	41	106.0456	47.66139	Дээд мандлын булш, хиргисүүр
63	106	9	49	47	43	14	106.1636	47.72056	Алтанцэцэгийн амны адагт байдаг Тахилын онгоны хөшөө чулуу
64	106	12	4	47	44	6	106.2011	47.735	Улаан хужиртын тахилын онгоны хөшөө чулуу
65	105	50	58.3	47	33	12.1	105.8495	47.55336	1. Хашлага чулуу
66	105	50	58.4	47	33	12	105.8496	47.55333	№2- А. Хүн чулуу
67	105	50	58.6	47	33	12	105.8496	47.55333	№3- А. Хүн чулуу
68	105	50	58.7	47	33	12	105.8496	47.55333	№4- А. Хүн чулуу
69	105	50	58.8	47	33	11.9	105.8497	47.55331	№5- А. Хүн чулуу
70	105	50	59.6	47	33	11.8	105.8499	47.55328	№6- А. Хүн чулуу
71	105	51	0	47	33	11.8	105.85	47.55328	№7- А. Хүн чулуу
72	105	51	0.4	47	33	11.7	105.8501	47.55325	№8- А. Хүн чулуу
73	105	51	58.3	47	33	12.1	105.8662	47.55336	№2-Б Хүн чулуу
74	105	50	58.6	47	33	12.1	105.8496	47.55336	№3-Б Хүн чулуу
75	105	50	58.8	47	33	12.1	105.8497	47.55336	№4-Б Хүн чулуу
76	105	50	58.9	47	33	12	105.8497	47.55333	№5-Б Хүн чулуу
77	105	50	59.6	47	33	11.9	105.8499	47.55331	№6-Б Хүн чулуу
78	105	51	100	47	33	11.9	105.8778	47.55331	№7-Б Хүн чулуу
79	105	51	0.4	47	33	11.8	105.8501	47.55328	№8-Б Хүн чулуу
80	105	50	58.2	47	33	12.4	105.8495	47.55344	№С-1 Арслан
81	105	50	59.6	47	33	12.4	105.8499	47.55344	№С-2 Хүн чулуу /3 нэг дор /
82	105	50	58.6	47	33	12.6	105.8496	47.5535	№Д-1. Хонь
83	105	50	58.8	47	33	12.6	105.8497	47.5535	№Д-2. Хүн чулуу
84	105	50	58.8	47	33	12.5	105.8497	47.55347	№Д-3. Хүн чулуу
85	105	50	58.9	47	33	12.5	105.8497	47.55347	№Д-4. Хүн чулуу

86	105	50	59	47	33	12.5	105.8497	47.55347	№Д-6. Хүн чулуу
87	105	50	59	47	33	12.5	105.8497	47.55347	№Д-7. Хүн чулуу
88	105	50	59	47	33	12.5	105.8497	47.55347	№Д-8. Хүн чулуу
89	105	50	59.1	47	33	12.5	105.8498	47.55347	№Д-9. Хүн чулуу
90	105	50	59.5	47	33	12.3	105.8499	47.55342	№Д-10. Хүн чулуу
91	105	51	0.5	47	33	11.8	105.8501	47.55328	Зэл чулууны эхлэл-1
92	105	51	1	47	33	11.8	105.8503	47.55328	№5 Зэл чулуу
93	105	51	10.4	47	33	10.4	105.8529	47.55289	№41 Зэл чулуу
94	105	51	11.3	47	33	10.4	105.8531	47.55289	№45 Зэл чулуу
95	105	51	13	47	33	10.2	105.8536	47.55283	№54 Зэл чулуу
96	105	51	16	47	33	10	105.8544	47.55278	№61 Зэл чулуу
97	105	51	18.9	47	33	9.6	105.8553	47.55267	№63 Зэл чулуу
98	105	51	20	47	33	9.5	105.8556	47.55264	№65 Зэл чулуу
99	105	51	20	47	33	9.5	105.8556	47.55264	№66 Зэл чулуу
100	105	51	20.1	47	33	9.5	105.8556	47.55264	№68 Зэл чулуу
101	105	51	20.4	47	33	9.5	105.8557	47.55264	№69 Зэл чулуу
102	105	51	22.1	47	33	9.3	105.8561	47.55258	№84 Зэл чулуу
103	105	51	22	47	33	9.3	105.8561	47.55258	№88 Зэл чулуу
104	105	51	24.4	47	33	9.2	105.8568	47.55256	№97 Зэл чулуу
105	105	51	28.3	47	33	9	105.8579	47.5525	№113 Зэл чулуу
106	105	51	28.8	47	33	9	105.858	47.5525	№116 Зэл чулуу
107	105	51	38.4	47	33	9	105.8607	47.5525	№162 Зэл чулуу
108	105	51	48	47	33	9.1	105.8633	47.55253	№173 Зэл чулуу
109	105	51	54.3	47	33	8.4	105.8651	47.55233	№207 Зэл чулуу
110	105	51	55.5	47	33	8.5	105.8654	47.55236	№208 Зэл чулуу
111	105	51	55.5	47	33	8.5	105.8654	47.55236	№211 Зэл чулуу
112	105	51	55.6	47	33	8.5	105.8654	47.55236	№213 Зэл чулуу
113	105	51	57.9	47	33	8.4	105.8661	47.55233	№225 Зэл чулуу
114	105	52	0.5	47	33	8.4	105.8668	47.55233	№236 Зэл чулуу
115	105	52	6	47	33	8.3	105.8683	47.55231	№268 Зэл чулуу
116	105	52	8.1	47	33	8.3	105.8689	47.55231	№287 Зэл чулуу
117	105	52	9.9	47	33	8.1	105.8694	47.55225	№303 Зэл чулуу

118	105	52	10.8	47	33	8	105.8697	47.55222	№310 Зэл чулуу
119	105	52	17.7	47	33	7.9	105.8716	47.55219	№315 Зэл чулуу
120	105	52	13.7	47	33	7.9	105.8705	47.55219	№332 Зэл чулуу
121	105	52	15.3	47	33	7.9	105.8709	47.55219	№340 Зэл чулуу
122	105	52	16.5	47	33	8	105.8713	47.55222	№347 Зэл чулуу
123	105	52	16.5	47	33	8	105.8713	47.55222	№348 Зэл чулуу
124	105	52	20.1	47	33	7.8	105.8723	47.55217	№360 Зэл чулуу
125	105	52	20.4	47	33	7.8	105.8723	47.55217	№362 Зэл чулуу
126	105	52	20.4	47	33	7.8	105.8723	47.55217	№363 Зэл чулуу
127	105	52	20.4	47	33	7.8	105.8723	47.55217	№364 Зэл чулуу
128	105	52	21.7	47	33	7.8	105.8727	47.55217	№369 Зэл чулуу
129	105	52	23.6	47	33	7.8	105.8732	47.55217	№376 Зэл чулуу
130	105	52	23.6	47	33	7.8	105.8732	47.55217	№377 Зэл чулуу
131	105	52	24.3	47	33	7.8	105.8734	47.55217	№379 Зэл чулуу
132	105	52	24.3	47	33	7.8	105.8734	47.55217	№381 Зэл чулуу
133	105	52	26.2	47	33	7.6	105.8739	47.55211	№386 Зэл чулуу
134	105	52	29.6	47	33	7.6	105.8749	47.55211	№399 Зэл чулуу
135	105	52	31	47	33	7.6	105.8753	47.55211	№403, 404 Зэл чулуу
136	105	52	41.4	47	33	7.8	105.8782	47.55217	№454 Зэл чулуу
137	105	52	41.8	47	33	7.5	105.8783	47.55208	№456 төгсгөлийн Зэл чулуу
138	105	50	54	47	33	11.2	105.8483	47.55311	Баруун хойд - 1
139	105	51	0.6	47	33	16.2	105.8502	47.5545	Зүүн хойд - 2
140	105	52	44.6	47	33	9.7	105.8791	47.55269	Зүүн урд- 3
141	105	52	29.6	47	32	51.7	105.8749	47.54769	Баруун урд- 3

Баян-Өлгийн аймгийн Алтай сумын үл хөдлөх дурсгалын тоо

Алтай сумын түүх, соёлын үл хөдлөх дурсгал					
Буган хөшөө	Хүн чулуун хөшөө	Хадны зураг	Тахилын онгон	Булш хиргисүүр	Хөшөө чулуу
3	8	3	29	231	8
Нийт 282					

Баян-Өлгий аймгийн Алтай сумын нутаг дахь түүх, соёлын үл хөдлөх дурсгалын жагсаалт

№	Дурсгалын төрөл	Оршин буй газрын нэр	Дурсгалын тоо
1	Хиргисүүр, буган чулуун хөшөө	Шар говь	2
2	Тахилгын онгон	Шар говь	11
3	Булш	Шар говь	3

4	Булш	Шар говийн эрэг	2
5	Булш	Дунд даваат	5
6	Түрэг булш	Доод даваатын гол	6
7	Булш	Доод даваатын голын урд дэнж	20
8	Булш	Дунд даваатын ам	7
9	Булш, хиргисүүр	Дунд даваатын ам	7
10	Булш, хиргисүүр	дээд даваат	11
11	Булш	дээд даваат сагсай голын хойд эргийн дэнж	4
12	Хиргисүүр	Рашаантын голын баруун тал	1
13	Барилгын үлдэгдэл	Түргэний ам	1
14	Хүн чулуун хөшөө	Хаан ширээ	3
15	Хадны зураг	шар хад	1
16	Булш, хиргисүүр	Хаан ширээ	23
17	Булш	Түргэний голын баруун эрэг	2
18	Хиргисүүр	Түргэний голын зүүн эрэг	8
19	Хөшөө чулуу	Түргэн голын баруун эрэг	1
20	Булш	Түргэн голын баруун эрэг	5
21	Хадны зураг	Түргэн гол	1
22	Булш, хиргисүүр	Рашаантын ам	13
23	Булш	Хар өлхөн	10
24	Дамба баатрын хөшөө	Сагсай голын зүүн эрэгт	1
25	Булш, хиргисүүр	Дамба баатрын хөшөөнөөс урд 1,5 км	11
26	Хиргисүүр	Сагсай голын зүүн эрэг	1
27	Цэнгэл хэлбэрийн булш	2-р бригад	20
28	Хөшөө чулуу	Бор бургасын аманд	1
29	Цэнгэл хэлбэрийн булш	Хар чулуут	30
30	Хиргисүүр	Бор бургасны ам	1
31	Хиргисүүр	Тошингийн ам	5
32	Буган хөшөө	Тошингийн ам	1
33	Буган хөшөө	Тошингийн ам	1
34	Хүн чулуун хөшөө	Тошингийн ам-3-р баг	1
35	булш	Ихэр толгой	15
36	Булш, хиргисүүр	Ихэр толгойгоос зүүн урагш 1 км	9
37	Хиргисүүр	Чигэртэйн ам	2
38	Тахилын онгон	Чигэртэй голын баруун эрэгт	18
39	булш	Чигэртэй гол	8
40	Хүн чулуун хөшөө	Чигэртэй гол	1
41	Хүн чулуун хөшөө	Чигэртэй голын баруун эрэг буюу Х. Силам хэмээх иргэний хаваржаа	3
42	Түрэг булш	Чигэртэй гол- Голын баруун эрэг	5
43	Булш	Чигэртэй гол- Чигэртэй голын баруун хойд тал	2
44	Хөшөө чулуу	Чигэртэй голын Чулуут гармын ойролцоо	6

1.3 Дэл уул орчмын түүх, соёлын дурсгалын судалгаа, бүртгэн баримтжуулалт, хадгалалт хамгаалалтын байдлын нээлттэй хэлэлцуулэг зохиох

БСШУЯ-ний харьяа Соёлын өвийн төвийн 2015 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу, Дундговь аймгийн музей, Өлзийт сумын Засаг Даргын Тамгын Газар, МУИС. ХУС-ийн Ази судлалын тэнхимтэй хамтран “Хөшөө дурсгал, дурсгалт газрыг хамгаалах олон улсын өдөр”-ийг тохиолдуулан 2015 оны 4 дүгээр сарын 15-нд МУИС-ийн хичээлийн 1-р байрны

дугуй танхимд “Дэл уулын орчмын түүх, соёлын дурсгалын судалгаа, бүртгэн баримтжуулалт, хадгалалт хамгаалалт”-ын байдлын тухай нээлттэй хэлэлцүүлгийг зохион байгууллаа.

Тус хэлэлцүүлэгт Боловсрол, Соёл, Шинжлэх ухааны яам, Монгол Улсын Их Сургууль, Шинжлэх Ухаан Технологийн Их Сургууль, Монголын Үндэсний музей, ШУА-ийн Түүх, археологийн хүрээлэн, ЮНЕСКО-гийн Монголын Үндэсний Комисс, Хөшөө дурсгал, дурсгалт газрын Монголын үндэсний хороо, Монголын тахилгат газар нутгийн судалгаа, мэдээллийн төв, Соёл Урлагийн их сургууль, Газарчин дээд сургууль зэрэг түүх, соёлын өвийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг эрдэм шинжилгээний байгууллагууд, улсын болон хувийн хэвшлийн их, дээд сургуулиуд болон Өлзийт сумын иргэн, Дундговь аймгийн нийслэл дэх нутгийн зөвлөлийн гишүүн н. Билэгтхүү, н. Батмөнх зэрэг сумын уугуул иргэд оролцов.

Хэлэлцүүлгийн эхний хэсэгт БСШУЯ-ны Соёлын өвийн хэлтсийн мэргэжилтэн Б.Даваацэрэн “Түүх, соёлын үл хөдлөх дурсгалын талаар баримтлах төрийн бодлого”, Монголын Үндэсний музейн захирал Д.Сүхбаатар (Ph D) “Дэл уулын түүх, соёлын дурсгалыг судалсан байдал“, ШУА.Түүх, археологийн хүрээлэн эрдэм шинжилгээний ажилтан Н.Батболд (Ph D) “Дэл уулын хадны зургийн дурсгал”, МУИС. ХУС. Ази судлалын тэнхимийн багш Ц.Баттулга (Ph D) “Дэл уулын бичиг соёлын дурсгал зэрэг сэдвээр, дараагийн хэсэгт ШУТИС. БуХС-ийн багш Ю.Болдбаатар (Ph D) “Дэл уул нь түүх, соёлын эртний өвийг хадгалсан газар мөн”, Дундговь аймгийн музейн захирал М.Бямбажав “Дэл уул орчмын түүх, соёлын үл хөдлөх дурсгалын өнөөгийн байдал”, Соёлын өвийн төвийн мэргэжилтэн Г.Анхсанаа “Дэл уулын орчмын соёлын өв, цаашид авч хэрэгжүүлэх ажлын талаар”, МУИС. ХУС. Ази судлалын тэнхимийн багш Б.Аззаяа (Ph D), Н.Гэрэлмаа нар “Дэл уулын дурсгал хээрийн дадлага судалгааны цогцолбор болох нь” гэсэн сэдвээр илтгэл тавьж хэлэлцүүлэв.

Хэлэлцүүлэгт Хөшөө дурсгал, дурсгалт газрын Монголын үндэсний хорооны тэргүүн Н.Уртнасан хөшөө дурсгал, дурсгалт газрын тухай олон улсын сүүлийн үеийн хандлага, өөрийн байгууллагын үйл ажиллагааны талаар танилцуулга хийсэн бөгөөд тус хэлэлцүүлгийг цаг үеэ олсон чухал ажил болсныг тэмдэглэлээ.

Мөн Өлзийт сумын засаг дарга И.Батбилэг Дэл уул орчмын байгаль, ан амьтан, сүүлийн жилүүдэд гар аргаар алт олборлож гаргасан нүхийг олон нийтийн байгууллага болон сум орон нутгийн хөрөнгө хүчээр нөхөн сэргээсэн тухай товч мэдээлэл хийлээ.

Хэлэлцүүлгийн төгсгөлд оролцогчид Дэл уулын дурсгалт газар иж бүрэн судалгаа хийх, орон нутаг болон мэргэжлийн судалгааны байгууллагууд харилцан уялдаатай ажиллах. Дурсгалт газрын хадгалалт хамгаалалтыг сайжруулахад орон нутгийн иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, говийн бүсийн аялал чиглэлтэй уялдуулан жуулчлалын бүтээгдэхүүн бий болгох, орон нутгийн иргэд, мэргэжлийн хүмүүсийг багтаасан төрийн бус байгууллага байгуулж идэвхитэй ажиллах зэрэг олон санал гаргаж цаашид энэ тал дээр илүү анхаарч ажиллахаар болов.

Хэлэлцүүлгийг “MBN tv”, “Olloo tv”, “C1tv” зэрэг 10-аад олон нийтийн мэдээллийн хэрэгслүүд сурвалжилсан болно.

Мөн Дундговь аймгийн музей, Өлзийт сумын Засаг Даргын Тамгын Газрын санхүүжилтээр Соёлын өвийн төв, МУИС. ХУС-ийн Ази судлалын тэнхимтэй хамтран “Дэл уулын түүх, соёлын дурсгал” нэртэй товхимол хэвлүүлсэн.

1.4. Улс, аймгийн музейн БМСанч нарыг хамруулсан үүлзалт зөвлөлгөөнийг зохион байгуулах

Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам, Соёлын өвийн төв хамтран соёлын биет ба биет бус өвийн бүртгэл, мэдээллийн сан бүрдүүлэх ажлыг сайжруулах, 2015 онд зохион байгуулагдах түүх, соёлын үл хөдлөх дурсгал тооллогыг явуулахад бүртгэн баримтжуулалтын мэргэжил, арга зүйгээр хангах чиглэлээр 2 өдрийн сургалтыг 2015 оны 4 дүгээр сарын 23-24-ний өдрүүдэд Улаанбаатар хотын БСШУЯамны хурлын зааланд зохион байгуулав.

Сургалтын бэлтгэл ажлыг хангаж, хөдөө орон нутгаас оролцогчдын байр, хоолны томилолтыг шилжүүлэх, хичээлийн хөтөлбөрийг боловсруулан батлуулах, гарын авлага лекцийн материал бэлтгэн хэвлүүлж оролцогчдод тараах ажлыг зохион байгуулав. Музейн БМСанчдын ажлын тогтвор суурьшил, туршлага, боловсролын түвшин, эзэмшсэн мэргэжлийн талаар судалгааг авсан болно.

Сургалтын эхний өдөр буюу 4-р сарын 23-ны өдрийн сургалт “Соёлын өвийн бүртгэл, мэдээллийн санг чадавхжуулах” сэдвийн дор явагдлаа. Сургалтанд улс, аймгийн 40 музейн бүртгэл, мэдээллийн санч болон эрдэм шинжилгээний ажилтан 46 хүн хамрагдсан.

Сургалт нь Соёлын өвийн төвийн захирлын 2015 оны А/24 тоот тушаалын хоёрдугаар хавсралтаар батлагдсан хөтөлбөрийн дагуу үдээс өмнөх хичээл биет өвийн чиглэлээр явагдлаа. Үүнд: музейн үзмэрийн бүртгэл, мэдээллийн сан бүрдүүлэх, санд цуглагдсан соёлын өвийн бүртгэл, бүртгэл, хэрэглэгдэхүүнийг архивлан хадгалах талаар тус төвийн мэргэжилтэн Ш.Энхтуяа, музейн үзмэрийн “RCH” болон “REGISTER” бүртгэлийн програмын цаашдын хөгжүүлэлт, уялдаа холбооны талаар програмист Б.Алтансүх, “RCH” бүртгэлийн бүрдүүлэлтийн байдлын талаар хэлтсийн дарга Д.Нарантуяа нар тус тус хичээл заалаа.

Үдээс хойшхи соёлын биет бус өвийг бүртгэн баримтжуулах, Монгол Улсын нэгдэн орсон олон улсын конвециуд, соёлын өвийг Дэлхийн өвд бүртгүүлэхийн ач холбогдлын талаар Биет бус соёлын өвийн хэлтсийн мэргэжилтэн Ж.Насанжаргал, А.Саруул нар заалаа.

Хичээлийн явцад музейн ажилтнуудын асуултанд хариулах, БМСанд тулгамдаад байгаа асуудлаар хэлэлцүүлэг хийлээ. Сургалтын үеэр энэхүү сургалтын зохион байгуулалтын талаарх болон цаашид ямар агуулга, сэдвийн хүрээнд сургалт авах хүсэлтэй байгаа талаар мөн санал асуулга авсан. Бүртгэл, мэдээллийн санч нарыг мэргэшүүлэх сургалтанд Байгалийн түүхийн музей, Уран зургийн галерейн Бүртгэл, мэдээллийн санч нар суугаагүй, хариуцлагагүй хандлаа.

Хэлэлцүүлгийн явцад музейнхнээс тавьсан саналыг нэгтгэн дүгнэвэл:

- Аймгийн музейн дэргэд аймгийн БМСан ажиллах болсоноор музейн үзмэрээс гадна, үл хөдлөх дурсгал, соёлын биет бус өвийг хариуцаж музейн БМСанчийн ажлын ачаалал эрс нэмэгдсэн. Хүн хүчний асуудал дутагдалтай байна.
- Сумын соёлын төв соёлын өвийг хариуцсан ажилтан байхгүй байна. Эдгээр асуудлыг шийдвэрлэх шаардлагатай байгааг хөдөө орон нутгаас оролцогчид санал нэгтэй хэлж байв.
- Шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангах шаардлагатай байна.
- Аймгийн музейн БМСанч нар “Аймгийнхаа БМСан”-г хариуцан ажиллаж байгаа боловч давхар ажлын урамшуулал, хөлс байхгүй. Байсныг хууль бус гээд өгөхөө больсон /Сүхбаатар аймаг/ энэ асуудлыг шийдвэрлэх шаардлагатай байна.
- “REGISTER” бүртгэлийн програм музейн бүртгэл тооллогод их ач тустай програм болсон. Хайлтыг нарийвчлалтай болгомоор байна.
- “REGISTER” бүртгэлийн програм дээр үзмэрийн гэрэл зураг бага хэмжээтэй орсноор дүрс муу харагддаг. Гэрэл зураг оруулдаг хэмжээг томсгох, сайжруулах шаардлагатай байна.

2015.04.24-ны буюу хоёрдахь өдрийн сургалт “Түүх, соёлын үл хөдлөх дурсгалын үзлэг, тооллого” сэдвийн дор явагдлаа. Энэ өдрийн сургалтанд аймаг, орон нутгийн музейн БМСанч, Эрдэм шинжилгээний ажилтан, 21 аймгийн Боловсрол, соёлын газрын мэргэжилтэнгүүд нийт 68 хүн сургалтанд хамрагдав.

2014 онд Соёлын өвийг хамгаалах тухай хууль шинэчлэгдэн батлагдаж, уг хуульд түүх, соёлын үл хөдлөх дурсгалын улсын тооллогыг явуулах тухай заалт нэмэгдэн орсонтой холбогдуулан 2015 онд улсын хэмжээнд анх удаа үл хөдлөх дурсгалын тооллого хийгдэх гэж

байна. Үүнтэй холбогдуулан аймаг орон нутгийн холбогдох мэргэжилтэнгүүдийг мэргэжил, арга зүйн заавар зөвлөмжөөр хангав.

Сургалтаар “Чулуун зэвсгийн дурсгалт газар, Үйлдвэрлэлийн ул мөр хадгалсан дурсгалт газар”, “Хадны зураг”, “Бичгийн дурсгал”, “Булш оршуулгын дурсгал”, “Тахил тайлгын байгууламж”, “Барилга, архитектурын байгууламж”, “Хөшөө дурсгал”, “Палеонтологийн дурсгалт газар” зэрэг үл хөдлөх дурсгалыг төрөл зүйлийн ангиллаар бүртгэхэд мэргэжил, арга зүйн заавар зөвлөмжийг ШУА-ийн Түүх, археологийн хүрээлэн, Палеонтологи геологийн хүрээлэн, Шинжлэх ухаан технологийн их сургууль, Монголын Үндэсний музей зэрэг холбогдох мэргэжлийн байгууллагуудын эрдэмтэн, судлаачид хичээлийг заалаа.

Үл хөдлөх дурсгалын бүртгэл судалгааны арга зүй, дурсгал оршиж буй газрын солбицол тогтоох GPS багаж ашиглах, тооллогын үеэр зөөврийн PC дээр ажиллах, дурсгалын гэрэл зураг авах, бүртгэлийг програм хангамжид оруулах хөтлөх талаарх хичээлүүдийг хэлтсийн мэргэжилтэн Г.Анхсанаа, Т.Эрдэнэцогт, Ж.Даваацэрэн, Б.Алтансүх нар тус тус заасан.

Сургалтанд оролцогчдын үзлэг тооллоготой холбогдсон асуултад хариулан БСШУЯамны Соёлын өвийн хэлтсийн үл хөдлөх дурсгал хариуцсан мэргэжилтэн Б.Даваацэрэн, Соёлын өвийн төвийн захирал Г.Энхбат нар хээрийн судалгааны үед багийн гишүүдийн ажиллах зарчим, оролцооны талаар дэлгэрэнгүй заавар зөвлөмжийг өгөв.

Заасан хичээлүүдийг гарын авлага болгон хэвлэн тараасан ба Соёлын өвийн төвийн www.monheritage.mn сайтад тусгай булан нээж видео хичээл хэлбэрээр болон татах хэвлэж авах байдлаар байршуулсан.

Үл хөдлөх дурсгалын үзлэг тооллогын 345 минутын дараах видео хичээлүүдийг youtube сайт дээр Соёлын өвийн төв гэсэн суваг нээж */https://www.youtube.com/playlist?list=PLieGWGaxzgUkNgkeYBM8tAhXBt9h6SxAn/* байршуулав.

Түүх, соёлын үл хөдлөх дурсгалын үзлэг, тооллогын видео хичээлүүд

№	Хичээлийн нэр	Үргэлжлэх хугацаа
1	Чулуун зэвсгийн дурсгалт газар, Үйлдвэрлэлийн ул мөр хадгалсан дурсгалт газар	37 минут
2	Хадны зураг, бичээсийн дурсгал	32 минут
3	Булш оршуулгын дурсгал	23 минут
4	Түрэг, Уйгурын үеийн тайлгын байгууламжууд	20 минут
5	Архитектурын дурсгал	33 минут
6	Нүүдэлчдийн хот суурины дурсгалт газар	22 минут
7	Монгол нутаг дахь хөшөө дурсгал	28 минут
8	Түүх, соёлын үл хөдлөх дурсгалын бүрдэл, тэдгээрийг тодорхойлох	25 минут
9	Палентологийн олдворт газрууд	25 минут
10	Түүх, соёлын үл хөдлөх дурсгалыг хэмжих, хамрах хүрээ тогтоох тухай	14 минут
11	Тоног төхөөрөмж ашиглах тухай	17 минут
12	Үл хөдлөх дурсгалын гэрэл зураг авах тухай	48 минут
13	Хээрийн судалгаа хийх зарчим, багийн гишүүдийн оролцоо	21 минут
	Нийт	**345 минут**

1.5. Монгол нутаг дахь сүм хийд, дурсгалт уран барилгын 3D хэмжилт, бүртгэн баримтжуулалтын Архангай аймагт

Тус Соёлын өвийн төв болон Бүгд Найрамдах Солонгос Улсын Соёлын өвийн судалгааны үндэсний хүрээлэн хооронд байгуулсан “Монгол нутаг дахь түүх, соёлын үл хөдлөх дурсгал болох барилга архитектурын дурсгалыг 3D цахим хэлбэрээр баримтжуулах, техникийн зураг боловсруулах, мэргэжилтэн бэлтгэх” харилцан ойлголцлын санамж бичгийн дагуу Архангай аймгийн Өлзийт сумын нутаг дахь Өөлд бэйсийн хүрээний Цогчин дугана, Жүдийн дацанг 3D цахим хэлбэрээр баримтжуулах ажлыг 2015 оны 6 дугаар сарын 9-17-ны хооронд

гүйцэтгэлээ.

Энэ жилийн ажил төвлөрөн хийгдсэн Өөлд бэйсийн хүрээ нь анх 1797 онд суурь нь тавигдаж, одоо байгаа газартаа 1843 онд байгуулагдсан 200 гаруй жилийн түүхтэй хүрээ хийд юм. XX зууны эхэн үеэр тус хүрээ нь 13 дуганатай, 3 жастай, сүм дугана нь Түвд, Монгол хосолсон хэв загвараар баригдсан 200 гаруй ламтай хүрээ байсан тухай архивын мэдээ баримт байдаг.

Гэвч 1937 оны эхээр энэ хүрээнээс 50 гаруй лам хувраг баривчлагдан бусад лам нарыг нь хүчээр хар болгон тарааснаас хүрээ хийд эзгүйрч хаагджээ. 1940-1990-ээд оныг хүртэл давхар оройтой Цогчин дуганад сумын ХБА-ийн түүхий эдийн агуулах, Жүдийн дуганад хүнсний скалад, цамын байшинд дэлгүүр, өлөнгийн цех, Маналын дуганад сүү тосны завод байрлан үйл ажиллагаа явуулдаг байсан бөгөөд ихэнх хүрээ хийдийг бодвол Өөлд бэйсийн хүрээний сүм дугана үндсэндээ саяхныг болтол бүгд бүрэн бүтнээрээ байжээ. Үүнийг ч нутгийн иргэд батлан хэлж байлаа.

Түүнчлэн 1990-ээд оны эхнээс улс орон даяар үндэсний ухамсар сэргэж, түүх, соёлын өвд анхаарч эхэлсэн үеэс Өөлд бэйсийн хүрээний үлдсэн сүм дуганаыг сэргээн засварлах түүх, угсаатны зүй буддын соёл судлаачдын болон энгийн сонирхогчид, сүсэгтэн олны эргэл мөргөлийн газар болгох санаачлага гарч эхэлжээ[1].

Энэ үүднээс тус сумын төр захиргаа олон нийтийн байгууллагууд сүсэгтэн олон идэвхтэй үйл ажиллагаа явуулж Монгол улсын ерөнхийлөгч асан Н. Багабанди, Н.Энхбаяр нарт тус бүр хүсэлт гаргаж байсан ба Соёлын өв сангийн захирал н.Бямбажавыг нутагтаа урьж ирүүлэн Өөлд бэйсийн хүрээний үлдсэн барилга байгууламжуудтай танилцуулан бүр Улаанбаатар хотын Цагаан сүлд компанийн мэргэжилтнүүдийг газар дээр нь ажиллуулж уг хүрээний байшин барилгыг сэргээн засварлахад 320 орчим сая төгрөг шаардлагатай гэсэн төсөв тооцоог хүртэл гаргуулсан гэдэг. Гэвч эдгээр үйл ажиллагаа өдийг хүртэл бодит ажил хэрэг болоогүй цагийн шуургыг давж үлдсэн цөөн дугана улам бүр эвдэрч муудсаар байна.

Орон нутгийн удирдлагуудтай дурсгалын хадгалалт хамгаалалтын талаар санал солилцож байгаа нь

Энэ бүх шалтгааныг харгалзан бид Өөлд бэйсийн хүрээний дуганууудыг 3D цахим хэлбэрээр баримтжуулах, техникийн зураг боловсруулах, мэргэжилтэн бэлтгэх сургалтыг зохион байгуулсан болно.

Дурсгалт газарт Соёлын өвийн төвөөс програмист Б.Алтансүх, техникийн ажилтан П.Чинбат, мэргэжилтэн Д.Эрдэнэцогт, Г.Анхсанаа нар БНСУ-ын Соёлын өвийн судалгааны үндэсний хүрээлэнгээс ЭША Kang-Hyun, судлаач Park Sung-Ho, Kim Ki-Ho, Han Ja-Yeon нар оролцов.

3D скан хийхийн өмнөх бэлтгэл ажил

Бэлтгэл ажлын хүрээнд Цогчин дугана дотор хураалттай байсан ноосыг зөөж цэвэрлэх ажлыг орон нутгийн удирдлагууд зохион байгуулсан. Судалгааны багийн гишүүд Өөлд бэйсийн хүрээний хадгалалт хамгаалалтын байдалтай биечлэн танилцаж Цогчин дугана дотор хуримтлагдсан малын өтөг бууцыг өнгөц цэвэрлэж судалгааны зорилгоор зарим хэсгийн нягтаршсан өтөг бууцыг шал хүртэл нь хусч цэвэрлэв.

Судалгааны тоног төхөөрөмж

• Leica ScanStation C10

Томоохон хэмжээний дурсгалыг сканнердах зориулалттай холын зайн өндөр нягтрал бүхий суурин 3D лазер сканнер.

[1]Соёлын өвийн өвийн төвийн УНБМСанд Өлзийт сумын уугуул тухайн үеийн Политехникийн дээд сургуулийн тэнхимийн багш Х. Пүрэвдагвагийн бичсэн “Түүхийн дурсгалт зүйлээ хайрлан хамгаалъя” хүсэлт бий.

• Mantis Vision 3D scanner

Өндөр нарийвчлалтай зөөврийн 3D лазер сканнер.

• Konica Minolta VIVID 9i 3D scanner

Жижиг болон дунд хэмжээний объектыг сканнердах зориулалттай өндөр нягтрал бүхий суурин 3D лазер сканнер.

3D скан хийх ажил

Leica ScanStation C10 сканнераар Цогчин дугана болон Жүдийн дацанг гадна, дотор талаас нийт 25 цэгээс скан хийж баримтжуулсан бол Mantis Vision 3D сканнераар Цогчин дуганы дотор талын зарим хэсгийг скан хийсэн. Жүдийн дацангийн дээврийн хэсгийн нарийн чимэглэлийг шөнийн цагаар ажиллаж VIVID 9i сканнераар баримтжуулсан.

Leica ScanStation C10 сканнераар 3D скан хийж байгаа нь

VIVID 9i сканнераар 3D скан хийж байгаа нь

Уг хамтарсан төсөл нь Монгол Улсын нутаг дэвсгэр дээрх түүх, соёлын үл хөдлөх дурсгал болох уран барилгын дурсгалын хэмжилтийн ажлыг мэргэжлийн түвшинд хийж компьютерын технологи ашиглан, техникийн зураг боловсруулан соёлын өвийн мэдээллийн сан бүрдүүлэх, мэргэжилтэн бэлтгэхэд зэрэг зорилготой.

Ажлын үр дүнд Өөлд бэйсийн хүрээний Жүдийн дацангийн 3-н хэмжээст орон зай дахь 34072432 ширхэг цэг, 502 MB, Цогчин дуганы 3-н хэмжээст орон зай дахь 37 844 774 ширхэг цэг, 697 MB хэмжээгээр тэмдэглэн бий болгосон цахим мэдээлэл цаашид энэ хийдийг сэргээн засварлах, хадгалж хамгаалах ажлын хэрэглэгдэхүүн болох юм. Өөлд бэйсийн хүрээний 3-н хэмжээст баримтжуулалт нь Монгол оронд буй бусад нурж устах аюулд орсон эртний хот суурин, сүм хийдийг цахим архив үүсгэн хадгалах, хамгаалах ажлын эхлэл болно.

Өөлд бэйсийн хүрээний 3D мэдээлэл

№	Барилга, байгууламж	Bounding box size	3-н хэмжээст орон зай дахь цэгийн тоо	Файлын төрөл	Файлын хэмжээ
1	Жүдийн дацан	Width: 32999.4883 mm Height: 6563.0891 mm Depth: 28485.3994 mm	34 072 432 ширхэг	XRL	502 MB
2	Цогчин дугана	Width: 19339.9521 mm Height: 6917.5688 mm Depth: 45992.0625 mm	37 844 774 ширхэг	XRL	697 MB

3D цэгэн үүл мэдээллийн ерөнхий харагдах байдал /Өөлд бэйсийн хүрээ/



Өөлд бэйсийн хүрээний Цогчин дуганы хөндлөн огтлолын зураг



Өөлд бэйсийн хүрээний Жүдийн дацангийн суурийн проекц



Өөлд бэйсийн хүрээний Жүдийн дацангийн тулгуур баганын зохион байгуулалтыг харуулсан зураг



1.6. Өндөр гэгээн Занабазарын мутрын хийц бүхий цутгуур бурхад, түүх, соёлын хосгүй үнэт дурсгалыг баталгаажуулсан дүрс бичлэгийн сан бүрдүүлэх

Түүх соёлын хосгүй үнэт бүтээлүүдийг дүрс бичлэгээр баримтжуулж мэдээллийн сан бүрдүүлэхэд Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 20.8; 21.2.7 дахь заалт, БСШУЯамны 2015 оны 7/302 тоот албан бичгийг үндэслэн Занабазарын мутрын бүтээлүүдийг хамруулахаар төлөвлөв.

Богд хааны ордон музей, Дүрслэх урлагийн музей дэх түүх, соёлын хосгүй үнэт зэрэглэлд батлагдсан Занабазарын бүтээлүүдийг дүрс бичлэгээр баримтжуулах ажлыг тухайн музейнүүдтэй гэрээ байгуулж, хамтран ажлын төлөвлөгөө боловсруулан хийж эхлээд байна.

Богд хааны ордон музейн Ногоон дара эх болон дара эхийн /21 ш/ дүрс бичлэгийг 2015 оны 12-р сарын 3-нд, Дүрслэх урлагийн музейн Язгуурын бурхад, Цагаан дара эх, Бодь суварга зэрэг Занабазарын мутрын бүтээлүүд /7 ш/-ийн дүрс бичлэгийг 2015 оны 12 дугаар сарын 9-ны өдөр тус тус хийхээр төлөвлөсөн.

№	Музейн нэр	Дүрс бичлэг хийх бүтээлүүд	Тоо/ш	Бичлэг хийх хугацаа
	Богд хааны ордон музей	1. Ногоон дарь эх 2. Дарь эх /Сэрдогжамаа/ 3. Дарь эх /Жүгдэрнамжилмаа/ 4. Дарь эх /Дүгсэлжэдмаа/ 5. Дарь эх /Гончигсүмцомбаа/ 6. Дарь эх /Пэрэнлэйдүлжид/ 7. Дарь эх /Жигдэнсумёови/ 8. Дарь эх /Жигдэнвандулма/ 9. Дарь эх /Нурвабамуу, Магсармаабамуу/ 10. Дарь эх /Жигдэнсумжал/ 11. Дарь эх /Чогдэрмаа/ 12. Дарь эх /Донжидмаа/ 13. Дарь эх /Хумдаадулам/ 14. Дарь эх /Шинжитүгжамба/	21 ш	2015. XII.03

		15. Дарь эх /Пунсалдулам/ 16. Дарь эх /Мидирварви/ 17. Дарь эх 18. Дарь эх /Тониржамаа/ 19. Дарь эх /Одсэржамаа//Жанрайсэг/ 20. Дарь эх /Дуламсэлвий/ 21. Дарь эх /Рэгнадсэлви/ 22. 490 минутын дүрс бичлэг		
2	Г.Занабазарын нэрэмжит Дүрслэх урлагийн музей	1. Маш гийгүүлэн зохиогч 2. Цаглашгүй гэрэлт 3. Үйл бүтээгч 4. Үл хөдлөгч 5. Бодь суварга 6. Цагаан дара эх 7. Аюуш /Унгараас ирсэн/		2015. XII.09-10

Занабазарын хосгүй үнэт дурсгалуудын дүрс бичлэгийг хийхдээ зөвхөн уг бүтээлүүдийн дүрсийг аваад зогсохгүй эрдэмтэн судлаачдыг урьж оролцуулан тэдний судалгааны дүн яриаг бичиж баримтжуулах юм. Бурханч лам Г.Пүрэвбат, урлаг судлаач Д.Энхдаваа, Ч.Болдбаатар, Гандан хийдийн лам Н.Амгалан, музейн эрдэм шинжилгээний ажилтнууд зэрэг судлаач, эрдэмтдийг оролцуулан тэдний судалгааны дүн яриаг баримтжуулан нийтдээ 490 минутын дүрс бичлэг хийгдэнэ.

Занабазар судлалын чиглэлээр судалгаа хийдэг эрдэмтэн судлаачдын яриаг дүрс бичлэгт буулган бичлэгийн эх хувийг тухайн музейн БМСанд, хувилсан хувийг Соёлын өвийн УНБМСанд хадгалах юм.

<u>1.7.“Түүх, соёлын үл хөдлөх дурсгалын үзлэг тооллого -2015” арга зүйгээр хангах, дүн мэдээг хүлээн авах нэгтгэх</u>

Тус хэлтсийн мэргэжилтэнгүүд Г.Анхсанаа, Т.Эрдэнэцогт, Ж.Даваацэрэн, Б.Алтансүх нар нь Үл хөдлөх дурсгалын үзлэг тооллогын ажлын явцад аймгуудыг мэргэжил арга зүйгээр хангах, үзлэгт, тооллогын тайланг хүлээн авах заавар зөвлөгөөг боловсруулах, БСШУЯаманд үзлэгт, тооллогын явцын талаар 2015 оны 9 ба 10 дугаар сарын байдлаар тайлан мэдээг гаргах зэргээр ажилласан.

Түүх, соёлын үл хөдлөх дурсгалын үзлэг тооллогод Улаанбаатар хотын 9 дүүрэг, 21 аймгийн 292 сумын нутаг дэвсгэр дэх 8950 дурсгалт газар хамрагдаж 77458 үл хөдлөх дурсгал тоологджээ.

Тоологдсон 77458 үл хөдлөх дурсгалаас 63474 дурсгалыг “RICH” программд оруулсан нь цахим хэлбэрт оруулах ажил 81.94 %-ийн гүйцэтгэлтэй байна.

Улсын хэмжээнд дараах 10 аймгийн 38 сум энэхүү үзлэг тооллогод хамрагдаагүй байна. Увс-11 сум, Архангай-9 сум, Ховд-7 сум, Говь-Алтай-4 сум, Сэлэнгэ-3 сум, Хөвсгөл-2 сум, Дорноговь, Өвөрхангай, Өмнөговь, Хэнтий тус бүр 1 суманд үзлэг тооллого хийгдээгүй байна.

СӨУНБМСанд 2015 оны 11 дүгээр сарын 30-ны байдлаар аймгуудаас үл хөдлөх дурсгалын тайлан мэдээг цахим болон цаасан хэлбэрээр хүлээн авах ажил хийгдэж байгаа ба 2015 оны 12 дугаар сарын 25-нд нэгдсэн тайланг БСШУЯаманд хүлээлгэн өгөхөөр ажиллаж байна.

ТҮҮХ, СОЁЛЫН ҮЛ ХӨДЛӨХ ДУРСГАЛЫН ҮЗЛЭГ ТООЛЛОГЫН ДҮН

/2015 оны 11-р сарын 30-ны байдлаар/

№	Аймгийн нэрс	Нийт сумын тоо	Үзлэг тооллого явагдсан сум	Дурсгалт газар	Нийт тоолсон үл хөдлөх дурсгал	RICH програмд оруулсан дурсгалын тоо
	Архангай	19	10	694	4497	4497
	Баян-Өлгий	13	13	445	4800	2500
	Баянхонгор	20	20	337	7548	6531
	Булган	16	16	559	2528	2528
	Говь-Алтай	18	14	1135	5629	5629
	Говьсүмбэр	3	3	55	306	306
	Дархан-Уул	4	4	69	362	362
	Дорноговь	14	13	431	2544	2544
	Дорнод	14	14	272	2287	317
	Дундговь	15	15	306	1551	1551
	Завхан	24	24	725	8932	8932
	Орхон	2	2	28	354	354
	Өвөрхангай	19	18	388	5310	1533
	Өмнөговь	15	14	212	2318	2200
	Сүхбаатар	13	13	229	1401	655
	Сэлэнгэ	17	14	174	3003	1520
	Төв	27	27	389	4669	3240
	Увс	19	8	227	566	
	Ховд	17	10	450	2481	4600
	Хөвсгөл	24	22	597	8021	5502
	Хэнтий	17	18	1165	8132	8132
	Улаанбаатар	9	9	63	219	41
		339	**301**	**8950**	**77458**	**63474**

4. ДОТООД АЖИЛ, ҮЙЛЧИЛГЭЭ

4.2. Гандантэгчинлэн хийдийн улсын тооллогоны материал хэрэглэгдэхүүнийг УНБМСанд төвлөрүүлэх татаж авах, сан үүсгэх

ССАЖЯам /хуучин нэрээр/, Гандантэгчэнлин хийдтэй зөвшилцсөний үндсэн дээр ССАЖ-ын сайдын 2013 оны А/117 тоот тушаалын дагуу ССАЖЯам, Гандантэгчэнлин хийдийн захиргаа, Соёлын өвийн төв, Үлэг гүрвэлийн төв музей, Байгалийн түүхийн музейгээс томилогдсон улсын тооллогын комисс Гандантэгчэнлийн хийдийн бурхан шүтээн, эд өлгийн зүйлсийн улсын тооллогыг 2013 оны 4 дүгээр сарын 16-наас эхлэн 2014 оны 12 дугаар сарын 01-нийг дуустал нэг жил, долоон сарын хугацаанд хийж гүйцэтгэлээ.

2013-2014 оны улсын тооллогод 1987 оны улсын тооллогын бүртгэлийн дэвтрийг баримтлан тоолж бүртгэлээ. 1987 оны улсын тооллогоор 1847320.00 төгрөгийг үнэ бүхий 4970 дэсийн 21193 бурхан шүтээн, эд өлгийн зүйлс тоологдсон байна.

1987 оны тоон дүнгээс нэг дахин их хэмжээний бурхан шүтээн, эд өлгийн зүйлс тоологдсон шалтгаанаар улсын тооллого 7 сараар сунгагдсан.

Гандантэгчэнлин хийдийн улсын тооллогоор нэр бүхий 21 дуган дацан, бусад газруудад хадгалагдаж байгаа бурхан шүтээн, эд өлгийн зүйлсийг тоолж бүртгэлээ

Гандантэгчэнлин хийдийн 2013-2014 оны улсын тооллогоор нийт 8333 дэсийн 46064 ширхэг бурхан шүтээн, эд өлгийн зүйлийн тоолж бүртгэлээ.

1987 оны тооллогын дүн	1987 оны бүртгэлд тусгагдаагүйг 2013-2014 онд нэмж тоолж бүртгэсэн	2013-2014 оны улсын тооллогоор нийт тоологдсон
5011 дэсийн 23265 ширхэг бурхан, шүтээн, эд өлгийн зүйл	3322 дэсийн 22799 ширхэг бурхан шүтээн, эд өлгийн зүйл	8333 дэсийн 46064 ширхэг бурхан шүтээн, эд өлгийн зүйл

- 1987 оны улсын тооллогоор бүртгэгдсэн 5011 дэсийн 23265 бурхан, шүтээн эд өлгийн зүйлийн бүртгэл тоологдсон.

- 1987 оны улсын тооллогын бүртгэлд тусгагдаагүй байсан 3322 дэсийн 22799 бурхан шүтээн, эд өлгийн зүйлийг нэмж шинээр тоолж бүртгэлээ.

Нийт тоологдсон бурхан шүтээн, эд өлгийн зүйлийг төрөл зүйлийг хүснэгтээр харуубал:

Танка зураг	Баримал, шуумал	Цутгамал	Хөөмөл	Сийлбэр	Оёмол урлал	Тахилын холбогдолтой	Түүхэн бие хүний холбогдолтой	Бусад
1	2	3	4	5	6	7	8	9
2763 дэсийн 21403 ширхэг	1669 дэсийн 14919 ширхэг	1513 дэсийн 2695 ширхэг	930 дэсийн 2613 ширхэг	325 дэсийн 446 ширхэг	127 дэсийн 200 ширхэг	479 дэсийн 2416 ширхэг	84 дэсийн 130 ширхэг	442 дэсийн 1242 ширхэг

Нийт тоологдсон бурхан шүтээн, эд өлгийн зүйлийг төрөл зүйлийн эзлэх хувийг графикаар харуулбал:



Тоологдсон бурхан шүтээн, эд өлгийн зүйлийн гэрэл зургийг нэгбүрчлэн 3-4 талаас мэргэжлийн түвшинд авч, гэрэл зургаар баримтжуулан бүртгэлээ. Улсын тооллогоор тоологдсон 8333 дэсийн 46064 бурхан шүтээн, эд өлгийн зүйлийн нийт 60536 кадр бүхий гэрэл зургийг авч компьютерт оруулан хадгалсан болно.

Дурсгалын гэрэл зургийг авахдаа дэргэд нь "Хэмжилтийн шугам", "Өнгөний масштаб", "Шинээр өгсөн дугаар"-ыг тавьж авлаа. Ингэснээр ижил төрлийн дурсгалыг өөр хооронд ялган таних гэрэл зургийн баримтжуулалт болох юм.

Энэхүү тооллогоор тус хийдийн бурхан шүтээн, эд өлгийн зүйлсийг гэрэл зургаар бүртгэн баримтжуулах ажил анх удаа хийгдэж байгаагаараа онцлог бөгөөд тус хийдийн бурхан шүтээн, дурсгалуудын гэрэл зургийн иж бүрэн мэдээллийн сан бүрдэж байгаа юм.

Бурхан шүтээн, эд өлгийн зүйлийн гэрэл зургийг мэргэжлийн төвшинд, өндөр нягтаршилтайгаар авсан ба нэг бүрчлэн дугаарлан тусгай 8333 фолдертэй 60536 кадр гэрэл зургийг тусгай файл үүсгэн компьютерт хадгалсан.

2013-2014 оны улсын тооллогоор "Монголын Бурханы Шашинтны Төв Гандантэгчэнлин хийдийн бурхан шүтээн, эд өлгийн зүйлийн бүртгэл"-ийн 17 ширхэг дэвтэрт бурхан шүтээн, эд өлгийн зүйлийн бүртгэлийг шинэчлэн, гараар бичиж хөтөлсөн.

Соёлын өвийн төвөөс Гандантэгчэнлин хийдийн бүртгэл, мэдээллийн санг бүрдүүлэх ажлын үндэс суурийг тавихад бүртгэн баримтжуулалтын арга зүйгээр туслан, "Гандантэгчэнлин хийдийн бурхан шүтээн, эд өлгийн зүйлийн бүртгэл буюу Gandan Data" цахим бүртгэлийн програмыг боловсруулан зохиож, тус хийдэд суурилуулсан.

Тооллогын ажлын үеэр гар бичмэл бүртгэл, авсан гэрэл зургаа нэг бүрчлэн цахим бүртгэлийн програмд оруулах ажил давхар хийгдсэн.

Цахим бүртгэл нь тухайн "дурсгалын нэр", "шинэ ба хуучин дугаар" "дуган, дацангийн байршил", "төрөл зүйл", "Занабазарын ур хийц", "Занабазарын сургууль хийц", "нандин шүтээн", "2013-2014 оны тооллогоор шинээр бүртгэсэн" зэрэг үзүүлэлтүүдээр хайлт хийх, хэвлэх боломжтой юм.

Цахим бүртгэлд оруулснаар тус хийдийн бүртгэл, мэдээлэлд шинэ технологи нэвтрүүлж, бурхан шүтээн, эд өлгийн зүйлийн бүртгэл, гэрэл зургийн иж бүрэн мэдээллийн сантай боллоо.

Тус хийдийн улсын тооллогын дүн мэдээг 2015 оны 3-р сард Гандантэгчэнлин хийдийн захиргаанд, 2015 оны 4-р сард БСШУЯаманд 2015 оны 5-р сард Засгийн газрын хуралдаанд танилцуулсан.

Улсын тооллогоор үйлдсэн гар бичмэл 17 дэвтрийн эх хувь, уг бүртгэлээ цахимд шивж оруулсан "Gandan Data" програм хангамж, 8333 фолдертэй 60536 кадр гэрэл зургийг тусгай цахим файл сан, тооллогын тайлан зэргийг Гандантэгчинлин хийдийн захиргаанд хүлээлгэн өгч, дээрх бүртгэлүүд, тайлан мэдээ тус бүрийн хувилсан1хувийг УНБМСанд хүлээн авч, Гандантэгчэнлин хийдийн мэдээллийн санг бүрдүүлээд байна.

<u>4.3. Улс, аймгийн музейн 2012-2014 оны улсын тооллогоны материал хэрэглэгдэхүүнийг УНБМСанд төвлөрүүлэн цэгцлэх, сан үүсгэх</u>

Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2012 оны 02 дугаар сарын 17-ны өдрийн 74 дүгээр тушаал, удирдамжийн дагуу 2012 оны 08 дугаар сарын 15-ны өдөр улс, аймгийн музейнүүдэд улсын тооллогыг зэрэг эхлүүлж, 2013 оны11 дүгээр сард аймгийн музейн тооллого, 12 дугаар сард Монголын үндэсний музейгээс бусад улсын музейн тооллого дууссан. Монголын үндэсний музейн тооллого 2015 оны 04 дүгээр сарын 01-нд эцэслэн дууслаа.

Монголын үндэсний музейн тооллого удаан үргэлжилсэн нь үзмэрийн тоо их, бүртгэлийн ажилд хуримтлагдсан асуудлыг нэг мөр цэгцлэх шаардлагатай байсантай холбоотой.

Улсын тооллогын ажлыг Тооллогын Төв комисс зохион байгуулсан ба тооллогыг газар дээр нь Соёл урлагийн хорооны даргын тушаал, аймгийн Засаг даргын захирамжаар салбар комисс байгуулагдан нийт 40 музейн 376 салбар комиссын гишүүд томилогдон ажилласан байна.

Тооллогын бэлтгэл ажилд зориулан улсын төсвөөс 189520100 төгрөгийг зарцуулан тооллогын програм хангамж зохион, програмыг музейн комьпютерт суулгах, сургалт, семинар

зохион байгуулж, гарын авлага хэвлүүлж тараах, жин хэмжүүрийн багаж, зөөврийн хэрэгсэл, тооллогын Ерөнхий бүртгэлийн дэвтэр зэрэг тооллого явуулахад шаардлагатай материал хэрэгслээр тооллогод хамрагдах музей болон орон нутаг судлах танхимыг нэгдсэн журмаар хангаж, бусад хэрэгцээнд зориулан аймгийн 23 музейд 20 415 000 төгрөг, улсын 12 музейд нийт 12 727 700 төгрөг, тооллогод хамрагдсан сүм хийд, байгууллагын харьяа зэрэг 9 байгууллагад 7 843 500 төгрөг нийтдээ 40986200 төгрөгийг олгосон байна.

2012-2013 оны музейн сан хөмрөгийн улсын тооллогод улсын 9, байгууллагын 7, аймгийн 23, хувийн өмчлөлийн 1 музей, сүм хийд 2 нийт 42 байгууллага хамрагдлаа.

Энэ нь өмнөх тооллогоос 6 байгууллагаар илүү байгаа нь 2011 онд байгуулагдсан Хархорум, Хөшөө цайдам, Төрийн түүхийн музейгээс гадна анх удаа Монгол банкны Эрдэнэсийн сан, Шанхын баруун хүрээ хийд, Төвхөн хийдэд хадгалагдаж байгаа түүх, соёлын дурсгалт зүйлсийг хамруулсантай холбоотой юм. Мөн өмнөх тооллогоор бүрэн хамрагдаж чадаагүй 20 аймгийн 257 Орон нутаг судлах танхимыг /дүүргийн 1 музей/ хамруулав.

Тооллогоор хийгдсэн ажил

- “Музейн үзмэр, эд өлгийн зүйлийн ерөнхий бүртгэл”/ББЗМаягт 10/-ийг үндэслэн Register цахим бүртгэлийн програм хангамж зохион тооллогод хамрагдсан 42 байгууллагад суурилуулж мэдээллийг Соёлын өвийн улсын нэгдсэн бүртгэл-мэдээллийн сан дээр нэгтгэлээ. Бүртгэлийг цахим хэлбэрт оруулснаар үзмэрийн хувийн дугаарын давхардал, тооллогын гар бичмэл бүртгэлд байсан механик алдаануудыг илрүүлж залруулах, хамгийн гол үр дүн нь үзмэрийн дэс, ширхэг, иж бүрдлийн бүрэлдэхүүн хэсгийн тоо гэсэн гурван хэлбэрээр нарийвчлалтай гаргасан. Ийнхүү анх удаа бүртгэлийг цахим хэлбэрт шилжүүлсэн нь музейн бүртгэл, мэдээллийн ажилд томоохон дэвшил боллоо.

- Тооллогоор урлаг, уран сайхан, түүх, угсаатны зүй, шашны холбогдолтой үзмэр, археологийн олдвор эд өлөг, байгалийн үзмэр гэсэн 6 төрөл зүйлээр ангилан гаргахад гэрэл зураг, баримт бичгийн тоо нийт үзмэрийн 17.6%-ийг эзэлж байгаа дүн гарсан нь цаашдаа музейн үзмэрийн чанар байдал, иж бүрдүүлэлтэд анхаарах шаардлагатайг харуулж байна.

- “Түүх, соёлын дурсгал, үзмэр, эд өлгийн зүйлийн шинэчилсэн дансны үнэ тогтоох журам”, “Түүх, соёлын дурсгал, үзмэр, эд өлгийн зүйлийн шинэчилсэн дансны үнийн жагсаалт”-ыг боловсруулан Сангийн сайдын 2013 оны 6 дугаар сарын 17-ны өдрийн 140 дүгээр тушаалаар батлуулж, түүний дагуу улс, аймгийн музейнүүдэд үзмэрийн шинэчилсэн бүртгэлийн үнэлгээ тогтоох ажлыг анх удаа хийлээ.

- Улсын тооллогын дүн мэдээг нэгтгэх зорилгоор Тооллогын төв комисс, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар, Төрийн өмчийн хороо, Урчуудын эвлэлийн хороотой хамтарсан өргөтгөсөн ажлын хэсэг байгуулан ажиллав. Ажлын хэсэг тооллогын ажилтай газар дээр нь очиж танилцан, хэсэгчилсэн хяналтын тооллого хийх, хасаж актлах, шилжүүлэх болон дутсан үзмэрүүдийг нягтлан шалгах, дүнг тулгах ажлуудыг хийж, музей бүр дээр улсын байцаагчийн дүгнэлт гаргасан. Харин мэргэжлийн хяналтын ерөнхий газраас улсын тооллогын нэгдсэн дүгнэлт гараагүй байна.

- Улсын тооллогын төв комиссын хурлыг 24 удаа зохион байгуулж, тооллогыг цаг хугацаанд нь чанартай гүйцэтгэх, тооллогын явцад илэрсэн дутагдлыг арилгах, тулгамдаж буй асуудлыг цаг алдалгүй холбогдох байгууллагад танилцуулан шийдвэрлүүлсэн.

Соёлын өвийн улсын нэгдсэн бүртгэл, мэдээллийн санд улсын тооллогын дүн мэдээ нэгтгэх ажлыг хариуцан гүйцэтгэж тооллогод хамрагдсан байгууллагуудын тайлан, дүнгийн судалгаа, “Музейн үзмэр, эд өлгийн зүйлийн ерөнхий бүртгэл”-ийн дэвтрийн хуулбар хувь, “register” програмын өгөгдөл/дата/, үзмэр, эд өлгийн зүйлийн гэрэл зураг /дижитал хэлбэр/ болон үнэлгээний илтгэх хуудас зэргийг хүлээн авч, нэгдсэн дүнг гаргалаа.

Улсын тооллогын дүн

- 2012-2013 оны улс, аймгийн музейн сан хөмрөгийн улсын тооллогоор 42 байгууллагын нийт 99366 дэсийн 228652 ширхэг 646829 иж бүрдэл үзмэрийг тоолж улсын бүртгэлд авлаа.

Д/д	Байгууллагын нэр	Дэсийн дүн	Тоо ширхэг	Иж бүрдэлийн тоо
1	Монголын үндэсний музей	19042	56546	76696
2	Байгалийн түүхийн музей	6094	7803	7803
3	Богд хааны ордон музей	4204	8631	35779
4	Дүрслэх урлагийн музей	9771	16561	18913
5	Чойжин ламын сүм музей	988	6370	137857
6	Уран зургийн галерей	3341	3590	4125
7	Монголын театрын музей	6568	9494	9494
8	Төрийн түүхийн музей	654	1079	1351
9	Хархорум музей	542	1052	1052
10	Хөшөө цайдам музей	145	175	236
11	Монгол цэргийн музей	3304	8262	9274
12	Үндэсний номын сан	516	516	135634
13	Улаанбаатар хотын музей	746	3340	3521
14	ШУА-н Палеонтологийн төв	232	320	3513
15	ШУА-н Археологийн хүрээлэн	1020	6893	6893
16	Архангай аймгийн музей	1696	3866	4637
17	Баян-Өлгий аймгийн музей	1298	5072	6052
18	Баянхонгор аймгийн музей	4074	10522	65811
19	Булган аймгийн музей	2285	442	4442
20	Говь-Алтай аймгийн музей	2489	2489	6267
21	Говьсүмбэр аймгийн музей	507	691	1131
22	Дархан-Уул аймгийн музей	882	1240	1493
23	Дорноговь аймгийн музей	2180	5533	6455
24	Данзанравжаагийн музей	258	1461	1515
25	Дорнод аймгийн музей	1636	3645	4041
26	Дорнод. Ялалтын музей	354	448	684
27	Дундговь аймгийн музей	3017	4475	5596
28	Завхан аймгийн музей	2313	10174	11760
29	Орхон аймгийн музей	1155	1601	2177
30	Өвөрхангай аймгийн музей	1200	2379	2538
31	Өмнөговь аймгийн музей	1037	2309	3105
32	Сүхбаатар аймгийн музей	1130	2025	2901
33	Сэлэнгэ аймгийн музей	2303	3201	3412
34	Төв аймгийн музей	2861	5381	6620
35	Увс аймгийн музей	2673	5679	28451
36	Ховд аймгийн музей	892	2977	5007
37	Хөвсгөл аймгийн музей	1835	3634	4158
38	Хэнтий аймгийн музей	1150	2080	3531
39	Эрдэнэ зуу музей	1823	7464	7633
40	Монгол банк. Эрдэнэсийн сан	417	1151	1190
41	Шанхын Баруун хүрээ хийд	671	3686	3686
42	Төвхөн хийд	63	395	395
	Нийт	**99366**	**228652**	**646829**

- Тооллогдсон үзмэрийг төрөл зүйлээр ангилбал: урлаг, уран сайхны үзмэр, эд өлгийн зүйл 7.3%, Түүхийн холбогдолтой үзмэр, эд өлгийн зүйл 40.8%, угсаатны зүйн холбогдолтой үзмэр, эд өлгийн зүйл 11%, шашин шүтлэгийн холбоотой үзмэр, эд өлгийн зүйл 25%, археологийн дурсгал 9.2%, байгалийн болон палеонтологийн дурсгал 6.6%-ийг тус тус эзлэж байна.



- Сангийн сайдын 2013 оны 6 дугаар сарын 17-ны өдрийн 140 дүгээр тушаалаар батлагдсан “Түүх, соёлын дурсгал, үзмэр, эд өлгийн зүйлийн шинэчилсэн дансны үнэ тогтоох журам”-ын дагуу шинэчилсэн дансны үнэлгээ тогтоох ажил улс, аймгийн 38 музей дээр явагдаж нийт 87,379,720,197.00 төгрөгийн бүртгэлийн үнэлгээ тогтоолоо.

Д\д	Музейн нэр	Хуучин бүртгэлийн үнэ	Шинэчилсэн дансны үнэ
1	Монголын үндэсний музей	1,299,710,831.00	3.337.347.366
2	Байгалийн түүхийн музей	157,263,078	316,399,029
3	Богд хааны ордон музей	1.800.357.954	14.766.747.928
4	Дүрслэх урлагийн музей	1846462900	26,531,729,500.00
5	Чойжин ламын сүм музей	1,359,850,908	3,453,589,310
6	Уран зургийн галерей	772,881,464	15,061,655,700
7	Монголын театрын музей	57,200,633	776,169,020
8	Төрийн түүхийн музей	369.354.725	3.407.292.940
9	Хөшөө цайдам музей	30,000,000	134.750.000
10	Хархорин музей		2,896,160,013
11	Монгол цэргийн музей	237,985,528,44	1,701,484,759
12	Улаанбаатар хотын музей	24,017,560	484,309,819
13	Монголын Үндэсний номын сан		2,974,884,400
14	Палеонтологийн төв		1,227,860,000
15	Архангай аймгийн музей	106,142,194	997,933,588
16	Баян-Өлгий аймгийн музей	36,020,138	1,476,877,350
17	Баянхонгор аймгийн музей	192,502,938	871,485,853
18	Булган аймгийн музей	20,717,600	326,396,0
19	Говь-Алтай аймгийн музей	25,262,611	905,009,600
20	Говьсүмбэр аймгийн музей	29,881,175	40,785,225
21	Дархан-Уул аймгийн музей	40,078,850	547,951,000
22	Дорноговь аймгийн музей	114,964,581	649,624,600
23	Данзанравжаагийн музей	825,274,300.00	1,392,620,000.00
24	Дорнод аймгийн музей	81,325,988	802,565,340
25	Дорнод. Ялалтын музей	30,535,269,8	84,973,300
26	Дундговь аймгийн музей	69,360,338	837,506,550
27	Завхан аймгийн музей	158,153,893	1,087,252,688
28	Орхон аймгийн музей	58,124,710	627.030.500
29	Өвөрхангай аймгийн музей	162,799,804	1,124,640,200

30	Өмнөговь аймгийн музей	75,491,538	756,319,780
31	Сүхбаатарын аймгийн музей	65,979,770	770,625,015
32	Сэлэнгэ аймгийн музей	163,996,543	1,964,925,410
33	Төв аймгийн музей	97,298,560	864,050,760
34	Увс аймгийн музей	46,604,361,60	3,409,578,100
35	Ховд аймгийн музей	81,746,727	989,815,500
36	Хөвсгөл аймгийн музей	32,333,915.00	827,272,000
37	Хэнтий аймгийн музей	88,338,892	910,387,522
38	Эрдэнэ зуу музей	848,722,690	7,305,931,900
	Нийт	**8.921.905.129**	**87.379.720.197.00**

- Улсын тооллогоор Дутагдсан үзмэр, эд өлгийн зүйл 9 музейгээс нийт 38 дэсийн 39 ширхэг, Солигдсон үзмэр, эд өлгийн зүйл /Эрдэнэ-зуу музейгээс/ 21 дэсийн 21 ширхэг, Маргаантай үзмэр, эд өлгийн зүйл 8 музейгээс 221 дэсийн 695 ширхэг, Сүм хийд, бусад байгууллагад гэрээгээр эзэмшүүлж байгаа үзмэр, эд өлгийн зүйл 4 байгууллагад 353 дэсийн 682 ширхэг, Яаралтай сэргээн засварлах шаардлагатай үзмэр, эд өлгийн зүйл23 музейд 1213 дэсийн 1501 ширхэг, Ерөнхий бүртгэлд тусгагдаагүй үзмэр, эд өлгийн зүйл 18 музейд 753 дэсийн 1680 ширхэг байсныг тус тус илрүүлэн, бүртгэлд авлаа.

- Ерөнхий бүртгэлээс хасаж, устгалд оруулах саналтай үзмэрийн шаардлага хангахгүй эд өлгийн зүйл 11 музейгээс 198 дэсийн 245 ширхэг, Ерөнхий бүртгэлээс хасаж, эргэлтийн хөрөнгөд шилжүүлэх саналтай үзмэр, эд өлгийн зүйл 13 музейгээс 156 дэсийн 349 ширхэг, Ерөнхий бүртгэлээс хасаж, үндсэн хөрөнгийн ангилал солих саналтай үзмэр, эд өлгийн зүйл 7 музейгээс 348 дэсийн 1125 ширхэг, Ерөнхий бүртгэлээс хасаж, шилжүүлэх саналтай үзмэр, эд өлгийн зүйл 6 музейгээс 79 дэсийн 102 ширхэг үзмэр, эд өлгийн зүйл оруулан шийдвэрлүүлэхэд бэлэн боллоо.

- Улсын тооллогод 19 аймаг, 1 дүүргийн 257 Орон нутаг судлах танхим хамруулж нийт 17111 дэсийн 29480 ширхэг 58037 иж бүрдэл үзмэр тоолж бүртгэлээ. Орон нутаг судлах танхимын тооллогоор дутагдсан үзмэр, эд өлгийн зүйл 7 аймгаас нийт 65 дэсийн 88 ширхэг, маргаантай үзмэр, эд өлгийн зүйл 2 аймгаас 4 дэсийн 4 ширхэг, солигдсон үзмэр, эд өлгийн зүйл 1 аймгаас 1 ширхэг (Увс аймаг Өндөрхангай), Ерөнхий бүртгэлд тусгагдаагүй үзмэр, эд өлгийн зүйл 4 аймгаас 1181 дэсийн 1268 ширхэг байгааг илрүүлэн, бүртгэлд авлаа.

Улсын тооллогын төв комиссоос улс, аймгийн музейнүүд зориулалтын бус барилгад үйл ажиллагаа явуулж байгаа нь үзмэр, эд өлгийн зүйлийн хадгалалт хамгаалалтанд тавигдах шаардлагыг хангахгүй, соёлын өвд эрсдэл үүсэх шалтгаан болж байна гэж үзэн цаашид музейн үзмэрийн хадгалалт хамгаалалт, сан хөмрөгийн өрөөнд мөрдөх шаардлагыг хангах, музейн үйл ажиллагааг сайжруулах, зарим музейн статусыг өөрчлөх, стандартын барилга байгууламжтай болгох санал гаргасан юм. Эдгээр асуудлыг 2016 оноос хэрэгжүүлэх зорилгоор Засгийн газрын тогтоолын төсөлд тусгалаа.

Улс, аймгийн музейнүүдээс судалгаа авч үзмэрийн зориулалтын хорготой болгох, сан хөмрөгийн өрөөг дохиолол, хяналтын системээр тоноглох, тавиур багаж хэрэгслэлээр хангахад 1 988 032 170 /нэг тэрбум есөн зуун наян найман сая гучин хоёр мянга нэг зуун дал/ төгрөг шаардлагатай байгаа бөгөөд 2016 оноос эхлэн жил бүрийн төсөвт тусгаж, үе шаттайгаар хэрэгжүүлэхээр төлөвлөж байна.

Музейн эрх зүйн орчныг улам боловсронгуй болгох зорилгоор Музейн хуулийн үзэл баримтлалыг Засгийн газрын 2014 оны 58 дугаар тэмдэглэлээр дэмжигдэн “Музейн тухай” хуулийг боловсруулж байна.

Засгийн газраас баталсан түүх, соёлын хосгүй үнэт 776 дурсгалт зүйлсэд дохиолол хамгаалалтын бичил мэдрэгч суурилуулах үүнд зориулсан зардлыг тухайн музейн төсөвт жил бүр тусгаж өгөх хэрэгтэй байна.

“Улс, аймгийн музейн сан хөмрөгийн улсын тооллогын нэгдсэн дүн”-гийн мөрөөр авах арга хэмжээ, нийт, улс аймгийн музейд зохион байгуулах үйл ажиллагааны талаар тусгай төлөвлөгөө боловсруулан Боловсрол, соёл шинжлэх ухааны сайдын тушаалаар батлан хэрэгжүүлэхээр төлөвлөөд байна.

Музейн үзмэр, эд өлгийн зүйлийн хадгалалт хамгаалалтыг эрс сайжруулах, зориулалтын барилга, сан хөмрөгтэй болгох, музейн үйл ажиллагааг олон улсын жишигт хүргэх, менежмент, маркетингийг өөрчлөх асуудал нь хойшлуулшгүй чухал болоод байгааг энэ удаагийн улсын тооллогын дүн харууллаа гэж үзэж байна.

Монголын үндэсний музейн сан хөмрөгийн улсын тооллого 2015 оны 4 дүгээр сарын 1-нд дуусантай холбогдуулан улс, аймгийн музейн сан хөмрөгийн тооллогын нэгдсэн дүнг БСШУЯ-наас 2015 оны 4 дүгээр сарын 14-ны өдөр Монгол улсын засгийн газрын хуралдаанд танилцуулах "Улс, аймгийн музейн сан хөмрөгийн тооллогын танилцуулга"-гийн тоон дүн бэлтгэлээ.

Тооллогын нэгдсэн тайлан, тоон дүнгийн хавсралтуудыг нэгтгэн гаргаж, баталгаажуулахад бэлэн болгоод байна.

Улсын нэгдсэн бүртгэл, мэдээллийн санд ирсэн улс, аймгийн музейн сан хөмрөгийн тооллогын материалыг цэгцлэн тооллогод хамрагдсан 299 байгууллагын 399 ширхэг "Музейн үзмэр, эд өлгийн зүйлийн ерөнхий бүртгэл"-ийн хуулбар, 85 хавтаст хэрэг тайлан, тооллогод хамрагдсан байгууллагын "Тоон дүнгийн судалгаа №1, №2", Мэргэжлийн хяналтын байцаагчдын дүгнэлт, тооллогын төв комиссын протокол нийт 6 хавтаст материал, "регистер" цахим бүртгэлийг Соёлын өвийн улсын нэгдсэн бүртгэл, мэдээллийн сангийн архивт авлаа.

Одоо хавтаст хэрэг бүрийн "дотоод товьёог"-ыг бэлтгэх ажил хийгдэж байна.

<u>4.4. Шинээр байгуулагдах Соёлын өвийн Үндэсний төвийн үйл ажиллагааны менежментийн төлөвлөгөө чиглэл, статусыг соёлын бүтээлч үйлдвэрлэлд тулгуурлан шинээр боловсруулах.</u>

БСШУ-ны Сайдын 2015 оны 01 тоот албан даалгаварт заасан байгууллагын онцлог давуу тал дээр суурилсан хөгжлийн стратеги бодлогыг боловсруулах, менежмент маркетингийн дунд, богино хугацааны төлөвөлгөөг гаргах хэрэгжүүлэх арга замыг тодорхойлж үр дүнг шалгуураар тооцож ажиллахыг үүргийг хэрэгжүүлэхээр ажиллаж байна.

Хууль эрх зүй, соёлын өвийн менежмент, соёлын өвийн судлагааны чиглэлээр ажилладаг мэргэжлийн хүмүүсээс заавар зөвлөмж авах, ажилтнуудын дунд сургалт зохион байгуулан, байгууллагынхаа стратеги төлөвлөгөөг шинэчилэхээр ажиллаж байна.

Бүх ажилтнуудыг хамруулан соёлын эдийн засаг бүтээлч үйлдвэрлэлийн чиглэлээр мэдлэг олгох сургалтыг 2015 оны 06 дугаар сарын 22-ны өдөр зохион байгуулав. Сургалтыг СУИС-ийн менежментийн тэнхимийн эрхлэгч, доктор, дэд. проф Ж.Эрхэмтөгс "Соёлын бүтээлч үйлдвэрлэл, менежмент зохион байгуулалт" чиглэлээр хичээл зааж тус төвийн стратеги төлөвлөгөөг шинэчлэн боловсруулах заавар зөвлөмж өгөв.

БСШУ-ны сайдын 2015 оны 01 албан тоот даалгаварт заасан үндсэн 6 албан даалгаварыг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг боловсруулж, хийгдэх ажлуудыг төлөвлөн гүйцэтгээд байна. Төвийн захирлын 2015 оны 07-р сарын 07-ны өдрийн 142-р албан тоотоор Албан даалгаврын төлөвлөлт болон хэрэгжилтийн талаарх мэдээ тайланг БСШУЯ-нд хүргүүлсэн болно.

Байгууллагын шинэ бүтцийг харуулсан схем



Соёлын өвийн төвийн шинэ бүтэц (санал)



“Байгууллагын архив, албан хэрэг хөтлөлт, төрийн байгууллагуудын ажлын зохион байгуулалтын улсын үзлэг”-т бэлтгэсэн тухай:

Засгийн газрын 2015 оны 195 дугаар “Байгууллагын архив, албан хэрэг хөтлөлт, төрийн байгууллагын ажлын зохион байгуулалтын улсын үзлэг зохион байгуулах тухай” тогтоол, Монгол Улсын Ерөнхий сайдын 2015 оны 124 дүгээр захирамж, БСШУЯамны төрийн нарийн бичгийн даргын 2015 оны 2/6194 тоот албан бичигт заасны дагуу тус төвийн захирлын 2015 оны А/66 тоот тушаалаар улсын үзлэгт бэлтгэх комиссыг байгуулан, ажлын төлөвлөгөө боловсруулж бэлтгэл ажлыг ханган ажиллалаа.

Үзлэгт бэлтгэх комисс нь БСШУЯамнаас ирүүлсэн “Байгууллагын архивын ажлыг дүгнэх үзүүлэлт, аргачлал”, “Албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааг дүгнэх үзүүлэлт, аргачлал”, “Төрийн байгууллагын архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд мэдээллийн технологи нэвтрүүлж буй байдлыг дүгнэх үзүүлэлт, аргачлал”, “Төрийн байгууллагын ажлын зохион байгуулалтыг дүгнэх үзүүлэлт, аргачлал”-ын дагуу байгууллагын архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааг цэгцлэн бэлтгэж, албан хэрэг хөтлөлтийн байдалд дотооддоо үзлэг хийж бэлтгэв.

Ажлын хүрээнд тус төвийн 2009-2015 оны холбогдох албан баримт бичгүүдийг архивын журмын дагуу эмхлэн цэгцлэх ажлыг хийсэн. Тус төвийн архив, албан хэрэг хөтлөлтийн талаар архивийн мэргэжилтнээс заавар зөвлөмж авч ажилласан ба байгууллагын ББНШК-ын бүрэлдэхүүнийг шинэчлэн, “Архив, албан хэрэг хөтлөлтийн журам”-д заасны дагуу тус төвийн архив, бичиг хэргийн журмыг боловсруулав. Төвийн захирлын 2015 оны 09-р сарын 07-ны өдрийн 174-р албан тоотоор улсын үзлэгийн тайлан мэдээг БСШУЯ-ны Улсын архивын үзлэгийн салбар комисст хүргүүлсэн.

ҮР ДҮНГИЙН ГЭРЭЭНД ТУСГАГДААГҮЙ БУСАД АЖИЛ

УНБМСангийн музейн үзмэрийн “RCH” бүртгэлийн талаар

Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 20; 21; 22 дахь заалтыг хэрэгжүүлж соёлын өвийн УНБМСанд улс, аймгийн музейнүүдээс үзмэрийн бүртгэлийг тусгай програм хангамжаар, интернет сүлжээ ашиглан хүлээн авах ажиллагаа байнга хийгддэг. 2015 оны байдлаар тус санд нийт 38 музейн 51527 дэсийн 94100 ширхэг үзмэр бүртгэгдсэн байна. 2015 оны байдлаар Монголын Үндэсний музей, Дүрслэх урлагийн музей, Монголын Театрын музей, Дундговь аймгийн музей, Байгалийн түүхийн музей, Өмнөговь аймгийн музей үзмэрээ БМСанд идэвхитэй бүртгэсэн байна.

2012-2014 онд улсын тооллогоор музейнүүд ерөнхий бүртгэлдээ үзмэрээ иж бүрдүүлэн бүртгэх, нэгтгэх ажиллагаа хийгдсэнтэй уялдуулан өмнөх онуудад БМСанд бүртгэгдсэн үзмэрийн бүртгэлүүдэд хөдөлгөөн хийгдсэн байна.

УНБМСангаас үзмэрийн бүртгэлийн бүрдүүлэлтийн байдалд дүн шинжилгээ хийж үзэхэд бүртгэлд үзмэрийн “зэрэглэлд хамрагдсан тухай”, “сэргээн засварлагдсан тухай”, “шилжилт хөдөлгөөний тухай” мэдээллээ нэмж хийгдэхгүй, үзмэрийн бүтээсэн “он цагийн” сонголтыг дутуу хийх зэрэг засах шаардлагатай зүйлс байсаар байгааг музейнүүд анхаарах цаг болжээ. Тус хэлтсээс 2015 оны 4 дүгээр сард зохион байгуулсан БМСанч нарын сургалтандаа тодорхой сэдвүүдээр заасан.

УНБМСангийн зүгээс ч RCH програм хангамжийн зарим талбарт жишээбэл нь зэрэглэлд хамрагдсан тухай мэдээллийн талбарт сонголтын тохиргоог цаг тухайд нь нэмж байх шаардлагатай байна.

№	Байгууллага	2015 оны 11-р сар хүртэл УНБМСанд нэмэгдсэн		УНБМСанд нийт бүртгэгдсэн /2015 оны байдлаар/	
		Дэс	Тоо ширхэг	Дэс	Тоо ширхэг
1	Богд хааны ордон музей	0	0	4099	12964
2	Чойжин ламын сүм музей	0	0	1123	6179
3	Дүрслэх Урлагийн музей	350	386	2908	3095

4	Монголын үндэсний музей	747	913	5743	8446
5	Байгалийн Түүхийн музей	136	141	3130	3196
6	Эрдэнэ Зуу музей	0	0	1200	2359
7	Уран Зургийн галерей	0	0	1619	1642
8	Монголын Театрын музей	332	476	3849	4536
9	Үндэсний номын сан	0	0	630	1122
10	Монголын цэргийн музей	16	16	330	330
11	Палеонтологийн төв	0	0	67	69
12	Археологийн хүрээлэн	0	0	759	2447
13	Улаанбаатар хотын музей	0	0	407	611
14	Архангай аймгийн музей	0	0	1314	2141
15	Баян-Өлгий аймгийн музей	0	0	883	1890
16	Баянхонгор аймгийн музей	3	5	1766	5338
17	Булган аймгийн музей	0	0	2274	4083
18	Говь-Алтай аймгийн музей	0	0	1602	1737
19	Говьсүмбэр аймгийн музей	0	0	424	424
20	Дархан-Уул аймгийн музей	0	0	866	866
21	Дорноговь аймгийн музей	0	0	805	6643
22	Дорнод аймгийн музей	0	0	1447	3332
23	Дундговь аймгийн музей	156	156	1550	1637
24	Завхан аймгийн музей	0	0	1260	1260
25	Орхон аймгийн музей	0	0	610	611
26	Өвөрхангай аймгийн музей	0	0	516	990
27	Өмнөговь аймгийн музей	38	354	980	1356
28	Сүхбаатар аймгийн музей	0	0	346	346
29	Сэлэнгэ аймгийн музей	0	0	1031	1049
30	Төв аймгийн музей	0	0	1487	1824
31	Увс аймгийн музей	16	78	1953	3987
32	Ховд аймгийн музей	0	0	192	192
33	Хөвсгөл аймгийн музей	0	0	1799	3861
34	Хэнтий аймгийн музей	0	0	1288	1713
35	Төрийн Түүхийн музей	0	0	645	654
36	Хөшөө цайдам музей	0	0	37	90
37	Хархорум музей	0	0	581	1073
38	Данзанравжаа музей	0	0	7	7
	Дүн	**1794**	**2525**	**51527**	**94100**

УНБМСанд бүртгүүлсэн хувь иргэний өмчлөлийн соёлын өвийн бүртгэлийн талаар

2012 оноос хойш Соёлын өвийн улсын нэгдсэн бүртгэл, мэдээллийн санд өөрийн өмчлөлд байгаа эд зүйлийг улсын бүртгэлд бүртгүүлэх тухай хүсэлт 21 иргэн гаргасны дотор 7 иргэний бүртгэлийн бүрдүүлэлт шаардлага хангахгүй, 14 иргэний 26 дурсгалын анхан шатны бүртгэлийг хүлээн авсан. Үүнээс хүсэлт гаргасан 9 иргэнд “анхан шатны бүртгэлийг хүлээн авсан тухай” албан бичгийг өгөөд байна.

Соёлын өвийн улсын нэгдсэн бүртгэл, мэдээллийн санд ирүүлсэн хувь хүний эд зүйлийн анхан шатны бүртгэлийг код өгч цахим бүртгэлд оруулахын тулд БСШУЯ-ны дэргэдэх Түүх, соёлын дурсгалт зүйлийн зэрэглэл, үнэлгээ тогтоох мэргэжлийн зөвлөлд хандан тухайн эд зүйл “түүх, соёлын дурсгалд хамаарах” эсэхийг албан ёсоор тогтоолгохоор бэлтгээд байна.

Соёлын өвийн улсын нэгдсэн бүртгэл, мэдээллийн санд ирүүлсэн хувь хүний эд өлгийн зүйлийн анхан шатны бүртгэлийн жагсаалт/2012-2015 он/

№	Өмчлөгч нэр, оршин байгаа газар	Д/д	Дурсгалын нэр	Материалын бүрдүүлэлтийн бүрдэл	СӨУНБМСанд хүлээн авсан хугацаа	Шийдвэр-лэгдсэн байдал
1	Пүрэвжавын Санчирмаа /СЭ77021261/ Хэнтий, Галшир сум	1	Галтай ланзан тамга (хийморьтой, туухайтай)	Бүртгэлийн маягт, гэрэл зураг 4 ш, хэмжээний зураг, 2 номын хуулбар 3 хуудас, 3 тодорхойлолт 3 хуудас	2012-03-09	
2	Цогтсайханы Сайханчимэг /УШ92072183/ УБ хот, СБД	2	Хатан Дондогдуламын хэрэглэж байсан толь, шүүгээтэй тавилга	Бүртгэлийн маягт, хүсэлт, ИҮ-ний хуулбар, гэрэл зураг 4 ш	2014-01-07	Хүсэлтийн дагуу анхан шатны бүртгэл хүлээн авсан албан бичиг СӨТ 2015-06-05, №110
3	Баасанцэрэнгийн Мөнх-Эрдэнэ /ЧК83031813/ УБ хот, ХУД	3	1206-1266 оны үеийн алтан зоос, 18 ширхэг	Бүртгэлийн маягт, хавсралт 2 хуудас	2014-02-07	Хүсэлтийн дагуу СӨТ-өөс Батламж №07, 2014 он
4	Базарын Цэрэннадмид /ЧГ47070229/ УБ хот, СХД	4	Эмээл, хазаар, ташуур	Бүртгэлийн маягт, гэрэл зураг 1 ш	2014-02	
5	Сэрдамбын Будрагчаа /ГГ88071311/ Булган, Гурван булаг сум	5	Кидан улсын үеийн жин, хэмжүүрийг батламжилсан тамга /тэмдэг/	Бүртгэлийн маягт, гэрэл зураг 3 ш, ИҮ-ний хуулбар	2014-03	
6	Осорын Оюумаа /ХБ56021965/ УБ хот, ЧД	6	“Бурхан багш 16 Найдан жүдэгийн хамт” танка	Бүртгэлийн маягт, гэрэл зураг 2 ш, ИҮ-ний хуулбар	2014-04-23	
	Осорын Оюумаа /ХБ56021965/ УБ хот, ЧД	7	“Жүжигшал Жанрайсиг” танка	Бүртгэлийн маягт, гэрэл зураг 2 ш	2014-04-23	

	Осорын Оюумаа /ХБ56021965/ УБ хот, ЧД	8	“Их Юань улсын мандсан төрийн Хөх судар” уйгаржин бичгээр	Бүртгэлийн маягт, гэрэл зураг 3 ш	2014-04-23	
	Осорын Оюумаа /ХБ56021965/ УБ хот, ЧД	9	“Гучин хоёр модон хүний үлгэр судар” уйгаржин бичгээр	Бүртгэлийн маягт, гэрэл зураг 3 ш	2014-04-23	
7	Цэрэнбадамын Ганболд /УС55011016/ УБ хот, ЧД	10	Бурханы шашны судар	Бүртгэлийн маягт, гэрэл зураг 5 ш, ИҮ-ний хуулбар	2014-06-30	Хүсэлтийн дагуу бүртгэлийн баталгаажуулсан маягт №08
8	Гооройн Баянзул /УХ47032911/ УБ хот, ЧД	11	Халтар манан хөөрөг	Бүртгэлийн маягт, гэрэл зураг 6 ш, ИҮ-ний хуулбар	2014-06-30	Хүсэлтийн дагуу анхан шатны бүртгэл хүлээн авсан албан бичиг СӨТ 2015-02-11, №47
9	Пүрэвийн Эрдэнэсүх /ХБ67121978/ УБ хот, СХД	12	Бурхан /цутгамал/	Бүртгэлийн маягт, 6 ш гэрэл зураг, өргөдөл, ИҮ-ний хуулбар, Бүртгэлийн баталгаажуулсан маягт №09	2014-07-19	Хүсэлтийн дагуу бүртгэлийн баталгаажуулсан маягт №09
10	Пүрэвжавын Батбуян /НЭ53072305/ Төв аймаг, Зуумод сум	13	Гартааман хөөрөг	Бүртгэлийн маягт, гэрэл зураг 4 ш, хүсэлт, ИҮ-ний хуулбар	2014-11-03	
	Пүрэвжавын Батбуян /НЭ53072305/ Төв аймаг, Зуумод сум	14	Мөнгөн даруулга, сувдан шигтгээтэй	Бүртгэлийн маягт, гэрэл зураг 4 ш	2014-11-03	
11	Доржчамбын Ганхүү /УС59072311/ УБ	15	“Мянганы суут хүн Чингис ханы	Бүртгэлийн маягт 3 ш, 28 ш гэрэл зураг,	2014-12-02	Хүсэлтийн дагуу анхан шатны

	хот, БГД		дүр төрх” марк 393 ш, ил захидал 16 ш, дугтуй 77 ширхэг /нэг иж бүрдэл/	задалж бүртгэсэн маягт 28 ш А4 зурагтай, хүсэлт, гарчиг 2 х, ИҮ-ний хуулбар, гэрэл зураг 4 ш, тодорхойлолт, диплом		бүртгэл хүлээн авсан албан бичиг СӨТ 2015-04-03, №70
12	Ганболдын Пүрэвдорж /НБ88072828/ УБ хот, ЧД	16	Шавар ваар /Хүннүгийн үе/	Бүртгэлийн маягт, хүсэлт, ИҮ-ний хуулбар, гэрэл зураг 4 ш	2014-12-07	Хүсэлтийн дагуу анхан шатны бүртгэл хүлээн авсан албан бичиг СӨТ 2015-01-06, № 01
13	Сэнгэжавын Батчулуун /А365011115/ Архангай, Цахир сум	17	Сүм хэлбэртэй хүрд /Гэсэр ламын хэрэглэж байсан/	Бүртгэлийн маягт, гэрэл зураг 6 ш, сонин хуулбар 2 хуудас, номын хавтас хуулбар 1 хуудас, хүсэлт, ИҮ-ний хуулбар, “Өвгөн Гэсэр богдын цадиг домгийн цоморлиг” ном 2013 он	2015-05-05	Хүсэлтийн дагуу анхан шатны бүртгэл хүлээн авсан албан бичиг СӨТ 2015-05-06, № 92
	Сэнгэжавын Батчулуун /А365011115/ Архангай, Цахир сум	18	Гавал тулга /Гэсэр ламын хэрэглэж байсан/	Бүртгэлийн маягт, гэрэл зураг 3 ш, сонин хуулбар 2 хуудас, номын хавтас хуулбар 1 хуудас, ИҮ-ний хуулбар	2015-05-05	
	Сэнгэжавын Батчулуун /А365011115/ Архангай, Цахир сум	19	Арцны халбага, чулуу /Гэсэр ламын хэрэглэж байсан/	Бүртгэлийн маягт, гэрэл зураг 2 ш, сонин хуулбар 2 хуудас, номын хавтас хуулбар 1 хуудас, хүсэлт, ИҮ-ний хуулбар	2015-05-05	
	Сэнгэжавын	20	Хүрд /Гэсэр	Бүртгэлийн	2015-05-05	

	Батчулуун /А365011115/ Архангай, Цахир сум		ламын хэрэглэж байсан/	маягт, гэрэл зураг 2 ш, сонин хуулбар 2 хуудас, номын хавтас хуулбар 1 хуудас, ИҮ-ний хуулбар		
	Сэнгэжавын Батчулуун /А365011115/ Архангай, Цахир сум	21	Хонх /Гэсэр ламын хэрэглэж байсан/	Бүртгэлийн маягт, гэрэл зураг 2 ш, сонин хуулбар 2 хуудас, номын хавтас хуулбар 1 хуудас, ИҮ-ний хуулбар	2015-05-05	
	Сэнгэжавын Батчулуун /А365011115/ Архангай, Цахир сум	22	Зааны ясан халбага /Гэсэр ламын хэрэглэж байсан/	Бүртгэлийн маягт, гэрэл зураг 1 ш, сонин хуулбар 2 хуудас, номын хавтас хуулбар 1 хуудас, ИҮ-ний хуулбар	2015-05-05	
	Сэнгэжавын Батчулуун /А365011115/ Архангай, Цахир сум	23	Эрдэнийн үрэл, уутай /Гэсэр ламын хэрэглэж байсан/	Бүртгэлийн маягт, гэрэл зураг 1 ш, сонин хуулбар 2 хуудас, номын хавтас хуулбар 1 хуудас, ИҮ-ний хуулбар	2015-05-05	
	Сэнгэжавын Батчулуун /А365011115/ Архангай, Цахир сум	24	Хануур, хатгуурын хэрэгсэл /Гэсэр ламын хэрэглэж байсан/	Бүртгэлийн маягт, гэрэл зураг 1 ш, сонин хуулбар 2 хуудас, номын хавтас хуулбар 1 хуудас, ИҮ-ний хуулбар	2015-05-05	
	Сэнгэжавын Батчулуун /А365011115/ Архангай, Цахир сум	25	Тунгийн халбага, ууттай /Гэсэр ламын хэрэглэж байсан/	Бүртгэлийн маягт, гэрэл зураг 2 ш, сонин хуулбар 2 хуудас, номын хавтас хуулбар 1 хуудас, ИҮ-ний хуулбар	2015-05-05	
14	Зоригтбаатарын Урантогос /НЭ83050862/ УБ хот, СБД	26	Долоон хошуу даншиг наадмын үеийн бөхийн зодог шуудаг	Бүртгэлийн маягт	2015-06	Хүсэлтийн дагуу анхан шатны бүртгэл хүлээн авсан албан бичиг СӨТ 2015-06-25, № 133

Төмөр замын музейг бүртгэн баримтжуулалтын мэргэжил, арга зүйгээр хангасан тухай

Улаанбаатар Төмөр замын музейн 2015 оны 9/491-р тоот хүсэлтийн дагуу мэргэжилтэн Ш.Энхтуяа тус музейн үзмэрийг бүртгэх талаар арга зүйн зөвлөгөө өгч хамтран ажиллав. Тус музей нь Намын төв хорооны 1968 оны 45-р тогтоолоор анх "Монголын төмөр түүхийн үзэсгэлэн" нэртэй суурь тавигдаж "УБТЗ-ын түүхийн музей" нь Монголын төмөр замын түүхийг харуулсан ховор чухал 2000 гаруй үзмэртэй боловч музейн бүртгэл, судалгаа, баримт байхгүйн улмаас бүртгэлээр хяналт тавих тогтолцоогүй явж ирсэн байна. Нийслэлийн мэргэжлийн хяналтын газраас тус музейд шалгалт хийж акт тавьснаар музейн эрхлэгч Ү.Наранцэцэг нь манайд хандсан. Иймээс манай байгууллагаас тус музейд:

- Соёлын өвийн улсын нэгдсэн бүртгэл, мэдээллийн сангийн эзэмшигчийн кодыг албан ёсоор өгсөн,
- "Музейн сан хөмрөгийг бүртгэх, баримтжуулах заавар" холбогдох бусад баримт бичгийг үндэслэн тус музейн үзмэрт хувийн дугаар өгөх, карт, бүртгэл хөтлөх тухай заавар, зөвлөлгөөг хэлстийн мэргэжилтэн Ш.Энхтуяа удаа дараа өгч протокол үйлдэв.
- "Музейн үзмэр, эд өлгийн зүйлийн ерөнхий бүртгэл"-ийн дэвтэр албан ёсоор кодлон тус тус олголоо.

Хувийн өмчлөлийн музейнүүдэд анхан шатны бүртгэл хөтлөлтийн талаар мэргэжил арга зүйн заавар өгсөн тухай

Улаанбаатар Төмөр замын музейн 2015 оны 9/491-р тоот, Монос дээд сургуулийн дэргэдэх Эмийн ургамлын музейн 2015 оны 57-р албан тоот, газрын тосны музейн 2015 оны 4-1159 албан тоот, Оюун ухааны олон улсын музейн 2015 оны 26 тоот албан тоотыг тус тус үндэслэн Үндэсний музейн мэргэжил арга зүйн төвтэй хамтарч хувийн болон байгууллагын музейнүүдийг бүртгэлийн арга зүйгээр хангах зорилготой сургалтыг 2015 оны 10 дугаар сарын 14-нд тус музей дээр зохион байгууллаа.

Уг Сургалтанд Мэдээлэл харилцаа холбооны дэргэдэх Маркийн музей, Төмөр замын музей, Монос дээд сургуулийн дэргэдэх Эмийн ургамлын музей, Тагнуулын ерөнхий газрын дэргэдэх музей, Газрын тосны музей, Угсаатны гэр музей гэсэн 6 байгууллагын 7 хүн хамрагдав. Оюун ухааны олон улсын музейд мэдэгдсэн боловч сургалтад хүнээ ирүүлээгүй болно.

Сургалтаар хэлтсийн дарга Д.Нарантуяа, мэргэжилтэн Ш.Энхтуяа, Ж.Даваацэрэн нар "Музейн бүртгэлийн эрх зүй", "Үзмэрийн биет дээр хувийн дугаар бичих, зүүх, бэхлэх арга зүй", "Үзмэрийн тоо ширхэгийг тодорхойлох", "Музейн үзмэр, эд өлгийн зүйлийн ерөнхий бүртгэл хөтлөх тухай", "Музейн үзмэрийн цахим бүртгэл" зэрэг мэргэжил арга зүйн хичээлүүдийг Үндэсний музейн мэргэжилтэнгүүдтэй хамтран заалаа. СӨУНБМСангаас Төмөр замын музей, Монос дээд сургуулийн музей, Оюун ухааны Олон улсын музейн хүсэлтээр "Музейн үзмэр, эд өлгийн зүйлийг бүртгэл"-ийн дэвтрийг олгосон.

Түүх, соёлын дурсгалд дүн шинжилгээ хийсэн тухай

Авлигатай тэмцэх газрын Мөрдөн шалгах хэлтсийн мөрдөн байцаагч албан тушаалтай комиссар М.Эрдэнэсайханы 2015 оны 01 дүгээр сарын 28-ны өдрийн "Шинжилгээ хийлгэх тухай тогтоол"-д заасан Хөвсгөл аймгийн Мөрөн сумын "Мөрөнгийн хүрээ Гандандаржаалин" хийдэд 2012 онд "Буддын шашныг хөгжүүлэх төсөл" нэртэй тендерийн хүрээнд нийлүүлэгдсэн хөөмөл, гуулин хийцтэй 2 ширхэг бурханы ур хийц, бүтээц, орц найрлагыг тогтооход захирал Г.Энхбат, Сэргээн засварлах хэлтсийн дарга С.Чинзориг, Биет соёлын өвийг хамгаалах хэлтсийн дарга Д.Нарантуяа нар шинжээчээр ажиллав. Дүн шинжилгээ хийхэд Авилгатай тэмцэх газрын Мөрдөн байцаагч, комиссар М.Эрдэнэсайханы хамтаар Д.Нарантуяа, тус хэлтсийн програмист Ж.Даваацэрэн нар 2015 оны 02 дугаар сарын 09-ний өдөр Хөвсгөл аймгийн Мөрөн сумын Гандандаржаалин хийд дээр биечлэн очиж, уг 2 ширхэг бурханыг биетээр нь үзэж шалгасан.

Ажлын явцад 2 бурханы гэрэл зургийг тал бүрээс нь баримтжуулан авсан ба бурхдыг хийсэн металын бүтэц, найрлагыг нь X-MET 7500 X-RAY аппаратаар уншуулж, бурхдыг хийсэн метал болон үсний өнгөнөөс дээж авсан. Уг бурхдаас авсан дээжийг тус төвийн сэргээн засварлах хэлтсийн лабораторийн материалын бүтцийг тодорхойлох GT 5000 X-

RAY аппаратаар шинжлэн уг 2 бурханы металын бүтэц, найрлагыг тодорхойлов. Шинжээчид ажлын дадлага туршлага, мэргэжлийн ур чадвар болон металын орц найрлагыг тогтоох тоног төхөөрөмж ашиглан уг 2 бурханы ур хийц, хэдий үед хийгдсэн, ямар метал орц найрлагатай болохыг нягтлан шалгаж, дүгнэлтийг АТГазарт хүргүүлсэн болно.

“Монголын музейн шилдэг үзмэрийн дээжис” номон дээр ажилласан тухай

Монгол Улсад орчин цагийн музей үүсэж хөгжсөний 90 жилийн ойд зориулсан ССАЖЯам /хуучин нэрээр/-наас “Монголын музейн үзмэрийн шилдэг дээжис” цувралыг эрхлэн гаргасан ба 1 дэх цуврал нь 2014 оны эцсээр буюу 12 дугаар сард хэвлэгдсэн билээ.

2015 оны эхний хоёр сард тус номын 2 ба 3 дахь цуврал орсон Байгалийн түүхийн музей, Үлэг гүрвэлийн Төв музей, Монгол Цэргийн музей, Үндэсний номын сан, Улаанбаатар хотын музей, Архангай, Баян-өлгий, Баянхонгор, Булган, Дорноговь, Данзанравжаагийн музей, Дорнод, Дундговь, Завхан, Орхон, Өвөрхангай, Эрдэнэзуу музей, Өмнөговь, Сүхбаатар, Сэлэнгэ, Төв, Увс, Ховд, Хөвсгөл, Хэнтий зэрэг 25 музейн үзмэрийн тайлбарыг бэлтгэх, нягтлан шалгах ажлыг уг номыг эрхэлсэн редакцитай хамтран хэлтсийн дарга Д.Нарантуяа, мэргэжилтэн Ш.Энхтуяа нар хийж гүйцэтгэлээ.

Музейн үзмэрийн баяжилтийн судалгааны талаар

2015 оны 2 дугаар сараас эхлэн 5 дугаар сарын хугацаанд музейн сан хөмрөгт баяжилтийн судалгааг 36 музейгээс авах ёстойгоос 6 музейгээс судалгаа ирүүлээгүй, 3 музейгээс баяжилт хийгдээгүй гэсэн мэдээ ирүүлсэн. Судалгаа ирүүлсэн 27 музейд 2012-2014 онуудад 529 дэсийн үзмэр худалдан авсан, 467 дэсийн үзмэр бэлэг хандиваар ирсэн, 372 дэсийн үзмэр шилжиж ирсэн, 412 үзмэр археологийн малтлагаар, 609 үзмэр хайгуул судалгаагаар, бусад эх үүсвэрээр 514 үзмэр нийт 2900 үзмэрээр сан хөмрөг баяжигдсан байна.

№	Байгууллагын нэр	Худалдаж авсан	Бэлэг хандиваар	Шилжиж ирсэн	Археологи малтлага	Хайлгуул, судалга	Бусад	Нийт	Тайлбар
1	Монголын үндэсний музей	7	40	199	70	1	98	415	
2	Байгалийн түүхийн музей	4	4	5		593	3	609	
3	Богд хааны ордон музей	3	5					8	
4	Дүрслэх урлагийн музей		1	3			18	22	
5	Чойжин ламын сүм музей							-	үзмэр баяжилт хийгдээгүй
6	Уран зургийн галерей	15	5					20	
7	Монголын театрын музей	13	3					16	
8	Монголын төрийн түүхийн музей	6	1	16				23	
9	Монгол цэргийн музей	30	154	27	1			209	
10	Үндэсний номын сангийн Үнэт ховор номын музей							-	судалгаа ирүүлээгүй
11	Улаанбаатар хотын музей	10						10	
12	Хөшөө цайдам музей							-	судалгаа ирүүлээгүй
13	Хархорум музей	31		97	340		2	470	
14	Эрдэнэ-зуу музей						15	15	
15	Архангай аймгийн музей							-	үзмэр баяжилт хийгдээгүй
16	Баян-Өлгий аймгийн музей							-	үзмэр баяжилт хийгдээгүй

17	Баянхонгор аймгийн музей	4	90	19		8		121	
18	Булган аймгийн музей							-	судалгаа ирүүлээгүй
19	Говь-Алтай аймгийн музей	7						7	
20	Говьсүмбэр аймгийн музей		12					12	
21	Дархан-Уул аймгийн музей	7		3			5	15	
22	Дорноговь аймгийн музей								судалгаа ирүүлээгүй
23	Дорнод аймгийн музей	51					94	145	
24	Дорнод. Ялалтын музей							-	судалгаа ирүүлээгүй
25	Дундговь аймгийн музей	99	27					126	
26	Завхан аймгийн музей	14	23				61	98	
27	Орхон аймгийн музей	4	14	1				19	
28	Өвөрхангай аймгийн музей	5	2				52	59	
29	Өмнөговь аймгийн музей	23	17	1			10	51	
30	Сүхбаатарын аймгийн музей	3	34				149	186	
31	Сэлэнгэ аймгийн музей	1	16					17	
32	Төв аймгийн музей	4						4	
33	Увс аймгийн музей	7	8	1	1	3	7	27	
34	Ховд аймгийн музей	122	6			3		131	
35	Хөвсгөл аймгийн музей								судалгаа ирүүлээгүй
36	Хэнтий аймгийн музей	59	5			1		65	
	Нийт	**529**	**467**	**372**	**412**	**609**	**514**	**2900**	

Хулгайд алдагдсан түүх, соёлын дурсгалын талаар

1990 оноос хойших музейн сан хөмрөгөөс алдагдсан үзмэрийн мэдээллийг гаргаж өгөхийг хүссэн Цагдаагийн ерөнхий газраас ирүүлсэн 2015 оны 04 дүгээр сарын 27-ны өдрийн 10/4-888 албан тоотын дагуу хэлтсийн мэргэжилтэн Ш.Энхтуяа Улсын нэгдсэн бүртгэл, мэдээллийн санд байгаа хулгайд алдагдсан дурсгалын мэдээллийг 2007 болон 2012 оны улсын тооллогын дүнгийн судалгаа болон Үндэсний музейгээс алдагдсан үзмэрийн шинэчилсэн судалгаа авч нэгтгэн алдагдсан үзмэрийн судалгааг шинэчлэв.

Хамтарсан эрдэм шинжилгээний хурал зохион байгуулсан тухай

Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам, ЮНЕСКО-гийн Монголын үндэсний хороо, Соёлын өвийн төв, Монгол Улсын Их сургууль, Монголын Үндэсний музей хамтран “Монголын соёлын өвийн хадгалалт хамгаалалт, тулгамдсан асуудлууд” сэдэвт эрдэм шинжилгээний бага хурлыг 2015 оны 05 дугаар сарын 12-ны өдөр МУИС-ийн нэгдүгээр байрны Эрдмийн дугуй зааланд зохион байгуулав.

Эрдэм шинжилгээний бага хуралд Архивын ерөнхий газар, ШУА-ийн Түүх, археологийн хүрээлэн, Үндэсний номын сан, Монголын Үндэсний музей, Богд хааны ордон музей, Шинжлэх ухааны технологийн Их сургуулийн соёл судлалын тэнхим, Улаанбаатар их сургууль, Дэлхийн өв-Орхоны хөндийн соёлын дурсгалт газрын хамгаалалтын захиргаа зэрэг соёлын өвийг хадгалагч, харилцагч байгууллагууд, эрдэмтэн судлаачдын төлөөллүүд оролцлоо.

Хурлын эхэнд төрөөс соёлын өвийн талаар баримталж буй бодлогын талаар БСШУЯамны Соёл урлагийн бодлого зохицуулалтын газрын дарга Д.Гантөмөр, Соёлын өвийн хэлтсийн дарга С.Урантөгс, Соёлын өвийн хадгалалтын олон улсын хэм хэмжээний талаар ЮНЕСКО-гийн Монголын Үндэсний комиссын Ерөнхий нарийн бичгийн дарга Г.Жаргалсайхан, Соёлын

өвийг хадгалж хамгаалахад Соёлын өвийн төвийн гүйцэтгэж буй үүрэг оролцоо чадавхийн талаар Соёлын өвийн төвийн захирал Г.Энхбат, Соёлын өвийн хадгалалт хамгаалалтад иргэний нийгэм, төрийн бус байгууллагуудын үүрэг, оролцооны талаар Н.Уртнасан нар тус тус илтгэв.

Эрдэм шинжилгээний бага хуралд тус хэлтээс Д.Нарантуяа, Б.Алтансүх, Ш.Энхтуяа, Г.Анхсанаа нар идэвхтэй оролцож Соёлын өвийн бүртгэл, мэдээллийн сан бүрдүүлэлт, соёлын өвийн бүртгэлд 3D технологи нэвтрүүлэх тухай, музейн тооллого, үл хөдлөх дурсгалын бүртгэн баримтжуулалт зэрэг сэдвүүдээр илтгэл тавьсан. Эрдэм шинжилгээний бага хуралд судлаачид, эрдэмтэд соёлын өвийн хадгалалт, хамгаалалтын байдал, тулгамдаж буй асуудлын талаар нийт 19 илтгэл тавьж, хэлцэгдлээ.

Тавигдсан илтгэлүүдээр хэлэлцүүлэг явуулж цаашид соёлын бүтээлч үйлдвэр хөгжүүлэх, соёлын өвийг аялал жуулчлалтай холбогдуулан хадгалалт хамгаалалтыг сайжруулах, олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх талаар нэгдсэн санал зөвлөмжийг боловсруулан БСШУЯам болон холбогдох дээд байгууллагуудад хүргүүлэхээр тогтов. Хуралд оролцогчдын илтгэлүүдийг нэгтгэн хэвлэж, олон нийтэд тараана.

Сургалтанд хамрагдсан талаар:

БСШУЯамнаас 2015 оны 05 дугаар сарын 22-23-ны өдрүүдэд зохион байгуулсан “Соёл урлагийн менежмент ба бүтээлч үйлдвэрлэл” сэдвийн хүрээнд соёл, урлагийн удирдах ажилтны сургалт, семинарт захирал Г.Энхбат, хэлтсийн дарга Д.Нарантуяа нар хамрагдав.

Монгол Уг сургалтаар соёлын үйлдвэрлэлийг хөгжүүлэх бодлого, хэрэгцээ шаардлага гарч буйтай холбогдуулан соёл, урлагийг эдийн засгийн эргэлтэд оруулах, соёлын бүтээлч үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд байгууллагын стратеги төлөвлөгөөг боловсруулах арга зүйн хичээлүүдийг заасан.

БСШУЯам, Монголын соёл, урлагийн академи, Улаан-Үд хотын Дорно дахины соёлын дээд сургуультай хамтран 2015 оны 8 дугаар сарын 16-20-ны өдрүүдэд зохион байгуулсан “Байкал-2015” сургалтад хэлтсийн дарга Д.Нарантуяа оролцов.

Түүх, соёлын хосгүй үнэт дурсгалын каталог ном хэвлүүлэх төсөл боловсруулсан тухай

Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 8.2; 8.3; 13.1.8 дахь заалтын дагуу Монгол Улсын Засгийн газрын шийдвэрээр 1995-2013 онуудад улсын болон аймаг орон нутгийн музей, Үндэсний номын сан, Эрдэнэсийн сан, эрдэм шинжилгээний хүрээлэн, сүм хийд зэрэг 26 газруудад хадгалагдаж байгаа 776 үзмэр, эд өлгийн зүйлийг “Түүх, соёлын хосгүй үнэт дурсгалт зүйл”-ийн зэрэглэлд батлагджээ.

Түүх, соёлын хосгүй үнэт зэрэглэлийн дурсгалуудад өвөг дээдсийн билэг оюун ухаан, гайхамшигт ур чадвараар бүтээгдэн, үеэс үед өвлөн уламжлагдан ирсэн тэрхүү түүх, соёлын нандин их өвийн дээжис хамрагдсан байдаг.

Хосгүй үнэт дурсгалт зүйлийн зэрэглэлд хамрагдсан үзмэр, эд өлгийн зүйлсийг олон нийтэд хүргэх, гадаад, дотоодод монгол соёлын өвийг сурталчлахад тэдгээрийг нэгтгэн танилцуулсан ном хэвлэл чухал юм.

Музей, сүм хийд, эрдэм шинжилгээний хүрээлэн, их сургууль, номын сан, эрдэнэсийн сан зэрэг газруудад байгаа түүх, соёлын хосгүй үнэт дурсгалуудыг нэгтгэн танилцуулсан ном урьд өмнө хэвлэгдэж байгаагүй юм.

Соёлын өвийн төвийн *www.monheritage.mn* вебсайтад түүх, соёлын хосгүй үнэт зэрэглэлд баталсан тухай Засгийн газрын 1995-2013 оны тогтоол шийдвэр, түүний хавсралтууд, хосгүй үнэт дурсгалуудын гэрэл зураг (бага пикселтэй оруулсан), тоон үзүүлэлт, төрөл зүйлийн тухай цахим мэдээллүүд байдаг. 2014 онд хэвлэгдсэн “Монголын музейн шилдэг үзмэрийн дээжис” цуврал гэрэл зургийн цомогт зөвхөн музейд байгаа хосгүй үнэт дурсгалуудын талаар товч мэдээлэл оруулжээ.

Өнөөгийн даяаршиж буй дэлхий ертөнцөд Монгол үндэстэн, угсаатны язгуурыг илтгэх түүх, соёлын нандин их өвийн дээжисийг судлан шинжилж, сурталчилан таниулж, хадгалж хамгаалах нь бидний эрхэм зорилгын нэгэн билээ. Уг каталогийг хэвлүүлснээр:

- Түүх, соёлын хосгүй үнэт дурсгалуудын талаарх товч мэдээлэл, тодорхойлолтыг агуулсан, гэрэл зураг бүхий ном болгон монгол, англи хэлээр хэвлэж, олон нийтэд түгээх нь Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 49.2.3 дахь заалтыг хэрэгжүүлж соёлын өвийг хамгаалах, сурталчлан таниулахад чухал ач холбогдолтой болно.

- Соёлын өвийг ил тод, нээлттэй сурталчилж, хэрэв алга болсон, хулгайд алдагдсан тохиолдолд Монгол Улсын бүртгэл, өмчлөлд байгааг нотолсон баримт болох юм.

Түүх, соёлын 776 хосгүй үнэт дурсгалыг багтаасан ном нь дурсгалын гэрэл зураг ба тодорхойлолт текстээс бүрдсэн, монгол англи хэл дээр байна. Уг ном В4 хэмжээтэй ба хатуу хавтастай, гадуур давхар цаасан /клише/ хавтастай, 2 цуврал хэсгээс бүрдсэн 200 сая төгрөгийн төсөвт өртөгтэй төслийг боловсруулан БСШУЯаманд 2015 оны 5-р сард өргөн барьсан.

Түүх, соёлын үл хөдлөх дурсгалын хүрээнд:

Түүх, соёлын үл хөдлөх дурсгалыг хамгаалах, сэргээн засварлах хөтөлбөрийн 7.2-т тусгагдсаны дагуу Соёлын өвийн төвөөс Завхан аймгийн Шилүүстэй сумын нутагт орших Дааган дэлийн буган чулуун хөшөө, Баянхонгор аймгийн Эрдэнэцогт сумын нутагт орших Шатар чулууны цогцолбор дурсгалд тайлбартай чулуун самбар энэ онд байрлуулах бөгөөд дээрх 2 дурсгалын товч тайлбарыг боловсруулсан.

ДААГАН ДЭЛИЙН БУГАН ЧУЛУУН ХӨШӨӨ

Монгол орны хүрэл зэвсгийн үеийн (нтө III-I мянган жил) гол дурсгал бол буган чулуун хөшөө билээ. Завхан аймгийн Шилүүстэй сумын нутагт орших Дааган дэлийн буган чулуун хөшөө нь түүх, соёл, урлаг уран сайхан, шинжлэх ухааны ач холбогдол бүхий соёлын өв юм.

Дааган дэлийн 8 буган чулуун хөшөөнд бугыг загварчлан дүрсэлснээс гадна шүтлэг бишрэлийг харуулсан нар, сар, онги тамга болон эртний дайчдын хэрэглэл болох бүс, бамбай, нум, хутга зэрэг зэр зэвсгийг тодорхой харуулсан байна.

Түүх, соёлын дурсгалаа хайрлан хамгаалцгаая !!!

ШАТАР ЧУЛУУНЫ ЦОГЦОЛБОР ДУРСГАЛ

Баянхонгор аймгийн Эрдэнэцогт сумын нутагт орших Шатар чулууны цогцолбор дурсгал нь хүрэл зэвсгийн үеийн (нтө III-I мянган жил) буган чулуун хөшөө, хиргисүүр, дөрвөлжин булш, дугуй далантай булш болон эртний Түрэгийн үеийн (нт VI-VIII зуун) хүн чулуун хөшөө, чулуун арслан, зэл чулуу зэрэг түүхийн олон үеийн дурсгал нэг дор оршдог дурсгалт газар билээ.

Шатар чулууны цогцолбор дурсгал нь эртний нүүдэлчдийн шүтлэг бишрэл, гоо зүй, угсаа гарвал зэргийг харуулах шинжлэх ухаан, танин мэдэхүйн ач холбогдолтой соёлын өв юм.

Түүх, соёлын дурсгалаа хайрлан хамгаалцгаая !!!

Соёлын баримтат өвийн талаар:

БСШУЯамны Соёлын өвийн хэлтсийн соёлын баримтат өв хариуцсан мэргэжилтэн Д.Бямбасүрэнгээс үүрэг болгосны дагуу хэлтсийн дарга Д.Нарантуяа нь Монголын Үндэсний номын сангийн Д.Тунгалаг Х.Түмэнбаяр, Т.Баярлах нарын мэргэжилтэнгүүдтэй хамтран “Соёлын баримтат өвийн үндэсний хөтөлбөр”-т заасны дагуу баримтат өвийг бүртгэх арга зүй, сургалт зохион байгуулах хөтөлбөрийг боловсруулан 2015 оны 10-р сарын 30-нд БСШУЯаманд хүлээлгэн өгөв.

Төрийн түүхийн музейн шалгалтын бүрэлдэхүүнд ажилласан тухай:

Засгийн газрын хэрэг эрхлэх газрын тэргүүн дэд дарга (Ш.Солонго)-ын баталсан “Шалгалтын удирдамж”-ийн 2-т заасан ажлын хэсгийн бүрэлдэхүүнд тус төвийн Сэргээн засварлах хэлтсийн дарга С.Чинзориг, Биет соёлын өвийг хамгаалах хэлтсийн дарга Д.Нарантуяа нар орж, “...Төрийн түүхийн музейн эзэмшилд байгаа түүх соёлын биет өв, дурсгалт зүйл сан хөмрөгийн хадгалалт хамгаалалт ашиглалттай холбогдсон норм стандартын хэрэгжилттэй танилцаж дүгнэлт гаргах”-д 2015 оны 11-р сарын 13-наас 18-ны өдрүүдэд ажиллав.

Шалгалтаар Соёлын тухай хууль, Соёлын өвийг хамгаалах тухай хууль, MNS: 5634-2006 МУ-ын стандартын 12 дугаар зүйл музейн сан хөмрөгт тавигдах шаардлагыг хэрэгжүүлэх талаар авсан арга хэмжээний талаар үнэлэлт дүгнэлт хийх зорилгоор уг шалгалтын удирдамжийн 1.в-д заасан “Музейн бүртгэл, мэдээллийн сан болон сан хөмрөгт бүртгэгдэн хадгалагдаж байгаа түүх, соёлын биет өв, дурсгалт зүйлийн бүрэн бүтэн байдал, сан хөмрөгийн бүрдүүлэлт,

цуглуулгын нөхцөл байдалд үнэлэлт, дүгнэлт өгөх, сан хөмрөгийн бүртгэл, баримтжуулалт, хадгалалт хамгаалалтын норм стандартын шаардлага журмыг хангаж байгаа эсэх үзэж үнэлэлт дүгнэлт өгөх”-ийг гол чиглэл болгон, зохих дүгнэлтийг гарган Засгийн газрын хэрэг газарт хүлээлгэн өгсөн.

Монголын Барилгын Үндэсний Ассоциацитай хамтран ажилласан тухайд:

БСШУЯамны 2015 оны 10/9107 албан тоот, мөн Монголын Барилгын Үндэсний Ассоциацийн 2015 оны 15/2016 албан тоотод заасныг тус тус үндэслэл болгон “Их тэнгэр” цогцолборын Хан-Уул харш, Хатан Туул зочид буудал, Маршал харшийн барилгуудын шинэтгэл, засварын ажлыг гүйцэтгэх Монголын Барилгын Үндэсний Ассоциацийн хүсэлтийн дагуу сэргээн засварлах хэлтсийн дарга С.Чинзориг, Биет өвийг хамгаалах хэлтсийн дарга Д.Нарантуяа нар 2015 оны 11 дүгээр сард дээрх барилгуудын дотор тааз, ханын чимэглэлийг хамгаалах, сэргээн засварлах, түүх, соёлын дурсгалт зүйлийг бүртгэн баримтжуулахад мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгч ажиллав.

Тус цогцолборын Хан-Уул харш, Маршал харш 1940-1950 оны үед баригдсан ба барилгын дотор тааз монгол хээ чимэглэл зурагтай юм. Уг барилгууд “улс”, “аймаг”, “нийслэлийн” хамгаалалтад байх жагсаалтад ороогүй, 2015 оны үл хөдлөх дурсгалын үзлэг тооллогоор зөвхөн Маршалын өргөө барилга нь хамрагдсан байна.

Барилгын гадна тал европ загвартай, дотор талын хана хаалга таазны хэсгүүдийг үндэсний хээ угалзаар чимэглэсэн чимэглэл нь анхны байдлаараа хадгалагдан үлджээ. Дээрх хоёр барилгын хана хаалга, таазны хээ угалзан чимэглэл, таазны хэсэгт зурагдсан уран зургуудыг Монголын орчин үеийн дүрслэх урлагийн үүсэл хөгжлийн эхэн үеийн бүтээлүүдэд хамруулж үзэж болохоор цогц байдлаараа бүрэн бүтэн үлдсэн түүх, соёлын дурсгалууд гэж үзэж байна.

Эдгээр барилгуудад засварын ажил хийх явцад барилгын дотор талын хана таазны засал чимэглэлүүдийн анхны төрх байдлыг алдагдуулахгүй, өөрчлөхгүйгээр хийх хэрэгтэй гэж үзэж байна.

Хэрэв зайлшгүй тохиолдлоор өөрчлөлт оруулах шинэчлэх шаардлагатай гэж үзвэл Соёлын өвийг хамгааалах тухай хуулийн 46-р зүйлийн 46.2 заасны дагуу БСШУЯамны дэргэдэх Мэргэжлийн зөвлөлд хандаж зохих дүгнэлт гаргуулж ажиллахыг, мөн цогцолборт Уран зургийн галерейд бүртгэлтэй уран зургуудаас /34 ш/ гадна санхүүгийн бүртгэл дэх маршал Х.Чойбалсангийн эдэлж, хэрэглэж явсан ширээ тавилга, эд зүйлс, бусад түүх, соёлын холбогдох зүйлсийг “Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйл”-ийн бүртгэлийн маягтын дагуу бүртгэн, гэрэл зургаар баримтжуулахыг зөвлөв.

Бусад ажлын талаар:

- ЮНЕСКО-гоос дэмжлэгээр 2015 оны 10 дугаар сард зохион байгуулсан Шороон бумбагарын бунхант булшны ханын зургийг бэхжүүлэх сургалтын төлөвлөгөө, төсвийг мэргэжилтэн Г.Анхсанаа боловсруулан ажилласан.
- Байгууллагад ирсэн хүсэлтийн дагуу Хүннүгийн үед холбогдох 83 археологийн дурсгалд тодорхойлолтыг мэргэжилтэн Ш.Энхтуяа бичиж хүлээлгэн өглөө.
- Өвөрхангай аймгийн Боловсрол, соёлын төвөөс “Бид соёлынхон” ур чадварын тэмцээнийг аймгийнхаа хэмжээнд Соёлын төвийн ажилтан, Номын сан, Музейн ажилтнууд дунд үе шаттай зохион байгуулж зохион байгуулсан байна. Зохион байгуулагчдаас санал болгосны дагуу музейн ажилтнуудын ур чадварын тэмцээнийг хэрхэн зохион байгуулах, шалгалтын тест боловсруулах ажлыг хамтран хийж, тэмцээний ерөнхий шүүгчээр газар дээр нь хэлтсийн мэргэжилтэн Ш.Энхтуяа очиж ажиллалаа. Тэмцээнд аймгийн музей болон Эрдэнэ-зуу музейн 10 ажилтан оролцсон ба гурван хэсэгтэй зохион байгуулсан. “Соёлын үйлчилгээг үзэгчдэд хүртээмжтэй болгох” сэдвийн дор илтгэл тавих, “Музейг хэр мэдэх тухай” тестийн шалгалт, бодит үзмэр дээр “Тайлбар хийлгэж” ур чадварыг сорьсон.

БҮТЭЭГДЭХҮҮН НИЙЛҮҮЛЭХ АНГИ-2. СОЁЛЫН БИЕТ БУС ӨВИЙГ ХАМГААЛАХ ХЭЛТСИЙН СТРАТЕГИЙН ЗОРИЛТЫГ ХАНГАХАД ЧИГЛЭСЭН АЖИЛ, ҮЙЛЧИЛГЭЭ

Энэ төрлийн ангид 1 тусгай арга хэмжээ, 7 үндсэн арга хэмжээ нийт 8 төрлийн ажил багтсан болно.

ТУСГАЙ АРГА ХЭМЖЭЭ

ЮНЕСКО-д 2016 онд нэр дэвшүүлэх “Хөхүүрийн монгол айраг исгэх зан үйл” СББӨ-ийн хэрэглэгдэхүүн боловсруулах, илгээх

Монгол Улсаас ЮНЕСКО-гийн Хүн төрлөхтний соёлын биет бус өвийн Төлөөллийн жагсаалтад нэр дэвшүүлж буй “Хөхүүрийн монгол айраг исгэх зан үйл”-ийн хэрэглэгдэхүүнийг Байгаль, соёлын өвийг хамгаалах сангийн тэргүүн Н.Уртнасантай хамтран монгол, англи хэлнээ 28 хуудас материалыг 10 минутын богино хэмжээний танилцуулга киноны хамт боловсруулан 2015 оны 3 дугаар сарын 26-ны өдөр илгээсэн болно.

2014 оны ЮНЕСКО-гийн Засгийн газар хоорондын Хорооны “Үйл ажиллагааны удирдамж”-ийн шинэчлэлийн дагуу 10-аас дээш СББӨ-ийн зүйл бүртгүүлсэн оролцогч улс орнуудын ССБӨ-ийн Төлөөллийн жагсаалтад нэр дэвшүүлж буй баримт бичгийг 2 жил тутамд нэг өвийн зүйл авч хэлэлцэх зааврыг үндэслэн Монгол Улсаас нэр дэвшүүлж буй энэхүү СББӨ-ийн зүйлийг 2017 онд болох Засгийн газар хоорондын 11 дүгээр хуралдаанаар хэлэлцэх болсоныг ЮНЕСКО-гийн Ерөнхий нарийн бичгийн дарга нарын Газраас албан ёсоор мэдэгдэв.

Мөн нэр дэвшүүлэх баримт бичиг, хэрэглэгдэхүүн боловсруулах ажлын хүрээнд 2015 оны 7 дугаар сард “Хөхүүрийн монгол айраг исгэх зан үйл”-ийн чиглэлээр дараах судалгааны ажлыг гүйцэтгэв. Үүнд:

- 2015 оны 7-р сарын 18-наас 19-ний өдрүүдэд Булган аймгийн Сайхан сумын “Дөрвөн түмэн адууны баяр”-т оролцож судалгааны ажлыг гүйцэтгэв. “Монгол хөхүүрийн айраг исгэх зан үйл”-ийн уламжлалт зан арга барил, технологийг хадгалж хамгаалах, холбогдох зан үйлийн хайгуул судалгаа хийх зорилгоор Булган аймгийн Сайхан сумын нутаг-Бөөрийн хөндий хэмээх газар нутаглаж буй малчин н.Пүрэвсүрэн тэргүүтэй хот айлд очиж “Монгол хөхүүрийн айраг исгэх зан үйл”-н уламжлалт зан үйлийг төрөлжсөн бүртгэл-мэдээллийн сан бүрдүүлэх, судалгаа хийх зорилгоор айраг исгэх зан үйл, айрагтай холбоотой бусад зан үйл, мал аж ахуйн тоног хэрэгсэл, ардын уламжлалт зан үйл, айрагтай холбоотой аман яриа, домог зэргийн тухай гэр бүлийн хүрээнд ярилцлага хийж тэмдэглэл, зураг авалт хийв. Энэхүү ажлын хүрээнд “Хамгийн сайхан айраг шалгаруулах тэмцээн”, “Адуунд явах”, “Адуу хураах”, “Унага барих”, “Гүү саах”, “Саамны дээж өргөх”, “Айрагны хөрөнгө авах” зан үйлийн талаар нийт 5 цагийн дүрс бичлэг болон 160 ширхэг зураг авч бүртгэн баримтжуулсан болно.

- 2015 оны 7-р сарын 26-ны өдөр Өвөрхангай аймгийн Хархорин сумын нутагт зохион байгуулагдсан Өндөр гэгээн Занабазарын түмэн өлзий гийсний 380 жилийн ойн Даншигийн Их баяр наадамд зориулан хийх "Өндөр Гэгээний төрсний ойн даншиг Их баяр наадамд Хөхүүрийн монгол айрагны дээжээр мялаалга өргөмүй" хэмээх мялаалгын үйл ажиллагаанд оролцож судалгааны ажлыг гүйцэтгэв. Мялаалгын үйл ажиллагаа нь "Хөхүүрийн шилдэг айраг" шалгаруулах уралдаан, шилдэг айраг шалгаруулах уралдааныг зохион байгуулах болон Хөхүүрийн айргийг хийх, хэрэглэх талаар үлгэр жишээ ажиллаж байгаа сумдыг шалгаруулах уралдаан, мялаалгын үйл ажиллагааны нээлт, хаалтын үйл ажиллагаа зэргээс бүрдсэн болно.

Уг арга хэмжээг соёлын өвийн төвийн биет бус өвийг хамгаалах хэлтэс хамтран зохион байгуулж үйл ажиллагааг бүртэн баримтжуулж 325 гэрэл зураг, 16 цагийн видео бичлэгийг хийж бүртгэл мэдээллийн санг баяжуулсан.

Айргийн баяр, мялаалгын ёслолын үйлажиллагааг зохион байгуулах хороог Ч. Сосорбарамаар ахлуулан 10 хүний бүрэлдхүүнтэй байгуулж ажиллав. Хороо бэлтгэл хангах тодорхой төлөвлөгөөгаргаж идэвхи санаачлагатай ажиллав. Тухайлбал, Мялаалгын үйл ажиллагаа, хөхүүрийн айрагны баярын тухай танилцуулга, хөхүүрийн шилдэг айраг хийдэг айл өрх шалгаруулах болзол, шилдэг сумдыг шалгаруулах уралдааны болзол, мөн шалгаруулах шүүгчдийн ажиллах журмыг боловсруулан баталж ажиллав. Хорооны гишүүд 5 аймгийн 16 суманд томилолтоор ажиллаж айргийн баяр, уралдаанд яаж оролцох талаар тайлбарлан танилцуулж бэлтгэлийг хангуулснаар баяр, уралдаанд 4 аймгийн 13 сум, 33 айл өрх оролцсон нь хөхүүрийн айраг хийдэг бүх аймаг сумдын 70% орчим хувийг хамарсан байна.

Хөхүүрийн айргийн энэ баяр, уралдаан юуны өмнө "Хөхүүрийн шилдэг айраг" хийж хэрэглэдэг айл өрхийг шалгаруулах уралдаанаар эхэлсэн юм. Уралдаанд айл өрх бүр 200 л айраг хөхүүрэндээ авчирч түүнээсээ амталгаанд өгч шалгаруулалтанд оруулсан болно. Уралдаанд дараах айл өрхүүд I, II, III байрт шалгарч "Өргөмжлөл", болзолд заасан мөнгөн шагналаар шагнуулав.

Үүнд:

Хамгийн шилдэг сайхан айрагтай шалгарсан айл өрх

I-р байр

Д. Энхбаяр /Архангай аймгийн Хотонт сум/

II-р байр

Ч. Лхагвасайхан /Булган аймгийн Могод сум/

Б. Ганболд /Өвөрхангай аймгийн Өлзийт сум/

III-р байр

Б. Шаарав /Өвөрхангай аймгийн Өлзийт сум/

П. Жаргалсайхан /Өвөрхангай аймгийн Төгрөг сум/

Т. Мягмарчулуун / Өвөрхангай аймгийн Сант сум/

Б. Ганзул / Өвөрхангай аймгийн Бүрд сум/

Ж. Цэндсүрэн / Өвөрхангай аймгийн Есөнзүйл сум/

Хөхүүрийн айраг хийх уламжлалыг сайн хөхиүлэн дэмжиж, уралдааныг сайн зохион

байгуулсан сумдыг хөхүүрийн айраг хийдэг айл өрхийн тоо, уралдаанд оролцсон айл өрхийн тоо, уралдаанд шалгарсан айл өрхийн тоо, хөхүүр болон айраг, хөхүүртэй холбоотой эд зүйл, гар урлалын зүйлс, мөн айрагтай холбоотой найр, зан үйл, биет бус соёлын өвийг уламжлан дэлгэрүүлж байгаа байдал зэрэг шалгууруудаар байр эзлүүлэн болзолд заасны дагуу "Өргөмжлөл" олгож мөнгөн шагналаар урамшуулав.

Үүнд: Хөхүүрийн айраг хийж хэрэглэдэг "шилдэг сум"-аар шалгарч байр эзэлсэн сумд

I-р байр
Өвөрхангай аймгийн Өлзийт сум

II-р байр
Төв аймгийн Дэлгэрхаан сум

III-р байр
Өвөрхангай аймгийн Сант
Өвөрхангай аймгийн Бүрд
Өвөрхангай аймгийн Хужирт

Шилдэг сайхан хөхүүр шалгаруулалт
1-р байр Өвөрхангай.Хужирт Ц.Анхбаяр
2-р байр Өвөрхангай Өлзийт Б.Шаарав
3-р байр Өвөрхангай Сант Ч.Батлут

Уран дэмбээч шалгаруулалтанд
1-р байр Өвөрхангай Өлзийт С.Батдэлгэр
2-р байр н.Чулуун
3-р байр Өвөрхангай Хархорин Ч.Далхаа

Зохион байгуулах хорооны гишүүд 5 аймгийн 16 суманд томилолтоор ажиллаж айргийн баяр, уралдаанд яаж оролцох талаар тайлбарлан танилцуулж бэлтгэлийг хангуулснаар баяр, уралдаанд 4 аймгийн 13 сум, 33 айл өрх оролцсон нь хөхүүрийн айраг хийдэг бүх аймаг сумдын 70% орчим хувийг хамарсан байна.

2.1. "Шувуучлахуй" СББӨ-ийг сурталчлах, хамгаалах, судалгаа хийх

ЮНЕСКО-д бүртгүүлсэн соёлын биет бус өвийн тайланг илгээхэд зориулсан баримтат кино хийх тухай Боловсрол, Соёл, шинжлэх ухааны яамны Төрийн нарийн бичгийн даргын 2015 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн А/146 дугаар тушаал, ЮНЕСКО-д 2011 онд бүртгэгдсэн "Шувуулахуй"-н олон төрөл зүйлийг судлах, бүртгэл мэдээллийн сан бүрдүүлэх тухай Соёлын өвийн төвийн захиралын А/34 дүгээр тушаалыг хэрэгжүүлэх Анч шувуугаар ан агнуулах спорт, урлагийн талаар таниулах, сурталчилах, мартагдсан өв соёлоо сэргээх, олон улсын анч шувуу сонирхогчтой харилцан туршилга солилцох, Монгол шувуулахуйн онцлогийг харуулах зорилгоор зорилгоор БСШУЯам, Соёлын өвийн төв, Монголын шувуулахуйн холбоотой хамтран 2015 оны 8 дугаар сарын 21-25-ны өдрүүдэд Чингисийн хүрээ аялал жуулчдын баазад Шувуулахуйн олон улсын наадам, олон улсын эрдэм шинжилгээний бага хурлыг анх удаагаа Монгол улсад амжилттай зохион байгууллаа.

Уг наадамд БНХАУ, Пакистан, Казахстан, Узбэкистан, Киргизтан, Катарын Алганнас шувуулахуйн холбоо мөн олон улсын Шувуулахуйн Холбоо зэрэг гадаад дотоодын 30

орчим төлөөлөгч хүрэлцэн ирж оролцлоо.

Мөн тус үйл ажиллагааны хүрээнд Монголын шувуулахуйн холбоотой хамтран “Монгол шувуулахуйн уламжлалт зан үйл”-ийн төрөлжсөн бүртгэл-мэдээллийн сан бүрдүүлэх хээрийн хамтарсан “ өдрийн хайгуул судалгааг Төв аймгийн Баян сум, Булган аймгийн Могод сум, Их тэнгэрийн ам болон Гачуурт аманд хийв.

Түүнчлэн Анч шувуугаар ан агнуулах Монгол шувууулахуйн онцлогийг харуулах, тасарсан өв соёлоо сэргээх, хойч үедээ өвлүүлэх, сурталчилах, түгээн дэлгэрүүлэх зорилгоор богино хэмжээний танин мэдэхүйн баримтат-уран сайхны киног БСШУЯ-ны санхүүжилтээр гүйцэтгэж 2015 оны 12 дугаар сарын 01-ны өдөр Соёлын өвийн төвийн 238 тоот албан бичгээр “Монгол шувуулахуй” шинжлэх ухааны бэсрэг баримтат киног БСШУЯ-нд хүргүүлсэн болно. Нийт 22 минутын киноны агуулгыг дараах байдлаар бүлэглэссэн болно. Үүнд:

1. Анч шувуудын төрөл зүйл
2. Монгол анч шувууд төрөл зүйл
3. Монгол шувуулахуй түүх болон түүх-археологийн олдворууд
4. Монгол шувуулахуйн бэлгэдэл, нийгмийн ач холбогдол
5. Орчин цагийн Монгол шувуулахуй

Тус киног бүтээх явцад Соёлын өвийн улсын бүртгэл мэдээллийн санд нийт 2 цаг 35 минутын хар дүрс болон 350 ширхэг гэрэл зураг бүхий баримтжуулалт хийж архивлав.

“Монгол шувуулахуй” киног бүтээснээр мартагдаж бүй өв соёлыг шувуу судлал, түүх, археологи, билэгдэл зүй зэрэг олон өнцгөөс тухайн СББӨ-ийг сурталчилан таниулав.

Соёлын өвийн төвөөс “Шувуулахуй” наадмын хүрээнд 2015оны 08 сарын 21нд Занабазарын музейд болсон “Монгол шувуулахуй” үзэсгэлэнг (Гэрэл зургийн үзэсгэлэн,

Уран, зураг, баримал, гар урлалын үзэсгэлэн, Шувуулахуй урлагийг харуулсан Д.Отгонсайханы чихмэлийн бие даасан үзэсгэлэн, Анч махчин шувуудын амьд үзэсгэлэн) дуу, дүрс бичлэгээр баримтжуулж нийт 1цагийн дүрс, 100 зураг архивлав.

Уг үзэсгэлэн нь улс үндэстэнүүдийн шувуулахуйн уламжлал болон хөгжлийн түвшинг харуулсан мөн анч махчин шувуудын төрөл зүйл ааш араншингийн тухай өргөн хүрээнд ойлголт өгсөнөөрөө онцлогтой болов.

Чингисийн хүрээ цогцолборт “Шувуулахуйн” наадамын нээлтийн үйл ажиллагаа, Эрдэм шинжилгээний хурал, Анч шувуудын үзүүлбэр, Тайга, анч нохдын үзүүлбэр, Наадамд зориулсан хүчит бөхийн барилдаан, Монголын морьт хараачдын үзүүлбэр, “Морьтны гайхамшиг” морин циркийн үзүүлбэрүүдийг баримтжуулж 2 цагийн дүрс, 200 зураг архивлав.

Төв аймгийн Баян суманд шувуулахуйн хиймэл үүр тойрох үйл ажилгаатай газар дээр нь очиж танилцан үйл ажиллагааг баримтжуулж 30 минутын дүрс 50 зураг архивлан наадмын үйл ажиллагааны хүрээнд нийт 210 минутын дүрс бичлэг, 350 орчим гэрэл зураг авч соёлын өвийн УНБМСанг баяжуулсан байна.

Энэхүү наадамыг Шувуулахуйн олон улсын эрдэм шинжилгээний хурал, “Шувуулахуйн

урлаг” сэдэвт үзэсгэлэн, Шувуулахуйн олон улсын соёлын наадам, Хээрийн аялал зэрэг өргөн цар хүрээтэй зохион байгуулснаар олон улсын эрдэмтэн судлаач, өвлөн уламжлагч нар өөрсдийн туршлага, мэдлэгээ солилцох, мөн 2003 оны Соёлын биет бус өвийг хамгаалах тухай Конвенцийн зарчмын дагуу улс хоорондын харилцан ойлголцол, хамтын ажиллагаанд жинтэй хувь нэмэр оруулсан нэн чухал ач холбогдолтой арга хэмжээ боллоо.

Оролцогчдын зүгээс тус арга хэмжээг үндэсний болон олон улсын хэмжээнд уламжлал болгон зохион байгуулах нь зүйтэй хэмээн дүгнэж байв

2.2. “Лимбэний битүү амьсгаа” СББӨ-ийг хамгаалах, сурталчлах

“ЮНЕСКО-гийн яаралтай хамгаалах шаардлагатай соёлын биет бус өвийн жагсаалт”-д 2011 онд бүртгэгдсэн Лимбэний битүү амьсгааны төрөл зүйлийг хадгалж хамгаалах, түгээн дэлгэрүүлэх тухайн өвийг сурталчлах, сургалт явуулах таатай орчин нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор Хөгжим бүжгийн Коллеж, Монголын театрын музейтэй хамтран 2015 оны 04 сарын 08-нд шавь сургалтын 2 танхимийг тохижуулах, сургалт явуулах өрөө танимыг бэлдэх ажлыг зохион байгуулсан.

Хөгжим бүжгийн Коллежид Алдартгавьяат хөгжимчин, Лимбэч, Шударгач Лувсандоржийн Цэрэндоржийн нэрэмжит №311 тоот танхимийг 7 төрлийн гэрэл зураг /түүхэн/, , ЮНЕСКО-гийн батламжийг жаазлан, 1 лимбэ хөгжмийн хоргонд хийж тус өрөөг тохижуулсан. Одоогийн байдлаар 2 багшийн 20 орчим сурагчид энэ өрөөнд байнгын хичээл, сургуулалтыг хийж байгаа ба телевизийн нэвтрүүлэг, гадаад дотоодын зочид төлөөлөгчдөд тус өрөөг ашиглан Лимбэний битүү амьгааны бэсрэг тоглолт, танилцуулга зэргийг хийж сургуулийнхаа үлгэр жишээ танхим болсон байна.

Монголын театрын музейд болсон сургалтын танхим, үзэсгэлэнгийн нээлтэд УГЖ, лимбэч Батжаргал, СӨТ-ийн ББСӨХ-ийн дарга Жаргалсайхан нар үг хэлж битүү амьсгааны гайхамшгийг эзэмшсэн лимбэч Л.Цэрэндорж, Л.Маам, М.Дорж, М.Бадам, Д.Галсантогтох, Ө.Батжаргал нарын гавьяат лимбэчид болон тэдний шавь нарыг олон нийтэд сурталчлах зорилгоор тус музейд “Лимбэний сургалтын танхим” нээж, Лимбэ, лимбэчдийн гэрэл зургийн үзэсгэлэнг зохион байгуулсан.

Битүү амьсгааны гайхамшгийг эзэмшсэн лимбэчдээс дурдвал Л.Цэрэндорж, Л.Маам, М.Дорж, М.Бадам, Д.Галсантогтох, Ө.Батжаргал нарын гавьяатыг нэрлэж болно. Дээрх лимбэчид болон тэдний шавь нар, ХБК-ийн сурагчид нээлтэнд оролцож лимбэний битүү амьсгааны гайхамшгаас тоглон үзүүлж СУИС-ийн багш Цэвэгсүрэн Битүү амьсгааны онцлогийг судлах асуудалд илтгэл тавьлаа.

Монголын театрын музейд 30х40 хэмжээтэй 10 гэрэл зураг, “Битүү амьсгал, битүү хөгөөр лимбэдэхүй–2014” баримтат киног нээлтийн үеэр гаргаж сурталчилсан.

Olloo телевизийн “Өв соёл” нэвтрүүлгээр “Лимбэний битүү амьсгаа”-ны үүсэл гэрэл, онцлогийн талаар ХБК-ийн Лимбэний багш Г. Нямжанцан, СУИС-ийн багш Ц. Цэвэгсүрэн нар оролцож олон нийтэд сурталчилсан.

2.3. Урианхайн соёлын олон төрөл зүйлийн судалгаа хийх

2015 оны 6 дугаар сарын 26-наас 7 дугаар сарын 9-ний өдрүүдэд Ховд аймгийн Жаргалант, Дуут, Буянт, Мөнххайрхан суманд Урианхайн соёлын баяр ёслол, уламжлалт мэдлэг ухааны төрөл зүйлийн хайгуул судалгаа хийх, бүртгэн баримтжуулах судалгааны зорилгоор ШУ-ны Академийн Хэл зохиолын хүрээлэн, Түүх-археологийн Хүрээлэнтэй хамтран 14 хоног ажиллалаа.

Ховд аймгийн урианхай судлалын судалгаанд нийт 20 хүнээс яриа авч бүртгэн 30 цагийн дүрс бичлэг 1200 ш зураг архивлаж, 250 гаруй хуудас ярилцлагыг хөрвүүлэн буулгав. Судалгааны ажлын хүрээнд доорхи ажлыг гүйцэтгэв.

• Байгаль, сав ертөнцийн тухай мэдлэг, заншил, цаг агаар шинжих уламжлалт арга барил, гар урлал, урианхай уламжлалт дархны урлал, хуримлах, худ ураг барилдах уламжлалт зан үйл, баяр ёслол, газар сав ертөнц, уул устай холбогдолтой хууч яриа домгийн хайгуул судалгааг голчлон анхаарав.

• СББӨ-ийн ангилал, төрөл зүйлс, тэдгээрийн хадгалалт хамгаалалт, СББӨ-ийг өвлөн уламжлагчдын талаарх нарийвчилсан судалгаа хийж, өвлөн уламжлагчийн жагсаалтад нэмэлт бүртгэлийг хийв.

• Ховд аймгийн СББӨ-ийн бүртгэл-мэдээллийн сангийн бүрдүүлэлтийн өнөөгийн байдалд үнэлгээ хийж дүгнэлт гарган цаашид боловсронгуй болгох чиглэлээр мэргэжлийн зөвлөлгөө, зааварчилгаа өгөв.

• СББӨ-ийг өвлөн уламжлагчдыг олж тогтоон, тэдгээрийн мэдлэг, арга ухаан, түүх намтар, ур чадвар, урын санг гэрэл зураг, дуу, дүрс бичлэгээр болон “Монгол улсын соёлын биет бус өв, түүнийг өвлөн уламжлагчийн бүртгэл” маягтаар бүртгэн баримтжууллаа.

• Тухайн Аймаг сумын бахархал, нэрийн хуудас болсон СББӨ-ийн ховор, хосгүй төрлүүд, түүнийг өвлөгч гарамгай авъяастнууд, яаралтай хамгаалах шаардлагатай өвүүдийн судалгаа, жагсаалтыг тус тус нарийвчлан гаргав.

• Ховд аймгийн ЗДТГ-ын Боловсрол, соёлын газрын соёлын асуудал хариуцсан мэргэжилтэн СББӨ-ийн бүртгэл мэдээллийн сан дахь урианхайн СББӨ-ийн олон төрөл зүйлийн жагсаалт болон өвлөн уламжлагч нарын жагсаалтыг гаргаж өгч судалгааны багтай хамтран ажиллалаа.

• Судалгаанд орон нутгийн удирдлага болон нутгийн эрдэмтэн судлаачид, ард иргэдийн санал бодлыг тусган ажиллав.

Мөн тус судалгааны хүрээнд 2015 оны 7 дугаар сарын 03-05-ны өдрүүдэд Налайх дүүргийн Цонжин болдог цогцолбор, Ариг Монгол хаад жуулчны баазад зохион байгуулагдсан Урианхай түмний соёл, урлаг, спортын “Алтан хүрээ VIII” наадам дээр судалгааны баг ажиллав. Урианхайчууд гурван жил тутам ийнхүү чуулж, язгуур урлаг, соёл, угсаатны спорт тоглоом наадгайгаараа өрсөлдөн нааддаг уламжлалтай. Урианхай түмний ёс, зан заншил, өв уламжлал, соёл, урлаг, спортын төрөл зүйлийг хадгалж хамгаалах, өвлүүлэн уламжлуулах, сэргээн хөгжүүлэх зорилготой уг наадамд Хэнтий, Дархан уул, Сэлэнгэ, Ховд, Баян-Өлгий, Говь-Алтай, Орхон аймаг болон Улаанбаатар хот, Багануур, Налайх дүүргийн нийт 20 гаруй багийн соёл урлаг, гар

урлалын ардын авьяастан, харваач, бөхчүүд нийлсэн 600-аад оролцогч оролцсон. Тус наадмын хүрээнд нийт 160 орчим минутийн дүрс бичлэг, 40 орчим гэрэл зургаар баримтжуулан Соёлын өвийн улсын нэгдсэн бүртгэл мэдээллийн санд архивлан авлаа.
СББӨ-ийн олон төрөл зүйлийн хувьд доох өвийн зүйлүүдийн талаар мэдээлэл, судалгаа, бүртгэн баримтжуулалтыг хийв.

1. Урианхай ардын уртын болон богино дуу
2. Урианхай тоглоом наадгай
3. Урианхай бэр гуйх, хуримлах, худ ураг барилдах зан үйл, баяр ёслол
4. Урианхай дарханы урлал
5. Дарханы дөш, хөөрөг залах, тахих ёслол
6. Гэр болон гэрийн сахиус тахих ёслол
7. Идээ, ундаанд эмийн ургамал ашиглал ардын арга ухаан, мэдлэг
8. Тэнгэр шинжих арга ухаан, мэдлэг
9. Уул, ус, удмын овоо тахих зан үйл
10. Уул, ус, газрын тухай хууч яриа, домог
11. Бөөгийн зан үйл
12. Маага гутал урлах арга барил, мэдлэг
13. Хувцас зүүсгэлийн тухай
14. Цагаан сар болон идээ ундаатай холбогдолтой Урианхай зан үйл
15. Уриайнхай харваа
16. Од гариг, зурхай ухаантай хобоотой зан үйл
17. Урианхай овог удамтай холбоотой хууч яриа, домог
18. Аман хуур
19. Тамга болон түүний бэлгэдэл

ДҮГНЭЛТ:

Судалгааны явцад урианхай болон тува урианхай нарын зан заншил өөр хоорондоо маш адил, нарийн холбоотой нь ажиглагдав. Урианхай харваа, тоглоом наадгай, тууль, цуурыг сэргээх чиглэлээр орон нутаг нэлээдгүй арга хэмжээ авсан нь ажиглагдаж байлаа. Мөн ураг удмыг уул, ус, овоо тахих зан үйл сэргэж буй хэдий ч холбогдох зан үйл нь эртний уламжлалыг бус нийтлэг хэв шинжийг дагаж үйлддэг хэмээн нутгийн хөгшчүүл хуучлав.
Хуримын зан үйл, бэр буулгах ёс, бусад баяр ёслол нь мөн л өнөөгийн нийтлэг хэв шинжийг дагах ба өөрийн ясны онцлог хэв шинж, зан заншил нь үгүй болж байна.
Мөн тува урианхай хэл соёл утсаж үгүй болж буй ахмад үеэс доош төрлөх хэлээрээ тэр бүр ярьдаггүй, мартагдаж байгаа тухай судалгаанд оролцсон ард иргэд онцлон ярьж байлаа.
Судалгааны явцад Дарханы дөш, хөөрөг тахих зан үйл анхаарал маш татав. Энэхүү зан үйлийг Буянт сумын Эрдэнэ гуйгаас өөр үйлдэж буй хүн байхгүй байна. Тус СББӨ-ийн зүйлийг цаашид нарийн судлах шаардлагатай хэмээн судалгааны баг дүгнэв.
Мөн Дуут сумын иргэн Отгонбаяр нь Урианхайчуултай холбогдолтой 600 гаруй домог цуглуулсан байгаа нь судалгааны багийн анхаарлыг татлаа.

Цаашид төрлийн судалгааг хийхэд нэг суманд 5-7 хоног суурин байж ард иргэдийн дотор орж судалгааг явуулбал илүү үр дүнтэй хэмээн үзэв. Судалгааны хугацааг доод тал нь 30 хоногоор төлөвлөх.

Мөн судалгааны явцад 65 хүртлэх насны хүмүүс соёлын олон төрөл зүйлийн мэдлэг ойлголт нь хомс, 70 дээш насны хүмүүс нь мэдэх хэдий ч насны онцлогоос болоод мартах, ярих боломжгүй болох мөн олдох нь их ховор байв.

Түүнчлэн судалгааны ажлыг төлөвлөхөд цаг агаарын гэнэтийн өөрчлөлтийг тооцох, орон нутгийн хөтөч дагуулж явах зэрэг асуудлуудыг анхаарах нь зүйтэй.

<u>2.4. СББӨ-ийн бүртгэлийн програм хангамжийг шинэчлэх</u>

Монгол үндэстний соёлын биет бус өвийн олон төрөл зүйл бүхий оноосон нэртэй өвийн тодорхойлолт, өвлөн уламжлагч хүнтэй холбоотой мэдээллүүд нэгдсэн програмыг үүсгэх, Монгол Улсын хэмжээнд СББӨ-ийн олон төрөл зүйл, СББӨ-ийг өвлөн уламжлагч хувь хүн бүхий төрөлжсөн мэдээллийн санг бий болгох,шаардлагатай статистик мэдээлэл боловсруулах зорилгоор СББӨ-ийн Бүртгэлийн програм хангамжийг шинэчлэх ажлыг 2015 оны Үр дүнгийн гэрээнд тусгасан. Энэхүү үйл ажиллагааны хүрээнд СӨТ-ийн Програм хангамжийн мэргэжилтэн Б.Алтансүхтэй хамтран "Хэрэглэгчийн шаардлага", програм хангамжийн дотоод бүтэц, агуулгыг шинэчлэн тодорхойлов.

Соёлын өвийн бүртгэл мэдээллийн сандСББӨ-ийн чиглэлээр хойш DV cam60 минутын 334 ширхэг нийт 334 цаг, мөн нийт 787 цагийн видео, 180 цагийн аудио бичлэгийн материал хальс,HD 100 цагийн бичлэг, нийт 1230 цагийн дүрс бичлэг, мөн нийт 7868 өвлөн уламжлагчийн бүртгэлийн Маягтад хадаглагдаж байна.

ССБӨ-ийн бүртгэлийн програм хангамжийг шинэчлэхэд зориулагдсан төсвийн санхүүжилт нь 2015 он 3 дугаар улиралд төлөвлөгдсөн байсан боловч эдийн засгийн хүндрэлээс шалтгаалан төсөв ирээгүй болно. Иймд тус хэлтсээс 2015 оны 10 дугаар сард "СББӨ-ийн бүртгэл мэдээллийн санг ЮНЕСКО-гийн сандартад нийцүүлэн програм хангамжийг боловсронгуй болгох" төслийг боловсруулан Бээжин дэх ЮНЕСКО-гийн төвөөс зохих хэмжээний санхүүжилтийг хүссэн ба тус санхүүжилтийн асуудал хэлэлцэгдэх шатанд явж байгаа болно.

Бид "СББББӨ-ийн цахим удирдлагын систем-програм хангамж"-ийн ажиллах хүрээний ерөнхий бүдүүвч, схемийг гаргасан болно. *Хавсралт 1*

<u>2.5. ЮНЕСКО-д бүртгэгдсэн "Морин хуур", "Уртын дуу, "Уртын дуу хөгжимдөх арга барил Лимбэний битүү амьсгаа" 3 өвийн тайлан боловсруулах, илгээх</u>

ЮНЕСКО-гийн Засгийн газар хоорондын Үйл ажиллагааны Удирдамжийн дагуу СББӨ-ийн жагсаалтад бүртгэгдсэн өвийн зүйлийн талаарх оролцогч улс орнууд Яаралтай жагсаалтад бүртгэгдсэн өвийн хамгаалалтын үйл ажиллагааг 4 жил, Төлөөллийн жагсаалтад бүртгэгдсэн өвийн хамгаалалтын үйл ажиллагааг 6 жил тутамд тайлагнах үүргийг хүлээсний дагуу Үндэсний тайланг илгээдэг.

2015 оны 12 дугаар сарын 15-ний өдрийн дотор Монгол Улс нь 2011 онд ЮНЕСКО-гийн СББӨ-ийн Яаралтай хамгаалах жагсаалтад бүртгэгдсэн "Монгол Лимбэчдийн уртын дуу тоглох уламжлалт арга барил–битүү амьсгаа"-ны талаарх хугацаат тайланг илгээх тул тус ажлыг гүйцэтгэж байна. Тайлан бичихэд тухайн улс орны соёлын бодлого зохицуулалтыг төлөвлөх эрх бүхий байгууллага тайланг ахлан бичдэг тул СӨТ бие даан тайлан боловсруулахад зохих хүндрэлүүд тулгарсан. Үүнд:

БСШУ-ны сайдын 2011 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн 194 тоот тушаалыг үндэслэн "СББӨ-ийг хамгаалах тухай Конвенци"-ийн хэрэгжилтийн Үндэсний тайланг боловсруулах ажлын хэсгийг бүрдүүлэн Монгол Улсаас ЮНЕСКО-д тайлагнадаг зарчимтай байсан нь сүүлийн жилүүдэд алдагдаж байна.

Иймд цаашид Үндэсний тайланг илгээхэд Ажлын хэсгийг байгуулж СӨТ-ийг татан оролцуулж, дараа дараагийн тайлан илгээх хугацаанд тус ажлын хэсгийг ажилуулахад анхаарлаа хандуулах шаардлагатай байна.

Хугацаат тайлангийн хуваарийн дагуу 2015 онд Морин хуур, Уртын дууны тайланг боловсруулж илгээх байсан хэдий ч 2012 оны 6 дугаар сарын 24-ний өдөр "СББӨ-ийн

хамгаалах тухай Конвенцийн хэрэгжилт Монгол Улс”-ын хугацаат ерөнхий тайланг илгээж 2012 оны 12 дугаар сард Франц Улсын Парис хотноо хуралдсан ЮНЕСКО-гийн Засгийн газар хоорондын 7 дугаар чуулганаар хэлэлцэгдсэн. Энэхүү тайланд дээрх 2 өвийн зүйлийн талаарх хамгаалалтын арга хэмжээний талаар тайлагнасан тул Ерөнхий нарийн бичгийн дарга нарын газраас хангалттай хэмээн үзэж энэ жилийн хугацаат тайлангийн хуваарьт багтааж тайланг илгээхийг хүссэн албан тоотыг ирүүлээгүй болно.

2016 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн дотор хуваарийн дагуу дараах СББӨ-ийн зүйлийг хамгаалах үйл ажиллагааны хэрэгжилтийн талаар хугацаат тайланг илгээх ёстой.

Үүнд:

1. Монгол наадам
2. Монгол хөөмэй
3. Шувуулахуй

2.6. “Монгол гэрийн уламжлалт урлал, зан үйл”-ийн БМСанг баяжуулах, бүрдүүлэх

Соёлын өвийн төвийн захирлын 2015 оны 3 дугаар сарын 10-ны өдрийн А/13 тоот тушаал, ЮНЕСКО-ийн соёлын биет бус өвийн Төлөөллийн жагсаалтад 2013 онд бүртгэгдсэн “Монгол гэрийн уламжлалт урлал, зан үйл”-ийг судлах, дуу, дүрс бичлэгээр баримтжуулах, бүртгэл-мэдээллийн сан бүрдүүлэх зорилгоор энэ судалгааны ажил чиглэгдсэн болно. Ажлын баг нь томилолтын хугацаанд Өвөрхангай аймгийн Бат-Өлзий суманд 2015 оны 3 дугаар сарын 13-16-ны өдрийн хооронд 4 хоног ажиллаа.

Судалгааны багийн бүрэлдэхүүнд:

1. Ц. Жаргалсайхан /Соёлын өвийн төвийн Биет бус соёлын өвийг хамгаалах хэлтсийн дарга, багийн ахлагч/
2. Л. Ганбаатар /”Монгол гэрийг хөгжүүлэх үндэсний төв”-ийн тэргүүн, гэрээт ажилтан/
3. Ж. Насанжаргал /Соёлын өвийн төвийн мэргэжилтэн/
4. О. Үүрийн туяа /Соёлын өвийн төвийн зураглаач/
5. С. Сайнзолбоо /Жолооч/ нар ажилласан болно.

2015 оны 3 дугаар сарын 13-ны өдөр Өвөрхангай аймгийн Бат-Өлзий сумын Соёлын төвийн эрхлэгч н. Дашлонжид, Өвлөн уламжлагч Н. Бэх-очир, Т. Мөнхбаяр, байгаль хамгаалагч н. Пүрэвтогтох нарт ажиллах удирдамж, чиглэл, хаана яаж зураг авах талаар танилцуулж санал солилцов. Уламжлалт гэрийн мод бэлтгэх талаар туршлагтай, олон жил уг өвийг уламжилж яваа өндөр настан Н. Бэх-очир, залуу гэр урлаач Т. Мөнхбаяр нарыг гэрийн мод бэлтгэж буй дүрс бичлэгт оролцуулахаар тохирцгоов.

2015 оны 3 дугаар сарын 14-ний өдөр Бат-Өлзий сумаас зүүн урагш 18км-т, Өвтийн амны Шар ширэнг гэх газар руу зураг авах баг өглөөний 9 цагт хөдлөв. Гэрийн модыг ууланд гарч бэлтгэхдээ сүх, хөрөө, татуурга зэрэг багаж хэрэгслийг бэлтгэн ойролцоох айлаас үхэр, булхай /мод ачаад чирч явдаг/-г авч зураг авалт эхэлсэн. Дүрс бичлэгийг О. Үүрийнтуяа, Ж. Насанжаргал нар тус тусдаа 60 орчим минут, нийт 120 минутын дүрсийг авч баримтжуулсан.

Үүнд:

1. Уулруу үхэр хөтлөн явж буй
2. Мод шинжиж байгаа
3. Уул ус, тэнгэр хангайдаа будаа өргөж байгаа
4. Мод бэлтгэж байгаа

5. Мод цуулж байгаа

6. Мод татуурагдаж байгаа

7. Муна бэлтгэж байгаа

8. Уулнаас үхэр булхайгаар буулгаж байгаа зэргийн дуу дүрс бичлэгээр баримтжуулан оройн 17 цаг 40 минутанд сумын төв рүү хөдлөв.

2015 оны 3 дугаар сарын 15-ны өдөр гэрийн модыг хэрхэн бэлтгэдэг, уулнаас мод авахад ямар ёс заншилаар хийж гүйцэтгэдэг зэрэг зан үйлийн чиглэлээр Өвлөн уламжлагч Н. Бэх-очир, Т. Мөнхбаяр нараас ярилцлага хэлбэрээр яриа авав. Байгаль хамгаалагч н. Пүрэвтогтохоос мод үржүүлэх, байгалиа хэрхэн хамгаалж байгаа, хэдэн га газар хэдэн мод тарьж байгаа тоо баримтын талаар ярилцлага хэлбэрээр баримтжуулан авсан болно.

Гэрийн модны урлал, зан үйл нь улирлын чанартай, өөрөөр хэлбэл дээрхи цогцолбор хэсгүүдийг урлахдаа 4 улиралд таарч тохируулж хийдэг уламжлалтай, уран нарийн утга учир, хийцтэй юм. Иймээс бид зөвхөн өвөл бус хавар, зун, намар гэрийн модны урлалаар цуврал зураг авч улирал бүрт судалгаа хийх хэрэгтэй байна. Мөн Баруун, Зүүн бүсийн, угсаатны онцлогоос хамааран Монгол гэрийн зан үйл, уламжлалт урлал зэргийг судлах, баримтжуулах, цогц судалгааг шат дараатай хийж соёлын өвийн УНБМС-г бүрдүүлэх шаардлага гарч байна.

Бүртгэл судалгаагаар нийт 180 минутын дүрс бичлэг, 65 гэрэл зураг авч санг бүрдүүлэв.

<u>2.7. “Соёлын биет бус өвийг хамгаалах Үндэсний хөтөлбөр”-ийг боловсруулах.</u>

ЮНЕСКО-гийн Хүн төрөлхтний СББӨ-ийн Төлөөллийн Жагсаалтад бүртгэгдсэн морин хуур, уртын дуу, хөөмэй, ЮНЕСКО-гийн Яаралтай хамгаалах шаардлагатай СББӨ-ийн Жагсаалтад бүртгэгдсэн уламжлалт бүжиг-бий, биелгээ, тууль, цуурын урлагийг хадгалж хамгаалах хөтөлбөрийг тус тус боловсруулан Монгол Улсын Засгийн газрын тогтоолоор батлуулж, 2005-2014 онд багтаан заасан хугацаанд нь хэрэгжүүлэв.

Цаашид зөвхөн ЮНЕСКО-гийн Дэлхийн өвд бүртгүүлснээр хязгаарлахгүй 2014 онд баталсан Соёлын өвийг хамгаалах тухай хууль (шинэчилсэн найруулга)-д заасан СББӨ-ийн төрөл зүйлийг цогцоор нь хамгаалах бодлогыг бүс бүсээр нь төлөвлөн хэрэгжүүлэх шаардлага тавигдаж байна. 2015 оны байдлаар Соёлын өвийн Улсын нэгдсэн бүртгэл мэдээллийн сан (цаашид УНБМС гэнэ)-д СББӨ-ийн өвлөн уламжлагчаар 7800 гаруй авьяас билэгт хүмүүс бүртгэгдсэн бөгөөд тэдгээрийн 60хувь нь ардын язгуур уламжлалт урлаг, 23 хувь нь гар урлал, 11 хувь нь эх хэл, аман уламжлал, 4 хувь нь үндэсний уламжлалт баяр ёслол, зан үйл, 2 хувь нь байгаль ертөнц, цаг улиралтай холбогдол бүхий ардын амьдрал ахуйн уламжлалт мэдлэг, арга ухааны ангилалд хамаарч байна.

Энэхүү нөхцөл байдлыг харгалзан үзээд “Соёлын биет бус өвийг хамгаалах үндэсний хөтөлбөр”-ийг цогц байдлаар боловсруулж Монгол Улсын нутаг дэвсгэрт аж төрдөг үндэстэн, угсаатан, ястан, үндэстний цөөнхөд соёлын биет бус өвөө тэгш хүндэтгэн, хадгалж хамгаалахад нь төрөөс дэмжлэг үзүүлж, соёлын олон төрөл зүйлийг өвлөн уламжлуулж, хөгжүүлэхэд хөтөлбөрийн зорилго оршив.

Хөтөлбөр нь СББӨ-ийг хамгаалах чиглэлээр дараах үндсэн 9 үйл ажиллагааг агуулсан болно. Үүнд:

1. Соёлын биет бус өв, угсаатны бүлгийн суурь судалгааг түүх, уламжлал, ёс заншил, ахуй нөхцөлтэй нь салшгүй уялдаатайгаар хийж гүйцэтгэх.

2. СББӨ-ийн мэдээллийн санг мэдээлэл харилцааны шинэ технологийг хэрэглэж баяжуулах.

3. ЮНЕСКО-гийн болон Монгол Улсын Төлөөллийн хийгээд Яаралтай хамгаалах шаардлагатай соёлын биет бус өвийн жагсаалтад бүртгэгдсэн өвүүдийг хадгалж, хамгаалах, түгээн дэлгэрүүлэх арга хэмжээ авах

4. СББӨ-ийн төрөл зүйлсээр тэнхимийн болон шавь сургалт явуулах

5. СББӨ-ийн чиглэлээр мэргэжилтэн бэлтгэх, мэргэжил дээшлүүлэх сургалт зохион байгуулах.

6. СББӨ-ийн чиглэлээр мэргэжилтэн бэлтгэх, мэргэжил дээшлүүлэх сургалт зохион

байгуудах.

7. Соёлын өвийн бүртгэл, мэдээллийн санд СББӨ-ийн программ хангамж суурилуулах, нэгдсэн сүлжээнд холбох.

8. Соёлын өвийн бүртгэл, мэдээллийн санг шаардлагатай техник хэрэгсэл, тоног төхөөрөмжөөр хангах

9. СББӨ-ийн бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих

СББӨ-ийг хамгаалах Үндэсний цогц хөтөлбөрийн төслийг боловсруулан БСШУЯ-нд 2015 оны 06 дугаар сарын 29-ны өдөр 137 тоот албан бичгээр хүргүүлсэн болно.

СОЁЛЫН БИЕТ БУС ӨВИЙГ ХАМГААЛАХ ХЭЛТСИЙН СТРАТЕГИЙН ЗОРИЛТЫГ ХАНГАХАД ЧИГЛЭСЭН АЖИЛ, ҮЙЛЧИЛГЭЭНД НЭМЭЛТЭЭР ХИЙСЭН АЖЛУУД

2015 онд Соёлын биет бус өвийг хамгаалах хэлтсийн стратегийн зорилтыг хангахад чиглэсэн ажил үйлчилгээнд нэмэлтээр 6 төрлийн ажлыг хийлээ.

Үүнд,

Сургалт семинар

Монгол Улсын СББӨ-ийг хамгаалах хүчин зүтгэлийг дэмжих зорилгоор Япон Улсын “Итгэлцлийн сан”-гийн тусламжтайгаар СББӨ-ийг хамгаалах тухай ЮНЕСКО-гийн Конвенцийг хэрэгжүүлэхэд Монгол Улсын чадавхийг бэхжүүлэх төслийн хүрээнд 1-р шатны сургалт “Конвенцийн хэрэгжүүлэлт болон Хамт олонд түшиглэсэн соёлын биет бус өвийн бүртгэл” сэдэвтэй 2012 оноос эхэлж явагдсан бөгөөд 2 дахь шат болох *“ЮНЕСКО-гийн СББӨ-ийн жагсаалтад нэр дэвшүүлэх хэрэглэгдэхүүнийг боловсруулах”* сургалтыг 2015 оны 10 дугаар сарын 05-09-ний өдрүүдэд Богд хааны ордон музейд зохион байгуулав.

Тус сургалтын гол зорилго нь: Монгол Улсын Соёлын Биет Бус Өвийг ЮНЕСКО-гийн СББӨ-ийн жагсаалтад нэр дэвшүүлэх хэрэглэгдэхүүнийг боловсруулахад холбогдох мэргэжилтнүүдийн чадавхийг дээшлүүлэн, СББӨ-ийг үр дүнтэй хамгаалахад чадваржуулан сургах юм.

Сургалтыг Японы “Итгэлцлийн сан”-гийн дэмжлэгээр Соёлын өвийн төв, ЮНЕСКО-гийн Монголын Үндэсний Комисс, ЮНЕСКО-гийн Бээжин дэх Төлөөлөгчийн газар хамтран зохион байгууллаа.

Энэхүү 5 өдрийн сургалтыг ЮНЕСКО-гийн итгэмжлэгдсэн олон улсын экспертүүд Норика Айкава, Александра Денес нар удирдан явуулж, Конвенцийн дагуу байгуулагдсан олон улсын, олон төрлийн бүтцийг шинжин түүнийг хэр ашигтайгаар хэрэглэх онолын болон практик хичээл, хээрийн аялалыг хамруулан Соёлын өвийн төв, 21 аймгийн соёлын мэргэжилтнүүд, болон төрийн бус байгууллага, өвлөн уламжлагчдын төлөөлөл зэрэг нийт 30 гаруй мэргэжилтнүүд оролцов.

2015 оны 10-рсарын 20-21. “Монгол Улс дахь СББӨ-ийн ТТБ-уудын чадавхийг бэхжүүлэх нь” Үндэсний семинарыг “Байгаль соёлын өвийг хамгаалах сан”, ЮНЕСКО-гийн МҮК-той хамтран зохион байгуулж оролцов. Тбб-уудын материалыг хүлээн авсан бөгөөд энэ хүрээнд “Соёлын биет бус өв ба Төрийн бус байгууллага” /зорилт, боломж, туршлага/ гарын авлага хэвлэгдэн гарав.

СББӨ-ийн үзлэг, наадам

Монгол улсын төрийн соёрхолт, туульч Баатарын Авирмэдийн нэрэмжит Монгол туулийн наадам

Монгол улсын Засгийн газрын 2011 оны 357 дугаар тогтоолоор батлагдсан “Монгол тууль” үндэсний хөтөлбөрт тусгагдсаны дагуу Төрийн соёрхолт туульч Баатарын Авирмэд /1935-1998/-ийн мэндэслсний 80 насны ойг тохиолдуулан алдар гавьяаг нь мөнхжүүлэх, урын сан, дэг сургуулийнх нь онцлогийг судлан сурталчлах, хойч үед өвлүүлэх ажлын хүрээнд Монгол туулийн амьд уламжлалыг хөгжүүлэх, олоннийтэд таниулах, туульчдын залгамж үеийг бэлтгэх зорилгоор Монгол туулийг наадмыг 2015 оны 06 сарын 27-ноос 07 сарын 01 хооронд амжилттай зохион байгууллаа.

Төрийн соёлрхолт “Туульч Баатарын Авирмэдийн урын сан судлал” сэдэвт эрдэм шинжилгээний бага хурлыг 2015 оны 07 сарын 27-нд Ховд аймгийн Дуут суманд зохион байгууллаа. Эрдэм шинжилгээний хуралд Ховд аймгийн Засаг даргын орлогч Ч.Чинбат, Аймгийн ЗДТГ-ын дарга, Доктор Б.Батмөнх, Монгол улсын шинжлэх ухааны Гавъяат зүтгэлтэн, Франц улсын шинжлэх ухааны дээд шагналт “Эрдмийн алтан дал мод” одонт доктор, профессор С.Дулам, ШУА-ийн хэл зохиолын хүрээлэнгийн секторын эрхлэгч, доктор Т.Баясгалан, Тус хүрээлэнгийн судлаач, ШУ-ны доктор, профессор Б.Катуу, СУИС-ын Театрын урлагийн сургуулийн захирал, доктор, профессор Ж.Долгорсүрэн, СУИС-ийн багш, Соёлын өвийн төвийн зөвлөх, докторант С.Юндэнбат нар, ХоИС-ийн НХУС-ийн ТЭЗүйн тэнхимийн багш, доктор, профессор М.Ганболд нарын 9 илтгэл хэлэлцэгдэж амжилттай болж өнгөрлөө. Энэ эрдэм шинжилгээний бага хуралд нийт 13 доктор, профессор оролцоо.

БСШУСайдын 2015 оны А/134 тоот наадам үзлэг зохион байгуулах тухай тушаалаар баталсан удирдамжийн дагуу Ховд аймгийн ИТХ, ЗДТГ-тай хамтран зохион байгуулсан Монгол тууль, цуурын улсын анхдагаар үзлэгийг амжилттай зохион байгууллаа.

Монгол улсын төрийн соёрхолт, туульч Баатарын Авирмэдийн нэрэмжит Монгол туулийн наадмаар зохион байгуулсан уралдаанд 11 багшийн 24 туульч оролцож дараах туульчид байр эзэллээ.

Туулийн наадмын тусай шагналт байр

Одгэрэл Төрмандах /Баянхонгор, Галуут сум/ Өргөмжлөл, Таархал, 100 доллар шагнал

Н.Намсрай /Увс, / Өргөмжлөл, Таархал, 100 доллар шагнал

Шагналт байр Өргөмжлөл, 1 сая төгрөг
Э.Баатаржав /УБ/,
Б.Болд /Баян-Өлгий Буянт/

Гутгаар байр
Төгсөө /Увс аймаг/ Өргөмжлөл 2.000.000 төгрөг

Дэд байр
Д.Чинтулга /Ховд аймгийн Дуут сум/ Өргөмжлөл 4.000.000 төгрөг

Тэргүүн байр
Дамдиндорж Ховд аймгийн /Дуут сум/ 6 сая төгрөг, цом

Туулийн наадамд оролцогчдод БСШУСайд Л.Гантөмөрийн Таархал 50,000 төгрөгийг гардууллаа.

Нэрт цуурч П.Наранцогтын нэрэмжит цуурын Баруун бүсийн улсын анхдугаар үзлэг

Засгийн газрын 2014 оны 72 дугаар тогтоолоор батлагдсан “Монгол цуур” үндэсний хөтөлбөрт тусгагдсаны дагуу Нэрт цуурч П.Наранцогт агсны алдар гавьяаг мөнхжүүлэх, урын сан, дэг сургуулийнх нь онцлогийг судлан сурталчлах, хойч үед өвлүүлэх ажлын хүрээнд монгол цуур хөгжмийн амьд уламжлалыг хөгжүүлэх, олон нийтэд таниулах, цуурчдын залгамж үеийг бэлтгэх зорилгоор 2015 оны 07 дугаар сарын 01-ний өдөр нэрт туульч Паадайн Наранцогтын нэрэмжит “Монгол цуурын улсын анхдугаар үзлэг” Ховд хотын Хөгжимт драмын театрт боллоо.

Монгол цуурын улсын анхдугаар үзлэгт нийт 21 оролцогч, 5 хамтлаг оролцож, өөрийн сайн тоглодог нэг аялгуу мөн заавал тоглох ая “Ээвийн голын урсгал” хэмээх цуурын аялгууг тоглож эхэлсэн уг наадамд Цуурын төрөлд тэргүүн байранд Дорнод аймгийн Баяннуур сумын цуурч Б.Загджав, дэд байранд Ховд аймгийн Дуут сумын цуурч Д.Батхүрэл, гутгаар байранд Ховд аймгийн Дуут сумын цуурч Н.Буяндэлгэр, хамтлаг цуурын төрөлд тэргүүн байранд “Тасрашгүй холбоо” хамтлаг, дэд байранд “Жангар” хамтлаг тус тус шагналт байруудыг эзэллээ.

Монгол цуурын улсын анхдугаар үзлэгт нийт 21 оролцогч, 5 хамтлаг оролцов. Тус наадмыг зохион байгуулах ажлын хэсэгт Соёлын өвийн төвийн мэргэжилтэн Ж. Насанжаргал, А. Саруул нар орж наадмын удирдамж боловсруулах, батламж хийлгэх,олон нийтийн телевиз, сонинд зар сурталчилгаа байршуулах зэрэг зохион байгуулалтын ажлыг хийж гүйцэтгэсэн байна. Мөн тус наадмыг СББӨ-ийн зураглаач О.Үүрийнтуяа дүрс бичлэгээр баримтжуулсан.

Хубилай сэцэн хааны мэндэлсний 800 жилийн ойн хүрээндзохион байгуулагдсан Олон улсын “Хөөмэйн баяр” –ын тайлан

Хубилай сэцэн хааны мэндэлсний 800 жилийн ойн хүрээнд Олон улсын “Хөөмэйн

баяр”-ыг БСШУЯ,Соёлын өвийн төвөөс Монгол Улсын Үндэсний дуу бүжгийн эрдмийн чуулга, Үндэсний номын сан, Монголын Үндэсний Урлагийн зөвлөл, “Монгол хөөмэй” холбоо хамтран 2015 оны 09 сарын 15-16-ны өдрүүдэд зохион байгууллаа.

Олон улсын хөөмэйчид, судлаачид өөрийн туршлагыг солилцох, цаашид хөөмэйн урлагийг сурталчлах, хамтран ажиллах хөрсийг бүрдүүлэхэд энэхүү “Хөөмэйн баяр”-ын зорилго оршисон билээ.

“Хөөмэйн баяр”-т Монгол улсаас гадна ОХУ-ын Тува, Буриад, БНХАУ-ын ӨМӨЗО, Франц улсаас эрдэмтэн судлаач, хөөмэйч нар оролцлоо.

“Хөөмэйн баяр”-ын хамтарсан тоглолтыг 2015 оны 09 сарын 15-ны өдрийн 15 цагт ҮДБЭЧ-ын байранд зохион байгууллаа.

Тоглолыг БСШУЯ-ны Соёлын бодлого зохицуулалтын дарга Д.Гантөмөр нээн үг хэлж, хөөмэйн урлаг, өв соёлыг хойч залуу үедээ өвлүүлэн уламжлуулах, түгээн дэлгэрүүлэх, сурталчилахад үнэтэй хувь нэмрээ оруулсан ахмад хөөмэйч нар болох МУУГЗ Б.Одсүрэн, МУГЖ Г.Ягваан, МУУГЗ А.Цэдэн-Иш нартаа хүндэтгэл үзүүлэхийн зэрэгцээ БСШУ-ны сайд Лу.Гантөмөрийн таархалыг хүндэтгэлтэйгээр гардуулан өгсөн билээ. Түүнчлэн БСШУ-ны сайдын таархалыг гадаад улсад монгол хөөмэйг сурталчилан таниулахад жинтэй хувь нэмэр оруулахад идэвхи зүтгэл гарган ажиллаж буй Транс Монголиа хамтлагийн ахлагч Да.Хосбаяр, шувуулахуйн өв соёлын сэргээн амьлуулах, хойч үедээ шавьлан сургах, өвлүүлэх уламжлуулах, түгээн дэлгэрүүлэх үйлсэд бодит хувь нэмэр оруулж буйг нь таархан Монголын шувуулахуйн холбооны тэргүүн Д.Отгонсайхан нарт тус тус олгов.

“Хөөмэйн баяр” хамтарсан тоглолтонд үе үеийн хөөмэйчид оролцож уран бүтээлээ танилцууллаа. Гоцлол чиглэлээр нийслэл, орон нутаг, гадны зочид 40 гаруй хөөмэйч, “Хөсөгтөн”, Говьсүмбэр аймгийн Боржгон чуулгын “Хөх толбот”, Хөгжим бүжгийн коллежийн “Нүүдэлчид”, БНХАУ-ын ӨМӨЗО-ны Шилийн гол аймгийн “Нутаг” хамтлагууд ҮДБЭЧ-ын бие бүрэлдэхүүн зэрэг нийт 100 уран бүтээлчид оролцов. Ерөнхий найруулагчаар ҮДБЭЧ-ын уран сайхны удирдаач МУУГЗ А.Цэдэн-Иш ажиллалаа.

Тоглолтын үер Монгол Улсын нэрийн өмнөөс ЮНЕСКО-ийн Хүн төрөлхтний төлөөллийн болон яаралтай хамгаалах шаардлагатай СББӨ-ийн жагсаалтад бүртгэлтэй өвүүдийг олон нийтэд сурталчилан таниулах зорилгоор “Дэлхийд данстай Монгол өв” үзэсгэлэнг дэлгэн толилуулав.

Тоглолт нийт 1 цаг 40 минут үргэлжисэн ба Соёлын өвийн төвөөс тус

тоглолтыг бүрэн эхээр нь баримтжуулсан болно.Энэхүү тоглолтын бүтэн бичлэгийг DVD болгон БСШУЯ-нд хүргүүлэх болно.

Хамтарсан тоглолтыг энгийн ард иргэдээс гадна Нийслэлийн ЕБС-ийн 1 дүгээр сургуулийн сурагчид, мөн мэргэжлийн боловсон хүчин, судлаачдыг бэлтгэдэг Боловсролын сургуулийн Дуу хөгжмийн ангийн багшийн анги, Соёлын дээд сургууль, СУИС, МУИС-ийн Ардын урлаг судлалын анги, Хөгжим бүжгийн коллежийн оюутан сургачид урилгаар үзэн сонирхосон юм.

Хөөмэйн баярт оролцсон нийт уран бүтээлчид, байгууллага, хамт олонд СӨТ-өөс гарын бэлэг, дурсамж гардуулсан болно. Үүнд:

- Дурсамжийн бичиг
- Бум-Эрдэнэ туулийн хувилбарууд 2 боть
- “Цуурын уламжлалт урлагийн өнөөгийн байдал, тулгамдсан асуудлууд” эрдэм шинжилгээний хурлын илтгэлийн эмхэтгэл,
- Туулийн онол практиккийн эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл.

2015 оны 09 сарын 16-ны өдрийн 9:00-12:00 цагт Үндэсний төв номын санд олон улсын “Хөөмэйн баяр”-ын эрдэм шинжилгээний хурал болж өндөрлөлөө.

Эрдэм шинжилгээний хурлыг БСШУЯ-ны Соёлын өвийн хэлтсийн мэргэжилтэн Ц.Цэндсүрэн нээж, хурлын 1-р хэсгийг удирдав. Хуралдааны 2-р хэсгийг Соёлын өвийн төвийн захирал Г.Энхбат урдирдаж, Б.Одсүрэн, МУУГЗ, СУИС-н Язгуур урлаг өвийн ангийн ахлах багш, “Монгол Хөөмэй” холбооны дэд тэргүүн хуралдааныг хаасан болно.

Хуралдаанд Монгол, БНХАУ-ын ӨМӨЗО, Франц улсын эрдэмтэд илтгэлээ танилцуулж, ОХУ-ын Буриад, Тува улсын эрдэмтдийн илтгэл ханын илтгэлээр оролцоо. Хуралдаанд танилцуулсан илтгэл:

- “Мэдлэг ойлголтоо нэмэгдүүлж, өв соёлоо хамгаалцгая”, А.Цэдэн-Иш, МУУГЗ, “Монгол Хөөмэй” Холбооны Тэргүүн
- “Хөөмийлэхэд хөөмэйн гүйцэтгэх үүрэг”, С.Юндэнбат, СУИС
- “Хөөмэйн судалгааны чиг хандлага”, Л.Хэрлэн, доктор, урлаг судлаач, МУИС-ийн ардын урлагийн тэнхмийн багш
- “Монгол улсын илтгэл”, Б. Хосбаяр, МУСТА, хөөмэйч, Монголын үндэсний урлагийн зөвлөлийн тэргүүн

- “Монгол хөөмэйн өвлүүлэлт”, Жоанни Кюрте, доктор, Франц улс

- “Юань гүрний ордны ая дуудлага, цоор дуу”, Э.Цогжавхлан, БНХАУ-ын ӨМӨЗО.

Хуралдааны хэлэлцүүлэгт хил дамнан өвлөгдөж буй ССБӨ болох монгол хөөмэйг хамтран сурталчилан, түгээн дэлгэрүүлэх, хамтарсан судалгаа хийх, хэл томъёоллыг нэг жиг болгох зэргийг хэлэлцэж, нэгдсэн ойлголтонд хүрч цаашид хамтран ажиллахаар болов.

ЮНЕСКО-гийн санхүүжилтээр хэрэгжиж буй “Монгол туулийн уламжлалыг хадгалж хамгаалах, сэргээн амилуулах нь” төсөл

ЮНЕСКО-гийн санхүүжилтээр 2013 оноос эхлэн хэрэгжүүлж буй “Монгол туулийн уламжлалыг хадгалж хамгаалах, сэргээн амилуулах нь” төслийн хүрээнд хийгдсэн шавь сургалтын тайлан, багш шавь нарын уулзалт 2015 оны 11 сарын 16-19-ны өдрүүдэд Нийслэлийн Хан-Уул дүүрэг дэх Богд хааны музейн “Хаан туульс”-ийн өргөөнд 4 өдөр зохион байгуулсан. Үр дүнгийн тайланг доктор профессор С.Дулам, тууль судлаач доктор Б.Катуу, Соёл урлагийн их сургуулийн багш МУГЗ Б.Одсүрэн, Соёлын өвийн төвийн зөвлөх, соёл судлаач С.Юндэнбат нар шалгаруулж дүгнэв.

Энэхүү үйл ажиллагааг бүрэн баримтжуулж тайлан, үзлэгийг 11 цагийн дүрс бичлэг, 600 фото зургаар баримтжуулан соёлын өвийн УНБМСанг баяжуулсан.

Төслийн хүрээнд БСШУЯ-ны харъяа Соёлын өвийн төвөөс аймаг нийслэлийн 9 туульчтай туулийн уламжлалыг өвлүүлэн уламжлуулах шавь сургалтын гэрээ байгуулан ажиллажээ. Багш шавийн энэхүү уулзалтад дараах туульчид шавь сургалтын үр дүнгээ тайлагнав.

Үүнд:

1. Увс аймгийн Ховд сумын туульч, малчин Идэшийн Нэргүйтэй шавь сургалтын гэрээ байгуулж, дөрвөд туулийн уламжлалыг уугуул нутаг усанд нь заан сургах ажлыг хийжээ. Уг сургалтад 3 хүн хамрагдаж, “Бум эрдэнэ”, “Алтай хайлах”, “Хангал ташаа хар хээр морьтой хаан цэргийн хөвгүүн” туулийг заан сургаж байгаа ажээ. Тэдгээрийг төлөөлж шавь И.Төгсөө нь уг тайланд “Бум эрдэнэ” туулийг туульч Цагаандайн Зодовын уламжлалаар хайлж хангалттай гэсэн үнэлгээг авав. Дөрвөд туулийн уламжлал сэргэн амилж буй нь энэ төслийн нэг үр дүн болж байна.

2. Эдүгээ 80 настай халх туульч Дандарын Өлзий “Алтан ноён Галуу хүү”, “Жигүүн жигүүн төмөр хаан” туулийг Баянхонгор аймгийн Галуут сумын 3, нийслэлийн 1 хүүхдэд заан сургаж, гэрээгээ сайн биелүүлжээ. Тайланд түүний шавь О.Төрмандах, О.Төрболд нар Ч.Мягмарсүрэн, М.Ууганболд нар оролцов.

3. Туульч Эрдэнэцогтын Баатаржав төв хөдөөгийн 3 хүнд “Алтайн магтаал”, Баянцагаан өвгөн”, “Алтай Чингэл баатар”, зэрэг туулиудыг өвлүүлэн сургаж байна. Түүний шавь нарыг төлөөлж Б.Амгаланбаатар “Бөх алтан нудрам” хэмээх урианхай туулийг хайлж хангалттай гэсэн үнэлгээг авав.

4. Мөн туульч Базаржавын Баярмагнай төв болон хөдөө орон нутгийн дунд сургуулиудтай хамтран ажиллаж “Гэсэр”, “Жангар” туулиудыг бага, дунд, ахлах ангийн сурагчдад хэсэгчлэн хайлж, монгол туулийн уламжлалыг биет байдлаар сурталчилж байна. Шавь сургалтын гэрээгээр “Жангар” туулийн зарим бүлгээс 2 хүүхдэд зааж өвлүүлэх шатандаа явж байна. Гэрээгээ биелүүлж буй гэж үзэв. Цаашид сургалтаа үргэлжлүүлэх хэрэгтэй гэж зөвлөв.

5. Туульч Авирмэдийн Балдандорж “Наран хаан хүү”, “Аргил цагаан өвгөн”, “Довон хар бөх” тууль, “Алтайн магтаалыг 3 хүнд өвлүүлэн сургаж байна. Тэдгээрийг төлөөлж түүний шавь Д.Чинтулга “Наран хаан хүү” хэмээх урианхай туулыг хайлж, хангалттай гэсэн үнэлгээг

авлаа.

6. Халх туульч Зундуйн Чулуунбаатар 3 хүнд “Агаан улаан хаан”, “Баяндай хааны хүү Баяндондог баатар” туулийг зааж өвлүүлж байна. Түүний шавь нарыг төлөөлж О.Ууганбаяр оролцож сайн үнэлгээ авлаа.

7. Мөн Увс аймгийн Наранбулаг сумын малчин, туульч Нямаагийн Анхбаярын шавь сургалтад 3 хүн хамрагдсан бөгөөд энэ удаад нутагт нь цас ихээр унаж, цаг агаар хүндэрсэн тул малаа орхиод ирж чадсангүй. Үүнийг хүндэтгэх шалтгаан гэж үзээд 2015 оны 7 сард Ховд аймагт болсон Туульчдийн наадмаар Н.Анхбаярын шавь нарын төлөөлөл болох Н.Намсрай “Хан харангуй” туулийг ур чадвартай хайлахыг шүүгчдийн энэ бүрэлдэхүүн биечлэн сонссоноо үндэслэн түүнийг гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлсэн гэж үзэв.

Жич:

8. Туульч Энхээгийн Мэндбаяр цэргийн албан хаагч бөгөөд НҮБ-ийн энхийг сахиулах үйл ажиллагаанд оролцохоор Африкийн Намиби улсад гадаад томилолтоор явсан тул шавь сургалтын гэрээг сунгаж, үр дүнг ирэх жил дүгнэх

9. Хэл мэдээ авалцаагүйн учирэнэ удаагийн тайланд Туульч Лхамжавын Баатархүү оролцож чадсангүй. Ойрын үед холбоо барьж, тайланг нь бичгээр авч, заасан шавийнх нь сурсан туулийг сонсож байж гэрээг нь дүгнэх хэрэгтэй гэж Соёлын өвийн төвд зөвлөв.

Мөн БСШУЯ-наас 2013 онд нэрийн төсөл бичиж санхүүжилт авсан туульч Б. Болд, шавь Ө. Одхүү, туульч Н. Дамдиндорж, шавь Д. Батхүрэл нарыг тус уулзалтанд хамруулсан.

Шавь сургалтын тайланг бичгээр болон шавь нарын сурсан туулийг хайлуулж дүгнэсэн ба шавь нарыг мөнгөн шагналаар урамшуулж нийт шавь сургалт явуулсан туульч багш нарт гэрчилгээ, төслийн хүрээнд хэвлэгдсэн туулийн 7 боть номноос гардуулсан болно.

“Монгол туулийн уламжлалыг хадгалж хамгаалах, сэргээн амилуулах нь” төслийг хэргэжүүлснээр туулийн амьд уламжлалыг сэргээн үргэлжлүүлэх, туулийг өвлөгч авъяастнуудын тоог нэмэгдүүлж, залгамж холбоог бэхжүүлэх, тууль цаашид бие даан тогтвортой хөгжин уламжлах дархлааг буй болгоход чиглэлд чухал алхам болов.

“Монгол тууль”-ийн өнөөгийн байдал, шавь сургалтын үр дүн сэдвээр Хэл зохиолын хүрээлэнгийн судлаач Б. Катуу Урианхай туулийн өнөөгийн байдал, тус хүрээлэнгийн судлаач доктор А. Алимаа Халх туулийн талаар илтгэлүүдийг тавьж, шүүгчдийн бүрэлдэхүүн шавь сургалтын тайлан, өвлөн суралцагч нарын үзлэгийн талаар зөвлөмж гарган танилцуулсан.

Туульч ба туулийн тухай цуврал нэвтрүүлгийн үргэлжлэл болгон “Оллоо” телевизтэй хамтран 20 минутын нэвтрүүлгийг “Халх тууль”-ийг голлон олон нийтэд сурталчлав.

Шавь сургалт явуулсны үр дүнд:

- Туульч, тууль сонирхогч, туулийн урлагийг судлаачдын тоо нэмэгдсэн. 2009 онд “Монгол тууль”-ийг ЮНЕСКО-гийн Яаралтай хамгаалах шаардлагатай өвийн жагсаалтад бүртгүүлэхээр судалгаа хийж байх үед монгол даяар тууль хайлдаг 7-8 хүн байсан бол эдүгээ туульч хэмээх алдарыг албан ёсоор хүлээсэн Урианхай, Баяд, Дөрвөд, Халх ястны

төлөөлөл 12 авъяастан энэхүү ховор нандин өвийг өвлөн уламжилж, 30 орчим өсвөрийн авъяастан өвлөн суралцаж байна.

- Туульчид өөрсдийн уламжилж яваа өвийнхөө тухайд бахархал омогшилтой болж, ур чадвар, урын сангаа нэмэгдүүлэхэд идэвхи санаачлагатай хандах болсон

- Туулийн урлагийн тухай олон нийтийн мэдлэг дээшилсэн, туулийн өвийг хамгаалахад, олон нийтийн оролцоо нэмэгдсэн

- Туулийн урлагийн нийгмийн үнэлэмж сайжирч, орон нутгийн болон үндэсний хэмжээний аливаа ёслол хүндэтгэлийн зан үйлд тууль, туульчдын оролцоо, эрэлт хэрэгцээ өссөн зэрэг ахиц дэвшил гарч байгааг тэмдэглэе.

Нэрт цуурч П.Наранцогтын нэрэмжит Төвийн бүсийн цуурын үзлэг

Монгол Улсын Засгийн газрын “Монгол цуур” Үндэсний хөтөлбөрт туснасны дагуу нэрт цуур Паарайн Наранцогтын алдар гавьяаг мөнхжүүлэх, урын сан, дэг сургуулийнх нь онцлогийг судлан суталчлах, хойч үздээ өвлүүлэх ажлын хүрээнд монгол цуур хөгжмийн амьд уламжлалыг хөгжүүлэх, олон нийтэд таниулах, цуурчдын залгамж үеийг бэхжүүлэх зорилгоор Нэрт цуурч П.Наранцогтын нэрэмжит Төвийн бүсийн цуурын үзлэгийг 2015 оны 11-р сарын 27-ны өдөр Улаанбаатар хотын Хан-Уул дүүргийн Соёлын ордонд БСШУЯ, Нийслэлийн Соёл урлагийн газар, Хан-Уул дүүргийн Соёлын ордонтой хамтран зохион байгууллаа.

Үзлэгийг нээж БСШУЯ-ны СӨХ-ийн Биет бус соёлын өв хариуцсан мэргэжилтэн Ц. Цэндсүрэн, Соёлын өвийн төвийн захирал Г.Энхбат нар үг хэлэв. Мөн энэ үеэр Нэрт цуурч П.Наранцогтын ач хүү “Хүннү цуур” холбооны тэргүүн Б.Наранбат үг хэлж төслийн хүрээнд хийсэн цууруудыг гардуулан өгөв.Энэхүү үзлэгт нийт 11 оролцогч оролцож заавал тоглох ая “Ээвийн голын урсгал, мөн өөрсдийн сайн тоглодог нэг аялгууг тоглож оролцлоо.

Үзлэгийн үйл ажиллагааг эхнээс нь дуустал үе шат, дэс дараалалтай 120 минутын дуу дүрс бичлэг, 48 ширхэг гэрэл зургаар баримтжуулж соёлын өвийн УНБМСанг баяжуулаа.

Үзлэгийг мэргэжлийн хүмүүсээс бүрдсэн шүүгчид уламжлалт арга барил, тоглох ур чадварыг харгалзан шалгаруулав.

Ерөнхий шүүгчээр С. Юндэнбат /СУИС-ийн багш, Соёл судлаач/, шүүгчээр Г. Нямжанцан /Хөгжим бүжгийн коллежийн Лимбэ, Цуурын багш/, Б. Санжаадорж /СУИС-ийн язгуур урлагийн танхимийн багш/ нар ажилласан болно.

Шилдэг оролцогчоор :

1. Мөнхбат-ХБК
2. Буянтөрх-СУИС
3. Нэмэхжаргал
4. Золзаяа-СУИС нар шалгарч өргөмжлөл, мөнгөн шагнал, Монгол туулийн цуврал боть номуудаар шагнагдав.

Мөн бусад бүх оролцогчдод тодорхой хэмжээний мөнгөн шагнал, цуурын тухай ном гардуулав. Шагналын санг П.Батчимэг захиралтай АПУ ТРЕЙДИНГ ХХК ивээн тэтгэж хамтран оролцов.

Үзлэгийн дараа бүр оролцогчдод хандаж шүүгчид болон мэргэжлийн уран бүтээлчид,

холбогдох албаны хүмүүс зөвлөгөө өгөв.

Энэхүү үзлэгт нийт 11 оролцогч оролцож үзлэгийн үйл ажиллагааг эхнээс нь дуустал үе шат, дэс дараалалтай 120 минутын дуу дүрс бичлэг, 48 ширхэг гэрэл зургаар баримтжуулж Соёлын өвийн УНБМСанг баяжууллаа.

СББӨ-ийн сурталчилгаа, мэдээлэл

- Монголын Төв номын санд СББӨ-ийг хамгаалах хэлтсээс эрхлэн гаргасан СББӨ-ийн 14 төрлийн 482 ширхэг ном, гарын авлагыг хүлээлгэн өгөх ажлыг зохион байгуулж тус байгууллагаар дамжуулан орон нутагт хүргүүлсэн байна.

- Соёлын өвийн төв нь 2015 оны 05 дугаар сарын 06-ны өдөр Монгол үндэстний соёлын биет болон биет бус өвийн судалгаа, бүртгэл мэдээллийн санг баяжуулах, олон нийтэд таниулан сурталчлах, судалгаан дээр суурилсан олон нийтийн танин мэдэхүйг дээшлүүлэх чиглэлээр дараах байгууллагуудтай **ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ САНАМЖ БИЧИГ** байгуулах ажлыг зохион байгуулсан. Үүнд:

- Шинжлэх ухааны Академийн Түүх, археологийн хүрээлэн,
- Шинжлэх ухааны Академийн Хэл зохиолын хүрээлэн,
- Уламжлалын академи,
- Олон улсын Монгол судлалын холбоо,
- МИУС-ийн Шинжлэх ухааны сургуулийн Антропологи, Археологийн тэнхим,
- Соёл Урлагийн их сургууль,
- Чингис хаан их сургууль,
- Улаанбаатар их сургуулийн Археологийн тэнхим

ЮНЕСКО-гийн санхүүжилтээр хэрэгжиж буй “Монгол туулийн уламжлалыг хадгалан хамгаалах, сэргээн амилуулах нь” төслийн хүрээнд:

- ЮНЕСКО-гийн санхүүжилтээр хэрэгжиж буй “Монгол туулийн уламжлалыг хадгалан хамгаалах, сэргээн амьлуулах” төслийн хүрээнд ШУ-ны Академийн Хэл зохиолын хүрээлэнгийн ЭША Б.Катуу, А.Алимаа нартай хамтран “Халх тууль”, “Бум-Эрдэнэ”, “Буянгийн тууль”, “Самдангийн тууль”, мөн туульч Э.Баатаржавын “Эртний урианхай туульс” номуудыг тус бүр 1000 хувь хэвлэн олны хүртээл болгов.

- “Оллоо ТВ”-тэй хамтран “Монгол тууль” болон түүний өвлөн уламжлагч нарыг алдаршуулан сурталчилах зорилгоор 2 удаагийн бүрэн хэмжээний нэвтрүүлгийг бэлтгэв:

- “Монгол тууль” танин мэдэхүйн баримтат- уран сайхны богино хэмжээний /15 минут/ киног бэлтгэн боловсруулж олны хүртээл болгоход бэлэн болоод байна.

ЮНЕСКО-гийн СББӨ-ийн жагсаалтанд бүртгэгдсэн өвийн БАТЛАМЖ хүлээн авах

Франц Улсын нийслэл Парис хотноо 2014 оны 11 дүгээр сарын 24-28-ны өдрүүдэд болсон НҮБ-ын Боловсрол, шинжлэх ухаан, соёлын байгууллага (ЮНЕСКО)-ын Соёлын биет бус өвийн конвенцийн Засгийн газар хоорондын хорооны 9 дүгээр хурлаар Монгол улсаас нэр дэвшүүлсэн Шагайн харвааг “Хүн төрөлхтний соёлын биет бус өвийн төлөөллийн жагсаалт”-д бүртгэн авсан бөгөөд БАТЛАМЖ-ийг 2015 оны 02 дугаар сарын 27-ны өдөр Дуурь бүжгийн эрдмийн театр хүлээн авах ёслолын арга хэмжээг зохион байгуулаа.

2015 онд СӨТ-ийн ББСӨХХ-ээс дуу, дүрс бичлэгээр баримтжуулсан ажлын тайлан

2015 онд DVcam хальсаар (60 минут) 9 цагийн, HD file-аар 100 цагийн дүрс бичлэг, 6386ш зургаар соёлын өвийн УНБМСанг баяжуулсан байна.

Дуу, дүрс бичлэгээр баримтжуулсан материалын агуулга.

№	Агуулга	Он, сар, өдөр	Хугацаа
1	Богд хааны ордон музей, Хаан туульсийн өргөө Туульч А. Балдандорж “Алтайн урианхай тууль”, “Аргал цагаан өвгөн”	2015.02.07	Дүрс 9 цаг
2	Шагайн харваа батламж хүлээн авах ёслол	2015.02.27	Зураг 20ш
3	Өвөрхангай аймаг Бат-өлзийт сумын Өвтийн ам, гэрийн модны бэлтгэх өвлийн бэлтгэл ажлын зураг, уламжлалт урлалын талаар өвлөгчдөөс авсан аман яриа	2015. 3.13-16	Дүрс 3 цаг Зураг 60ш
4	Шүүх эмнэлэгээс Төв гандан руу зөөсөн “Аграмба Равсалын Санжайжавын Лагшин шүтээн” занданшуулсан шарил	2015. 3.17	Дүрс 42 минут
5	Гачуурт, Туул гол, Мөсөн шагай харвааны улирлын хаалтын наадам, тоглоомын дүрэм, Мөсөн шагай тоглож буй үйл явц, тайлбар, өвлөгчдийн ярилцлага.	2015.3.19	Дүрс 40 минут
6	Налайх дүүрэг, П.Даваанням Галын тахилга тахих үйл явц, зан үйлийн тухай, ярилцлага	2015. 3.29	Дүрс 3 цаг
7	Театрийн музей, Лимбэний битүү-амьсгааг суртчилан таниулах тамхим тохижуулах, “Лимбийн эгшиг”гэрэл зураг , лимбэний үзэсгэлэн,үйл ажиллагаа	2015.4.08	Дүрс 40 минут Зураг 66 ш
8	Төв гандан, Г.Пүрэвбат лам “Аграмба Равсалын Санжайжавын Лагшин шүтээн” Занданшуулсан шарилыг сэргээн засварлах үйл явц	2015.4.13	Дүрс 10 минут Зураг 21 ш
9	Боловсрол соёл шинжлэх ухааны яам, 402 хурлын танхим, “Соёлын өвийн бүртгэл,мэдээллийн санчийг чадавхижуулах”“Түүх, соёлын үл хөдлөх дурсгалын үзлэг тооллого-2015” сургалтын үйл ажиллагаа	2015.4.23-24	Дүрс 11цаг 40 минут
10	ҮДБЭТ, “Мөнгөн мод” оны шилдэг уран бүтээл шалгаруулах ёслол	2015.5.14	Дүрс 2цаг 13 минут
11	Ш.Энхтуяа гарын увидас, эрчим хүч	2015.5.14	Дүрс 2 цаг
12	Монгол костюмд Барга үндэстний талаар хүмүүсийн ярилцлага	2015.5.22	Дүрс 1 цаг
13	Монгол шувуулахуйн холбоо М.Мэндсайхан хувийн архивийн шувуулахуйн дүрсийг СӨТ-ийн УНБМС-д авав.	2015.5.28	Дүрс 5 минут Зураг163 ш
14	Чингисийн талбай “Монгол гэр төсөл”	2015.5.29	Дүрс 20 минут Зураг9 ш
15	Австрийн сэргээн засварлалт семнар	2015. 6.4	Дүрс 2 цаг Зураг 24 ш
16	Б.Амгаланбаатар СӨТ-ийн байранд тууль хайлав.	2015.6.5	Дүрс 2 цаг
17	Биет өвийн солонгосчуудтай хийсэн санамж бичгийн зураг авав.	2015.6.9	Зураг 92 ш
18	Төрийн ордонгоос Аюуш бурханыг Дүрслэх Урлагийн Музей руу шилжүүлэв.	2015.6.15	Дүрс 18 минут
19	Увс аймгийн Хяргас сум, Туульч М.Парчины мэндэлсний 160жилийн ой “МОНГОЛ ТУУЛИЙН ТҮҮХЭН ХӨГЖЛИЙН АСУУДАЛ” олон улсын эрдэм шинжилгээний хурал	2015.6.24	Дүрс 6 цаг Зураг 40ш
20	Ховд аймгийн Ховд хот “Хан алтайн дуулал” цогцолборын шавь тавих нээлт	2015.6.28	Дүрс 1 цаг Зураг 30ш
21	Ховд аймгийн Дуут сум, Монгол улсын төрийн соёрхолт Алтайн урианхайн их туульч Б.Авирмэдийн мэндэлсний 80жилийн ойд зориулсан хөшөөний нээлтийн үйл ажиллагаа болон Б.Авирмэд судлал хэвлэлийн бага хурал	2015.6.28	Дүрс 4 цаг Зураг 580ш
22	Ховд аймгийн Хөгжимт драмын театр, Монгол улсын төрийн соёрхолт Алтайн урианхайн их туульч Б.Авирмэдийн нэрэмжит туулийн наадам	2015.06.29-30	Дүрс 15 цаг Зураг 400ш
23	Ховд аймгийн Хөгжимт драмын театрт Нэрт цуурч П.Наранцогтын нэрэмжит цуурын анхдугаар үзлэг	2015.07.01	Дүрс 8 цаг Зураг 800ш
24	Ховд аймгийн Ховд хот цуурын кино дүрс бичлэг	2015. 07.01	Дүрс 3 цаг Зураг 10ш

25	Ховд аймгийн Жаргалант, Дуут, Буянт, Мөнххайрхансуманд Урианхайн соёлын баяр ёслол, уламжлалт мэдлэг ухааны төрөл зүйлийн хайгуул судалгаа хийх, бүртгэн баримтжуулах судалгаа	2015.07.02-07.08	Дүрс 30 цаг Зураг 500ш
26	Цонжин болдог цогцолбор, Ариг Монгол хаад жуулчны бааз ,Урианхай түмний соёл, урлаг, спортын “Алтан хүрээ VIII” наадам налайх дүүрэг,	2015.07.03-05	Дүрс 160 цаг Зураг 60 ш
27	Өндөр гэгээн Занабазар Богдын мэлмий гийсний 380 жилийн ойд зориулсан “Гэгээн Гурван Үсэг Бичиг” судар бичлэгийн үзэсгэлэн Энэтхэг, Түвд,Монгол хэмээх гурван орнуудын хэл, үсэг бичгийг “Гэгээн Гурван Үсэг Бичиг” хэмээн энэхүү үзэсгэлэнд гурван орны бичиг үсгийн соёлыг Занабазарын нэрэмжит Дүрслэх Урлагын Музейд 16 зүйлийн үсэг бичгийг дэлгэн харуулав.	2015.07.10	Дүрс 1 цаг Зураг 58ш
28	Булган аймгийн Сайхан сум, “Дөрвөн түмэн адууны баяр”	2015.07.18-19	Дүрс 5 цаг Зураг 160ш
29	Өвархангай аймаг Хар хорин сум, “Айрагны нутгаар-2015” Өндөр Гэгээн Занабазарын түмэн өлзий гийсний 380жилийн ой Даншигийн их баяр наадамд зориусан “Хөхүүрийн монгол айрагны дээжээр мялаалга өргөмүй” мялаалгын баяр	2015.07.25	Дүрс 16 цаг Зураг 350ш
30	“Жангар судлал”олон улсын эрдэм шинжилгээний хурал, “Ойрд түмний наадам” Увс аймгийн улаангом хотодхооронд болов	2015.08.01-06	Дүрс 20 минут Зураг 320 ш
31	Улаанбаатар хот, Хүй долоон худагт “Даншигийн наадам- Хүрээ цам-2015” 108 цам	2015.08.09	Дүрс 10 цаг Зураг 160ш
32	Соёлын өвийн төвд зураг, Б.Катуу гуай туулийн тухай ярив. Мөн түүний номын зураг	2015.08.13	Дүрс 1 цаг 30минут Зураг 50ш
33	Чингисийн хүрээ цогцолборын “Чингис хааны төв өргөө” –нд эрдэм шинжилгээний хурал болов.	2015.08.21	Дүрс 2цаг Зураг 150ш
34	Шувуулахуй наадмын хүрээнд Занабазарын нэрэмжит Дүрслэх Урлагын Музейд “Монгол шувуулахуй” үзэсгэлэн нээгт	2015.08.21	Дүрс 1 цаг Зураг 100ш
35	Чингисийн хүрээ цогцолборт “Шувуулахуйн” наадмын нээлт	2015.08.22	Дүрс 2 цаг Зураг 200ш
36	Төв аймаг баян суманд шувуулахуйн хиймэл үүр тойрох үйл ажиллагаа	2015.08.24	Дүрс 30минут Зураг 50ш
37	Богд хааны ордонд Хаан туульсийн өргөөнд “Цуурын сургалт”-ын нээлтийн үйл ажиллагаа болов.	2015.09.04	Дүрс 35минут Зураг 17ш
38	Нийгэмд хандсан сайн үйлсийн аян	2015.09.11	Дүрс 20минут Зураг 214ш
39	Өвөрмонголоос ирсэн оролцогчидийг Соёл урлагийн их сургуулийн хөөмэйн танхимтай танилцуулав.	2015.09.14	Дүрс 10 минут Зураг 50 ш
40	Монгол улсын драмын эрдмийн театр,Олон улсын “Хөөмий наадам”	2015.09.14-16	Дүрс 2 цаг 15 минут Зураг 141 ш
41	Монголын үндэсний музей, Хувилай сэцэн хааны мэндэлсэний 800 жилийн ойд зориулсан үзэсгэлэн Хувилай сэцэн хааны өв	2015.09.15	Зураг 153 ш
42	Чингисийн талбай, Хувилай сэцэн хааны мэндэлсэний 800 жилийн ойд зориулсан нээлтийн үйл ажиллагааны тоглолт	2015.09.15	Дүрс 15 минут Зураг 173 ш
43	Үндэсгий номын сан, Хувилай сэцэн хааны мэндэлсэний 800 жилийн ой “Хөөмий баяр” олон улсын эрдэм шинжилгээний хурал , Хувилай сэцэн хааны мэндэлсэний 800 жилийн ой марк нээлт	2015.09.16	Дүрс 2 цаг Зураг 189 ш
44	Өвөрмонголоос ирсэн оролцогчидийг Хаан жист амралтанд “Хөөмий баяр” хаалт	2015.09.16	Дүрс 15 минут Зураг 50 ш
45	Монгол улсын их сургууль, У.Эрдэнэбатаас “Монгол шувуулахуйн” тухай яриа авав	2015.09.22	Дүрс 20 минут
46	БСШУЯ ,Олон улсын үндэсний хувцасны хурал	2015.09.22	Дүрс 2 цаг
47	Соёлын төв өргөө, Хувилай хаан олон улсын эрдэм шинжилгээний хурал	2015.09.23	Дүрс 20 минут

48	Өвөрхангай аймаг өлзийт, 10 хурууны тоглоом дэмбээдэх	2015.09.24-25	Дүрс 3 цаг Зураг 160ш
49	Үндэсний түүхийн музей, А.Очир гуай Монгол шувуулахуйн тухай яриа өгөв.	2015.09.29	Дүрс 3 минут Зураг 2ш
50	Богдын музейд, “UNESCO-ийн Соёлын Биет Бус Өвийн жагсаалтанд нэр дэвшүүлэх хэрэглэгдэхүүнийг боловсруулах” чадавхи бэхжүүлэх сургалт	2015.10.05-09	Дүрс 5 цаг Зураг 151 ш
51	Үндэсний филормон “Соёлын биет бус ба төрийн бус байгууллага” номын нээлтийн үйл ажиллагаа	2015.10.19	Дүрс 8 минут Зураг 24ш
52	Ш.Энхтуяа гарын увидас, эрчим хүч	2015.10.20	Дүрс 2 цаг
53	Шороон Бумбагарын археологийн дурсгалыг бэхжүүлэх, ханын зургыг хамгаалах,сэргээн засвардах сургалт	2015.10.21	Дүрс 34 минут Зураг 79 ш
54	Төв гандан “Аграмба Равсалын Санжайжавын Лагшин шүтээн” Занданшуулсан шарил олон нийтэд мөргүүлэв.	2015.10.21	Дүрс 30 минут Зураг 3ш
55	СӨТ уртын дуу Д.Балжинням, дөрвөд тууль И.Төгсөө дөрвөд бүжиг	2015.10.22	Дүрс 2 цаг 30 минут Зураг 3ш
56	Архангай аймаг Цахир сум“Аграмба Равсалын Санжайжавын Лагшин шүтээн” занданшуулсан шарил эх газар тавив.	2015.10.24	Зураг 321ш
57	Монгол шувуулахуйн баримтат киноны дүрс, Д.Гантөмөрийн яриа .	2015.10.29	Дүрс 6 минут
58	Монгол шувуулахуйн баримтат киноны дүрс, Б.Аким гуайн яриа .	2015.10.29	Дүрс 10 минут
59	Р.Галбаяр Зүү ороох хатгамал, судар	2015.11.2	Дүрс 40 минут Зураг 4 ш
60	Богд хааны ордон Хаан туульсийн өргөө “Монгол туулийн хадгалаж хамгаалах” төслийн хүрээнд Шавь сургалтын тайлан, туульч багш, шавь гарын уулзалт	2015.11.16-18	Дүрс 11 цаг Зураг 600 ш
61	Занабазарын нэрэмжит Дүрслэх Урлагийн Музей Очирваан цамын хувцас	2015.11.26	Дүрс 40 минут Зураг 41ш
62	Цуурын төвийн бүсийн үзлэг Хан-Уул дүүргийн соёлын ордон	2015.11.27	Дүрс 2 цаг Зураг 50 ш

“Соёлын биет бус өвийн хадгалалт, хамгаалалтын менежментийн систем”-ийн бүтэц, зохион байгуулалт



БҮТЭЭГДЭХҮҮН НИЙЛҮҮЛЭХ АНГИ-3. СОЁЛЫН ӨВИЙГ СЭРГЭЭН ЗАСВАРЛАХ ХЭЛТСИЙН СТРАТЕГИЙН ЗОРИЛТЫГ ХАНГАХАД ЧИГЛЭСЭН АЖИЛ, ҮЙЛЧИЛГЭЭ

Энэ төрлийн ангид 1 тусгай арга хэмжээ, 6 үндсэн арга хэмжээ нийт 7 төрлийн ажил багтсан болно.

ТУСГАЙ АРГА ХЭМЖЭЭ

"Хэрлэн барс" суваргыг бэхжүүлэх сэргээн засварлах ажил

Нэг. Хэрлэн барс хотын цамхагийг сэргээн засварлах ажилд хэрэглэх хөх тоосго хийх ажил

1.1. Тоосго шатаах, зуух барих ажил

Дорнод аймгийн Цагаан-овоо сумын нутагт орших 10 дугаар зууны үед холбогдох Хэрлэн барс хотын суваргыг одоогийн байгаа эх төрх байдалдньбэхжүүлэх, сэргээн засварлах зорилгоор суваргад ашигласан тоосгоны хэмжээ, чанартай ижил 8-10 мянган ширхэг хөх тоосго хэрэглэгдэх тул дээрх тоосгыг уг дурсгалын орчимд бэлтгэхээр төлөвлөсөн юм.

Тоосго хийх хар, цагаан өнгийн шавар татах, тоосго шатаах зуухны нүх ухах , хэвлэсэн тоосгоо хатаах талбайн хар шороон хөрсийг хуулж тэгшлэх, тоосго шатаах зууханд ашиглах 10500 ширхэг тоосгыг Дорнод аймгаас татаж дурсгалын дэргэд байрлуулах ажлыг 2015 оны 5 дугаар сар 21-ний өдрөөс эхлэн 6 дугаар сарын 04-ний өдөр хүртэл 14 хоногийн хугацаанд хийлээ.

Тоосго шатаах зуух барих эхний ажил

Тоосго шатаах нүхэн зуух барих газрыг цамхагаас зүүн урагш 1.2 кморчимд Хэрлэн голын сав дагуух мөргөцөгийн эрэг дээр тэгш газар сонгов.

Шатаах зуух барих нүхний амсарын диаметр 4.2 метр, нүхний гүн 4.75 метр болно. Зуухны зургаан талд 6 ширхэг яндангийн нүх, 1 агаарын хоолойн нүхийг тус тус гаргалаа. Эдгээр нүхний диаметр 50 см, гүн нь 3. 20 метр боллоо. Тоосго оруулах үүдэвчний хэсгийн урт нь 2метр, өргөн нь0.80см, гүн нь 0.50см болно. /Гэрэл зураг 1, 2/

Зуухны үүдэвч хэсгийн урт 6метр, гүн нь 4.5 метр, өргөн нь 1.5метр ба зуухны хэсэг үүдэвч хоёрыг холбосон хүзүүвч хоолойг 4.5 метрийн гүнд 4.75 метр урттай хонгил ухаж холбосон болно. /Гэрэл зураг 3. 4/

Тоосго шатаах зуух барихад ашиглах 10.500 ширхэг улаан тоосгыг Дорнод аймгийн төвөөс татаж зуух барих газар байрлуулах ажлыг тоосго нийлүүлэхээр гэрээ хийсэн "Дорнод зангиат" ХХК 2015 оны 5дугаар сарын 23-нд газар дээр нь тээвэрлэн авчирч хүлээлгэн өгсөн. /Гэрэл зураг 5/

Тоосго шатаах зуух барих 2 дахь ажил

Тоосго шатаах зуухыг барих ажилд БНХАУ- улсын Шаньси мужийн зуух барих мэргэжилтэн Chang Mingsuoөөрөө биечлэн удирдаж, барьж дуусгаар 2015 оны 6 дугаар сарын 29-нөөс 7 дугаар сарын 24-ний өдөр хүртэл ажиллав.

Тоосго шатаах зуух барих ажлын эхэнд зуухны ам яндан, агаарын хоолой, нүүрс татах нүх, үүдэвчний орох хэсгүүдийн хэмжээг томосгож ухах, сул хайрган хөрсний нуралттай хэсгүүдийг тоосгоор доторлон засварлах ажлуудыг хийлээ. Зуухны ам галлагааны хэсгийн нүхийг томосгож галд тэсвэртэй тоосгоор доторлож хөрсний нуралтаас хамгаалсан хамгаалалт хийв. /Гэрэл зураг 6/

Зуухны яндангийн агаарын хоолой, нүүрс татах нүхнүүдийг үргэлжлүүлэн 3 метр хүртэл ухаж, зуухны дотор тал, яндан агаарын хоолой, нүүрс татах нүхнүүдийн хэсэгт газрын түвшингээс доош 1.5-3 метрийн хооронд үргэлжлүүлэн хийж, байгалийн сул хайрган хөрсний нуралтыг зогсоож хамгаалах зорилгоор энэ үеийн хайрган хөрсийг 12-15 см өргөнтэйгээр нурааж улаан тоосгоор доторлон хамгаалалт хийв.

Мөн зуухны шалны хэсгийг 30 см-ээр доошлуулан 3.30 метр хүртэл ухав. /Гэрэл зураг 7. 8/

Үүдэвчний орох хэсгийн хайрган хөрс, шавар хөрстэй хэсгүүдэд банзаар хашлага хийж шат засах, 4 метр үргэлжлэх хонгилын хэсгийн өргөнийг 1.5 метр, таазны хэсгийг 1.6 метр өндөр болгон нэмж ухлаа.

Зуухны амны урд талын галлагааны хэсгийн хонгилын таазыг 1.8 метр өндөр болгож, дээрх хэсгүүдэд нуралтаас хамгаалсан тоосгон арк хийж доторлогоо хийв. /Гэрэл зураг 9. 10/

Тоосго шатаах зуухны газрын гүнд байрлах хэсгүүдийг өргөтгөн тоосгоор доторлон засварлаж дуусаны дараа зуухны дээд хэсгийг барьж босгох ажлыг зуухны нүхний амсар дээр 4.2 метрийн диаметртэй 2 метрийн өндөртэй хагас дугуй кубик оройн хэсгийг тоосгоор өрж босгох ажлаар эхэлсэн болно.

Өдөрт 8-10 үе тоосгон өрлөг өрж, өмнөх өдрийн өрлөгийн бэхжилт явагдсаны дараа, дараагийн үеийг өрөх байдлаар 50 давхар тоосгон өрлөг хийгдсэн. Кубик оройн өрлөгийн хамт гадна шороон хучилтыг давхар хийлээ. Кубик оройн дээд хэсэгт 0.80см диаметртэй дугуй нүх гаргалаа. /Гэрэл зураг 11.12/

Зуухны кубик оройн баруун талд зуух руу тоосго зөөж оруулах 80 см өргөнтэй, 1.60 метрийн өндөртэй 2 метрийн урттай хагас дугуй оройтой үүд гаргав. Зуухны 6 ширхэг яндан агаарын хоолой, нүүрс татах нүхнүүдийн дээр тоосгоор 2 м өндөртэй яндан өрж зуухны оройн хэсэгтэй ижил өндөртэй болголоо. /Гэрэл зураг 13. 14/

Зуухны кубик орой, яндангуудын хэсгийн шороон хучилтанд 60 м3 шороо зөөж шороон хучилтын өндөр 2 метр гаруй болов. /Гэрэл зураг 15/

<u>1.2 Тоосго цохиж, хэвлэх ажил.</u>

Шавар татах, талбай засах

Хэрлэн барс цамхагийг сэргээн засварлах ажилд хэрэглэгдэх хөх тоосго хийх шаврыг 2014 онд хээрийн судалгааны ажлаар сонгосон билээ.

Цамхагаас зүүн тийш 15 км-т байрлах Зүүн түрүүний тариалангийн талбайн зүүн хойд талын өндөр мөргөцөгийн баруун хэсгээс тоосго хийхэд ашиглаж болох бор, шар өнгөтэй 2 төрлийн шаврыг зөөж тээвэрлэн авчирсан ба шар өнгийн шаврын нийт хэмжээ 36м3 болно. /Гэрэл зураг -16/

Түүхий тоосго хатаахад ашиглах 22 х 22 метрийн хэмжээтэй талбайн хар шороон хөрсийг хусаж тэгшлэх, хотгор гүдгэрийг засах ажлыг хийж гүйцэтгэлээ. /Гэрэл зураг -17/

Тоосго цохих, хэвлэх ажлын явц

Тоосго цохих ажилд гурван төрлийн бор, цайвар саарал, зуухны нүх ухахад гарсан бор шаргал өнгийн шавруудыг ижил хэмжээгээр хольж тоосго цохих түүхий шаврыг бэлтгэлээ.

Тоосго цохих шавраа шигшиж ангилах, ижил хэмжээгээр хольж тогоолох зэргээр боловсруулах ажлыг урьдчилан хийж бэлтгэж байв. Мөн тоосго цохих, хэвлэх явцад хэт халуун, чийг багатай хуурай байсан тул хэвлэсэн тоосго хатаах талбайн хотгор гүдгэрийг нарийн тэгшлэх, услаж чийглэн норгох ажлыг давхар хийж гүйцэтгэлээ. /Гэрэл зураг -18.19/

Эхний 2 өдөрт цохисон тоосго хатахдаа хагарч хэрэглэх боломжгүй болсон батоосго хагарах шалтгаан нь өдөртөө хэт халуун, тоосго хатаах талбайн хөрс хуурайшилт ихтэй зэргээс шалтгаалсан байна. Иймд талбайг байнга услаж , өдөрт цохисон тоосгоо хучиж чийгийг нь хадгалж, орой нар шингэхээр хучилтаа авч шөнө хатаах байдлаар тоосгыг хэвлэлээ. Тоосго цохих ажилд 5-6 хүн ажиллаж өдөртөө 400- 500 ширхэг тоосго цохин хэвлэж, тоосгоо хаталтаар нь ангилах, хэлбэрийг засах, хураах, хучих ажлуудыг тоосго хэвлэх үед өдөр тутам хийсэн болно. Тоосгоны зуурмаг, хатаалтын талбайг услахад өдөрт 3 тонн ус хэрэглэж байв.Өдөрт хэвлэсэн тоосгоноос хатаалт хураалтын явцад хагарах хэлтрэх зэрэг гэмтлээр 20-30 орчим ширхэг тоосгоны хорогдол гарч байв. /Гэрэл зураг - 20/

Хатаалт бүрэн явагдсан тоосгоо өдөр өдөрт нь ангилан шатаах зуухандаа оруулж

өрөх ажлыг 2015 оны 7 дугаар сарын 16-наас эхлэж өдөрт 800- 1000 орчим тоосго зөөж нийт 8400 ширхэг тоосго зууханд оруулж өрлөө. /Гэрэл зураг - 22/

1.3 Тоосго шатаах, хөргөх ажил.

Тоосго шатаах явц

Шатаах зуухны оройн хэсгийн хучилтыг нэмж давхарлах, усны тогооны хэсгийг засварлах, үлдэгдэл тоосгоо зөөж оруулах, тоосго зөөж оруулсан зуухны амыг хаах, зуухны галлагааны амны хэсгийг барих ажлуудыг хийхэд 3 хоног зарцуулж, 2015 оны 8-р сарын 07-ноос зуухны галлагааг эхлэв. /Гэрэл зураг - 23, 24, 25, 26/

Тоосго бүхий зуухыг нийт 17 хоног өдөр шөнө тасралтгүй галлаж, галлагааны туршид хэрэглэсэн хүрэн нүүрсний илчлэгийн хэмжээ тоосго шатаахад шаардагдах илчлэгийн хэмжээнд хүрэхгүй, шаталтын хугацаа маш богино байсан тул Дорнод аймгийн төвийн дэргэдэх Адуунчулууны уурхайгаас 27.2 тонн нүүрс татаж, галлагааны хаалт хийхэд илчлэг өндөртэй нүүрс хэрэгтэй болсон тул Говьсүмбэр аймгаас олборлосон Алаг толгойн нүүрс 5тонн, Улаанбаатар хотын дэргэдэх Налайхын нүүрс 350 кг нийт 32.5 тонн нүүрс татаж хэрэглэв. Нүүрсний илчлэг бага, шаталт хурднаас шалтгаалан өдөр шөнийн туршид ээлж гарган 1цагаас 1,30 минут тутамд галлагаа хийж байв. /Гэрэл зураг - 27, 28/

Тоосго хөргөлт

Хөргөлтын ажлыг 2015 оны 8 дугаар сарын 24-нөөс эхлэж 10 хоног турш үргэлжлүүлэв. Хөргөлтийн ажилд өдөрт 10тонн ус хэрэглэлээ. Зуухны дээд талын тогоог 2 цаг тутамд усаар дүүргэж байсан ба нэг удаа усаар дүүргэхэд 500-600 литр ус хэрэглэж байв.

Зуухны хажуу талд шөнийн ээлжинд хэрэглэх 5 тонн усан сан бэлтгэж усаа хуримтлуулсан. /Гэрэл зураг - 29, 30/

Усан хөргөлтын явцад 8 дахь өдрөөс эхлэн зуухны амны хэсгүүдэд усны уурны нэвчилтын толбо үүсэж эхэлсэн тул 10 дахь өдөр нь бүтэн усан хөргөлт хийж хөргөлтийг зогсоов. /Гэрэл зураг - 31, 32/

Усан хөргөлтийг дуусанаас 1 өдрийн дараа зуухны дээд хэсэгт тоосго багтахуйц жижиг нүх гаргаж нэг ширхэг тоосго сугалж авсан ба шатааж, усан хөргөлтөөр хөргөсөн тоосгоны өнгө хөх саарал болсон байв.

Түүхий тоосго шатаах, хөргөх ажлыг 2015 оны 8 дугаар сарын 03 наас 9 сарын 04-ний хооронд 30 хоногийн хугацаанд хийв.

1.4 Шатны өргөтөгөл

Хэрлэн барс хотын найман талт тоосгон цамхагийг тойруулан долоон давхар нийт 19 метр өндөр төмөр шат 2014онд зөвхөн хүн гарч судалгаа хийх хэмжээнд нарийхан угсарсан байна.

Шатны өргөн 0.80см орчим өргөнтэй хийгдсэн байна.2 дахь давхарын шатны тулгуур баганыг цамхагний тоосгоны дээр дарж, хүнд даралт өгөхүйц байдлаар шийдсэн дээш өрсөн бүх давхарын даац энэ хэсэгт даралт өгч, суварганы тоосго хагарах бутарч унах байдлаар гэмтэл учруулсан байна.

Давхар хоорондын тулгуур цөөн савалгааны эсрэг хөндлөн холбоос муу хийгдсэнээс болж савалгаа их хөдөлгөөнтэй, мөн давхар бүрийн шат хэтэрхий нарийн, хүн дээр нь ажиллах боломжгүй хийгдсэн байна.

Давхар хооронд гарах шатыг хөдөлгөөнтэй эгц босоо хийсэн нь дээш доош ачаа зөөх боломжгүй, 2 гараараа бариад буухад хүртэл эрсдэлтэй хийгдсэн байна. Давхар бүрийн шатны банзыг доош буулган хураасан байна. Энэ удаагийн шатны өргөтгөл хийх ажлыг ерөнхий аргачлалын дагуу доорхи дараалалаар хийж гүйцэтгэлээ.

Үүнд:

- Цамхагны гадна шатны бүх давхарын тулгуур багананд нэмэлт тулгуур хөл хийх.
- 2 дахь давхарын шатны тулгуур баганын суварган дээр дарсан хэсгүүдийг өөрчлөн цамхагаас хөндий зайтай хийх.

- 1 дүгээр давхараас эхлэн бүх давхаруудад өмнөх шатны гадна талаар 1.20 см өргөнтэй өргөтгөл хийх.1 дүгээр давхараас эхлэн бүх давхаруудад шатны өргөтгөлийн гадна ирмэгт 90 см өндөртэй хашлага хийж өгөх.

- Давхар бүрийн өргөтгөлийн гадна талаар дээш явган гарах шатыг 80 см өргөнтэй, хашлага бариултай налуу хийж, давхар бүрийн шатны найман талд савалгааны эсрэг босоо налуу холбоос бэхэлгээ хийх.

- Шатны бүх давхаруудыг хуучин шинэ банзаар шаллах. Шатны найман талаас троссоор татлага хийх.

- Шатны 1- ээс дээш давхар бүрт тоосго шавар гаргах цахилгаан өргүүрийн хэсгийг барих.

- Цамхагны дотор талын шатанд 80см өргөнтэй өргөтгөл, шатны дотор талд хашлага, давхар бүрт савалгааны эсрэг хөндлөн налуу холбоос хийх.

Цамхагны гадна долоон давхарын шатны 1 ба 2 дугаар давхар бүрийн найман булангийн тулгуур багананд нэмэлт зэрэгцээ тулгуур хөл хийх ажлыг 1 дүгээр давхараас эхлэв. 1 дүгээр давхарын шатны булан бүрийн тулгуур хөл нумарч хазайсан хөлний доод хэсэгт ивсэн чулуун ивээс хагарч доош суулт өгсөн хэсгүүдийн ивээсийг солив. Нэмэлт хөлийг 1 дүгээр давхарын доод хэсгээс 2 дугаар давхарын дээд хэсэг хүртэл 6м - ийн урттай трубагоор 1 ба 2 дугаар давхаруудын найман булангийн тулгууруудыг хамт хийв. Энэ хэсгийн нэмэлт тулгуур хөлийн доод үзүүрийг зэрэгцээ хөлтэй нь богино турбогоор, дунд хэсэгт нь 1 дүгээр давхарын дээд хэсгийн хөндлөн турботой, дээд үзүүрийг 2 дугаар давхарын доод хөндлөн турботой холболт хийж, хөдөлгөөн нумралт үүсэхээс хамгаалав. /Гэрэл зураг - 33, 34/

3 дугаар давхарын шатны тулгуур баганын доод үзүүрүүд суварган дээр дарсанаар дээд талын бүх шатны жин энэ хэсэгт даралт өгч, салхинд шат савлах хөдөлгөөний нөлөөгөөр суварганы тоосго хагарах бутрах байдлаар доош суулт өгсөн байна. Энэ хэсгийг өөрчлөхөд 2 дугаар давхарын сууринаас 3 дугаар давхарын суурь хөндлөн турбаны хооронд хоёр зэрэгцээ бага зэрэг налуу тулгуур багана нэмэлтээр хийж, найман булан бүрт гурван багана хийж, дээд шатны хүндийн жинг энэ хэсэгт шилжүүлэв. Үүний дараа шатан дээр дарсан хэсгүүдийг суварганаас хөндий зайтай байхаар тасдаж богиносгов. 3, 4, 5, 6 дугаар давхаруудын найман талуудын гол хэсгүүдэд нэмэлтээр эгц босоо тулгуурууд хийв. /Гэрэл зураг - 35-42/

Цамхагны бүх давхаруудад өмнөх шатны гадна талаар 1.20 см өргөнтэй өргөтгөл хийх ажлыг 1 дүгээр давхараас эхлэн хийв. Өргөтгөлийн шатыг угсрахад суварганы давхар бүрийн найман талын буланд нэг, булан хоорондын хэсгүүдэд 2 босоо багана байхаар төлөвлөн хийв.

1,2,3 дугаар давхарын өмнөх шатны хөндлөн богино гурван холбоосуудыг 1.80-2.40 метрийн урттай холбоосоор сольж, холбоосын тоог урт талтай хэсгүүдэд найм, богино талтай хэсгүүдэд зургаан холбоосоор нэмэлт холболт хийж, холбоосны зайг ойртуулсанаар шатны шал банз хотолзох, хугарахаас хамгаалах, мөн шатны савалгаа ганхалт багасав.

4,5,6,7 дугаар давхарын шатны өргөтгөлийг доод давхаруудтай ижил холболтоор хийв. Нэгдүгээр давхараас эхлэн бүх давхаруудад ажилтнуудын аюулгүй ажиллахад нөлөөлөх хашлагыг шатны өргөтгөлийн гадна ирмэгтэй зэрэгцээ түвшинд буюу 0.90 -1.0 метр өндөртэй хөндлөн хашлага хийлээ. /Гэрэл зураг - 43, 44, 45/

Давхар бүрийн өргөтгөлийн гадна талаар дээд давхаруудад явган гарах шатыг 0.80 см өргөнтэй налуу, бариул хашлагатай хийв. Цамхагны зургаан талд тойруулан зургаан хэсэгт явган шат хийж, шатны гишгүүрийг 8-12 эгнээтэй, эгнээ бүрт хоёр зэрэгцээ турбагоор гишгүүр хийлээ. Давхар бүрийн шатны найман талуудад савалгаа ганхалт хөдөлгөөний эсрэг хөндлөн диагнал холбоосуудыг нэмэлтээр хийв. /Гэрэл зураг - 46, 47, 48, 49, 50/

Шатны бүх давхаруудыг хуучин, шинэ банзаар шаллахад өргөтгөлийн хэсгийн шалыг нарийн хэсэгт 4-5 ширхэг, өргөн хэсэгт 6-7 ширхэг банзаар, өмнөх шатны банз дутуу хэсгүүдийг 7-8 ширхэг банзаар шаллав. Шатны 4 талаас троссон татлагатай байсан дээр

4 татлага нэмж найман талаас нь троссоор татлага хийв. /Гэрэл зураг - 51, 52, 53/

Шатны 1 дүгээр үеэс дээш давхар бүрт тоосго шавар зуурмаг ачаа гаргах цахилгаан өргүүрийн суурийг суварганы урд талд хийж өгөв. Цахилгаан өргүүр бүхий ачаа ачих шатны хэсгийн нийт өндөр нь 20 метр ба 6 хөлтэй залгаа бүрийн хэсэгт нэмэлт бэхэлгээ, ганхалтаас хамгаалсан хөндлөн диагнал холбоосуудын хийсэн. Давхар бүрт гарсан ачааг буулгах хүзүүвч хоолойг давхар тус бүрт хийж банзаар шаллав. Цахилгаан өргүүрийн тавцанг гүйх троссон 4 ширхэг зам хийж ачааны тавцан холбож өгөв . /Гэрэл зураг - 54, 55, 56/

Цамхагны дотор талын таван давхар шатыг давхар бүрт нь дөрвөн талыг нь 0.80 см-ээр дотогш нь өргөтгөж, дөрвөн талын богино хөндлөн 3 холбоосууд урт холбоосоор сольж, холбоосны тоог тал бүрт 5-6 ширхэгээр нэмж холболт хийв. Өмнөх хэсгийн болон өргөтгөлийн хэсгүүдийг шинэ банзаар шаллав. Шатны тулгуур хөлнүүдийн ивээсийг засаж хөлөнд нь тушаа холболтууд хийв. Мөн давхар бүрт савалгааны эсрэг хөндлөн налуу холбоос хийв. /Гэрэл зураг - 57, 58, 59, 60, 61, 62/

Шатны өргөтгөлд ашигласан материалын зарцуулалт

1-р давхарт турба 63ш
2-р давхарт турба 55ш
3-р давхарт турба 48ш
4-р давхарт турба 45ш
5-р давхарт турба 41ш
6-р давхарт турба 38ш
7-р давхарт турба 28ш
Суварганы дотор талд турба 37ш
Өргөгч механизм суурилуулах хэсэг турба 44 ш
Хомучик 12 шуудай
Шатны банз 320 ширхэг
Прусс 10 боодол
3 хайрцаг хадаас
Тасдагч ир 18 ширхэг

Хэрэглэгдээгүй үлдсэн материал

Турба 90- 100 орчим ширхэг
Холбогч хомучик 6 шуудай
Банз 20 орчим ширхэг
Тасдагч ир 16 ширхэг

Хоёр. Дурсгалын сэргээн засварлалтын ажил

<u>2.1.Цамхагийн ханын тоосгон өрлөгийг сэргээн засварлах ажилд хэрэглэх шавар зуурмагийн найрлагыг турших.</u>

Цамхагаас зүүн тийш 15 км-т Зүүн түрүүний тариалангийн талбайн зүүн хойно байрлах өндөр мөргөцөгийн баруун хэсгээстоосго хийхэд ашигласан шар өнгийн шаварнаас 2 тонн орчмыг зөөн авчирч цамхагийн дотор талын ханын өрлөгт ашиглалалаа.Зөөж авчирсан шаврын барьцалдалгаа шаварлаг чанар нь бага байна гэж үзсэн тул Эрээний хоолойн

№	Шавар	Элс	Шохой
1	60%	20%	20%
2	50%	25%	25%
3	75%	12.5%	12.5%
4	75%	25%	
5	75%		25%

Хүснэгт 1

цайвар өнгийн шаварнаас 1 тонн орчимыг татан авчирч өрлөгийн шавар зуурмагийн найрлагыг хэд хэдэн төрлөөр туршиж үзэв. Туршилтаар хийгдсэн зуурмагуудын бэхжилтийг ирэх жилийн сэргээн засварлалтын ажил эхлэх үед шалгаж үзэхээр тооцоолов. / Хүснэгт 1. /

Цамхагийн баруун хойд талын 1,2 дугаар давхарын залгаа, шаталсан өрлөгийг сэргээсэн тоосгоны өрлөгт хүснэгт 1–ийн 3 дахь найрлагаар шавар зуурч ашиглав. / Гэрэл зураг - 63 А, 63 Б/

2.2.Цамхагийн гадна өрлөгийн завсарт хийсэн шохойн шаваасны найрлагыг турших.

Цамхагийн гадна талд тоосгон өрлөгийн завсарт чигжсэн шохойн шаваасны найрлагыг хэд хэдэн төрлөөр туршиж үзэв. \Хүснэгт 2.\ Цамхагийн баруун хойд талын 4 дүгээр давхарын ханын хуучин тоосгон өрлөгийн завсаруудад шохойн чигжээсийн хагарал тогтоц, хатуулаг чанарыг туршиж 4 хэсэг газарт чигжээс хийв. /Гэрэл зураг - 64/

2.3. Цамхагийн гадна ба дотор талын нурсан тоосгон өрлөгийг хэсэгчлэн

№	Шохой	Элс
1	85 %	15 %
2	90 %	10 %
3	95 %	5 %
4	100 %	

Хүснэгт 2

засварлах.

Цамхагийн тоосгон өрлөгийг сэргээн засварлах ажлыг засварын ажлын зургийн дагуу хуучин тоосгонд бэхжүүлэгч түрхэж, тоосгон өрлөгийн завсарт ган холбоосуудыг хавчуулан өрлөгийг хийлээ.

Засварын ажлыг 1дүгээр давхар буюу зоорийн дотор талын хэсэгт нурсан ханыг сэргээн засварлах ажлаар эхлэв. Энэ давхарын 5 хэсэг газарт их бага хэмжээтэй нурсан ханын өрлөгийг засварлан нөхөлт хийлээ. /Гэрэл зураг - 65. 66. 67. 68. 69/

1 дүгээр давхарын тоосгон өрлөгийг 1 ба 2 дугаар давхарын залгааны хэсэгт хийгдсэн модон багана, дам нуруунууд хүртэл өрж өрлөгийг сэргээв. /Гэрэл зураг - 70. 71. 72. 73/

Цамхагийн гадна талын өрлөгийн нуралттай хэсгийг хэсэгчлэн сэргээх ажлыг цамхагийн баруун урд, баруун, баруун хойд, /Гэрэл зураг - 74. 75. 76. 77. 78.79. 80/ зүүн урд, зүүн талын хэсгүүдийн 1 болон 2 дугаар давхарын залгааны шаталсан өрлөгүүдэд зургийн дагуу хийв. /Гэрэл зураг - 81. 82. 83. 84. 85/

Дээрх сэргээн засварласан өрлөгийн тоосгоны завсарт хийх шохойн лагшингийн чигжээсийг хүснэгт 2-ийн 3 дахь найрлагаар найруулж чигжээсийг хийлээ. /Гэрэл зураг - 86. 87/

2.4. 2015 онд тоосгон өрлөг сэргээн засварлах ажилд хэрэглэсэн материал

Ашигласан тоосгоны тоо 1600ширхэг – 66м2 өрлөг хийсэн.
Шохойн хэмжээ 22 уут - 1100 кг
Шаврын хэмжээ 3 тонн
Элс 1 тонн

Гурав. 2016 оны сэргээн засварлалтын явцад нэмэлтээр хийх ажлууд

2016 оны сэргээн засварлалтын явцад ажлын зурагт тусгагдаагүй нэмэлтээр оруулж хийх, ажлын зурагт тусгагдсан хэдий ч дахин нягтлан үзэх шаардлагатай ажлууд байна.

Үүнд:

3.1.Цамхагийн суурийн хэсэгт ашиглах шавар чулууны хэмжээг гаргах, өрлөг, сууринд ашиглах шаврыг сонгох.

Цамхагийн дагдаршуулсан шавар чулуун суурь олон жилийн явцад борооны усанд идэгдэн урсах байдлаар цамхагийн суурийн эргэн тойронд их бага хэмжээгээр нимгэрч багассан байна. Энэ суурийн хэсгийн дагдаршуулсан шавар бүтэц, чулуун өрлөгийг анхны байдлаар сэргээн засварласны дараа цамхагийн суурь хэсгийн тоосгон өрлөгийг засварлах ажлыг хийх шаардлагатай байна. Энэ хэсгийн ажил 2015 оны ажлын зурагт тусгагдаагүй болно. Суурийн хэсгийн дагтаршуулсан шавар, чулуун өрлөгийн засварлах ажилд хэрэглэх шавар элсний хэмжээ 20м^3, чулууны хэмжээ 10м^3 орно гэж тооцоолов.

Суурийн хэсэгт ашиглах хавтгай чулууг дурсгалаас баруун хойд зүгт 35 км-т байрлах Хадатын хөндий хэмээх газраас, одоо байгаа суурины шавартай адил төрлийн цайвар шаргал өнгийн шаврыг дурсгалаас мөн баруун хойд зүгт 18-км орчимд байрлах Эрээний хоолой хэмээх намаг шавартай газраас татаж болохоор байна.

Цамхагийн шавар суурийг 10 см орчмын зузаантай дэлдэж нягтаршуулан хатаан, 3-4 үе давхарлаж хийнэ. Шавар суурийн дээр чулуун өрлөгийг 1 үе өрж хийнэ. Суурийг засварлах ажлын хугацаа 8- 12 хоног гэж үзлээ.

3.2.Цамхагийн 1,2 дугаар давхарын ханын залгааны тоосгон өрлөгүүдийн дунд сэргээн байрлуулах багана, дам нуруунуудын хэмжээсүүдийг гаргасан тухай

Цамхагийн дотор талын 1, 2 -дугаар давхарын ханын залгааны хэсгийн тоосгон өрлөгийн дотор хийсэн багана, дам нуруу, ханын өрлөгийн завсарт орсон шалны банзны дутуу хэсгүүдийг шинээр сэргээн байрлуулсаны дараа энэ хэсгүүдийн тоосгон өрлөгийг сэргээн засварлах шаардлага бий болсон. Иймд дээрхи хэсгүүдэд орох багана дам нурууны хэмжээсүүдийг давхар бүрт тооцоолон гаргав.

1,2 дугаар давхарын ханын залгааны хэсэгт дам нуруу 6 ширхэг,багана 4 ширхэг орно. Тэдгээрийг хэмжээс байрлалаар нь ангилвал.

1, 2 дугаар давхарын ханын залгааны баруун талын хэсэгт 2 ширхэг дам нуруу, 2 ширхэг багана.

2 ширхэг дам нурууны урт 4.5 метр, 80 см, тэдгээрийн диаметр 16 см, болно.
2 ширхэг баганы урт 3.5метр, 1.5м, диаметр 22 см болно. /Гэрэл зураг - 88/

Энэ давхарын урд хэсэгт 1 ширхэг дам нуруу орно. Дам нурууны урт 5.1 м, диаметр 18см болно. /Гэрэл зураг - 89/

Мөн энэ давхрын зүүн талд 3 ширхэг дам нуруу, 1 ширхэг багана орно.
3 ширхэг дам нурууны урт 4.5 метр, 1.5 метр, 1.1 метр, диаметр 18см, 16см, болно.

1 ширхэг баганы урт 1.70м, диаметр 18-20см болно /Гэрэл зураг - 90/

Мөн энэ давхарт ханын тоосгон өрлөгийн завсарт орох шалны богино банзны өргөн 25-30см, зузаан 3.5см нийт урт 30 метр орчим болно.

2,3 дугаар давхарын ханын залгааны тоосгон өрлөгийн дунд баруун талд 2 ширхэг, урд талд 1 ширхэг, нийт 3 ширхэг дам нуруу орно. Дам нурууны урт 3.80 метр , 1.30метр, 1.20метр, диаметр 16см, 18см, 19см болно. /Гэрэл зураг - 91. 92/

3.3. Цамхагийн 3,4,5,6 дугаар давхарт байрлах дам нуруунуудыг тогтоох төмрийн хэмжээсүүдийг гаргасан тухай.

Цамхагийн 3,4,5,6 дугаар давхарын модон шалны дэр дам нуруунуудын хойд талын үзүүр хэсгүүд нь ханын тоосгон өрлөг дотор орж бэхлэгдсэн, урд үзүүр хэсгүүд нь хоорондоо углуургаар холбогдож байсан хэдий ч он цагийн уртад өмхөрч муудан углуургууд хугарч салсанаар доош унжих, зарим хэсгүүд нь хугарч унах байдлаар ихэд гэмтсэн байна.

Дээрх давхаруудын дам нурууны үлдэгдлүүдийг одоогийн байгаа байдлаар нь хамгаалах хэрэгтэй гэж үзсэн болно. Ажлын зурган дээр эдгээр дам нуруунуудад 14 см –ийн швелер төмөр ашиглан тулгуур ивээс хийж хамгаалахаар хийгдсэн. Тулгуурт

ашиглах швелер төмрийн жин хэтэрхий хүнд, хананд тогтооход эрсдэл гарч болзошгүй гэж үзэж байгаа тул тулгуур төмрийг аль болох хөнгөн байхаар сонгосон.

Углуурга нь салсан, доош унжсан нуруунуудын доод талд нь тулгуур ивээс төмөрбарьж, дэр нуруунд төмрөө 2-3 хэсэгт бөгжлөн тогтоож , түүнээс дээш нь бүрээстэй троссоор цамхагны дээд хэсгээс татлага хийж сойх байдлаар хамгаалалтын тогтоолго хийхболомжтой гэж бид үзэж байна. Дам нурууг тогтоох энэ аргыг хоёр зөвлөлдөн шийдвэрлэнэ.

Ивээсэнд ашиглах уголник төмрийн өргөн 7 см, зузаан 4мм байхаар тооцоолсон ба ивээсэнд хэрэглэгдэх төмрийн хэмжээсүүдийг давхар бүрт тооцоолж гаргав.

3 дугаар давхарын урд хэсэгт голоороо хугарсан 1 дам нуруунд тулгуур төмөр хамгаалалт хийнэ. Тулгуур ивээс төмрийн урт 1.80 метр, жин 3 кг болно. /Гэрэл зураг - 93/

4 дүгээр давхарт 3 ширхэг дам нуруунд 2.50метр 1.80метр , 1.90метр урттай 3 ширхэг, нийт жин 9 кг болно. /Гэрэл зураг - 94/

5 дугаар давхарын 6 ширхэг дам нуруунд 3.20метрийн урттай 2 ширхэг, 3.80 м, урттай 1 ширхэг, нийт жин 15 кг болно. /Гэрэл зураг - 95/

6 дугаар давхарын 4 ширхэг дам нуруунд 2.80метр, 2.70метрийн урттай тус бүр 1 ширхэг уголник төмөр, нийт жин нь 8.50 кг орно гэж тооцоолов. /Гэрэл зураг - 96/

<u>3.4 Цамхагийн дотор ханын гадар дээрх шувууны сангас, тосон будгийн бохирдолыг цэвэрлэх талбайн хэмжээсийг гаргасан тухай.</u>

Цамхагийн 1, 2, 3 дугаар давхарын дотор хананд бий болсон шувууны сангас, тосон будгаар бичсэн бичээсний бохирдолыг цэвэрлэх шаардлагатай гэж үзэв.

2 дугаар давхарын ханын дотор талын хэсэг нимгэн өнгөлгөө шавардлагатай шавар өнгөлгөөний дээр бурхадын хөрөг зурагтай байсан гэж сурвалжид тэмдэглэж үлдээсэн байдаг. Одоогоор дээрх хананд шувууны сангас тосон будгийн бохирдол маш их, бурхадын хөрөг зураг гэх зүйл үгүй болж ногоон өнгийн будгийн үлдэгдэл, бийрээр татсан хар өнгийн зураасны хэсгүүд бүдэг харагдаж байна. Энэ хэсгийн бохирдлыг маш нямбай цэвэрлэсний дараа бурхадын дүрслэл байгаа эсэхийг нарийн шалгах шаардлагатай байна. Энэ хэсгийн ажил ажлын зурганд тусгагдаагүй тул шинээр нэмж оруулсан. Шувууны сангасны бохирдолтой талбай 126 м^2, тосон будгийн бохирдолтой талбай 12м^{2}болно. /Гэрэл зураг - 97/

<u>3.5. Цамхагийн давхар бүрт гаргасан шагайвч цонхнуудыг торлох торны хэмжээсүүдийг гаргасан тухай.</u>

Цамхагийн 3 дугаар давхраас эхлэн шаталсан хэлбэрээр давхар бүрт гаргасан шагайвч цонхнуудыг сэргээн засварлах ажил дуусаны дараа дотор талаас нь торлож шувуу, сарьсан багваахай орох боломжгүй болгож хамгаалалт хийхгүй бол дээрхи амьтан үүрлэн их хэмжээгээр бохирдуулах болно. Цамхагт нийт 15 ширхэг шагайвч цонхтой ба цонхонд ойролцоогоор 7,5м^2 нарийн ширхэгтэй төмөр тор, төмөр торонд хүрээ хийх нимгэн палсо төмөр 40- 45метр орно гэж тооцоолов. Энэ хэсгийн ажил ажлын зурагт тусгагдаагүй нэмэлтээр орсон.

<u>3.6. Цамхагийн суурь, 1,2, 3, 4 дүгээр давхарын гадна талын давхар хоорондын залгааны хэсэг дэх шаталсан өрлөгүүдийг ажлын зурагтай харьцуулж нятлан үзсэн тухай.</u>

Цамхагийн ханын суурийг цайвар шаргал өнгийн шавар элс \ нарийн хайрга\ хольж дагтаршуулж давхарлан дэлдэж бэлдээд шаврын дээр байгалийн чулуугаар 1 үе тэгш өрлөг тавьж дээр нь ханын тоосгон өрлөгийн хийсэн байна.

Суурийн шавар давхаргын зузааныг зүсэлт хийхгүйгээр мэдэх боломжгүй, чулуун өрлөгийн өндөр харилцан адилгүй 0.15- 0.20см орчим байна.

Ханын суурийн тоосгон өрлөгүүд цамхагийн бүх талдаа эвдрэл ихтэй байгаа нь сууринаас дээш өрлөгийн шатлалыг нарийн гаргахад хүндрэлтэй болсон байна.

Цамхагийн 1 дүгээр давхарын зүүн урд болон зүүн, зүүн хойд, хойд, баруун хойд,

талын тоосгон ханын эвдрэлтэй хэсгүүдэд ажиглалт хийж тоосгон өрлөгийн шатлалын талаар байж болохуйц гэж үзсэн доорхи тооцооллыг хийж үзлээ.

Суурийн чулуун өрлөгнөөс дээш 6үе тоосгон тэгш өрлөг хийгээд дотогш нь 6 см орчмоор татаж, үүнээс дээш 12 үе тоосгон тэгш өрлөг хийж дахин 6 см орчмоор дотогш татсан гэж үзлээ. /Гэрэл зураг - 98. 99/ Энэ үеэс дээш 17 үе тоосгон тэгш өрлөг хийгээд, 6см орчим өргөнөөр гадагш татаж 4 үе тоосгон тэгш өрлөг, мөн энэ үеэс дахин гадагш 6 см орчим татаж, 6 үе тоосгон тэгш өрлөг,дахин 6 см–ээр гадагш татаж 4 үе тоосгон тэгш өрлөг хийсэн нь зүүн болон баруун хойд, хойд булангын өрлөгүүдэд тодорхой харагдаж байна. /Гэрэл зураг - 100/

Баруун хойд болон хойд буланд мэдэгдэж байгаа дээд талын 4 үе тоосгон өрлөг нь 6 үе тоосгон өрлөг байсан бололтой, энэ 4 үе тоосгон өрлөгийн дээд хэсгийн өрлөгийн шаврын үлдэцэд ажиглалт хийснээр 2 үе тоосгон өрлөг нь нурж, доод 4 үе тоосгон өрлөг нь үлдсэн байна гэж бид үзлээ.

Энэ үеийг 6 үе тоосгон тэгш өрлөгтэй байсан гэж үзвэл, \ зураг 101.\ энэ үеийн дээр гадна ирмэгээс 6 орчим см-ээр дотогш нь татсан 4 үе тоосгон тэгш өрлөг, энэ өрлөгийн гадна ирмэгээс 0.52-0.55 см өргөнөөр дотогш татаж 2 дугаар давхарын ханын өрлөгийн хийсэн байх магадлалтай байна.

Энэ удаагийн засварын ажлын үеэр цамхагийн суурь, 1, 2 дугаар давхарын ханын залгааны хэсэгт гаргасан шаталсан өрлөгийн хэсгүүдэд ажиглалт хийж ажлын зурагтай харьцуулж үзэхэд бага зэргийн зөрүүтэй зүйлс байгаа тул дахин нягталж үзэх хэрэгтэй гэж үзлээ. Тиймээс 2016 онд хийгдэх засварын ажлын явцад дээрхи хэсэгт хийсэн ажиглалтуудыг дахин сайтар шалгаж, 2,3,4 дүгээр давхарын гадна өрлөгийн хэсгүүдэд тодорхойгүй байгаа зүйлсийг дахин нягтлаж шалгаад, 2 талаасаа хамтран зөвшөлцөөд шийдвэрүүдээ гаргаад явах боломжтой гэж үзэж байна.

2015 оны 11 дүгээр сард Соёлын өвийн төвийн захирал Г.Энхбат БНХАУ-д Торгоны замын ухиан дор “Нэг Бүс, Нэг Зам” сэдэвт соёлын өв, дурсгалт уран барилга, барилгын инженерийн чиглэлийн олон улсын хуралд оролцох үедээ “Хэрлэн барс” дурсгалын сэргээн засварлалатанд хамтран оролцож буй БНХАУ-ын Соёлын яамны харъяа Хятадын Соёлын өвийн академийн төлөөлөлтэй зөвлөлдөх уулазалт зохион байгуулан болно. Уулзалтаар хоёр тал 2015 оны ажлыг дүгнэн ярилцсан ба 2016 оны 8 дугаар сар гэхэд төслийг дуусган хүлээлгэн өгөхөөр тохиролцов.

2015 оны тайланд бичсэн зарим нэмэлт ажлыг хоёр тал хүлээн зөвшөөрч хамтран ярилцан шийдвэрлэхээр болов.

Дүгнэлт

2015 онд Доронд аймгийн Цагаан-овоо сумын нутагт орших Хэрлэн барс хотын цамхагийг сэргээн засварлах ажилд хэрэглэх хөх тоосгыг дурсгалын дэргэд бэлтгэх, шатны өргөтгөл хийх, цамхагийн дотр ханын 1 ба 2 дугаар давхарын зарим хэсгийг нөхөж сэргээн засварлах ажлыг тус тус хийлээ.

2015 оны 5 дугаар сард дурсгалт газрын орчимд хээрийн гал түймэр их байсан тул 5 дугаар сард эхлэх ажил 1 сараар хойшлон 6 дугаар сард эхэлсэн болно. 2015 оны 6 дугаар сараас хойш технологийн дагуу тоосгоны шавар татах, тоосго хэвлэх, тоосго шатаах зуух барих, цамхагийн зарим хэсэгт нөхөлт сэргээн засварлалт хийх зэрэг ажлыг технологи гормын дагуу БНХАУ-ын мэргэжилтнүүдтэй хамтран хийлээ.

Мөн ханын тоосгон өрлөгийг сэргээн засварлах ажилд хэрэглэх шавар зуурмаг, өрлөгийн завсарт хийсэн шохойн шаваасны найрлагыг турших ажлыг хийлээ.

Цамхагийн шавар суурийн хэсгийн засварлах ажил, 1,2,3 дугаар давхаруудын ханын залгааны хэсгийн өрлөг дотор хийгдэх дам нуруу багана хийх зэрэг ажлууд ажлын зурагт тусгагдаагүйн учраас дээрх хэсгүүдийн ханын өрлөгийг сэргээн засварлах ажлын гүйцээж хийх боломжгүй болох, 2015 оны 9 дүгээр сарын 20-ноос байгаль цаг агаар хүйтэрч ханын өрлөг хийх технологи горим алдагдах болсон тул ажлыг зогсоосон болно.

Мөн ирэх жил нэмэлтээр тусгагдаж хийгдэх цамхагийн суурийн хэсэгт ашиглах шавар чулууг сонгох, тэдгээрийн хэмжээ, цамхагийн 1,2 дугаар давхарын ханын

дотор талын тоосгон өрлөгийн дунд сэргээн байрлуулах багана, дам, нуруунуудын хэмжээс, цамхагийн 3,4,5,6 дугаар давхаруудад байрлах дам нуруунуудыг тогтоох ивээс төмрийн хэмжээсүүд, цамхагийн дотор ханын гадар дээрх шувууны сангас, тосон будгийн бохирдолыг цэвэрлэх талбайн хэмжээс, цамхагийн давхар бүрт гаргасан шагайвч цонхнуудыг торлох торны хэмжээс, цамхагийн суурь, 1, 2, 3, 4 дүгээр давхарын гадна талын давхар хоорондын залгааны хэсэг дэх шаталсан өрлөгүүдийг ажлын зурагтай харьцуулж нятлах үзэх зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэлээ.

Мөн 2016 онд ажлын зургийн дагуу хийгдэх цамхагын модон хаалга, 1-р давхарт байрлуулах модон хийц бүхий шат, ус зайлуулах хоолой, цамхагийн дээвэр зэрэг ажлуудын төсөв энэ жил зарцуулагдаагүй Соёлын өвийн төвийн дансанд байгаа болно.

2015 оны Хэрлэн барс хотын цамхагийг сэргээн засварлах ажил нь монголын талын мэргэжитнүүдэд онол, практик хосолсон дурсгалт уран барилгыг сэргээн засварлах арга ажиллагаанд суралцуулсан үр дүнтэй ажил болсон гэж дүгнэж байна.

Үүнд:

Монголын талын мэргэжилтнүүд Хятадын мэргэжилтнүүдээс хөх тоосго хийх, тоосго шатаах зуух хийх, тоосго шатаах арга технологийг суралцсан байна.

Дурсгалт уран барилгыг сэргээн засварах ажлын зургийг хэрхэн хийдэг талаар мэдэгдэхүүнтэй болсон байна.

Дурсгалт уран барилгыг сэргээн засварлахад шаардлагатай технологи, арга ажиллагааны талаар мэдлэгтэй болсон байна.

Хятад мэргэжилтнүүдийн заавар зөвлөгөөгөөр монголын талын мэргэжилтнүүд бие дааж сэргээн засварлах ажилд гар бие оролцсон байна.

Хэрлэн барс хотын суваргыг сэргээн засварлах ажилд Соёлын өвийн төвийн сэргээн засварлах хэлтсийн дарга С. Чинзориг, Сэргээн засварлагч Д. Нямдорж, А. Мөнгөнцоож, Э. Батжаргал, Б. Бадаруугаан, С. Сайнзолбоо, БНХАУ –ын мэргэжилтэн Chang Mingsuo, Лью, орчуулагч Б. Тогтохжаргал, туслах ажилтан Б. Бямбасүрэн, Г. Ганзориг, Ч. Чулуунбаатар, Г. Мөнхбаяр Х. Тогтохбаяр, П. Цогтбаатар , Д. Жамьян, Д. Батбаяр, тогооч Э. Болормаа нар ажиллав.

Гэрэл зургийн жагсаалт:

Гэрэл зураг 1.

Гэрэл зураг 2.

Гэрэл зураг 3.

Гэрэл зураг 4.

Гэрэл зураг 5.

Гэрэл зураг 6.

Гэрэл зураг 7.

Гэрэл зураг 8.

Гэрэл зураг 9.

Гэрэл зураг 10.

Гэрэл зураг 11.

Гэрэл зураг 12.

Гэрэл зураг 13.

Гэрэл зураг 14.

Гэрэл зураг 15.

Гэрэл зураг 16.

Гэрэл зураг 17.

Гэрэл зураг 18.

Гэрэл зураг 19.

Гэрэл зураг 20.

Гэрэл зураг 21.

Гэрэл зураг 22.

Гэрэл зураг 23.

Гэрэл зураг 24.

Гэрэл зураг 25.

Гэрэл зураг 26.

Гэрэл зураг 27.

Гэрэл зураг 28.

Гэрэл зураг 29.

Гэрэл зураг 30.

Гэрэл зураг 31.

Гэрэл зураг 32.

Гэрэл зураг 33.

Гэрэл зураг 34.

Гэрэл зураг 35.

Гэрэл зураг 36.

Гэрэл зураг 37.

Гэрэл зураг 38.

Гэрэл зураг 39.

Гэрэл зураг 40.

Гэрэл зураг 41.

Гэрэл зураг 42.

Гэрэл зураг 43.

Гэрэл зураг 44.

Гэрэл зураг 45.

Гэрэл зураг 46.

Гэрэл зураг 47.

Гэрэл зураг 48.

Гэрэл зураг 49.

Гэрэл зураг 50.

Гэрэл зураг 51.

Гэрэл зураг 52.

Гэрэл зураг 53.

Гэрэл зураг 54.

Гэрэл зураг 55.

Гэрэл зураг 56.

Гэрэл зураг 57.

Гэрэл зураг 58.

Гэрэл зураг 59.

Гэрэл зураг 60.

Гэрэл зураг 61.

Гэрэл зураг 62.

Гэрэл зураг 63.

Гэрэл зураг 64.



Гэрэл зураг 65.

Гэрэл зураг 66.

Гэрэл зураг 67.

Гэрэл зураг 68.

Гэрэл зураг 69.

Гэрэл зураг 70.

Гэрэл зураг 71.

Гэрэл зураг 72.

Гэрэл зураг 73.

Гэрэл зураг 74.

Гэрэл зураг 75.

Гэрэл зураг 76.

Гэрэл зураг 77.

Гэрэл зураг 78.

Гэрэл зураг 79.

Гэрэл зураг 80.

Гэрэл зураг 81.

Гэрэл зураг 82.

Гэрэл зураг 83.

Гэрэл зураг 84.

Гэрэл зураг 85.

Гэрэл зураг 86.

Гэрэл зураг 87.

Гэрэл зураг 88.

Гэрэл зураг 89.

Гэрэл зураг 90.

Гэрэл зураг 91.

Гэрэл зураг 92.

Гэрэл зураг 93.

Гэрэл зураг 94.

Гэрэл зураг 95.

Гэрэл зураг 96.

Гэрэл зураг 97.

3.1. Улс, аймгийн 14 музейн 230 ширхэг үзмэрийг бэхжүүлэх сэргээн засварлах:

2015 онд соёлын өвийн төвийн соёлын өвийг хамгаалах, сэргээн засварлах хэлтэс нь улс, аймгийн 14 музейн хүсэлтийн дагуу 230 ширхэг үзмэрийг бэхжүүлж сэргээн засварлах ажлыг хийхээр төлөвлөсөн болно.

№	Байгууллага	Нийт сэргээн засварлах үзмэрийн тоо	Хүлээж авсан үзмэрийн тоо	Сэргээн засварлагдсан үзмэрийн тоо	Тайлбар
1	Дүрслэх урлагийн музей	2ш	2ш	2ш	
2	Сүхбаатар аймгийн музей	10ш	10ш	10ш	
3	Монголын үндэсний музей	2ш	2ш	2ш	
4	Археологийн хүрээлэн	50ш 80ш	50ш 80ш	50ш 80ш	Хэрлэн барс-99 Евразиат-31
5	Хан богд сумын соёлын төв	1ш	1ш	1ш	
6	Эрдэнэ зуу музей	10ш	10ш		Хууль шүүхийн асуудал эцэслэн шийдэгдээгүй тул түр хойшлуулсан.
7	Өмнө-говь аймгийн музей	1ш	1ш	1ш	
8	Уран зургийн галерей	8ш			Үзмэрээ ирүүлээгүй
9	Богд хааны ордон музей	3ш	3ш	3ш	
10	Түүхийн хүрээлэн	1ш	1ш	1ш	
11	Дундговь аймгийн музей	10ш	10ш	10ш	
12	Уран зургийн галерей / цэвэрлэгээ /	45ш	45ш	45ш	
13	Говь -алтай аймгийн музей	4ш	4ш	4ш	
14	Театрын музей	3ш	3ш	3ш	
	Нийт	**230ш**	**222ш**	**212ш**	

Улс, аймгийн 14 музейн 230 ширхэг үзмэрээс сэргээн засварлахаас 222 ширхэг үзмэр хүлээн авч 2015 онд 212 үзмэрийг цэвэрлэж бэхжүүлэн, сэргээн засварлалаа.

Эрдэнэ зуу музейн 10 ширхэг үзмэрийн шүүхийн асуудал нь эцэслэн шийдэгдээгүй тул засвар хийх ажлыг түр хойшлуулсан болно.

2015 оны дээрх төлөвлөгөөт ажил дээр нэмэлт захиалгаар 4 музейн 54 ширхэг үзмэр нэмэгдэн, 2015 онд тус хэлтсийн сэргээн засварлагчид нийт 266 үзмэр, эд өлгийн зүйлсийг бэхжүүлж, сэргээн засварлажээ.

Нэмэлтээр сэргээн засварласан музейн үзмэрүүд

№	Байгууллага	Хүлээж авсан үзмэрийн тоо	Сэргээн засварлагдсан үзмэрийн тоо	Тайлбар
1	Орхон аймгийн музей	7ш	7ш	ясан савх 5ш ясан шор 2ш
2	Улаанбаатар их сургууль	1ш	1ш	ясан халбага 1ш
3	Түүхийн хүрээлэн	45ш	45ш	Евразиат төслийн археологийн олдвор метал - 14ш Хэрлэн барс - археологийн олдвор бичигтэй цаасны хэсгүүд - 31 ш
4	Чойжин ламын сүм музей		1ш	Дорж шүгдэн бурханы мутрын барьцыг тогтоосон
	Нийт		**54ш**	

3.2. Музейн үзмэрийн материал бүтцийн судалгаа хийх

Богд хааны ордон музейн хүрэл алт шармал бурхадын 3D скайнер хийж баримтжуулах ажлын хүрээнд дээрх бурхадын металлын орц найрлагыг судлан баримтжуулах ажлыг давхар хийхээр төлөвлөн ажилласан. 2014 онд ШУА-ийн Түүх, археологийн хүрээлэнгийн хээрийн судалгааны ажлын явцад илэрсэн олдворуудыг 2015 онд сэргээн засварлуулах хүсэлтийн дагуу 130 үзмэр сэргээн засварласан. Эдгээрийн 30 ширхэг метал олдворт, мөн Богд хааны ордон музейн 3 ширхэг үзмэрүүдэд материал бүтцийн судалгааг хийгээд байна.

№	Музейн нэрс	Үзмэрийн нэрс	Хийгдсэн ажил
1	Богд хааны ордон музей	Алт шармал бурхан 3 ш - Богд зонхов. - Таван хаан - Манал.	Металын орц найрлагыг тодорхойлох
2	Түүх, археологийн хүрээлэн	Хэрлэн барс - археологийн олдвор метал - 7ш. Евразит төслийн археологийн олдвор метал - 23 ш	Металын орц найрлагыг тодорхойлох
	Нийт	**33ш**	

3.3.“Их бурхант” дурсгалыг сэргээн засварлах ажил

Дорнод аймгийн нутаг дахь “Их бурхант” цогцолборын Жанрайсиг бурханы нүүрний бэхжүүлэлт, аж ахуйн хэрэгсэл татаж авчирах ажил

Соёлын өвийн төвийн захирлын 2015 оны 05 дугаар сарын 19-ны өдрийн А/31 тоот тушаалын дагуу, тус төвийн сэргээн засварлагч Н. Жамбал, Т.Сүхбаатар, Н. Бат-Эрдэнэ, Б. Эрдэнэчимэг (жолооч) нарын бүрэлдэхүүнтэй сэргээн засварлах баг Дорнод аймгийн Халх гол сумын нутаг дахь “Их Бурхант” цогцолборт 2015 оны 5 дугаар сарын 20-25-ныг хүртэл ажиллаа.

Дээр дурьдагдсан хугацаанд “Их Бурхант” цогцолборын гол дүр Жанрайсиг бурханы 2014 оны сэргээн засварлалтын ажлын үед хийдсэн (шинээр засварласан) нүүрний зарим хэсгүүд тодруулбал хамрын хянга яс, хоёр нүдний хүүхэн хараа, доод зовхи дүрслэлтэй хацартай нийлэх хэсэг, нүдний хоёр захын төгсгөл хэсгийн чамархайтай нийлэх хэсэг, хамрын самсаа угалз дүрслэлтэй хэсгийн хацартай нийлэх хэсэг, хамрын үзүүр хэсэг, уруулын дээд хамартай залгах хүн хонхорхойн хэсэг зэрэг хийцүүдийг (ус чийгэнд тэсвэрлэх чадвартай шар шавар, шохой, давсны холимог зуурмагаар хэлбэр форм гарган хийсэн) В72- хамгаалалтын уусмалаар 2-4см-н нэвчилттэйгээр 2 удаагийн давтамжтайгаар бэхжүүлэлт хийсэн болно.

Жанрайсиг бурханы нүүрний дээрх хэсгүүд 2014-2015 онуудад шавар форм, хэлбэрээр байсан нь 2 үндсэн шалтгаантай.

1. Дүүргэлтэнд ашигласан зуурмаг нь нар, салхи, бороо гэх мэт байгалийн хүчин зүйлсэд хэр тэсвэртэй эсэх, хийцтэй бүтээлэг чулуунуудын доор дүүргэлтэд байхдаа хэр бэхжилттэй эсэх, суулт үүсч байгаа эсэхэд судалгаа хийх

2. 2014 оны сэргээн засварлалтын ажлын (намрын 2 дугаар ээлж 40 хоног) тал хувь нь төлөвлөгдсөн хугацаандаа санхүүжилт тасалдсаны улмаас хийгдээгүй зэрэг шалтгаануудаас болж хийгдээгүй. Харин 2015 оны 5 дугаар сард хийгдсэн бэхжүүлэлтийн ажил нь Жанрайсиг бурханы нүүрний хэсгийг сэргээн засварлахаар төлөвлөгдсөн 2015 оны 08 дугаар сарыг хүртэлх хугацаанд борооны улмаас уг бурханы нүүрний шавар форм бүхий хэсгүүдийг хамгаалах, үүний үр дүнд шавар зуурмагны шинж чанарыг тодорхойлох, өнгөн хэсгийн өгөршилт, зуурмагийн гүндэх нягтаршил зэргийг тодруулахад чиглэгдсэн болно.

Бэхжүүлэх ажилд 0,5 литрийн савалгаатай 8 шил ацетон, 250гр В73 (уусгаагүй)-г ашигласан ба 5% процентоор найруулсан бэхжүүлэгч уусмалаар бэхжүүлэх ажил хийгдсэн болно.

Мөн Их бурхант цогцолборын сэргээн засварлалтын ажил эхэлсэн 2012 онд хэрэглэж эхэлсэн, сэргээн засварлах баг хамт олны байрлаж байсан гэр, зарим хэрэглэгдэхүүнийг Улаанбаатар хотод татаж авчрахаар шийдвэрлэсэн юм.

Гэрийн хэрэглэгдэхүүнээс гадна сэргээн засварлах нийт 3 жилийн хугацаанд цогцолбор дээр хуримтлагдсан, эвдэрч гэмтсэн цахилгаан тоног төхөөрөмжийн үлдэгдэл, хэрэглэж байсан гал тогооны хэрэгсэл, хөлдөөгч, том оврын гаазан плитка, тог цахилгааны хуучин утас, зарим нэг цавуу, будагны үлдэгдэл зэргийг мөн татаж авчирсан болно.

Дорнод аймгийн нутаг дахь “Их Бурхант” цогцолборын Жанрайсиг бурханы нүүрний болон арын долоон бурханы нэг Доржнамжим бурханыг сэргээн засварласан ажлын тайлан

Соёлын Өвийн Төвийн захирлын 2015 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн А/25-р тушаалын дагуу сэргээн засварлагч Н.Жамбал, Э.Батжаргал, Т.Сүхбаатар, Б.Бадар-Ууган, С.Даваадарь, Ж.Даваацэрэн, Б.Эрдэнэчимэг /жолооч/ нарын бүрэлдэхүүнтэй сэргээн засварлах баг Дорнод аймгийн Халх гол сумын нутаг дахь “Их Бурхант” цогцолборт 2015 оны 7 дугаар сарын 27-ны өдрөөс 2015 оны 8 дугаар сарын 15-ныг хүртэлх хугацаанд ажиллаа.

Сэргээн засварлалт явагдсан хугацаанд тус цогцолборын гол дүрийн бурхан Жанрайсигийн нүүрний тодруулбал хүн хонхорхой-хамрын угалзны орчмын хэсэг, нүд-нүдний хоёр талын хэсэг, хацар-доод зовхины орчмын хэсэг, хамар, эрүү орчмын хэсэг тэдгээрийн хэлбэр форумыг шинэ аргын чулуугаар нөхөн хийх мөн арын долоон бурханы баруун захын бурхан Доржнамжим бурханыг цементэн бохирдлоос салгаж сэргээн засварлах ажлуудыг хийж гүйцэтгэлээ.

Доржнамжим бурханы хувьд гол бурхан, суурь бад, суурь бадны доод 4 давхарлагат чулуун тавцан зэргийг бүрэн задлаж,өрлөг хоорондын холбогч зуурмаг цемент,бурханы үндсэн чулуун хийцийн дутуу болон хагарч эмтэрснийг цементээр нөхсөнийг цэвэрлэж салгасны дараа өрлөгийн ажлыг эхлүүлсэн юм. Уг бурханыг 1997 оны сэргээх үед өрлөгийг өндөр агууламж бүхий цементээр хооронд нь нааж, суурь бад болон бурханы таншин хормогчны 15%, мутар цээжин биеийн 20%-30%, арын гэрлийн 90%-ийг хооронд нь наах, нөхөж барих зэргээр цементлэсэн байсан юм. Ялангуяа арын гэрлийн цементэн бүрхүүлийн цаана улаан цагаан тоосгоор өрлөг хийсэн ба гэрлийн арын тулгуур болгосон цементэн шаваасны дотроос арын долоон бурханы алиных нь ч байхаар гэрэл дүрслэлтэй нимгэн гонзгой чулуу, Луваанжалбуу бурханы толгойн баруун захын могой дүрслэлтэй жижиг гурвалжин чулуу зэрэг хийцтэй чулуунууд гарсан болно. Мөн бурханы өрлөгийн завсар зайгаар биологийн бохирдол/сарьсан багваахайн баас,оготно луусны хөөө г.м/ ихээр гарч уг бохирдлыг бүгдийг зайлуулж шинэ өрлөгийн ажил эхэлсэн юм.

Доржнамжим бурханы суурь бадны доод чулуун давхарлагат тавцангийн чулуунууд газрын хэвгийн дагуу хазайсныг бүгдийг задалж, хамгийн доод үеийг хөрснөөс ил гаргаж, уллагаа багсармал/шар шавар- бор шороон хөрс- шохой- давс/-аар нягтруулан тэгшилсний дараа өрлөгийн ажил хийгдэж эхэлсэн юм. Жанрайсиг бурханы арын долоон бурханы зүүн захын бурхан Цагаан Дарь-Эх бурханы суурь бадны өндрөөс Доржнамжим бурханы суурь бад 20,5см-ээр дутуу байсныг тогтоож /Доржнамжим бурханы суурь өрлөгийн хамгийн доод үе хөрсөнд 45 хэмээр налж шигдсэнийг чулуун ивүүр,багсармал уллагаагаар дээш татсан/ тэгшилж өндрийг адил түвшинд болгосон болно.

Ингээд бурханыг задалсны дараа хийц бүхий хэсгүүдийн цементэн бохирдлыг гар зубиль,гар пачар, хатуу хайлшин ир бүхий гадсан багажны тусламжтайгаар цэвэрлэж,ус чийг авахуулахгүйгээр боож дараа жилийн сэргээн засварын ажилд бэлтгэн тависан болно. Доржнамжим бурханы суурь бадыг бүрэн засч хийц бүхий хэсгүүдийг хооронд нь чулууны цавуугаар нааж,эмтэрч хагарсан хэсгүүдийг шинэ аргын чулуугаар нөхөн хийсэн ба уг бурханы сэргээн засварын ажил хараахан дуусаагүй болно.

Ер нь 2015 оны 7-8 сард хийгдсэн сэргээн засварын ажлыг эхлэхдээ цогцолбор дурсгал дээр /Жанрайсиг бурханы эргэн тойрон/ ургасан хог ургамалг түүж цэвэрлэн зайлуулж, сэргээн засварын ажил явагдах талбайг бэлтгэсэн ба орон нутгийн шар шавар 1тн орчим, Халх голын хайрга мөн 1тн орчим, урьд оны үлдэгдэл шохой, давс, Буйр нуурын бүдүүн ширхэглэлт элс зэргийг сэргээн засварын ажилд ашигласан юм. Дээр нь ажилд шаардлагатай чулууны цавуу, силикон цавуу, багаж тоног төхөөрөмжийн запас сэлбэгийг Улаанбаатар хотоос татан аваачиж сэргээн засварлалтыг явуулсан болно.

Жанрайсиг бурханы нүүрийг сэргээн засварлах ажил 2014 он, 2015 оны 5 дугаар сард хийгдсэн бэхжүүлэлтийн ажлын үргэлжлэл болж хийгдсэн ба уг том бурханы нүүрний нарийн хийцтэй хэсгүүд болох хүн хонхорхой-хамрын угалз тойрсон хэсэг, нүд-нүдний хоёр тал, хамар, хацар-зовхины уулзах хэсэг зэрэг газруудыг орон нутгийн эрдэс хайрга чулууны мөхлөгт ширхэг-чулууны цавууны холимог шинэ аргын чулуугаар хийгдсэн болно.

2014 онд нөхвөрлөн хийсэн нүүрний байгалийн чулуун хийцтэй залгуулан орон нутгийн шар шавраар хэлбэр форумыг гарган барьж, түүнийгээ ойролцоогоор 25см:15см, 25см:30см, 5см:15см зэрэг янз бүрийн хэмжээтэй дөрвөлжлөн корпуслан ухаад, гарсан нүхнүүдэд элсэнцэр чулууны жижиг хэсэг-мөхлөг-талстуудыг шинэ аргын чулуун холимогтой хамт дүүргэлт хийн нааж,шавар форум аргын чулуун форум хоёрыг уулзуулан хөөж засах аргаар хийж гүйцэтгэлээ.

Дүгнэлт:

2015 оны 7-8 дугаар саруудад 20 хоногийн хугацаанд хийгдсэн сэргээн засварын ажил төлөвлөсний дагуу явагдсан ба хугацаа цөөн хоног /20 хоног төлөвлөснөөс замд 4 хоног, үлдсэн 16 хоногт ажлаа амжуулах/, Их Бурхантын заставаас тог аваагүй /380в-ийн дизель мотор 1ш,220в-ийн бензин мотор 1ш/ цахилгаан үүсгүүрээр тог цахилгаанаа хангасан /урьд жилүүдэд мөн төвлөрсөн тогноос гадна цахилгаан үүсгүүрээр нэмэлтээр ашигладаг байсан юм/, дурсгал дээр ажлын 16 хоногийн бүтэн 6 хоног бороо, манантай / 8 дугаар сарын 02-09-ний үд хүртэл/ үе таарсан зэргийг эс тооцвол хэвийн явагдлаа. Дурсгалын сэргээн засварлалтанд ашиглаж байгаа зарим бага, дунд оврын цахилгаан багаж,таслагчууд 2-3 жил дараалан ашиглаж байгаа, эвдрэл гэмтэл гарсан даруйд запас сэлбэг/ гол якорь, унтраалга кноп, шааригг, нүүрсэн шоотиг/-ийг солиж ажиллуулж байсан ч чулууны үйрмэг тоосонцор, ажлын хүнд ачаалал зэргээс болж элэгдэлд орж цаашид ашиглах боломжгүй болж байгаа тул дараагийн шатны ажилд тодорхой тооны шинэ багаж авах шаардлагатай байна.

ДОРНОД АЙМГИЙН НУТАГ ДАХЬ “ИХ БУРХАНТ” ЦОГЦОЛБОРЫН ЖАНРАЙСИГ БУРХАНЫ НҮҮРНИЙ БЭХЖҮҮЛЭЛТ, АЖ АХУЙН ХЭРЭГСЭЛ ТАТАЖ АВЧИРАХ АЖЛЫН ЗУРАГ

Бэхжүүлэлт хийх ажлын явц

Бэхжүүлэлт хийхийн өмнөх цэвэрлэгээ

Бэхжүүлэлт хийх ажлын явц

Бэхжүүлэлт хийгдсэний дараа

Сэргээн засварлах ажлын өмнөх үеийн зураг-2015 он

Сэргээн засварлалтанд хэргэлэгдэх янз бүрийн ширхэглэлтэй хайрга бэлтгэл, ба аргын чулуу зуурмаг хийх ажлын үеийн зураг

Доржнамжим бурханы сэргээн засварлалт хийхээс өмнөх үеийн зураг

Доржнамжим бурханы сэргээн засварлалт хийхээс өмнөх үеийн зураг

Доржнамжим бурханы цементээр нааж өрсөн өрлөгийг задлах үеийн зураг

Доржнамжим бурханы цементээр нааж өрсөн өрлөгийг задлах үеийн зураг

Бурханы хийц бүхий хэсгүүдийн цементэн бохирдолыг салгах ажлын явцын зураг

Бурханы хийц бүхий хэсгүүдийн цементэн бохирдолыг салгах ажлын явцын зураг

Бурханы суурь бадыг дахин өрж, дутуу хэсгүүдийг аргын чулуугаар гүйцээн хийсэн ажлын зураг

Бурханы нүүрний хүн хонхорхой,хамрын угалз орчмын хэсгийг шинэ аргын чулуугаар нөхөн хийсэн сэргээн засварын ажил

Бурханы нүүрний хацар,доод зовхины орчмын шинэ аргын чулуугаар нөхөн хийсэн сэргээн засварын ажил

Бурханы нүд, нүдний хоёр талын хэсгийг шинэ аргын чулуугаар нөхөн хийсэн сэргээн засварын ажил

Бурханы нүүрний эрүү орчмын хэсгийн сэргээн засварлах ажлын үеийн зураг

Бурханы хамарыг шинэ аргын чулуугаар нөхөн хийсэн сэргээн засварын ажил

Бурханы хамарыг шинэ аргын чулуугаар нөхөн хийсэн сэргээн засварын ажил

Бурханы нүүрний хэсэг сэргээн засварын дараа

Сэргээн засварлах багийн гишүүд болон ажлын сүүлийн хоёр өдөр хийсэн цэвэрлэгээний ажил

Сэргээн засварлагчдын байрлаж байсан майхан суулц,ажиллах үеийн цаг агаарын нөхцөл байдал

3.4. “Баяннуурын цогцолбор” дурсгалын ханын зургийг авран хамгаалах.

2014 оны дулаалга битүүмжлэлийг авах, үүссэн хөгц мөөгөнцөрийг цэвэрлэх ажил

Булган аймгийн Баяннуур сумын нутаг орших Улаан хэрмийн шороон бумбагарын ханын зураг болон уг бунханы доторх модон бэхэлгээний хэсэгт үүссэн хөгц мөөгөнцөрийн бохирдлыг цэвэрлэх болон өмнөх намар хийсэн дулаалга битүүмжлэлийг авах, бунханы нөхцөл байдалтай танилцахаар 2015 оны 5 дугаар сарын 04-08-ны өдрүүдэд Соёлын өвийн төвийн сэргээн засварлагч А. Мөнгөнцоож, Н. Бат-эрдэнэ, Б. Бадар-ууган, Т. Сүхбаатар нарын бүрэлдэхүүнтэй багийг томилон ажиллуулав.

Бунхан дотор дүрслэгдсэн хүмүүсийн дүрслэл, бунхны үүдэвч хэсэгт байх 2 луу болон 8 хүний дүрс харьцангуй тод хэвээрээ тогтвортой байсан. Зарим хэсэгтээ ханын зургийн ар үндсэн гадарга болох шавар хана бага зэрэг сийрэгжсэн мөн зарим хэсэгт шаврын өнгөн хэсэг хөндийрч ховхорсон, өрх цооногуудын харалдаах дүрслэлүүд урьд өмнөхөөс илүү бүдгэрэх муудах хандлагатай. Урд урдны жилүүдийг бодвол хөгц мөөгөнцөр зурагнууд дээр маш ихээр ургасан байдалтай байлаа.

Бунханы ханын зургийг өвөл хөлдөхөөс сэргийлж дулаалсан дулаалга хучлагыг авж, бэхэлгээний модон банз, палканд хөгц мөөгөнцөр их хэмжээгээр ургасан байсныг цэвэрлэсэн.

Зургийн гадар дээр ургасан мөөгөнцрийг зөөлөн үстэй багсаар механикаар цэвэрлэгээ хийж, доторх модон бэхэлгээнд ургасан мөөгөнцрийг багс, шпатель зэргээр хусаж арилган спиртийн 60-70%-ийн усан дахь уусмалыг хөвөнд шингээн арчиж цэвэрлэж ариутгасан.
Цэвэрлэгээний ажил дууссаны дараа бунханы гадна орчинг цэвэрлэж, бунханы үүдэвч хэсгийн ханыг дагаж борооны ус дуслах, урсахаас сэргийлэн хучилтын хөөсөнцөр хавтангуудыг ирмэглэн байрлуулж тавьж, агаар бунханд шууд нэвтэрхээс сэргийлэн бунханы үүдэвч хэсгийг мөн хөөсөнцөр хавтангаар хаалт хийв.

Баяннуурын байгууламжинд салхин сэнс тавьсан тухай

2015 оны 6 дугаар сарын 22-26-ны өдрүүдэд сэргээн засварлагч Д. Нямдорж, А. Мөнгөнцоож, Т.Сүхбааатар, Б.Бадар-Ууган нарын бүрэлдэхүүнтэй баг Улаан хэрмийн Шороон бумбагарын гадна талын хамгаалалтын сендвичин байгууламжид салхиар ажилладаг 4 ширхэг сэнсэн агааржуулалт суурьлуулах ажлыг гүйцэтгэсэн.

Уг агааржуулалтын хоолой болон сэнсний диаметр нь 200 мм ба агаар сорох хоолойн нийт өндөр нь 1 метр. Агааржуулалтын сэнсний соролт нь гадаах салхины хурдаас шууд хамааралтай байна.

Агааржуулалтыг суулгахад хамгаалалтын байгууламжийн 10 см зузаантай сендвичин дээврийг хоолойн 20см–ийн диаметрээр цоолж, 30см орчим гүнзгий суулгаж, төмрийн дээш эргүүлсэн ирмэгийг хоолойтой нэвт өрөмдөж, тавлагчаар тавлаж, завсар зайг силикон цавуугаар битүүмжилж ус орохоос сэргийлсэн.

“Шороон бумбагарын бунхант булшны ханын зургийг сэргээн засварлах, хадгалж хамгаалах” нь сэдэвт ЮНЕСКО-ийн сургалт

Энэхүү сургалтын төсөл нь Булган аймгийн Баяннуур сумын нутагт орших, манай эриний 6-7-р зууны үед холбогдох эртний нүүдэлчдийн язгуартны бунхант булшны ханын зургийг хадгалах хамгаалах, аюулгүй байлгах асуудлыг шийдвэрлэхэд оршино.

Дурсгалт газрын соёлын ач холбогдол, мөн манай улсад энэ төрлийн дурсгалт газрыг хадгалж, хамгаалахтай холбогдолтой хангалттай туршлага байхгүй зэргийг Монгол Улсын засгийн газар харгалзан үзээд ЮНЕСКО-гийн туслалцааг хүссэн билээ.

Дурсгалыг хадгалах хамгаалах үндсэн асуудлуудыг шийдвэрлэхийн тулд энэ төсөлд 3 гол асуудалд анхаарал хандуулах шаардлагатай. Үүнд: Ханын зурагнуудыг хадгалах, археологийн дурсгалт газрыг хадгалж, хамгаалах, боловсон хүчний чадамжийг нэмэгдүүлэх, дурсгалт газрыг олон нийтэд танилцуулснаар ямар анхан шатны нөлөөлөл гарч ирэхийг тодорхойлох зэрэг болно.

2014 оны үйл ажиллагааны үр дүнд тулгуурлан ханын зураг сэргээн засварлах боловсон хүчиний чадавхийг дээшлүүлэх, дурсгалын ханын зургийг хамгаалах, сэргээн засварлах зорилгоор ЮНЕСКО, Соёлын өвийн төв хооронд 2015 оны 09 сарын 25-ны өдөр байгуулсан 4500283248 тоот гэрээний дагуу сургалтыг “Шороон бумбагарын бунхант булшны ханын зургийг сэргээн засварлах, хадгалж хамгаалах” нь сэдэвийн хүрээнд ЮНЕСКО, Боловсрол, Соёлы, Шинжлэх ухааны яам, ЮНЕСКО-гийн Монголын Үндэсний Комисс, Соёлын өвийн төв хамтран зохион байгуулсан.

СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР

Булган аймгийн Баяннуур сурын нутагт орших Шороон бумбагарын бунхант булшны ханын зургийг сэргээн засварлах, хадгалж хамгаалах онол, практик хосолсон 19 өдрийн сургалт 2015 оны 10 дугаар сарын 19-ны өдрөөс 2015 оны 11 дүгээр сарын 06-ны өдрүүдэд зохион байгуулагдсан.

Онолын нийт 8 өдрийн хичээл нь Улаанбаатар хот, Соёлын өвийн төвийн 204 тоот өрөөнд зохион байгуулагдаж, Практикийн 10 өдрийн хичээл нь Булган аймгийн Баяннуур сумын нутагт орших Майхан уулын Шороон бумбагарын дурсгалт газар зохион байгуулагдсан.

Нийт 19 өдөр үргэлжилсэн энэхүү сургалтыг “ Булган аймгийн Баяннуур сумын нутагт орших Майхан уулын Шороон бумбагар дахь археологийн дурсгалыг хадгалах, хамгаалах, тогтвортой хөгжлийг хангах менежмент” төслийн хүрээнд дурсгалын ханын зургийг хамгаалах, сэргээн засварлахад үндэсний мэргэжилтнүүдийн чадавхийг дээшлүүлэх зорилгын дор Үндэсний 8 оролцогч болох Соёлын өвийн төвийн 7 сэргээн засварлагч болон Шинжлэх ухааны академийн, Түүх, археологийн хүрээлэнгийн 1 сэргээн засварлагчийг хамруулан ЮНЕСКО, Боловсрол, Соёл, Шинжлэх ухааны яам, ЮНЕСКО-гийн Монголын Үндэсний Комисс, Соёлын өвийн төв хамтран нийт 15 хүний бүрэлдэхүүнтэйгээр зохион байгуулав.

Сургалтын гол зорилго:

1. Дурсгалын өнөөгийн хадгалалт, хамгаалалтын байдалд хэрхэн үнэлэлт дүгнэлт өгөх, эрсдлийг хэмжих, эрсдлийг шалтгаан, үнэлгээг гаргах;
2. Бунханы ханын зургийг хэрхэн сэргээн засварлах, бэхжүүлэх, ямар төрлийн цэвэрэлэгээний материалууд хэрэглэх;
3. Ханын зургийг сэргээн засварлахад хэрэглэгддэг олон улсын дэвшилтэт технологи судлах, ханын зураг сэргээн засварлах олон улсын жишээнээс суралцах, харьцуулах;
4. Ханын зургийг хадгалж хамгаалах, сэргээн засварлах болон сэргээн засварлагчийн ажлын тодорхойлолт эрх үүргийн талаарх олон улсын хууль, дүрэм, журам, актууд судлах;

СУРГАЛТЫН БЭЛТГЭЛ ҮЙЛ АЖИЛЛАГАА

Сургалтын үеэр гарын авлага болж тараагдах материал, илтгэлүүд нийт 280 гаруй хуудас материалыг орчуулан гарын авлага болгон тус бүр 15 хувь хэвлэж үүнээс 13 хувь нь сургалт эхлэхийн өмнө бүх оролцогчдод тараагдсан.

Сургалт нь хот, хөдөө болон онол практик хосолсон сургалт учраас хөдөөний буюу

дурсгалт газар дээрхи сургалт зохион байгуулах бэлтгэл ажлыг хангасан.

Дурсгалт газар дээр сургалт явуулах орчин нөхцлийг бүрдүүлж иж бүрэн гэрийг худалдан авч 2015 оны 10 дугаар сарын 21-ны өдөр дурсгалт газар руу тээвэрлэн буулгаж, барьж бэлтгэсэн, дараа дараагийн сургалт, үйл ажиллагаануудад хэрэг болох үүднээс зөвхөн нэг удаагийнх бус олон хэрэглэгдэх чанартай техник, тоног төхөөрөмж зөөврийн дуу өсгөгч, микрафон, самбар, проектор, дэлгэц, эвхэгддэг ширээ, сандал,гэр дулаацуулах зуух зэргийг худалдан авч, түлээ, нүүрс, цахилгаан үүсгүүр болон сургалтын цайны завсарлагад хэрэглэгдэх завсарлагын зүйлс, ус, цай, кофе, дадлага ажилд хэрэглэгдэх сургалтын материалууд гэх мэт зүйлсийн хамт тээвэрлэн буулгаж бэлэн байдлыг хангасан болно.

Сургалтанд оролцогчдын сургалтын материал гарын авлага

Шороон бумбагарын дурсгалт газар дээр сургалт явуулахаар бэлтгэсэн гэр

1 дэх өдрийн сургалт: 2015 оны 10 сарын 19.

Сургалтын нээлтлийн үйл ажиллагаа

Сургалтын нээлтийн ажиллагаа нь 2015 оны 10 дугаар сарын 19-ны өдөр Соёлын өвийн төвийн 204 тоот өрөөнд эхэлсэн. Нээлтийн ажиллагаанд Боловсрол, Соёл, Шинжлэх ухааны яамыг төлөөлж мэндчилгээ дэвшүүлэхээр тус яамны Соёлын өвийн хэлтсийн мэргэжилтэн Б.Даваацэрэн, ЮНЕСКО-гийн Монголын Үндэсний комиссын Ерөнхий нарийн бичгийн дарга Г.Жаргалсайхан үг хэлж, Соёлын өвийн төвийн захирал Г.Энхбат нээлтийн ажиллагаа удирдан явуулсан. Тус үйл ажиллагааны мэдээлэл Монголын улсын хэвлэл мэдээллийн салбарын төлөөлөл болох UBS, MNC, C1, NTV зэрэг 4 телевиз, 7 сайтаар олон нийтэд цацагдсан.

Эхний өдрийн сургалт сургагч багш Клаудио Марготтини (ЮНЕСКО-гийн зөвлөх) хичээлээр эхэлж, сургалтын эхэнд гарын авлага сургалтын материалын талаар танилцуулсан.

Г.Жаргалсайхан, ЮНЕСКО-гийн Монголын Үндэсний комиссын Ерөнхий нарийн бичгийн дарга

Б.Даваацэрэн, БСШУЯ-ны Соёлын өвийн хэлтсийн мэргэжилтэн

Сургалтанд оролцогчид

Г.Энхбат, Соёлын өвийн төвийн захирал

Мөн ЮНЕСКО–гоос олон улсад соёлын болон байгалийн өвийг хамгаалахад хэрэгжүүлсэн томоохон төслүүдийн талаар танилцуулга хийсэн. Одоогоор ЮНЕСКО-д соёлын болон байгалийн 107 өв бүртгэлттэй байгаагийн 76 орчим хувьд нь геологи болон байгалийн хүчин зүйлсийн нөлөөгөөр өөрчлөлт орж байдаг талаар дурдаж, соёлын өвийг хамгаалах сэргээн засварлах цогц үйл ажиллагааны өмнө хийгдэх судалгааны ажлын салшгүй нэг хэсэг нь тухайн дурсгалт газрын геологи газар зүйн тогтоц чулууллагын талаар мэдсэн байх шаардлагатай хамгийн чухал сэдэв болох инженер, геологийн тогтоцын талаархи илтгэлээр лекцийг эхлүүлэв.

Үүнд инженер геологийн ерөнхий ойлголт, түүний шинж чанар, байгалийн тогтоцын онцлог, чулуулгын төрөл зүйл бүтцийн судалгаа, түүний хувирал нөлөөллийн талаарх лекцүүд оров.

Энэ өдрийн хичээлээр оролцогчид инженер, геологийн асуудал нь соёлын өвийг хадгалж хамгаалах, сэргээн засварлах цогц үйл ажиллагааны өмнө хийгдэх судалгааны ажлын салшгүй нэг хэсэг, соёлын өвийн дурсгал нь тухайн оршин буй газрын хаа газар зүйн тогтоц геологийн чулууллагын төрөл зүйлээс хамаарч хэрхэн байгалийн нөлөөлөлд автаж эвдэрч сүйрэх, гэмтэж, муудах нөлөөлөлийн хүчин зүйлс , шалтгааны эх үүсвэр болдог, яагаад хамгийн түрүүнд энэ сэдвийг мэддэг байх шаардлагатай талаар мэдээлэл ойлголттой болсон.

2 дахь өдрийн сургалт : 2015 оны 10 сарын 20.

Энэ өдрийн хичээлийг сургалт багш Клаудио Марготтинин удирдлага дор эхний өдрийн хичээлийн үргэлжлэл болох чулууллаг хөрсний бүтэц, гадаргын усны нөлөөлөл болон гүний ус үүсэх геологийн үйл явцын талаар онолын хичээл орсон. Энэ өдрийн хичээлийн үр дүнд оролцогчид геологийн газрын зураг дээр ажиллаж Шороон бумбагарын дурсгалт газрын газар зүйн тогтоц хөрсний бүтэцийн онцлогын талаар тодорхой мэдээлэлтэй болсон.

Мөн энэ өдөр ЮНЕСКО-гийн зөвлөх, ханын зургийн хадгалалт хамгаалалт, сэргээн засварлалтын олон улсын эксперт сэргээн засварлагч тус сургалтын сургагч багш Родолфо Люжан Лансфорд Улаанбаатарт ирсэн.

Клаудио Марготтини
Сургагч багш ЮНЕСКО-гийн зөвлөх

Сургалтанд оролцогчид

3 дахь өдрийн сургалт : 2015 оны 10 сарын 21.

Энэ өдрийн хичээлээр газар зүйн урьдчилсан судалгаа цооног өрөмдлөг хийх, гео физикийн тандалтын судалгаагаар чулууллагын давхарга, хөрсний бүтэц, чулуу хөрсний бэхжилтын шинж чанарыг тодорхойлж газрын үнэлгээ хийх талаар голчлон үзэж үүнтэй уялдуулан олон улсын жишээнүүдийг хамтатган үзэв.

Мөн энэ өдрийн төлөвлөгөөнд орсон үйл ажиллагаануудын нэг нь дурсгалт газар явагдах дадлага хичээлийн бэлтгэл ажлыг хангах, сургалт явуулах гэр, техник, тоног төхөөрөмж, өвлийн улирал учраас гэрийн дулаацуулах түлээ, нүүрс гэх мэт зүйлсийг дурсгал газар тээвэрлэн буулгаж, сургалтын гэрийг барьж бэлэн болгох байсан ба соёлын өвийн төвийн бэлтгэл ажлын баг 2015 оны 10 сарын 21-ны үдээс хойш бүх зүйлсийг тээвэрлэн очиж бэлтгэл ажлыг хангасан.

Мөн зохион байгуулагч талууд болон мэргэжилтнүүдийн уулзалтыг тус төвийн 204 тоо өрөөнд зохион байгуулсан. Уулзалтанд ЮНЕСКО-гийн Бээжин оффисын төлөөлөгч Федерика болон олон улсын экспертүүд Родолфо Люжан Лансфорд, Клаудио Марготтини, Боловсрол, Соёл, Шинжлэх ухааны яамны Соёлын өвийн хэлтсийн мэргэжилтэн Б.Даваацэрэн, ЮНЕСКО-гийн Монголын Үндэсний Комиссын төлөөлөгч Эрдэмбилэг, Палеонтологи, археологийн музейн шинэчлэл төслийн төлөөлөгч Т.Дуламсүрэн, Соёлын өвийн төвийн захирал Г.Энхбат болон Соёлын өвийн төвийн сэргээн засварлах хэлтсийн дарга С.Чинзориг, Орчуулагч Ж.Бодьбаатар нар оролцсон. Уулзалтын үеэр Баяннуурын, Шороон бумбагарын бунхант булшны өнөөгийн хадгалалт хамгаалалтын нөхцөл байдал, тулгамдаж буй асуудалууд, цаашид энэ дурсгалыг олон улсад мөрдөж буй ЮНЕСКО-гийн зарчимын дагуу хамгаалах боломжтой эсэх, хэрхэн хамгаалах болон цаашид авах арга хэмжээний талаарх Боловсрол, Соёл, Шинжлэх ухааны яамнаас баримтлаж буй бодлогын талаар талууд хорондоо санал солилцов.

Зохион байгуулагч талуудын санал солилцох уулзалт

5 өдөр: 2015 оны 10 сарын 23.

Дурсгалт газар дээрхи сургалтын нээлтийн ажиллагаа эхлэхийн өмнө ЮНЕСКО-гийн олон улсын эксперт Родолфо Люжан Лансфорд, Клаудио Марготтини , ЮНЕСКО-гийн Бээжин оффисын төлөөлөгч Федерика болон Соёлын өвийн төвийн захирал Г.Энхбат, Соёлын өвийн төвийн Соёлын өвийг хамгаалах сэргээн засварлах хэлтсийн дарга С.Чинзориг, орчуулагч Б.Лхамсүрэнгийн хамт шороон бумбагарын ханын зургийн дурсгалын өнөөгийн хадгалалтын байдалтай танилцаж, нөхцөл байдалд шинжилгээ, дүгнэлт хийж, орон нутагт хийх сургалтын хөтөлбөрт бага зэргийн өөрчлөлт оруулах талаар ярилцсан.

Дурсгалт газарт 2015 оны 8-р сард ирэхэд бунханы доторх нөхцөл байдал, ханын зураг ерөнхийдөө тогтвортой байсан. 2015 оны 10-р сарын 23 нд бунханыг нээхэд бунханы үүдэвчний баруун талд дүрсэлсэн цагаан барсын цээж толгой их биеийн хэсгүүд, мөн үүдэвчний зүүн талын хананд дүрсэлсэн хөх лууны урд хөл, цээжний хэсгүүдийн өнгө будгийн гадарт хөрсөнд агуулагдах давс талсжсан хэлбэртэй тархсан байсан. Давсны талсжилт их тархсан хэсгүүдийн өнгө будаг суларч хөндийрөх, хуурч унах байдлаар зургийн дүрслэл их гэмтсэн байсан. Иймээс ханын зургийн хуурч хөндийрсөн гэмтлийг засварлах гадарт тархсан давсны тархалтыг цэвэрлэх ажлуудыг яаралтай хийх зэрэг ажлын нөхцөл байдалтай байдалтай уялдуулан хичээлийн хуваарьт бага хэмжээний өөрчлөлт оруулж илүү дадлага, сэргээн засварлах ажил талруу гаа өөрчлөхөөр болсон.
Дурсгалт газар дээрх хичээлийн нээлт 2015 оны 10 сарын 23-ны 10 цагт эхэлсэн. Үйл ажиллагааг нээж Соёлын өвийн төвийн Захирал Г.Энхбат болон ЮНЕСКО –гийн Бээжин дахь оффисийн төлөөлөгч Федерика нар үг хэлэв.

Орон нутаг дахь сургалтын нээлт

Соёлын өвийн төвийн захирал Г.Энхбат, ЮНЕСКО –гийн Бээжин дахь оффисийн төлөөлөгч Федерика нар үг хэлэв

Нээлтийн ажиллагааны дараа хичээлийг Родолфо Люжан Лансфорд болон Клаудио Марготтини нар удирдан явуулсан бөгөөд хичээлийн эхэнд товчхон танилцах арга хэмжээ болж оролцогчид өөрсдийгөө төлөөлөгчдөд танилцуулсан.

Энэ үйл ажиллагааны дараа оролцогчдын хамт дурсгал руу орж бунханы ханын зургийн хадгалалтын нөхцөл байдалтай танилцаж, дурсгалын өнөөгийн байдалд дүн шинжилгээ хийж, тулгарч буй асуудлуудыг нарийвчлан гаргаж нөхцөл байдлыг дүгнэж, цаашид юу хийх талаар хэлэлцүүлэг хийв.



Хичээлийн явц

Оролцогчид дурсгалын нөхцөл байдалтай танилцаж буй

6 дахь өдөр: 2015 оны 10 сарын 24.

Энэ өдрийн хичээлээр дурсгалын газар зүйн, геологийн бүтэц чулууллагийн төрөл зүйл болон дурсгалын доторхи ханын шавар өнгөлгөөний найрлага, ханын зургийн будгийн өнгөний төрөл зэрэг хэрэглэгдсэн хэрэглэгдэхүүнүүдийг судлах судалгааг хэрхэн хийх талаар хичээл орсон. Мөн бунханы хэсгийн ханын чулууллагийн бүхэллэг, хатууллаг бат бөх чанар, даралт даах чадварын үнэлгээг гаргасан. Бунханын зүүн талын хананаас нурж унасан шавар өнгөлгөөнөөс жижиг хэмжээний дээж авч шаврын бүтэц ус даах чанарыг шалгах туршилт хийсэн. Мөн энэ хэсгийн нурсан ханын шавар өнгөлөгөөний хэсгүүдийн тусгайлан хуванцар саванд хийж тавьсан.

Бунханы чулуун ханын бүхэллэг чанарыг тодорхойлох хэмжилт

Ханын өнгөлгөөнд ашигласан шаврын ус даах чанарыг тодорхойлох туршилт

Бунхан доторхи шавар өнгөлгөөгүй чулуун ханын нуралт маш их байгаа тул бунханы ханын өнгөлгөөнд ашигласан шавартай ижил төрлийн шавар олж нуралт үүсээд буй хэсгүүдэд шавраар өнгөлгөө хийвэл нуралтыг багасаж зогсоох боломж байж болно гэж үзсэнээр ижил төрлийн шавар бунханы ойролцоо газруудаас хайж дээж авах ажлыг хийсэн.

Бид бунханы хуучин шавар өнгөлтөөтэй ижил төстэй байж болох дээжүүдийг дурсгалын ойр орчмын 3 цэгээс авч, шинжилгээ хийлгэхээр сургагч багш Клаудио Марготтинид өгсөн.

Бунханаас зүүн урагш 5 км орчимд голын хөндийгөөс шаврын дээж авч буй зураг

Бунханаас баруун зүгт 100 м орчмын зайтай газраас шавар шорооны дээж авч буй зураг

Энэ өдрийн хичээлийн явцад шороон бумбагарын бунхант байгууламжын хөрс чулууллагийн тогтоцоос шалтгаалан ханын өнгөлгөө шавар нь ханын зургийн суурь дэвсгэрийн үүрэг гүйцэтгэхээс гадна, бунханы чулуун хана хөрсийг нуралтаас хамгаалах хамгаалалтын тулгуурийн үүргийг давхар гүйцэтгэж байгаа нь өөр бусад ижил төрлийн дурсгалуудаас эрс ялгаатай, энэ онцлогт нь тохирсон хамгаалалтын арга боловсруулж туршилт хийж үзэх шаардлагатай гэж үзсэн.

8 дахь өдөр: 2015 оны 10 сарын 26.

Энэ өдрийн хичээлээр хөрсний усны шилжилт хөдөлгөөн болон түүний онцлог, шинж чанар, бунханд нөлөөлж буй хөрсний ус чийгний эх үүсвэр хаанаас байж болох, бунханы модон байгууламжид тархсан мөөгөнцөрийг хэрхэн цэвэрлэх, ханын зургийн хөндийч хууларсан хэсгүүдийг ямар аргаар засварлах, зургийн гадарын давсыг цэвэрлэх талаар ярилцаж олон улсад ашиглаж байсан аргачлалын талаар танилцуулсан.

Хичээлийн явц

9 дэх өдөр: 2015 оны 10 сарын 27

Энэ өдрийн хичээлд оролцогчдыг 3 багт хуваж ажил үүргийг хуваарилсан.

Үүнд: 1-р багт: С.Чинзориг, Д.Нямдорж – Бунханы зүүн талын план зургийг гаргаж, гэмтлүүдийг тодорхойлж, хэмжилт хийж, ханын зургийг бэхжүүлэх ажил хийх;

2-р багт: Н.Бат-Эрдэнэ, Г.Анхсанаа, Э.Батжаргал: Бунханы хойд хэсгүүдийн план зургийг гаргах, гэмтэл болон ханын ерөнхий хэмжилт хийх, ханын зургийг бэхжүүлэх, дижитал хэлбэрээр баримтжуулалт хийх,

3-р багт: А.Мөнгөнцоож, Б.Бадар-Ууган, Н.Нандинцэцэг- Бунханы зүүн хананы план зургийг гаргах, цэвэрлэгээ хийхэд шаардагдах уусмал бэлтгэх, Модон бэхэлгээ болон чулуун хананы мөөгөнцөрийг устгах.

Хичээлийн үрдүнд 3 баг дурсгалын ерөнхий план зургийг гаргаж бүх гэмтлийн тэмдэглэгээнүүдийг хийж, дараагийн өдөр хийх ажлын бэлтгэл хангасан.



Хичээлийн явц

10 дахь өдөр: 2015 оны 10 сарын 28.

Дадлага буюу цэвэрлэгээний ажил хийгдсэн.

Ханын зургийг хууларч хөндийрсөн хэсгүүдийг буцаан дарж хэлбэржүүлэж бэхжүүлэх дадлага ажлыг багш Родолфо өөрөө биечлэн удирдан зааж оролцогчид цааш нь үргэлжлүүлэн бэхжүүлэх ажлыг хийж эхэлсэн. Бэхжүүлэх ажлыг хийхдээ нимгэн муутуу цаасыг усаар тохирох хэмжээнд хүртэл норгож ханын зургийн хөндийрсөн хэсгүүд дээр дарж, хөндийрсөн шавар өнгө будгийг суулгаж өгөх засварлах ажлыг хийсэн.

Ханын зургийн өнгө будгийн давхарга хуурч унасан гэмтэлүүдийг засварлахын өмнө

Бунханыг анх нээгдэх үед ханын зургийн өнгө будгийг бэхжүүлэх зорилгоор паралойд В-72 -ийн уусмалаар бэхжүүлсэн зургийн өнгө бусад ханын хэсгүүдтэй харьцуулахад бага зэргийн бараан өнгөтэй, бэхжүүлэлт хийсэн хэсгүүдийн өнгө будаг харьцангуй тогтвортой, бэхжүүлэгч түрхээгүй хэсгүүдийн ханын цайвар шохойн өнгөлөгөө хууларч унах байдлаар гэмтэлүүд үүссэн байсан. Мөн бэхжүүлэлт хийсэн зарим ханын зургийн гадар, бэхжүүлэлт хийгдээгүй ханын хэсгүүдэд ижил төрлийн цайралт үүсэж буй нь ханын зургийн дүрслэлийг бүдгэрүүлэх шалтгаан болж байна гэж үзсэн. Ханын зургийн гадарт үүссэн цайвар өнгө, Паралойд В-72 –ийн давхаргыг Толуолын 100 % уусмалаар цэвэрлэх туршилтын ажлын үүдэвчний зүүн талын тугны хажууд зогсоо хүний дүрслэл дээр хийж цэвэрлэх боломжтой гэж үзсэн

Мөн Бунханы модон бэхэлгээнд нилэнхүйдээ тархсан мөөгөнцөрийг устгахад Хлорид 3% -ийн уусмал найруулан туршилт хийж, бүх модон бэхэлгээнд энэхүү уусмалыг ашиглан цэвэрлэгээ хийхээр болсон

Модон бэхэлгээний мөөгөнцөр ханын чулуу шавар өнгөлөгөөн дээр ханан дээр тархсан байдал /цэвэрлэгээний ажлын өмнө/

Модон бэхэлгээнд тархсан мөөгөнцөр /цэвэрлэгээний өмнө/

Ханын зургийн гэмтлийг засварлах аргачлалыг заах явц

Муутуу цаас ашиглан ханын зургийг өнгө будгийн хуурч хөндийрсөн хэсгүүдийг бэхжүүлэх, давс зайлуулах ажлын явц

Ханын гадарт үүссэн давсны талстыг зайлуулах туршилтын ажил

11 дэх өдөр: 2015 оны 10 сарын 29.

Муутуу цаас ашиглан ханын зургийг өнгө будгийн хуурч хөндийрсөн хэсгүүдийг бэхжүүлэх, давс зайлуулах ажлыг хийж дуусгасан.

Ханан дээр наасан муутуу цаас нь ханын зургийн хөндийрсөн хэсгүүдийг дарж наахаас гадна тухайн ханын зургийг гэмтээж байгаа зургийн гадарга дээр ил гарсан болон далд хэлбэрт байгаа давсыг өөртөө татаж гадагшлуулах үүрэгтэй бөгөөд бүрэн хатсан үедээ өөрөө хууларч унадаг. Хатах хүртэл нь хүлээх шаардлагатай.

Багш Родолфо бунханы ханан дээр үүссэн мөөгөнцөрийг Кальци карбонатын 3% -ийн уусмал ашиглан хэсэг газар туршилт хийсэн.

Бунханы модон бэхэлгээнд үүссэн хөгц, мөөгөнцөрийг цэвэрлэх ажлын явц

12 дахь өдөр: 2015 оны 10 сарын 30.

Дурсгалт газар дээрхи хичээлийн сүүлийн өдөр. Бүх модон бэхэлгээний мөөгөнцөрийн бохирдолын цэвэрлэгээ, ханын зургийн бэхжүүлэлт, ханын зураг бунхант байгууламжын нуралт гэмтлийг тодорхойлох гар зургийн хэмжилтийн ажил хийгдэж дуусан. Мөн бунханы дулаалагын ажлыг өмнөх жилүүдийн адилаар хийж гүйцэтгэсэн.

Үүний дараа бунхан болон бунханы ойр орчмын бүх хог хаягдал, бохирдолыг шатааж, шатаах боломжгүй хог хаягдалыг булж, дурсгалын ойр орчимд цэвэрлэгээ хийж дуусан.

Модон бэхэлгээний мөөгөнцөрийн цэвэрлэгээний дараа



Ханын зурганд бэхжүүлэлт хийсэн байдал



Бунханы дээврээс, хажуу хананаас унасан чулууг цэвэрлэсэн байдал

Бунханы дулаалга хучилтыг хийж буй байдал

15 дахь өдөр: 2015 оны 11 сарын 02.

Энэ өдрийн хичээлээр ханын зургийг хамгаалах сэргээн засварлахад баримтлаж буй олон улсын туршлагаас судалж, сэргээн засварлалтын арга барил, нэр томьёо мөн ханын зургийн эвдрэлийн шалтгаанууд, ханын зургийн төрлүүдийг судлаж урьд үзсэн хичээлүүдийн мэдлэгийг бататгасан.

16 дахь өдөр: 2015 оны 11 сарын 03.

Ханын зургийг хамгаалахад баримтлах сэргээн засварлалтын ажилтай хамааралтай олон улсын журам конвенцын талаарх мэдээлэл, сэргээн засварлагчдын мэргэжлийн тодорхойлолт, ажлын онцлог, мэдсэн байх шаардлагатай мэдлэг, чадваруудын талаар хичээл орсон.

Хичээлийн явцад ханын зургийн бүрэлдэхүүн хэсэгт хэрэглэгддэг материалуудын шинж чанар өөрчлөлтын талаар ярилцаж бага хэмжээний туршилтыг Са О - дээр хийсэн.

Туршилтын явц

17 дахь өдөр: 2015 оны 11 сарын 04

Урьд өдрийн хичээлийн үргэлжлэл, мөн ханын зураг бунхант байгууламжын дотор үүссэн гэмтэл бохирдолын тэмдэглэгээр график зургаар хэрхэн тэмдэглэх аргачлалын талаар БНАСАУ -ын Когуриогийн бунханы ханын зургийн гэмтлийн график зурганд дээр ярилцаж хичээл орсон. Шороон бумбагарын ханын зургийн гэмтлийн график зурган дээр тэмдэглэх ажлыг дуусгаж калкин цаасан дээр буулган дижитал хэлбэрт скайнардан оруулсан.

Зураг ханын зургийн план зургийг скайннардаж дижитал хэлбэрт оруулсан байдал



Бунханы хойд талын ханын эвдрэл гэмтлүүдийг тэмдэглэсэн график зураг



Бунханы зүүн хананы эвдрэл гэмтлийн график зураг



Бунханы баруун хананы эвдрэл гэмтлийн график зураг

18 дахь өдөр: 2015 оны 11 сарын 05.

Энэ өдрийн хичээлд ханын зургийн төрөл зүйлийн талаар танилцуулга хичээл орж тэдгээрийг хийхэд технологийн ямар ялгаатай талууд байдаг хэрхэн туршиж хийж болох талаар ярилцаж оролцогчид тус бүр нэг нэг төрлийн ханын зургийн хуулбар хийхээр шаардлагатай материал болох элс, хайрга, хөрс, шохой сүрэл үс хялгас гэх мэт зүйлсийг ашиглан фресско стекко шороон бумбагарын ханын зураг зэрэг төрлүүдээс төлөөлүүлэн жижиг шавар хана хийж, түүнийгээ хатааж зураг зурахад бэлэн болгосон.

Ханын зургийн дэвсгэр бэлдэх ажлын явц

19 дэхь өдөр: 2015 оны 11 сарын 06.

Дадлага ажил. Урьд өдөр нь бэлэн болгож тавьсан ханын загвар бэлдэц дээр оролцогч тус бүр өөр өөрсдийн сонгосон ханын зургийн бүтээх арга технологийн дагуу зураг зурах ажлыг хийсэн .

Ханын зураг зурах явц

Ханын зураг зурах явц

Хаалтын ажиллагаа 04:30 минутаас СОРТ Ресторанд зохион байгуулагдсан ба Соёлын өвийн төвийн захирал Г.Энхбат хаалтын ажиллагааг хөтөлж, Боловсрол, Соёл, Шинжлэх ухааны яамны Соёлын өвийн хэлтсийн мэргэжилтэн Б.Даваацэрэн, ЮНЕСКО-гийн Монголын Үндэсний комиссын Ерөнхий нарийн бичгийн дарга Г.Жаргалсайхан мөн удирдагч багш Родолфо Люжан Лансфорд нар үг хэлж, ЮНЕСКО-гийн Монголын Үндэсний комиссын төслийн зохицуулагч Туул, О.Чанцалдулам, соёлын өвийн төвийн нийт ажилчид байлцаж оролцогчдод Сертификат гардууллаа.

3.4. "Түүх, соёлын үл хөдлөх дурсгалыг хамгаалах, сэргээн засварлах хөтөлбөр"-ийн 7.2, 7.3 дахь ажлууд

Баянхонгор аймгийн Эрдэнэцогт сумын нутагт орших Шатар чулууны цогцолбор дурсгал, Завхан аймгийн Шилүүстэй сумын Дааган дэлийн буган чулуун хөшөөний цогцолбор дурсгалт газар танилцуулга самбар байрлуулж, судалгаа хийсэн тухай

Монгол улсын Засгийн газрын 2007 оны 303 дугаар тогтоолоор батлагдсан "Түүх, соёлын үл хөдлөх дурсгалыг хамгаалах сэргээн засварлах хөтөлбөр"-ийн хүрээнд 2015 оны 7 дугаар сард Соёлын өвийн төв "Бодь буян" ХХК-тай гэрээ байгуулан 8 сая төгрөгний үнэ бүхий 2 ширхэг чулуун танилцуулга самбарыг хийлгүүлэн, хөтөлбөрийн үйл ажиллагааны төлвөлгөөний 7.2.2, 7,2,7 дахь заалтанд заагдсан дурсгалт газар байрлуулах ажлыг хийв.

Соёлын өвийн төвөөс Баянхонгор аймгийн Эрдэнэцогт сумын Шатар чулуу, Завхан аймгийн Дааган дэлийн дурсгалт газар товч тайлбар бүхий чулуун танилцуулга самбарыг 2015 оны 7 дугаар сар 22-ноос 27 хооронд байрлуулав. Соёлын өвийн төвөөс самбар байрлуулах сэргээн засварлагч Д.Нямдорж, Н.Бат-Эрдэнэ, мэргэжилтэн Г.Анхсанаа нар, Бодь буян ХХК-ийн ажилтан н.Бямбаа нарын бүрэлдэхүүнтэй баг ажиллав.

Шатар чулууны дурсгал. Баянхонгор аймгийн Эрдэнэцогт сумын төвөөс урагш 11 км зайд /Түйн голын зүүн биед/ Шатар чулууны ам хэмээх газарт түүхийн өөр өөр цаг үед холбогдох олон төрлийн дурсгал нэгэн доор бөөнөөр оршдог. Энд буй хөшөө чулуу, булшнууд нь алсаас өрсөн мэт харагдах тул ийнхүү Шатар чулуу хэмээх нэрийг авчээ. Дурсгалт газар нь 4-5 км өргөн, 8 км орчим урттай.

Энэ аманд: /Гэрэл зураг -1/

Хадны сүг зураг
Дөрвөлжин хүрээт хиргисүүр
Дүгрэг хүрээт хиргисүүр
Дөрвөлжин булш
Дүгрэг булш
Өнцөгтөө буган чулуут дөрвөлжин булш
Шоргоолжин булш
Цагирган хэлбэрт булш
Хүн чулуу- зэл чулуут хашлага
Зэл чулуут хашлага
Энгийн хашлага зэрэг нэр төрлийн 50 гаруй дурсгал бий.

Монголын эртний түүхийн олон үеийн дурсгал нэг доор бөөгнөрсөн, эрдэм шинжилгээний үүднээс онц сонирхолтой, байгаль орчинтойгоо уялдан зохилдсон Шатар чулууны дурсгал нь онцгой анхааран хамгаалбал зохих түүх, соёлын ховор өв юм.

Дурсгалт газар самбар байрлуулахад Баянхонгор аймгийн музейн ажилтан Б.Батжаргал, Эрдэнэцогт сумын Соёлын төвийн эрхлэгч Л.Ганчимэг, байгаль орчны улсын байцаагч Н.Энхтүвшин нар байлцсан бөгөөд салбарыг дурсгалт газрын зүүн талд, бүлэг дөрвөлжин булшны дэргэд баруун тийш харуулан байрлуулав. /Гэрэл зураг - 2, 3/

Мөн эдгээр чулуун дурсгалуудын бохирдол, эвдрэл гэмтлийг тодорхойлов. Ихэнх хөшөө дурсгалд хаг их хэмжээгээр ургасан, биологийн бохирдол болох шувууны сангасны бохирдол их байна. Шувууны сангасны бохирдлыг 50 % этилийн уусмалаар цээвэрлэж үзэхэд бохирдол тодорхой хэмжээнд бүдэрч, бүрэн арилахгүй байна.

Дээрх дурсгалуудын ихэнх нь хагарч цуурсан, эвдрэл гэмтэлтэй болсон байна.

Тухайлбал:

- Дөрвөлжин булш тоногдсон ба зэл балбал 30 орчим чулуу нь мэдэгдэж байна. Дөрвөлжин булшны хашлага чулуун дээр ханан хээ болон арслан сийлж чимэглэсэн хээ нь хаг болон сангасны бохирдолын дороос бүдэг мэдэгдэж байна.
- Завилсан хүний дүрслэлтэй хүн чулуун хөшөө. Толгой хугарсан, цементээр залгаж нааж байсан оромтой, цемент, сангасны бохирдол маш их.

- Арслангийн дүрслэлтэй чулуун дурсгал, толгой нь хугарч унасан, цементээр нааж байсан оромтой, цемент, сангасны бохирдол их.

- Жижиг арслангийн толгой нь салж унасан. Цементээр нааж байсан оромтой, цемент, сангасны бохирдолтой.

- Том, жижиг хоёр арслан их биеэрээ хугарсан. Цементээр эвлүүлж наасан оромтой. Цемент, сангасны бохирдолтой .

- Зүүн талын дөрвөлжин булш, шинээр ухсан байдалтай тоногдсон байна.

- Босоо хүний дүрслэл бүхий барималын цээж, толгой, их биеэрээ хугарсан, хугарсан хэсгүүд эвлүүлж сэргээн засварлах боломжтой бүрэн бүтэн болно. Хажууд нь зэл балбал чулуу 8 ширхэг байна.

Дааган дэлийн буган хөшөө.

Завхан аймгийн Шилүүстэй сумын Дааган дэл уулын хойд энгэрийн уужим дэвсгэрт хоёр эгнээ найман буган хөшөө буй. Эдгээрийн хоёр нь ойчиж, газарт гүнзгий шигдэн өвс хагаар хучигджээ. Монгол нутагт орших буган чулуун хөшөөдийн дотороос дүрслэл тод, хадгалалт хамгаалалт сайтай, анх байгуулагдсан газартаа цогцоороо оршиж байгаа дурсгал юм.

Дурсгалт газар самбар байрлуулахад Шилүүстэй сумын Соёлын төвийн эрхлэгч н.Оюун-Эрдэнэ нар байлцсан бөгөөд самбарыг дурсгалт газрын баруун талд, баруун тийш харуулан байрлуулав.

Дааган дэлийн буган хөшөөдийн 2 нь газарт унасан байдалтай. Бүх буган чулуун хөшөөдын нийтлэг бохирдол нь хаг, шувууны сангасны байна. Нийт хөшөө чулуунуудад гадна өнгөн давхаргад үелэн хуурч хөндийрөх, нарийн зураасан ан цав үүсэх зэрэг гэмтлүүд их байна.

Гэрэл зураг -1. Шатар чулууны дурсгалын баруун талаас харагдах байдал

Гэрэл зураг 2. Шатар чулуун дурсгалын дэргэд танилцуулга самбар байрлуулах ажлын явц

Гэрэл зураг 3. Шатар чулуун дурсгалын дэргэд байрлуулсан танилцуулга самбар

Гэрэл зураг 4, 5. Шатар чулуун дурсгалын шувууны сангас болон хагны бохирдлыгцээвэрлгэний тест хийж байгаа явц

Гэрэл зураг 6, 7. Шатар чулуун дурсгалын эвдрэл гэмтэл

Гэрэл зураг 8. Дааган дэлийн буган хөшөөдурсгалын урд талаас харагдах байдал

Гэрэл зураг 9. Дааган дэлийн буган хөшөөдурсгалын дэргэд байрлуулсан танилцуулга самбар

Гэрэл зураг 10. Дааган дэлийн буган хөшөө дурсгалын газарт унасан буган хөшөө

Гэрэл зураг 11-14. Дааган дэлийн буган хөшөөнд цэвэрлэгээний тест хийх явц

3.6. Дорнод аймгийн музейн үзмэр сэргээн засварлах

Дорнод аймгийн музейн үзмэрүүд болох Х.Чойбалсангийн эдэлж, хэрэглэж байсан буйдан, кресло, сандалыг сэргээн засварлах ажлыг 2015 оны 3 дугаар сарын 12-ны өдрөөс 2015 оны 3 дугаар сарын 17-ны хооронд Соёлын өвийн төвийн сэргээн засварлагч А.Мөнгөнцоож, Б.Мягмарсүрэн, О.Оюунчимэг, Т.Сүхбаатар нарын бүрэлдэхүүнтэй багийг томилон ажиллуулав.

Буйдангийн суудлын урагдсан арьс, хоёр ширхэг креслийн суудлын урагдсан арьс, сандалны урагдсан тавцан 12 ш, сандалны урагдсан түшлэг 6ш тус тус арьсыг шинээр адил ойролцоо материалаар сольсон. Шинээр сольсон хэсгээ хуучин арьстай нь ижил өнгөтэй болгож (acrylic) будгаар будаж, лакдсан. Нийт 18 ширхэг сандалны хөдөлсөн, салсан хэсгүүдийг салгаж цавууны бохирдолыг цэвэрлээд цавуудаж наах зэрэг сэргээн засварлах ажлыг хийж дуусгасан Тайланийн маягтанд бичсэн болно.

Буйдан:

Суудалын арьс 80% нь урагдалтай, 50% нь урагдаж байхгүй болсон.
Зөөлөвч хөвөн нь урагдаж дутаж 70%нь байхгүй. Доод нугалсан хүрээ урагдаж, хатаж агшсан.

Засварын өмнө

Кресло:1 №97,441

Дээд тал нь урагдсан,хоёр хажуу ирмэг урагдсан. Арьс хатаж, атирж татсан. Он удаан жилийн тоос шорооны бохирдолтой.



Кресло:2

Креслийн суудлын арьс их хэмжээгээр урагдсан, засах боломжгүй болсон. Он удаан жилийн тоос шорооны бохирдолтой. Өмнө нь урагдсан арьсны доор юм тавьж нааж байсан.

Сандал1:№97,41,12

Наалтаараа салж хөдөлгөөн орсон.баруун хойд хөл цууралттай. Түшлэгний ар талын арьс уранхай,суудал уранхай скочидсон.

Сандал2: №97,41,2

Наалтаараа салж хөдөлсөн,түшлэгний хойд арьс урагдсан,суудалны арьс урагдалтай.

Сандал3: №97,41,1

Наалтаараа салж хөдөлсөн,түшлэгний хойд арьс урагдсан,суудалны арьс урагдалтай.

Сандал4: №97,44,10

Наалтаараа салж хөдөлсөн,түшлэгний хойд арьс салсан,суудалны арьс урагдалтай.

Сандал 5: №97,41,13

Наалтаараа салж хөдөлсөн,түшлэгний хойд кноп дутсан,суудалны арьс урагдалтай

Сандал 6:№94,41,17

Суудалны урагдаж цоорсон,түшлэгний урд болон ард талын арьс урагдсан,сандал наалтаараа салж хөдөлгөөн орсон.

Сандал 7:№97,41,4

Суудалны булан урагдаж цоорсон,кноп дутуу суларсан,сандал наалтаараа салсан хөдөлгөөн орсон.

Сандал 8:№97,41,3

Суудал уранхай,түшлэгийн ар тал цөмөрсөн,хөдөлгөөн орсон.

Сандал9:№97,41,11

Суудал уранхай,түшлэгний ар тал цөмөрсөн,урд тал будаг болсон,Наалтууд салсан хөдөлгөөн орсон,баруун урд хөлний углуурга цуурж хугарсан.

Сандал 10: №97,41,15

Суудал уранхай,түшлэгний ар тал дээд хэсэгтээ цөмөрсөн, хөдөгөөн орсон.

Сандал 11: №97,41,6

Суудал уранхай,түшлэгний урд тал халцарж будаг болсон.Зүүн урд хөл углуургаараа хугарсан,хөдөлгөөн орсон.

Сандал 12: №97,41,16

Түшлэгний ар тал урагдсан,баруун урд хөл гуйль тавж хадсан,тушаа байхгүй болсон. Хөдөлгөөн орсон.

Сандал 13: №97,41,7

Суудал уранхай,түшлэгний ар тал цөмөрсөн,наалт нь салж хөдөлгөөн орсон

Сандал 15: №97,41,14

Түшлэгний ар тал нь уранхай,хөдөлгөөн орсон.

Сандал 16 :№97,41,8

Суудал уранхай,хөдөлгөөн орсон.

Сандал 17: №97,41,9

Баруун урд хөл углуургаараа доошоо цуурч хугарсан. Хөдөлгөөн орсон.

Буйдангийн бүрээсийг сольж буй ажлын явц

Креслийн бүрээсийг сольж буй ажлын явц.

Сандалны түшлэгний дутсан конопыг шинээр хийж хадав.



Шинээр орлуулсан материалыг хуучин артай нь адил төстэй болгож будав.

Засварын дараа;

СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ СЭРГЭЭН ЗАСВАРЛАХ ХЭЛТСИЙН СТРАТЕГИЙН ЗОРИЛТЫГ ХАНГАХАД ЧИГЛЭСЭН АЖИЛ, ҮЙЛЧИЛГЭЭНД НЭМЭЛТЭЭР ХИЙСЭН АЖЛУУД

2015 онд Үр дүнгийн гэрээнд тусгагдсан Соёлын өвийг хамгаалах, сэргээн засварлах хэлтсийн стратегийн зорилтыг хангахад чиглэсэн ажил үйлчилгээнд нэмэлтээр 2 төрлийн ажлыг хийлээ.

Үүнд,

Чойжин ламын сүм музейн Занхан сүмд байрлах Доржшүгдэн бурханд зориулж иргэн Б.Чулуудайн өгсөн барьцнуудыг уг бурханы барьц болгон тогтоосон ажил

Чойжин ламын сүм музейн хүсэлтийн дагуу Соёлын Өвийн Төвийн сэргээн засварлагч Н.Жамбал,Т.Сүхбаатар нар 2015 оны 01 дүгээр сарын 19-ны өдөр тус музейн сүмд байрлах Доржшүгдэн бурханы шинээр хийгдсэн барьцнуудыг тогтоох ажлыг хийж гүйцэтгэлээ.

Шинээр хийгдсэн барьцнуудыг уг дурсгалд хүчил шүлтгүй даавуун нарийн уяа, зохих ширхэглэл бүхий нийлэг сатурк зэргийг ашиглан бэхлэн тогтоолоо

Доржшүгдэн бурханы шинээр хийгдсэн барьцнуудыг анх хүлээн авах үеийн зураг



Шинээр хийгдсэн барьцнуудын талаарх мэдээлэл

Д/Д	НЭР	ХЭМЖЭЭ	МАТЕРИАЛ
	Усан сэлэм	Урт-71 см Жин-1850 гр	Ган төмөр,бариулын очир нь гууль цутгуур
	Төмөр гох /очир толгойтой модон иштэй	Урт-91 см Жин-1300 гр	Улаан таримал мод,ган төмөр
	Эрдэнийн хулгана	Урт-17 см Жин-300 гр	Улаан таримал мод
	Илд	Урт-159 см Жин-2750 гр	Төмөр,модон бариул,акрилка будаг
	Сум	Урт-108 см Жин-200 гр	Бүргэдийн өд,гууль,зэсэн бөгжтэй ган зэв,интоорын мод, акрилка будаг

Доржшугдэн бурханы шинээр хийгдсэн барьцнуудыг угсарч тогтоох ажлын явцын зураг

5.1. Чойжин ламын сүм музейн "Хүндэтгэлийн хаалга"-ны оройд орших бодь гөрөөснүүдийн дунд байрлах Хорол /хүрд/ суринаас салж гэмтсэнийг сууринд буцаан тогтоосон сэргээн засварын ажлын тайлан

Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамны Соёлын өвийн хэлтсийн 2015 оны 10/8021 дугаарт албан бичгийн дагуу Соёлын Өвийн Төвийн сэргээн засварлагч Н.Жамбал, Т.Сүхбаатар, Н.Бат-Эрдэнэ нарын бүрэлдхүүнтэй сэргээн засварлах баг 2015 оны 09 дүгээр сарын 07-08-ны өдрүүдэд Чойжин ламын сүм музейн хүндэтгэлийн хаалганы оройд байрлах Хорол/хүрд/ -г хуучин сууринд тогтоох сэргээн засварын ажлыг хийлээ.

Уг хүндэтгэлийн хаалганы орой дээврийн хийц бүхий шатаамал шавар бүтээц нь нийтдээ сийлбэртэй хөх тоосгон хийцтэй /нуруу, тосгуур, цэцгэн хээ бүхий эдэлхүүн, домгийн амьтад дүрслэлтэй шатаамал шавар эдэлхүүн/ ба хийц тус бүрийг хооронд нь шохой-шавар-давс холимог холбогчоор нааж тогтоох аргаар бүтээгдсэн байна.

Сүм баригдсанаас хойш 100 гаруй жилийн хугацаанд дээрх бүтээцийн холбох шавардлага, уллагаа шавар зэрэг нь хөдөлгөөн орж суулт, гажилт үүссэн зэргээс ан цав ихээр гарч дурсгалын бүрэн бүтэн байдалд сөрөг нөлөөг маш ихээр үзүүлэхээр болжээ.

Иймд зөвхөн хүндэтгэлийн хаалганы тухайд авч үзэхэд дээврийн шатаамал шавар бүтээцийн сэргээн засварлалтыг нэн даруй хийх шаардлагатай ба уг дурсгал дээр ажиллах орчин өвөрмөц нөхцөл байдалтай байна. Үүнд: хүндэтгэлийн хаалганы эргэн тойронд заавал засварын шат угсарч ажиллах шаардлагатай/ дээврийн нуруу, тосгуур хийцүүд бүгд хөдөлгөөнд орж суларсан учир дээгүүр нь гишгэж ажиллах боломжгүй, сүмийн хашаанд крантай машин орох боломжгүй г.м/байна. Хүндэтгэлийн хаалганы орой дээрх Хорол, бодь гөрөөснүүд нь хоёр үзүүр дээрээ амаа ангайн, сүүлээ нумруулсан матар лууны дүрслэлтэй, ар өвөр хоёр талдаа цэцэг дүрслэлтэй дөрвөлжин нүүр ваарыг 6:6-гаар эгнүүлж дотор дүүргэлтийг хөх тоосгоор өрж, ташуу ирмэгтэй нимгэн, мөлүү ирмэгтэй зузаан шатаамал хөх тоосгон хавтанцараар тагласан дэл дээр байрлаж байдаг байна. Хорол,бодь гөрөөснүүд нь суурь бадны ёроол доороос тагласан таг модонд суулгасан 7см:2, 5см:8см-ын харьцаатай углуурга модоор хаалганы орой дээрх дэлний хамгийн дээд тавцанд гаргасан углуурганы нүхэнд сул сууж байрлуулсан байдалтай байсан болно. Хорол/хүрд/-ны доод шатаамал шавар хийц нурж хөдөлгөөн орсныг түрүү үед /хэдийд засварласныг мэдсэнгүй/ цементээр нөхөж тогтоосон ба тэр нь дахин нурж улмаар хорол нь унаж оройн гал, суурь бад зэрэг хэсгүүдэд хонхойж гэмтсэн байна.

Цаг хугацаа давчуу, сүм музей дээр зохиогдох арга хэмжээ тулсан үе таарсан учир хоролны гэмтлийг засалгүй шууд байрлуулсан болно.Цаашид хүндэтгэлийн хаалганы дээврийн засварын ажлын үед дээрх хоролыг сэргээн засварлах шаардлагатай /ер нь хорол,бодь гөрөөснүүдийн суурь бадны ёроолын таг,дотуур гол мод,углуурга моднуудыг цаашид солих шаардлагатай болсон байна/. Хоролны доод суурийг хуучин нурсан цементэн бохирдлоос салгаж,сүмийн хашаан дотор байсан хуучин үзүүр ирмэг нь хагарч тал болсон хөх тоосгонуудыг /6ш/ ирмэг үзүүрийг засч бөөрөнхийлөн үндсэн хийцтэй дөхүү хэлбэртэй болгон өрлөг хийж,дээд тавцанг орчин цагийн барилгын чулуун плитаг зүсч тааруулан хийж зассан болно.Холбогч шавардлагыг хурдан хатааж бэхжүүлэхийн тулд 80%-ийн гипс, 15%-ийн цемент, 5%-ийн шар шаварны холимгоор хийсэн ба хуучин өнгийг дагуулан будалтыг усан суурьтай акрилак будгаар хийсэн болно.

Хүндэтгэлийн хаалганы дээрхи хорол салхинд унасан анхны байдал

Түр цагийн шат угсарсан байдал ба сэргээн засварлагчдын ажиллаж байгаа ажлын явцын зураг

Хүндэтгэлийн хаалганы дээрхи хоролны доод суурь хуучин цементээр нөхөж тогтоосон нь нурсан байдал

Хоролны доод суурь,цэцэг дүрслэл бүхий шатаамал шавар дэлний өрлөг хийц цуурч ангайж суулт өгсөн байдал

Хоролны хоёр хажуугийн бодь гереес

Хоролны доод суурины дутуу зарим хэсгүүдийг хөх тоосго ашиглан орлуулан хийж байгаа ажлын явц

Хоролны доод тавцанг засаж сэргээсэн байдал

Хоролыг тогтоосны дараах үеийн зураг

ҮР ДҮНГИЙН ГЭРЭЭ

1.Гэрээ байгуулагч Талууд:

1.1.Нэг талаас: Төсвийн ерөнхийлөн захирагч

БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ САЙД ЛУВСАННЯМ ОВОГТОЙ ГАНТӨМӨР
(албан тушаал, нэр) *(эцэг/ эх/-ийн нэр, нэр)*

1.2.Нөгөө талаас: Төсвийн шууд захирагч

СОЁЛЫН ӨВИЙН ТӨВИЙН ЗАХИРАЛ ГАЛБАДРАХ ОВОГТОЙ ЭНХБАТ
(албан тушаал) *(эцэг /эх/-ийн нэр, нэр)*

Бид дор дурдсан асуудлаар харилцан тохиролцсоны үндсэн дээр энэхүү гэрээг байгуулав.

2.Гэрээний агуулга, зорилго

2.1."Байгууллагын үйл ажиллагааны жилийн төлөвлөгөө" нь энэхүү гэрээний салшгүй бүрэлдэхүүн хэсэг бөгөөд түүнд төсвийн шууд захирагчаас хэрэгжүүлэх хөтөлбөр, нийт болон тусгай арга хэмжээнүүд, манлайллын зорилтууд, тэдгээрийн гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт (тоо, чанар, хугацаа, хүрэх үр дүн)-үүд болон бусад эрх үүргийг тусгав.

2.2.Энэхүү гэрээний зорилго нь үйл ажиллагаагаа оновчтой төлөвлөж хэрэгжүүлэх, ажлын байрны шаардлагад нийцүүлэн мэдлэг чадвараа дээшлүүлэх, төрийн албаны тухай хууль тогтоомж, стандарт, ёс зүйн хэм хэмжээг чанд сахиж, сонирхлын зөрчилгүй ажиллах, байгууллагын үйл ажиллагааны ил тод байдлыг хангаж, төсвийн болон эд хөрөнгийг зохистой ашиглах, хүний нөөцийн чадавхийг бэхжүүлэх зэрэг манлайллын зорилтуудыг хангах талаар төсвийн шууд захирагчийн тухайн жилд гүйцэтгэх үүрэг, хүлээх хариуцлагыг тодорхойлоход оршино.

НЭГ. ТАЛУУДЫН ХҮЛЭЭХ ҮҮРЭГ

1. Төсвийн шууд захирагчийн хүлээх үүрэг

1.1.Энэхүү гэрээний хавсралт болох "Байгууллагын үйл ажиллагааны жилийн төлөвлөгөө"-нд тусгагдсан ***20 нийт арга хэмжээ*** (*энэхүү загварын 1.2-т дурдсан тусгай арга хэмжээ орохгүй*)-г гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт (тоо, чанар, хугацаа, хүрэх үр дүн) бүрээр ханган хэрэгжүүлнэ.

1.2.Энэхүү гэрээний хавсралт болох "Байгууллагын үйл ажиллагааны жилийн төлөвлөгөө"-нд тусгагдсан арга хэмжээнээс төсвийн ерөнхийлөн захирагчийн тусгайлан сонгосон **1.4, 2.2, 3.6** дахь нийт ***3 тусгай арга хэмжээг*** гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт (тоо, чанар, хугацаа, хүрэх үр дүн) бүрээр ханган хэрэгжүүлнэ.

1.3.Төрийн жинхэнэ албаны удирдах ажилтны манлайллын зорилтын хүрээнд дор дурдсан арга хэмжээг хэрэгжүүлнэ:

Хүснэгт 1

Манлайллын зорилт	***Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ***	***Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт*** *(тоо, чанар, хугацаа)*
1	2	3
1.Төрийн жинхэнэ албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг чанд сахиж, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар: Зорилт 1 -Холбогдох хууль тогтоомжийг мөрдөн үйл ажиллагаандаа нэвтрүүлэн ажиллана.	а) "Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхолын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай" хуулийн дагуу хөрөнгө орлогын мэдүүлгийг заасан цаг хугацаанд өгнө. б) "Соёлын өвийг хамгаалах тухай хууль", "Төрийн албаны тухай" хууль болон бусад удирдах дээд байгууллагаас гарсан цаг үетэй холбоотой тушаал шийдвэр, удирдамжийг хэрэгжүүлэн ажиллана.	Жилийн турш
	в) Улс, аймгийн музейн дүрэм, Олон улсын музейн ёс зүйн дүрмийг мөрдлөг болгон ажиллана.	Жилийн турш
2. Байгууллагын ил тод байдлыг хангах талаар: Зорилт 1 -Байгууллагыг ил тод, ардчилсан зарчмын дагуу улирдан зохион байгуулж, удирдлагын менежментийн шинэлэг хэлбэрийг нэвтрүүлэн ажиллана.	а) Хэлтэс бүр улиралд 1 удаа хэлтсийн үйл ажиллагааны талаар бусад хэлтсүүддээ зориулж нээлттэй өдөр зохион байгуулж ажиллана. Байгууллагын удирдлагын менежментийг өөрчилж ил, тод харилцааг бий болгон ажиллана.	Жилийн турш
3.Төсвийн хөрөнгийн төлөвлөлт, зарцуулалтын ил тод байдлыг хангах талаар: Зорилт 1 -Төсвийн зарцуулалтыг ил тод, зөв зохистой, хяналттай хэрэгжүүлнэ.	а) 2015 оны байгууллагын төсвийг нийт ажилтнуудад нээлттэй танилцуулна. б)"Шилэн дансны тухай" хууль, "Төсвийн тухай" хуулийг мөрдлөг болгон ажиллана. в) Байгууллагын жилийн төсвийг үр дүнтэй, зөв зохистой зарцуулан ажиллана. г) Төсвийн зарцуулалтын тухай тайланг цаг тухайд нь тайлагнан ажиллана.	Жилийн турш

4. Байгууллагын эд хөрөнгийг зохистой ашиглах талаар: Зорилт 1 -Байгууллагын тоног төхөөрөмжийг зүй зохистой ашиглах, эд хөрөнгийн ашиглалтад хяналт тавин ажиллана.	а) Байгууллагын "Өмч хамгааллын комисс"-н ажлыг удирдлагаар ханган, хяналт тавин ажиллана. б) Байгууллагын ажилтнуудад холбогдох тоног төхөөрөмжийг хариуцуулан гэрээ байгуулж ажиллана.	Жилийн турш
5. Байгууллагын хүний нөөцийн чадавхийг бэхжүүлэх талаар: Зорилт 1 -Байгууллагын хүний нөөцийн зохистой бодлогыг хэрэгжүүлэн, хүний нөөцийн чадавхийг дээшлүүлэх ажлыг зохион байгуулан удирдлагаар ханган ажиллана.	а) Байгууллагын хүний нөөцийн судалгаа хийнэ. б) Хүний нөөцийн чадавхийг дээшлүүлэх зорилготой ажилтнуудаа мэргэжил дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлэн удирдлагаар ханган ажиллана.	Жилийн турш

1.4.Мэдлэг чадвараа дээшлүүлэх талаар дор дурдсан зорилтыг хэрэгжүүлнэ.

Хүснэгт 2

Мэдлэг чадвараа дээшлүүлэх зорилт *(шалгуурүзүүлэлт)*	***Зорилтыг хэрэгжүүлэх арга зам (өөрийгөө хөгжүүлэх чиглэл)***	***Хуанлийн хугацаа, хүн/өдөр***
1	2	3
Мэдлэг чадвараа дээшлүүлэх зорилт -1: (*шалгуур үзүүлэлт*)	БНХАУ-д Хэрлэн барс хотын суваргыг бэхжүүлэх зорилгоор хамтын ажиллагаа өрнүүлэх, хамтарсан сэргээн засварлалт зохион байгуулах	180

1.5. Төрийн албаны тухай хууль тогтоомж, стандартыг мөрдөж ажиллана.

2. Төсвийн ерөнхийлөн захирагчийн хүлээх үүрэг

2.1. Төсвийн шууд захирагчтай байгуулах гэрээнд тусгаж хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээ (нийт болон тусгай арга хэмжээ)-нүүд, тэдгээрийн гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтийг тодорхойлно.

2.2. Манлайллын зорилтууд, тэдгээрийн гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтийг тодорхойлно.

2.3.Тухайн төрийн байгууллага болон эрх шилжүүлсний үндсэндээр бусад байгууллага хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхэд шаардлагатай төсвийгэрх бүхий байгууллагаар батлуулна.

2.4.Тухайн төрийн байгууллага болон эрх шилжүүлсний үндсэн дээр бусад байгууллагын хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээний санхүүжилтийг хугацаанд нь хийнэ.

2.5.Гэрээнд тусгагдсан хөтөлбөр, нийт болон тусгай арга хэмжээнүүд, манлайллын зорилтоо хэрэгжүүлэхэд нь төсвийн шууд захирагчид байнгын дэмжлэг туслалцаа үзүүлж, гэрээний биелэлтийг хангах боломж, нөхцөлийг бүрдүүлнэ.

2.6.ТТХ-ийн 14 дүгээр зүйлийн 14.2 дахь хэсэгт заасан бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.

ХОЁР. БУСАД ЗҮЙЛ

3.Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах

3.1.Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг талууд харилцан тохиролцсоны үндсэндээр шийдвэрлэж, албажуулан гэрээнд хавсаргана. Энэхүү гэрээний хугацаа сунгагдахгүй.

4.Гэрээ байгуулах болон дүгнэх хугацаа:

4.1.Гэрээг 2015 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 2015 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг дуусталх хугацаагаар байгуулав.

4.2.Төсвийн шууд захирагч гэрээний биелэлтийг 20... оны ....дугаар сарын ....-ны дотор багтаан тайлагнаж, төсвийн ерөнхийлөн захирагч 20... оны .... дугаар сарын ....-ны дотор багтаан түүний биелэлтийг дүгнэнэ.

5.Гэрээний урамшуулал ба хариуцлага

5.1.Төсвийн шууд захирагч гэрээгээр хүлээсэн үүргээ хангалттай сайн биелүүлсэн тохиолдолд түүнийг урамшуулах асуудлыг төсвийн ерөнхийлөн захирагч холбогдох хууль тогтоомж, эрх зүйн акт, байгууллагын Хөдөлмөрийн дотоод журамд заасны дагуу шийдвэрлэнэ.

5.2.Төсвийн шууд захирагч гэрээгээр хүлээсэн үүргээ хангалтгүй биелүүлсэн тохиолдолд төсвийн ерөнхийлөн захирагч түүнд туслалцаа дэмжлэг үзүүлэх, шаардлагатай гэж үзвэл холбогдох хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

6. Гэрээ байгуулсан:

Төсвийн ерөнхийлөн захирагч

Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд ..... /Л.Гантөмөр/
(албан тушаал) *(гарын үсэг)*
Тэмдэг

.....
(огноо)

Төсвийн шууд захирагч

Соёлын өвийн төвийн захирал ..... /Г.Энхбат/
(албан тушаал) *(гарын үсэг)*
Тэмдэг

УЛААНБААТАР ХОТ
ТТ33332 9104208

2015 09 14

.....
(огноо)

хөдлөх дурсгалыг бүртгэн баримтжуулах	Ханхонгор, Цогт-Цэций, Ханбогд, Манлай гэсэн 7 сумын нутагт 2015 оны 9 дүгээр сарын 20-ноос 10 дугаар сарын 20-ныг хүртэл 30 хоногийн хугацаатай ажиллана. 1.2.3. Аймгийн музей, сумдын соёлын төвийн ажилтнууд, байгаль орчны байцаагч нар хамтран ажиллаж, тэдэнд түүх, соёлын үл хөдлөх дурсгалыг хамгаалах талаар мэдлэг чадвар олгож, арга зүйгээр хангана.	дурсгалын 80-90% нь хамрагдаж, нь анхан шатны бүртгэл, гэрэл зураг, видео бичлэг бүхий мэдээллээр баяжигдан хадгалагдсан байна.		
1.3. Дэл уулын орчмын түүх, соёлын дурсгалын судалгаа, бүртгэн баримтжуулалт, хадгалалт хамгаалалтын байдлын тухай нээлттэй хэлэлцүүлэг зохиох	1.3.1. 2015 оны 4 дүгээр сард Дундговь аймгийн Өлзийт сумын нутаг орших Дэл уулын дурсгалыг вертуал хэлбэрт оруулсан төрөлжсөн вэб хуудас танилцуулах, дурсгалыг хамгаалах талаар эрдэмтэн судлаачдыг оролцуулсан илтгэл, нээлттэй хэлэлцүүлэг хийнэ. 1.3.2. Эрдэмтэн судлаачдыг оролцуулсан нээлттэй хэлэлцүүлэг-эрдэм шинжилгээний хурал зохион байгуулах	Хэлэлцүүлгийн үр дүнд Дэл уулын дурсгалын талаар олон нийтэд мэдээлэл өгөх, Дурсгалыг хамгаалах талаар олон нийтийн оролцоог дээшлүүлэх	15.590.228	Д.Нарантуяа Г.Анхсанаа Б.Алтансүх П.Чинбат Т.Эрдэнэцогт Дундговь аймгийн музей
1.4 Музейн 7 үзмэр болон үл хөдлөх 5 дурсгалыг 3D-ээр сканнердан, бүртгэн баримтжуулах	1.4.1. Богд хааны ордон музейн 7 үзмэрийг 3D-ээр сканнердан, бүртгэн баримтжуулах ажлыг 2015 оны 1-11 дүгээр сард хийж гүйцэтгэнэ. 1.4.2. Сүхбаатар аймагт орших Хөрөгийн хөндийн 5 хүн чулуун дурсгалыг 3D-ээр сканнердан, бүртгэн баримтжуулах ажлыг 2015 оны 7 дугаар сард хийж гүйцэтгэнэ. 1.4.3. 3D-ээр скайннердан, бүртгэн баримтжуулсан хүн чулуун дурсгал болон музейн үзмэрийн талаарх мэдээлэл, судалгааны ажлыг тайлагнах, дүгнэх	Байгууллагын БМС болон тухай дурсгал хадгалагдаж буй газрын БМСан орчин үеийн дэвшилтэт аргаар тухайн дурсгалыг баримтжуулсан мэдээллийн сантай болно. Мэдээллийг сурталчилгаанд ашиглаж болно.	16.687.228	Д
1.5 Улс, аймгийн музейн 42 БМСанч нарыг хамруулсан уулзалт зөвлөгөөнийг зохион байгуулах.	1.5.1. Уулзалт зөвлөгөөнийг 2015 оны 5 дугаар сард зохион байгуулах ба RCH 3.0 музейн үзмэрийн бүртгэлийн програмын тухай танилцуулга, шинэчлэн батлагдсан Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн БМСантай холбоотой хэсэг болон шинээр батлагдах Соёлын өвийн УНБМС-тай холбоотой журмыг танилцуулна. Соёлын биет өвийг (хөдлөх, үл хөдлөх дурсгал) бүртгэн баримтжуулах, БМС бүрдүүлэх, -Соёлын биет бус өвийг бүртгэн баримтжуулах, БМС бүрдүүлэх тухай арга зүйн сургалт зохион байгуулна.	Улс, аймгийн музейн БМСанч нарт хууль, эрх зүйн бичиг баримтыг танилцуулах, ажлын арга зүйгээр хангах, музейн БМС Соёлын өвийн УНБМСангийн хамтын ажиллагааны тухай нэгдсэн ойлголтонд хүрнэ.	19.359.728	Г.Энхбат Д.Нарантуяа Ш.Энхтуяа Б.Алтансүх

БАТЛАВ.ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧ: ..... /Л.Гантөмөр/
(Гарынүсэг, тэмдэг)

“Соёлын өвийн төв”-ИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ /2015ОН/

Хөтөлбөр *(хөтөлбөрийн нэр)*,**хэрэгжүүлэх арга хэмжээ**	**Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт**		**Төсөв** *(мян.төг.)*	**Хариуцах нэгжийн нэр** *(Эсхүл менежерийн нэр)*
	Арга хэмжээ (гарц)-ний шалгуур үзүүлэлт/ *тоо, чанар, хугацаа*/**-ийн хүрэх түвшин**	**Хүрэх үр дүнгийн шалгуур үзүүлэлтийн хүрэх түвшин**		
1	2	3	4	5
1.0. Соёлын биет өвийг хамгаалах хэлтэс"-ийн стратегийн зорилтыг хангахад чиглэсэн ажил, үйлчилгээ:				
1.1. Түүх, соёлын үл хөдлөх дурсгалын хадгалалт хамгаалалтыг төлөвлөх цахим удирдлагын системийн хэрэглэгчийн шаардлага боловсруулах	- Археологийн малтлага судалгааны зөвшөөрөл, үйл ажиллагаа, үр дүнг тайлагнах дэд систем -Түүх, соёлын үл хөдлөх дурсгалт газрыг Аялал жуулчлал, соёлын бүтээлч үйлдвэрлэлд ашиглах үйл ажиллагааг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнах дэд систем -Яаралтай авран хамгаалах, сэргээн засварлах шаардлагатай үл хөдлөх дурсгалын мэдээллийг нэгтгэх дэд систем	-Төрийн болон орон нутгийн соёлын асуудал хариуцсан албан тушаалтнуудын ажлын уялдаа холбоо сайжирч түүх, соёлын үл хөдлөх дурсгалын хадгалалт хамгаалалтын байдал бодитоор сайжрах системийн загварыг тодорхойлсон байдал. -Түүх, соёлын үл хөдлөх дурсгалын хадгалалт хамгаалалт, хяналтанд олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх боломж бүрдсэн системийн загварыг тодорхойлсон байдал.	18.495.228	Г.Энхбат Д.Нарантуяа Б.Алтансүх Г.Анхсанаа Т.Эрдэнэцогт П.Чинбат
1.2. Баянхонгор аймгийн өмнө болон баруун хойд талын 10 сум, Өмнөговь аймгийн зүүн болон хойд талын 7 сумдын нутаг дахь түүх, соёлын үл	1.2.1. Баянхонгор аймгийн Эрдэнэцогт, Жаргалант, Галуут, Баян-Овоо,Өлзийт, Жинст, Баянлиг, Баянговь, Шинэжинст гэсэн 10 сумын нутаг дэвсгэрт 2015 оны 7 дугаар сарын 20-ноос 8 дугаар сарын 20-нийг хүртэл 30 хоногийн хугацаатай ажиллана. 1.2.2.Өмнөговь аймгийн Цогт-Овоо, Мандал-Овоо, Булган,	СӨУНБМСан болон Баянхонгор аймгийн БМСанд аймгийн үл хөдлөх дурсгалын 50%, Өмнөговь аймгийн БМСанд аймгийн үл хөдлөх	19.265.228	Д.Нарантуяа Г.Анхсанаа Т.Эрдэнэцогт П.Чинбат

1.6 Монгол нутаг дахь сүм хийд, дурсгалт уран барилгын 3D хэмжилт, бүртгэн баримтжуулалт-Архангай аймагт	1.6.1. БНСУ-тай хамтран ажиллах гэрээг 2015 оны 5 сард гарын үсэг зурж баталгаажуулна. Архангай аймгийн Өлзийт сумын нутагт орших Өөлд бэйсийн хүрээний Цогчин дуганг 3D хэмжээсээр бүртгэн баримтжуулах ажлыг Солонгос улсын мэргэжилтнүүдийн хамт 2015 оны 6-7 сард хийж гүйцэтгэнэ. Цуглуулсан мэдээллийг 2015 оны 12 дугаар сард боловсруулж дуусна.	Солонгос улсын мэргэжилтнүүдтэй хамтран ажиллах, суралцах, дадлагажиж чадвар эзэмшинэ. Соёлын өвийн УНБМСангийн мэргэжилтнүүд сүм хийд, дурсгалт уран барилгын 3 хэмжээст мэдээллийн санг бүрдүүлэх ажлыг эхлүүлнэ.	16.046.228	Т.Эрдэнэцогт Г.Анхсанаа Б.Алтансүх
1.7 Өндөр гэгээн Занабазарын мутрын хийц бүхий цутгуур бурхад-түүх, соёлын хосгүй үнэт дурсгал болохыг баталгаажуулсан дүрс бичлэгийн сан бүрдүүлэх	1.7.1 2015 оны 1-4 дүгээр улиралд МУ-ын ЗГ-ын тогтоолоор батлагдсан 779 ширхэг түүх, соёлын хосгүй үнэт дурсгалаас Өндөр гэгээн Занабазарын өөрийн гараар бүтээсэн 54 цутгуур бурхадын талаарх түүх, соёл, шинжлэх ухааны үнэ цэнэтэй мэдээллийг холбогдох эрдэмтэн судлаачдаар баталгаажуулан тайлбарлуулсан дүрс бичлэгийн сан үүсгэнэ.	Урьд өмнө нь түүх, соёлын хосгүй үнэт дурсгалыг сэдэвчлэн төрөлжүүлж, эрдэмтэн судлаачдаар танилцуулга, тайлбар хийлгэж байгаагүй ба Занабазарын бүтээлээр эхлүүлэн цаашид археологи, угсаатны зүй, дэлгэмэл бүтээл, байгаль, палеонтолог зэрэг олон сэдвээр төрөлжсөн дүрс бичлэгийн сан үүснэ. Занабазарын өөрийн гараар урласан 50 гаруй цутгуур бурхадын мэдээллийн сан үүснэ.	17.520.328	Д.Нарантуяа Ш.Энхтуяа Б.Алтансүх Ж.Даваацэрэн
1.8 “Түүх, соёлын үл хөдлөх дурсгалын үзлэг тооллого-2015” арга зүйгээр хангах, дүн мэдээг хүлээн авах, нэгтгэх	1.8.1. 2015 оны 10 дугаар сард Улаанбаатар хот, 21 аймгаас үзлэг тооллогын дүн мэдээг нэгтгэн, БСШУЯаманд хүлээлгэн өгнө.	Улсын хэмжээнд үзлэг тооллогонд хамрагдсан дурсгалууд хувийн дугаартай болсон байна. Бүх дурсгал нэгдсэн програм хангамжийн мэдээллийн санд шижигдсэн байна.	15.259.928	БӨХХэлтэс
"2.0. “Соёлын биет бус өвийг хамгаалах хэлтэс"-ийн стратегийн зорилтыг хангахад чиглэсэн ажил, үйлчилгээ:				
2.1. “Шувуучлахуй” СББӨ-ийг сурталчлах, хамгаалах, судалгаа хийх	2.1.1. Түүхийн эх сурвалжид шувуучлахуйтай холбоотой түүхэн дурсгалт газар, шувуучлан ан гөрөө хийж буй хадны зураг зэрэг дурсгалт газраар судалгаа хийх 2.1.2. Шувуучлах зан үйлийг судлаж буй судлаачид, ард	Дэлхийн соёлын биет бус өвд бүртгэгдсэн дурсгалын тайлант хугацаанд эрдэмтэн судлаачдын	11.079.510	Ц.Жаргалсайхан А.Саруул Ж.Насанжаргал

	иргэдтэй хамтран ажиллах	оролцоотй хээрийн судалгаа, 4 цагийн дүрс бичлэгийн сан бүрдэнэ. Олон нийт, орон нутгийн ард иргэдийн энэ төрлийн СББӨ-ийг хамгаалах оролцоог нэмэгдүүлнэ.		
2.2. ЮНЕСКО-д 2016 онд нэр дэвшүүлэх "Хөхүүрийн монгол айраг исгэх зан үйл" СББӨ-ийн хэрэглэгдэхүүн боловсруулах, илгээх	2.2.1. 2015 оны 3 сарын 31 гэхэд ЮНЕСКО-д бүртгүүлэх өв илгээгдсэн байна. Монгол орны айраг хийх зонхилох бүс нутаг болох Булган, Архангай, Өвөрхангай, Дундговь аймагт 2015 оны 2,3 дугаар улиралд судалгаа хийгдэнэ. 2.2.2. Тус бүс нутагт тодорхой нэр бүхий өрх айлд очиж Хөхүүрийн айраг хийх арга ухааныг гэрэл зураг, дүрс бичлэгт бүртгэн баримтжуулна.	2016 онд Монгол орноос Дэлхийн Соёлын өвд "Хөхүүрийн монгол айраг" СББӨ-ийн төрөл зүйлийг нэр дэвшүүлнэ. Судалгааны хэрэглэгдэхүүн цуглагдана.	14.089.510	Ц.Жаргалсайхан А.Саруул Ж.Насанжаргал
2.3."Лимбэний битүү амьсгаа" СББӨ-ийг хамгаалах, сурталчлах	2.3.1. Монголын театрын музей, Хөгжим бүжгийн коллежтэй хамтран "Лимбэний эгшиг" танхим байгуулж, өвийг сурталчлах, судлах, шавь сургалт явуулах үйл ажиллагааг явуулна. -Өвийг сурталчилсан телевизийн 1-2 нэвтрүүлэг -Лимбэний битүү амьсгааны тухай 14 хоногт 1 удаа, 2-3 сарын хугацаатай анхан шатны сургалт ЕБС болон ХБК-ийн сурагчдад явуулна.	"Лимбэний битүү амьсгаа" СББӨ-ийг хамгаалах талаар улсын байгууллага, СББӨ-ийг өвлөн уламжлагч хүмүүсийн хамтын оролцоо, хамрах хүрээ өргөжнө.	9.629.510	Ц.Жаргалсайхан СББӨХХэлтэс
2.4. Урианхайн соёлын олон төрөл зүйлийн судалгаа хийх	2.3.1. Урианхайчуудтай холбоотой СББӨ-ийн олон төрөл зүйл Тууль, цуурын судалгааг Увс, Ховд аймагт хийнэ. Судалгааг Түүхийн хүрээлэн болон Хэл зохиолын хүрээлэнгийн судлаачидтай хамтран зохион байгуулна. Энэ ажлыг 2015 оны 3 дугаар улиралд хийнэ.	Соёлын өвийн УНБМсанд Урианхайчуудтай холбоотой СББӨ-ийн 50 орчим төрөл зүйлийн бүртгэл мэдээллийн төрөлжсөн сан үүснэ.	11.810.910	Ц.Жаргалсайхан СББӨХХэлтэс
2.5. СББӨ-ийн бүртгэлийн програм хангамжийг шинэчлэх	2.4.1. Монгол үндэстний соёлын биет бус өвийн олон төрөл зүйл бүхий оноосон нэртэй өвийн тодорхойлолт, өвлөн уламжлагч хүнтэй холбоотой мэдээллүүд нэгдсэн програмд орно. Энэ ажлыг 2015 оны 4 дүгээр улиралд хийнэ.	Монгол улсын хэмжээнд СББӨ-ийн 1500 орчим төрөл зүйл, СББӨ-ийг өвлөн уламжлагч 7000 гаруй хувь хүнтэй холбоотой төрөлжсөн мэдээллийн сан үүснэ. Статистик мэдээлэл боловсрогдоно.	11.772.410	Ц.Жаргалсайхан СББӨХХэлтэс

2.6.ЮНЕСКО-д бүртгэгдсэн “Морин хуур”, “Уртын дуу”, “Лимбэний битүү амьсгаа” 3 өвийн тайлан боловсруулах, илгээх	2.6.1. 2015 оны 10 сар гэхэд өв тус бүр дээр тайлан англи хэл дээр бичигдэнэ. 2.6.2. Тайланг баталгаат шуудангаар илгээнэ.	Эдгээр 3 өвийг хамгаалах талаар хийсэн ажлын тайланг 2015 оны 10 сарын эцэс гэхэд ЮНЕСКО-д илгээсэн байна. ЮНЕСКО-оос тайланд үнэлэлт дүгнэлт өгнө.	9.399.510	Ц.Жаргалсайхан СББӨХХэлтэс
2.7. “Монгол гэрийн уламжлалт урлал, зан үйл”-ийн БМСанг баяжуулах, бүрдүүлэх	2.6.1. Монгол орны төвийн бүс нутаг, Өвөрхангай аймгийн Хужирт суманд гэрийн мод бэлтгэх, гэр хийх уламжлалт арга ухааныг гэрэл зураг, дүрс бичлэгээр бүртгэн баримтжуулж УНБМсанд төвлөрүүлэн хадгална. 2.6.2. Монгол орны баруун, зүн бүс нутаг дахь гэрийн мод бэлтгэх, гэр хийх уламжлалт арга ухааны тухай судалгаа хийж, дүгнэлт гаргана.	ЮНЕСКО-д бүртгэгдсэн “Монгол гэрийн уламжлалт урлал, зан үйл”-ийн өвийг хамгаалах, бүртгэн баримтжуулалтын цогц мэдээллийн сан үүсэх эхлэл тавигдана.	10.726.510	Ц.Жаргалсайхан СББӨХХэлтэс
2.8. “Соёлын биет бус өвийг хамгаалах Үндэсний хөтөлбөр”-ийг боловсруулах	2.8.1. Өмнө нэг төрлийн соёлын биет бус өвийн төрөл зүйлийг хамгаалах дагнасан хөтөлбөрүүд байсан бол 2016 оноос монгол нутагт буй үндэстэн угсаатны бүхий л өвийг орон нутаг, газар зүйн бүс нутгаар нь, тухайн өвийг бүртгэл мэдээлэл бий эсэх, судлагдсан эсэх, өвлөн уламжлагдсан эсэх, устаж буй эсэх олон зорилтын хүрээнд аймаг орон нутгийн ЗДТГ, судалгааны хүрээлэн, эрдэмтэн судлаачид, ард иргдэийн оролцоотойгоор хамгаалах ажлын төлөвлөгөө боловсруулагдана.	Монгол үндэстний бүхий л соёлын биет бус өвийн төрөл зүйл нэгдсэн удирдлага, системтэйгээр хамгаалагдах эх суурь тавигдана.	23.502.800	Г.Энхбат Ц.Жаргалсайхан СББӨХХэлтэс
"3.0. “Соёлын өвийг сэргээн засварлах хэлтэс"-ийн стратегийн зорилтыг хангахад чиглэсэн ажил, үйлчилгээ:				
3.1. Музейн, эрдэм шинжилгээний байгууллагад хадгалагдаж буй үзмэр, эд өлгийн зүйсийг бэхжүүлэх, сэргээн засварлах	3.1.1. Улс, аймгийн 12 музей, байгууллагын 226 ширхэг үзмэрийг цэвэрлэж бэхжүүлэх, сэргээн засварлах. 1.Дүрслэх урлагийн музейн 2ш 2.Сүхбаатар аймгийн музей 10ш 3.Монголын үндэсний музей 2ш 4.Археологийн хүрээлэн 130ш 5.Ханбогд сумын соёлын төв 1ш 6.Эрдэнэ зуу музей 10ш 7.Уран зургийн галерей 53ш 8.Өмнөговь аймгийн музей 1ш 9.Богд хааны ордон музей 3ш 10.Театрын музей 3ш 11.Түүхийн хүрээлэн 1ш 12.Дундговь аймгийн музей 10ш	226 ширхэг үзмэр сэргээн засварлагдан бэхжүүлэгдэж, музейн сан хөмрөгт хадгалагдана.	28.164.000	С.Чинзориг Сэргээн засварлах хэлтэс

	2015 оны 1-4 дүгээр улиралд			
3.2. Музейн үзмэрийн материал бүтцийн судалгаа хийх	Богд хааны ордон музейн скайнер хийгдэх бурхад болон болон ШУА-ийн Археологийн хүрээлэнгийн сэргээн засварлахаар ирсэн олдвор, эд өлгийн зүйлсэд Япон улсын буцалтгүй тусламжаар ирсэн багаж, төхөөрөмжийг ашиглан металл, төмөрлөгийн бүтцийн судалгаа хийгдэнэ.	Богд хааны ордон музейн 10 ширхэг, Археологийн хүрээлэнгийн 100 гаруй олдворт материал бүтцийн судалгаа хийгдэж, мэдээллийн сан үүснэ.	22.734.800	С.Чинзориг
3.3. "Их бурхант" дурсгалыг сэргээн засварлах	3.2.1. 2015 оны 5-6 дугаар сард дурсгалын гол шүтээн Жанрайсиг бурханы нүүрний хэсгийг сэргээн засварлана. 3.2.2. 2015 оны 8 дугаар сард Жанрайсиг бурханы арын талын Цагаан дарь эх, Манчиргарбу гэсэн 2 бурханыг сэргээн засварлана.	"Их бурхант" дурсгалын гол шүтээн бурхан, арын 7 бурханы 2 ширхэг бурхан нь сэргээн засварлагдана.	34.072.300	Сэргээн засварлах хэлтэс Н.Жамбал Сэргээн засварлагчид
3.4. "Баяннуур цогцолбор" дурсгалын ханын зургийг авран хамгаалах	3.4.1. Булган аймгийн Баяннуур сумын нутагт орших Улаан хэрмийн шороон бумбагарын бунхант булшны ханын зарим зурганд цэвэрлэгээ бэхжүүлэлт хийнэ. 3.4.2. Ханын зургийн хадгалалт хамгаалалтын талаар судалгаа хийгдэнэ. 2014 оны 2-4 дүгээр улирал	Ханын зурганд үүссэн мөөгөнцөрийг цэвэрлэнэ. Ханын зургийн хөндийрсөн зарим будгийг бэхжүүлнэ.	23.882.800	ССАЖЯам С.Чинзориг Туслах ажилтнууд
3.5. "Түүх, соёлын үл хөдөх дурсгалыг хамгаалах Үндэсний хөтөлбөр"-ийн 7.2, 7.3 дахь ажлууд	3.4.1. Завхан аймгийн Шилүүстэй сумын Дааган дэл, Завхан аймгийн Алдархаан сумын Мөнгөт хясаа гэсэн 2 дурсгалт газар байрлуулах танилцуулга самбар хийх 3.4.2. Танилцуулга самбаруудыг байрлуулах 3.4.3. Завхан аймгийн Алдархаан сумын Мөнгөт хясааны дурсгалаас хуулбар хийх	2007 оны Засгийн газрын 303 дугаар тогтоолор батлагдсан "Түүх, соёлын үл хөдлөх дурсгалыг хамгаалах, сэргээн засварлах хөтөлбөр"-ийн хэрэгжилт биелэлт хангагдах нөхцөл бүрдэнэ.	46.802.800	С.Чинзориг СӨСЗХэлтэс
3.6. "Хэрлэн барс" суваргыг бэхжүүлэх ажил	3.5.1. БНХАУ-ын мэргэжилтнүүдтэй хамтран дурсгалын дэргэд хөх тоосгох шатаах зуух хийх, уламжлалт аргаар тоосго шатаах ажлыг 2015 оны 5-7 сард хийнэ. 3.5.2. Суварганд бэхжүүлэлт, сэргээн засварлалт хийж 2015 оны 10 дугаар сард дуусгана.	2007 оны Засгийн газрын 303 дугаар тогтоолоор батлагдсан "Түүх, соёлын үл хөдлөх дурсгалыг хамгаалах,сэргээн засварлах хөтөлбөр"-ийн хэрэгжилт биелэлт хангагдах нөхцөл бүрдэнэ. Дурсгалд инженерийн шийдэлтэй бэхэлгээ, бэхжүүлэлт хийгдэнэ.	26.677.800	С.Чинзориг СӨСЗХэлтэс

3.7. Дорнод аймгийн музейн үзмэр сэргээн засварлах	3.6.1. Маршал Х.Чойбалсангийн төрсний 120 жилийн ой болж байгаа тул түүний хэрэглэж байсан том хэмжээний буйдан, сандал зэргийг аймгийн музейд нь очиж сэргээн засварлана. 2015 оны 4 дүгээр сард буюу 1-2 дугаар улиралд	Дурсгал сэргээн засварлагдана.	24.110.800	Н.Мөнгөнцоож СӨСЗХэлтэс
4. Дотоод ажил, үйлчилгээ				
4.1. БНХАУ-д эртний уламжлалт аргаар хөх тоосго хийх талаарх судалгаа хийх, туршлага судлах 4.2.Гандантэгчинлэн хийдийн улсын тооллогоны материал хэрэглэгдэхүүнийг УНБМСанд төвлөрүүлэх татаж авах, сан үүсгэх 4.3. Улс аймгийн музейн 2012-2014 оны улсын тооллогоны материал хэрэгдэгдэхүүнийг УНБМсанд төвлөрүүлэн цэгцлэх, сан үүсгэх 4.4. Шинээр байгуулагдах Соёлын өвийн Үндэсний төвийн үйл ажиллагааны менежментийн төлөвлөгөө чиглэл, статусыг соёлын бүтээлч үйлдвэрлэлд тулгуурлан шинээр боловсруулах.			БСӨХХ, ББСӨХХ

Төсвийн шууд захирагч: ..... / Г.Энхбат /
(Гарынүсэг, тэмдэг)

-х-

ҮР ДҮНГИЙН ГЭРЭЭ БАЙГУУЛАХ АРГАЧЛАЛ

"Төсвийн шууд захирагчийн үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлж, дүгнэх журам (цаашид /Журам/ гэх)"-ын 1 дүгээр хавсралт "Төсвийн шууд захирагчийн үр дүнгийн гэрээ (цаашид /Гэрээ/ гэх) байгуулах Үлгэрчилсэн загвар (цаашид /Загвар/ гэх)"-ын дагуу төсвийн шууд захирагчийн гэрээ байгуулахад энэхүү аргачлалыг баримтална.

НЭГ. ТАЛУУДЫН ХҮЛЭЭХ ҮҮРЭГ

1.Төсвийн шууд захирагчийн хүлээх үүрэг

Журмын 4.1.2-т зааснаар гэрээ байгуулах бэлтгэл ажлын хүрээнд "Байгууллагын үйл ажиллагааны жилийн төлөвлөгөө" бэлэн болсон байх шаардлагатай бөгөөд энэхүү төлөвлөгөө нь гэрээ байгуулах гол нөхцөл болно.

Загварын 1.1-ийн ***"нийт арга хэмжээ"*** гэсний өмнөх зайд тухайн жилд төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх нийт арга хэмжээ (тусгай арга хэмжээнээс бусад)-ний тоог энэхүү гэрээний хавсралт болох "Байгууллагын үйл ажиллагааны жилийн төлөвлөгөө"-нөөс авч бичнэ.

Загварын1.2-ын**"тусгайлан сонгосон"**гэсний дараах зайд журмын 1.3.2-т заасан "тусгай арга хэмжээ"-ний шалгуурыг баримтлан төсвийн ерөнхийлөн захирагчийн тусгайлан сонгосон ***тусгай арга хэмжээ*** бүрийн өмнөх дугаар (**2.1, 3.4.** гэх мэт.)-ийг, ***"тусгай арга хэмжээ"*** гэсний өмнөх зайд тусгай арга хэмжээний нийт тоог "Байгууллагын үйл ажиллагааны жилийн төлөвлөгөө"-нөөс тус тус авна.

Загварын 1.3-т:

- төрийн жинхэнэ албан хаагчийн эрхэмлэн дээдлэх зүйлсийг баримтлах, ёс зүйн хэм хэмжээг сахих болон ашиг сонирхлын зөрчил, авлигаас ангид байхтай холбоотой хууль тогтоомжийг сахин биелүүлэх,
- байгууллагын үйл ажиллагааг олон нийтэд ил тод, нээлттэй байлгаж, хүнд сурталгүй төрийн үйлчилгээг иргэдэд хүргэх,
- төсвийн хөрөнгийн төлөвлөлт, хадгалалт, зарцуулалтын ил тод байдлыг хангах, санхүүгийн тайлан мэдээг үнэн зөв гаргах,
- байгууллагын эд хөрөнгийг зохистой ашиглах, үр ашигтай хөрөнгө оруулалт хийх, эд хөрөнгийн тооллого, тооцоо, бүртгэлийг үнэн зөв, чанартай хийх,
- байгууллагын хүний нөөцийн төлөвлөлт, төрийн албан хаагчдын мэдлэг чадварыг дээшлүүлэх, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах бодлого, хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх зэрэг зорилтуудыг тусгана.

Загварын 1.3-ын Хүснэгт 1-ийн 1 дэх баганад манлайллын зорилтуудыг, 2 дахь баганад, тухайн зорилтыг хэрэгжүүлэхэд чиглэгдсэн арга хэмжээг, 3 дахь баганад арга хэмжээний гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт (тоо, чанар, хугацаа)-ийг тус тус тодорхойлж тусгана.

Загварын 1.4-ийн Хүснэгт 2-т төсвийн шууд захирагч байгууллагын үйл ажиллагааны хэтийн төлөвлөгөө болон стратегийн бусад баримт бичигт тусгагдсан зорилго, зорилтыг хэрэгжүүлэх, өөрийн Ажлын байр (албан тушаал)-ны тодорхойлолтод заасан шаардлагыг хангахад чиглэгдсэн ***мэдлэг чадвараа дээшлүүлэх*** зорилтыг тодорхойлно.

Загварын 1.5-д ***төрийн албаны тухай хууль тогтоомж, стандартыг чанд мөрдөх талаарх*** хууль тогтоомж, эрх зүйн акт, стандарт болон өөрийн байгууллагын

батлан гаргасан дүрэм, журам, төсвийн ерөнхийлөн захирагчийн шаардлагатай гэж үзсэн бусад холбогдох асуудлыг нэр заан тусгана.

2. Төсвийн ерөнхийлөн захирагчийн хүлээх үүрэг

Төсвийн ерөнхийлөн захирагч нь Төсвийн шууд захирагчийн гэрээнд тусгаж хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээнүүд, манлайллын зорилт, тэдгээрийн гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтийг тодорхойлох, санхүүжилтийг цаг хугацаанд нь хийх, ТТХ-ийн 14 дүгээр зүйлийн 14.2.1-14.2.10-т заасан төсвийн ерөнхийлөн захирагчийн бүрэн эрхийг хэрэгжүүлэх, төсвийн шууд захирагчийн санал болгосон бусад асуудлыг харилцан тохиролцож Загварын 2 дахь хэсэгт тусгана.

ХОЁР.БУСАД ЗҮЙЛ

3.Гэрээн доруулах нэмэлт, өөрчлөлт

Загварын 3.1-д байгууллагын үйлажиллагааны гадаад, дотоод орчин өөрчлөгдсөний улмаас байгууллагын зорилт, чиг үүрэг, зохион байгуулалтын бүтэц, орон тоо өөрчлөгдсөн, мөн нэмэлт хөтөлбөр, арга хэмжээг баталгаажуулах шаардлагатай гэж талууд үзсэн тохиолдолд гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг харилцан тохиролцож шийдвэрлэнэ. Талуудын аль нэг нь, эсхүл хоёул үүрэгт ажлаасаа өөрчлөгдсөн тохиолдолд шинээр томилогдсон талууд харилцан тохиролцсоны үндсэн дээр гэрээг хэвээр үргэлжлүүлэн мөрдөх, эсхүл түүнд нэмэлт, өөрчлөлт оруулж болно.

Шинээр томилогдсон талууд нэмэлт, өөрчлөлтийн талаар харилцан тохиролцсон зүйлээ албажуулж, гэрээнд хавсаргана. Гэрээг шинэчлэн байгуулах хүртэл өмнөх гэрээ хүчин төгөлдөр байна.

4.Гэрээ байгуулах болон дүгнэх хугацаа

Загварын 4.1-д гэрээний үйлчлэх хуанлийн хугацааг, Загварын 4.2-т төсвийн шууд захирагч гэрээний биелэлтийг тайлагнах болон төсвийн ерөнхийлөн захирагч гэрээний биелэлтийг дүгнэх хуанлийн хугацааг тус тус заана.

5.Гэрээний урамшуулал ба хариуцлага

5.1.Төсвийн шууд захирагч гэрээний биелэлтийн үнэлгээгээр **"А"** буюу **"Маш сайн"**, **"В"** буюу **"Сайн"** үнэлгээ авсан тохиолдолд холбогдох хууль тогтоомж, эрх зүйн акт, байгууллагын Хөдөлмөрийн дотоод журмыг үндэслэн, журмын 7.1-д заасан урамшуулыг олгох талаар нарийвчлан тусгаж болно.

5.2.Төсвийн шууд захирагч гэрээний биелэлтийн үнэлгээгээр **"D"** буюу **"Дутагдалтай"**, **"F"** буюу **"Хангалтгүй"** үнэлгээ авсан тохиолдолд тухайн төсвийн шууд захирагчийн ажлын үр дүн, мэдлэг чадварыг нь дээшлүүлэхэд төсвийн ерөнхийлөн захирагчийн зүгээс хэрхэн туслах, эсхүл ТАТХ, ТТХ, Хөдөлмөрийн тухай хууль, холбогдох бусад хууль тогтоомж, байгууллагын Хөдөлмөрийн дотоод журмыг үндэслэн журмын 7.1-д заасан хариуцлага хүлээлгэх талаар нарийвчлан тусгаж болно.

..... oOo .....